



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



KFW

**“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ”**

ТӨСӨЛ II/III-Р ҮЕ ШАТ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН
БОДЛОГО**

2022 он

Агуулга

Хураангуй	1
1. Төслийн танилцуулга	3
1.1 Төслийн ерөнхий танилцуулга	4
1.2 Төслийн бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөө	8
1.3 Төслийн зохион байгуулалт, үйл ажиллагааны зохицуулалт	10
1.4 Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын зорилго, арга зүй	12
2. Хууль эрх зүйн шаардлага	15
2.1 Нийгмийн нөлөөлөл	17
3. Төлөв байдлын урьдчилсан үнэлгээ	19
3.1 Төслийн бүс нутгийн иргэдийн амьжиргаа	24
3.2 Газар ашиглалт	25
3.3 Засаглал	26
3.4 Сорилтууд	26
4. Байгаль орчин, нийгмийн эрсдэл	29
4.1 Ерөнхий мэдээлэл	29
4.2 Төслийн үйл ажиллагаа ба тэдгээрийн байгаль орчин, нийгмийн холбогдох эрсдэл	30
4.3 Бага хэмжээний дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл	35
4.4 Хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой нийгмийн эрсдэл	37
5. Оролцогч талууд болон олон нийтийн оролцоог хангах	39
5.1 Орон нутгийн түвшний оролцоо	39
5.2 Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулах аргачлал	39
5.3 Гомдол болон санал хүсэлт хүлээн авах механизм	43
6. Төслийн хүрээнд соёлын өвийн талаар баримтлах бодлого	47
7. Хөдөлмөрийн менежментийн талаар баримтлах бодлого	48
7.1 Ялгаварлан гадуурхалгүй болон тэгш боломжийг хангах	48
7.2 Хөдөлмөрийн нөхцөл, болзол	48
7.3 Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	49
7.4 Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ	51
7.5 Осол аваарыг бүртгэх үйл явц	51
7.6 Төслийн гүйцэтгэгчийн ажилчдын ёс зүйн дүрэм	52
7.7 Ажлын байрны талаар асуудлыг дэвшүүлэх	52
7.8 Харуул хамгаалалтын ажилтан	52
8. Үйл ажиллагааны эрсдэлийн менежментийн удирдамж	55

8.1	Алхам 1: Байгаль орчин, нийгмийн стандартын эрсдэлийн үнэлгээ болон нөлөөллийг бууруулах журмыг тусгах нь	56
8.2	Алхам 2: Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн анхан шатны дүн шинжилгээ.....	57
8.3	Алхам 3: Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн менежмент	58
8.4	Алхам 4: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	59
8.5	Алхам 5: Удирдлага болон хяналт шинжилгээ.....	59
8.6	Алхам 6: Тайлан мэдээлэх.....	60
9.	БОНМБ-ыг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц	61
10.	БОНМБ-ын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ.....	63
11.	ТӨСӨВ.....	65
	Хавсралт 1 : Байгаль орчин болон нийгмийн анхан шатны үнэлгээний загвар.....	68
	Хавсралт 2: Төслийн талбайн үнэлгээний шалгах хуудас	73
	Хавсралт 3: Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД).....	88
	Хавсралт 4: Ковид-19 халдварын нөлөөллийг бууруулах арга хэмжээ	104
	Хавсралт 5: Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний загвар	107
	Хавсралт 6: Нийгмийн нөлөөллийн үнэлгээ	132
	Хавсралт 7: Ноцтой гэнэтийн ослын үед осол мэдээлэх үйл явц	135
	Хавсралт 8: Гомдол санал хүсэлт гаргах маягт	139
	Хавсралт 9: Төслийн гүйцэтгэгчийн ажилтнуудын ёс зүйн дүрэм	140
	Хавсралт 10: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин болон нийгмийн хяналтын хуудас	143
	Хавсралт 11: Тайлан мэдээлэх стандарт журам.....	151
	Хавсралт 12: Санамсаргүй олдворын журам	153
	Хавсралт 13: Төслийн оролцогч талууд.....	155
	Хавсралт 14: Байгаль орчин, нийгмийн асуудлын эрх зүй, байгууллагын хүрээ	163

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөлд хамрагдсан аймаг болон ТХГН-ийн байршил	6
Хүснэгт 2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	7
Хүснэгт 3. Баруун бүсийн зургаан аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар.....	8
Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаа, 2020-2021.....	9
Хүснэгт 5. Үндэсний болон Германы сэргээн босголтын зээлийн банкны эрсдэлийн стандартын ангиллын жагсаалт	15
Хүснэгт 6. Аймгуудын мал сүргийн тоо, мянган толгой (2020).....	22
Хүснэгт 7. Төсөл хэрэгжиж буй бүс нутагт хамрагдах аймгуудын ястнууд (хувь).....	23
Хүснэгт 8. Хүн ам ба газар нутаг, хамрагдах сум.....	24
Хүснэгт 9. Төслийн тодорхойлсон эрсдэл ба боломжит хөрөнгө оруулалт	31
Хүснэгт 10. Оролцогч талуудын оролцооны байдлын жишээ.....	41
Хүснэгт 11. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний загварын жишээ	41
Хүснэгт 12. Санал хүсэлтийн загвар.....	42
Хүснэгт 13. Аюулгүй байдлын арга хэмжээ	53
Хүснэгт 14: Хүлээгдэж буй үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хэрэгжилтийн тойм.....	56
Хүснэгт 15. Төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын нэгдмэл байдал	56
Хүснэгт 16: Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хүрээнд чадавх бэхжүүлэх байдлын тойм.....	63
Хүснэгт 17. Шаардлагатай байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны төсөв	65

Зургийн жагсаалт

Зураг 1. Эрсдэлийн удирдлага ба эрсдэлийг бууруулах шатлал	4
Зураг 2. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг	5
Зураг 3. Төслийн удирдлага ба боловсон хүчин	11
Зураг 4. Монгол орны жилийн дундаж хур тунадас 2020	19
Зураг 5. Монгол орны экологийн бүс.....	20
Зураг 6. Мал сүргийн тоо 2016-2019, сая толгой.....	21
Зураг 7. Аймгуудын мал сүргийн тоо, мянган толгой (2020).....	22
Зураг 8. Төслийн гомдол барагдуулах механизм	46
Зураг 9. Төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого (БОНМБ)-ыг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц	61

Товчилсон үгийн жагсаалт

Аймаг	Аймаг, сум/Орон нутгийн засаг захиргааны нэгж
АБОАЖГ	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
АЦУОШГ	Аймгийн цаг уур, орчны шинжилгээний газар
БОЯБХУАӨДЗТ I	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл I
БОЯБХУАӨДЗТ II/III	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл II/III
ГЭЗХАХЯ	Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам
ОБЗ	Орчны бүсийн зөвлөл
ОБМТ	Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө
СоС	Ёс зүйн дүрэм
КОВИД	"КО" - "корона", "ВИ" - "вирус", "Д" - "дизийз" буюу өвчин гэсэн үгийн товчлол
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНУАД	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм
БОНУА	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагаа (Дэлхийн Банк)
БОНЭМАБ	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМБ	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНУАС	Байгаль орчин, нийгмийн стандарт (Дэлхийн банк)
ӨУХ	Өргөтгөсөн удирдах хороо
СДОА	Сум дундын ойн анги
ТХЗБ	Төслийн хэрэгжилтийн зөвлөх баг
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУБХХ	Олон Улсын Байгаль хамгаалах холбоо
ГСБЗБ	Kreditanstalt für Wiederaufbau (Германы сэргээн босголт, зээлийн банк)
ОНТХГ	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
СЯ	Сангийн яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
БДГ	Байгалийн дурсгалт газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар
БНГ	Байгалийн нөөц газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ГСГЗ	Голын сав газрын захиргаа
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГХЗ	Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа
ТНӨИ	Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд
ТЗБ	Төслийн хэрэгжүүлэгч агентлаг
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
Төсөл	БОЯБХУАӨДЗТ II/III
ҮАС	Үйл ажиллагааны стандарт
Сум	Дүүрэг/засаг захиргааны нэгж
ДЦГ	Дархан цаазат газар
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Хураангуй

Монгол Улсад хэрэгжих “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III-р үе шатны хүрээнд нь тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн үйл ажиллагаанд төвлөрч хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, мөн Монгол орны биологийн олон янз байдлын тогтвортой менежментийг хангахад чиглэсэн хоёр үндсэн зорилготой.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III-р үе шатны хүрээнд Монгол орны баруун болон баруун өмнөд хэсгийн таван аймгийн ТХГН-ын хамгааллын менежментийг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Тус төсөл нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд,

1. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах
2. ТХГН түүний Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
3. Урьдчилсан тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгогдсон долоо хүртэлх бие даасан ТХГН-ийн бизнес төлөвлөгөөнүүд болон менежментийг хэрэгжүүлэх
4. ТХГН-ийн сүлжээний чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг хийх

Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого (БОНМБ) нь “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III-р үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төслийн үр дүнг сайжруулах, байгаль орчин, нийгмийн аливаа болзошгүй сөрөг эрсдэл, нөлөөллийг тодорхойлоход чиглэсэн баримтлах стандарт арга хэмжээ юм.

Холбогдох дүгнэлтээс хамаарч, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах эсвэл сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хангах зорилгоор төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үед байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч үзэх шаардлагатай.

БОНМБ-ыг хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэх нэгж, мөн Ховд, Увс аймаг дах төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон нутгийн ажилтнууд хариуцан ажиллана. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн холбогдох ажилтнууд нь ТХГН-ийн удирдлага, орчны бүсийн зөвлөл, хувийн аж ахуй нэгж, хоршоод, төрийн бус байгууллагууд болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орон нутгийн иргэдтэй нягт хамтран ажиллана.

Дэд бүтцийн бүтээн байгуулалт, өөрөөр хэлбэл захиргааны барилга байгууламжийг бүтээн байгуулалтын явцад гарах газар ашиглалтын өөрчлөлтэй холбоотойгоор байгаль орчин, нийгэмд үзүүлэх гол нөлөөлөл нь илрэх боломжтой юм. Гэсэн хэдий ч төслийн ихэнх үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх эрсдэл болон нөлөөлөл багатай байх боломжтой тул БОНМБ-д тодорхойлогдсон төслийн нэгдсэн стандарт арга хэмжээ, мөн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД)-д тусгагдан холбогдох журмын дагуу удирдан хэрэгжүүлж болно (Хавсралт 3-т тодорхойлогдсон БОНҮАД).

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-г гүйцэтгэгч байгууллага нь боловсруулж улмаар тус боловсруулсан БОНМТ-г төслийн хэрэгжилтийн зөвлөх баг болон төсөл хэрэгжүүлэх нэгж нь Германы сэргээн босголт, зээлийн банкны бага хэмжээний барилгын ажилд зориулсан шаардлага, стандарт болон холбогдох загварын дагуу хянана. Дунд хэмжээний барилгын ажил нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ*)-г шаардах ба энэхүү БОННҮ*-г Байгаль орчин, аялал

жуулчлалын яам (БОАЖЯ)-ны үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөр хянагдаж батлагдана. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г Германы сэргээн босголт, зээлийн банк болон Дэлхийн Банкны шаардлагын хүрээнд боловсруулна. БОННУ-г зөвлөх багын тусламжтайгаар боловсруулагдах бөгөөд улмаар Германы сэргээн босголт, зээлийн банкаар хянагдаж батлагдана.

Үйл ажиллагааны хүрээнд одоогийн газар ашиглалтын байдалд гарах тодорхой өөрчлөлт нь нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлж болох буюу орон нутгийн иргэдийн одоогийн амьжиргааны үйл ажиллагааны хүртээмжийн байдал сэргөөр нөлөөлөх боломжтой юм. Иймд, эдгээр үйл ажиллагаа нь олон нийтийн оролцооны аргад суурилсан зарчмаар нөлөөлөлд өртсөн хүмүүст зохих нөхөн олговор олгох, мөн үр өгөөжийг тэгш хүртэх боломжийг хангахын тулд нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, холбогдох нөлөөллийн үнэлэхийн тулд нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ННУ)-г хийж боловсруулах, мөн хамтын зөвшилд хүрэх шаардлагатай байдаг. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн нэг ч иргэний амьжиргааг дордуулахгүй байх гэсэн үндсэн зарчмын хүрээнд төслийг хэрэгжүүлнэ.

БОНМБ нь төслийн үйл ажиллагааг Монгол Улсын байгаль орчин, нийгмийн бодлого, хууль тогтоомж, түүнчлэн Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж, мөн Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн 1-ээс 10 дугаар стандартын шаардлагуудыг ханган хэрэгжүүлэх зорилгын хүрээнд боловсруулсан болно. Гэсэн хэдий ч Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хязгаарлалтын улмаас БОНМБ-ын агуулга, холбогдох үйл ажиллагааны зааварчилгааг ихээхэн хязгаарлагдмал нөхцөл боловсруулсан.

БОНМБ-ын дэлгэрэнгүй мэдээллийг орчны бүсийн зөвлөлийн хурлын үеэр танилцуулах бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад олж авсан санал хүсэлт болон зөвлөмжүүдэд үндэслэн цаашид шинэчлэгдэх болно. Өөрөөр хэлбэл, энэхүү боловсруулсан БОНМБ-ыг цаашид шаардлагатай тохиолдолд төслийн үйл ажиллагаатай уялдуулан сайжруулан шинэчлэх боломжтой баримт бичиг юм.

БОНМБ нь санал хүсэлт, гомдол барагдуулах механизмын журмыг агуулдаг бөгөөд энэ нь цаашид БОНМБ-ын талаарх санал, зөвлөмжийг хүлээн авах боломжийг олгоно. Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн санал, гомдол гаргахыг хүссэн хүн нь дараах хаягаар холбогдож болно. Үүнд,

- Төсөл хэрэгжүүлэгч багийн хуульч, энэхүү хуульч нь мэдээллийг хүлээн авч нууцыг хадгална.
- Холбогдох ТХГН-ийн захиргааны дарга.
- Хамгийн ойрын Сумын Засаг Даргын Тамгын Газар.

1. Төслийн танилцуулга

Монгол Улсын байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь 2008-2017 оны хооронд Монгол орныг дөрвөн чухал томоохон экологийн бүс нутагт хуваан авч экологийн бүс нутгийн үнэлгээ болон биологийн олон янз байдлын чухал газруудын орхигдлын дүн шинжилгээг хийсэн. Улмаар тэргүүлэх ач холбогдлоор нийт 216 газрыг 2030 гэхэд гурван үе шаттайгаар Улсын тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээнд хамруулах шаардлагатай бүс нутаг гэж тодорхойлсон.

Германы Сэргээн Босголт, Зээлийн Банкны санхүүжилтээр БОАЖЯ-аар дамжуулан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I үе шатыг 2015-2021 оны хооронд хэрэгжүүлсэн бөгөөд тус төслийн гол зорилго нь Монгол Улсын ТХГН-ийн тогтолцооны менежментийг бэхжүүлэх, орон нутгийн хүн амын амьжиргааг сайжруулахад чиглэж байсан. “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I үе шатны хүрээнд Монгол Улсын хойд, төв болон зүүн хэсэгт сонгогдсон ТХГН-ууд болон тэдгээрийн хамгаалалтын бүсэд хөрөнгө оруулалт хийсэн.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III-р үе шатны зорилго нь Монгол орны баруун болон баруун өмнөд бүс нутгийн түвшинд буюу газарзүйн томоохон бүс нутгуудын хэмжээнд ТХГН-ийн орчны бүс, тэдгээрийн экологийн холбоос нутгийн менежментийг бэхжүүлэх замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, мөн ТХГН-ийн орчны бүс, тэдгээрийн экологийн холбоос нутаг дах орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилготой юм.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III-р үе шат нь Германы Сэргээн Босголт, Зээлийн Банкны 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн газрын 5.27 сая Еврогийн хамтарсан санхүүжилтээр 2020-2027 оны хооронд хэрэгжинэ. “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I-ээс III-р үе шат хүрээнд өөр хоорондоо уялдаатай хийгдэж байгаа үйл ажиллагаанууд нь үндсэндээ биологийн олон янз байдал болон байгаль хамгаалах чиглэлээр Монгол-Германы хамтын ажиллагааг дэмжиж ажиллах юм.

2016-2020 оны хооронд Монгол Улсын Их Хурал (УИХ)-аар 19 ТХГН-ийг шинээр, мөн одоогийн 10 ТХГН-ийн талбайг өргөтгөн баталснаар ТХГН-ийн нийт хэмжээг 3.09 сая га-аар нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 20.94 хувийг ТХГН эзэлж байна. Тухайлбал, төслийн хүрээнд сонгогдсон 5 ТХГН болох Булган Их Онгогийн байгалийн цогцолборт газар, Говийн Их дархан цаазат газрын Б хэсэг, Ачит нуур-Дэвэлийн Арлын байгалийн цогцолборт газар, Хомын талын байгалийн цогцолборт газар болон Алтан хөхий уулын байгалийн дархан цаазат газар нь дээрх УИХ-аар гаргасан шийдвэрийн хүрээнд өргөтгөгдсөн байна. Ингэснээр Монгол Улсын хэмжээнд ТХГН-ийн тоог 120 болгон нэмэгдүүлж, улмаар нийт 32,738,817,176 га талбайг хамгаалалтад аваад байна.

Эдгээр ТХГН-ийн 21 газрыг Олон улсын байгаль хамгаалах холбоо (ОУБХХ)-ны Ia, Ib & II ангиллын дагуу Дархан цаазат газраар, 37 газрыг ОУБХХ-ны Ib, II & V ангиллын дагуу Байгалийн цогцолборт газраар, 48 газрыг ОУБХХ-ны IV ангиллын дагуу Байгалийн нөөц газраар, 14 газрыг ОУБХХ-ны III ангиллын дагуу Байгалийн дурсгалт газраар тус тус бүртгэсэн. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт багтсан ТХГН-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-д үзүүлэв.



Зураг 1. Эрсдэлийн удирдлага ба эрсдэлийг бууруулах шатлал

Энэхүү байгаль орчин нийгмийн менежментийн бодлого (БОНМБ) нь эрсдэл, нөлөөллийг урьдчилан таамаглах, үнэлэх зарчим, зааварчилгаа болон холбогдох журмыг тодорхойлох замаар төслийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдэл, мөн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхэд баримтлах баримт бичиг юм. Нөгөө талаас БОНМБ нь байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт учирч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг эрсдэлийн менежмент болон Зураг 1-т үзүүлсэн нөлөөллийг бууруулах үе шатын дагуу хийж төслийн эерэг үр дүнг тодорхойлох, мөн тэдгээрийг сайжруулахад зорилготой.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хэрэгжилтийн үе шатанд нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орон нутгийн иргэд, мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэл дунд зэрэг, өөрөөр хэлбэл төслийн нөлөөллийн цар хүрээ (тухайлбал, нөлөөллийн эрчимшил, орон зай, хугацаа болон давтамж) нь ихээхэн хязгаарлагдмал, нөгөө талаас нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн боломжтой байхаас гадна нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь богино тул Германы Сэргээн Босголт, Зээлийн Банкны төслийн тогтвортой байдлын удирдамжийн дагуу В ангилалд хамаарагдаж байна.

1.1 Төслийн ерөнхий танилцуулга


“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шатны төлөвлөлт, мөн загвар нь “Биологи уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I үе шатны хэрэгжилтийн үр дүн, түүний үйл ажиллагаанаас хуримтлуулсан туршлага зэрэгт үндэслэн гарсан болно.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шатны зорилго нь ТХГН-н болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг нэгтгэх, мөн Монгол Улсын баруун болон болон баруун өмнөд хэсэгт орших

таван аймгийн газар нутгийг ландшафтын түвшинд хамгаалах чиглэлийн байгаль хамгааллын шинэ загварыг санхүүжүүлэхэд чиглэнэ.

Энэхүү ландшафтын түвшинд суурилсан арга нь ТХГН-ийн экологийн нийлмэл байдал, экологийн коридор нутаг, мөн тухайн ТХГН, түүний экологийн коридор нутгийн амьдрах орчин, биологийн төрөл зүйлийн хамгааллыг дэмжих, мөн үүний зэрэгцээ орон нутгийн иргэдийн амьдралын хэв маяг, тогтвортой амьжиргааг дэмжихэд чиглэдэг.

Орчны бүсийн менежмент нь орчны бүсийн менежментийн зөвлөл, түүний бүтцийг байгуулж улмаар ТХГН-ын менежментийн төлөвлөгөөг 10 жилээр боловсруулах чиглэдэг.



Зураг 2. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг

Төсөл хэрэгжиж буй бүс нутгийг сонгохдоо ландшафтын холбоос нутаг, байгаль орчин, засаглал болон нийгэм эдийн засгийн чадавх зэргийг харгалзан үзэж өндөр ач холбогдол бүхий байдлаар нь буюу онооны систем (их оноо)-ээр үнэлж газруудыг сонгосон. Дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн болно. Үүнд,

- Загвар төлөвлөгөө боловсруулахад сумдын тоог харгалзах (цөөн сумд өндөр оноо авсан)
- Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулах нь” төсөлтэй хамтран ажиллах Ховд аймгийн хамрагдсан байдал.
- Сонгосон газруудын холбоос нутгийн боломжит байдал.
- Төсөлд хамрагдах боломжит сумдын Засаг дарга нарын сонирхол
- Орчны бүсийн менежментийн зөвлөлийн оролцоо, тэдгээрийн санаачилгыг үнэлсэн байдал.

- Төслийн загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжит байдал

Зураг 2-т төсөл хэрэгжих газар нутгийн ерөнхий тойм зургийг, мөн Хүснэгт 1-т төсөлд хамаарагдах ТХГН-ууд, тэдгээрийн байрлах аймгуудын мэдээллийг оруулав. Эдгээр 7 дархан цаазат газар, арван хоёр байгалийн цогцолборт газар, таван байгалийн нөөц газар, хоёр байгалийн дурсгалт газар багтаж байна. Үүнээс таван ТХГН нь сүүлд шинээр газрын нутгийн хэмжээг өргөтгөсөн ТХГН бөгөөд Хүснэгт 1-т тодруулж өгсөн болно.

Хүснэгт 1. Төсөлд хамрагдсан аймаг болон ТХГН-ийн байршил

ТХГН	Тогтоол, он	Хэмжээ
Аймаг, ТХГН: Увс/Баян-Өлгий аймаг¹		
Түргэн уулын дархан цаазат газар	УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоол	119,973.00
	УИХ-ын 2008 оны 05 дугаар тогтоол	130,473.00
Цагаан шувуутын дархан цаазат газар	УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоол	20,504.00
	УИХ-ын 2008 оны 05 дугаар тогтоол	33,304.00
Сийлхэмийн нурууны Байгалийн цогцолборт газар "А" хэсэг	УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоол	147,875.31
Сийлхэмийн нурууны Байгалийн цогцолборт газар "Б" хэсэг		
ТХГН тойрсон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн коридор нутгууд		
Аймаг, ТХГН: Ховд/Баян-Өлгий аймаг²		
Мөнххайрханы Байгалын цогцолборт газар	УИХ-ын 2006 оны 26 дугаар тогтоол	506,094.61
Мянган Угалзатын нурууны Байгалын цогцолборт газар	УИХ-ын 2002 оны 39 дүгээр тогтоол	303,774.59
Мянган Угалзат нуруу (БЦГ)	УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол	167,189.11
Булган гол - Их Онгогийн Байгалийн цогцолборт газар	УИХ-ын 2011 оны 18 дугаар тогтоол	92,743.00
	УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоол	246,081.90
Хөх сэрхийн нурууны дархан цаазат газар	УИХ-ын 1977 оны 76 дугаар тогтоол, УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоол	69,720
ТХГН тойрсон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн коридор нутгууд		
Аймаг, ТХГН: Увс аймаг³		
Увс нуурын дархан цаазат газар	УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоол	441,223.00
Хан Хөхийн нурууны байгалийн нөөц газар	УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоол	221,598.00
Хяргас нуурын байгалийн цогцолборт газар	УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоол	341,302.00
Алтан Элсний дархан цаазат газар	УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоол	150,244.00
Тэс голын сав газрын байгалийн нөөц газар	УИХ-ын 2006 оны 26 дугаар тогтоол	103,704.00
Булганхангай уулын байгалийн нөөц газар	УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол	11,407.31
Мөнгөт цахир байгалийн дурсгалт газар	УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол	630.78
Ачит нуур-Дэвэлийн арал байгалийн цогцолборт газар	УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоол	10,618.00
	УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол	210,234.00
ТХГН тойрсон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн коридор нутгууд		
Аймаг, ТХГН: Увс/Ховд/Баян-Өлгий/Завхан аймаг⁴		
Хар ус нуурын байгалийн цогцолборт газар	УИХ-ын 1997 оны 47 дугаар тогтоол	852,995.33
Цамбагарав уулын байгалийн цогцолборт газар	УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоол	113,748.43
	УИХ-ын 2010 оны 6 дугаар тогтоол	90,734.62

1 Кластер 1, Увс аймагт багтсан сумд: Бөхмөрөн, Сагил, Түргэн, Тариалан, Ховд, Баян-Өлгий аймгийн хувьд: Ногоон нуур, Улаанхус сумдад

2 Кластер 2Ховд аймаг, Үүнд: Алтай, Булган, Дуут, Мөст, Мөнххайрхан, Ховд, Цэцэг, Үенч сумд багтана. Баян-Өлгий аймгийн хувьд: Булган, Дэлүүн сум.

3 Кластер 3, Увс аймаг, Ховд, Бөхмөрөн, Баруунтуруун, Давст, Хяргас, Наранбулаг, Малчин, Тэс, Улаангом, Өндөрхангай, Завхан, Зүүнговь, Зүүнхангай зэрэг сумдад багтана. Баян-Өлгий аймгийн хувьд: Ногоон нуур сумдад.

4 Кластер , Увс аймаг, дараах сумд багтана: Өмнөговь сум. Ховд аймгийн хувьд: Буянт, Чандмань, Дөргөн, Дарви, Эрдэнэбүрэн, Ховд, Жаргалант, Манхан, Мянгад, Зэрэг сум. Баян-Өлгий аймгийн хувьд: Алтанцэгц, Баяннуур сум. Завхан аймгийн хувьд: Дөрвөлжин сум.

ТХГН	Тогтоол, он	Хэмжээ
Алтан хөхий уулын байгалийн нөөц газар	УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол	99,611.06
Манхан талын байгалийн нөөц газар	УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоол	82,807.12
Хомын талын байгалийн цогцолборт газар	УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол	411,403.82
ТХГН тойрсон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн коридор нутгууд		
Аймаг, ТХГН: Баянхонгор/Говь-Алтай/Ховд аймаг ⁵		
Их говь Дархан Цаазат Газар "Б" хэсэг	Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны 84-р зарлиг	927,112.00
	УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоол	1,835,725
Их говь Дархан Цаазат Газар "А" хэсэг	Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны 84-р зарлиг	4,633,299.77
Алаг хайрхан уулын үндэсний нөөц газар	УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоол	36,723.14
Ээж хайрхан уулын байгалийн дурсгалт газар	УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоол	23,095.96
ТХГН тойрсон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, эко коридор		

Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газруудын удирдлага, санхүүжилт нь тухайн орон нутгийн засаг захиргаанд харьяалагддаг ба орон нутгийн засаг захиргаа нь төрөөс татаас авдаг. Тухайн орон нутгийн Засаг даргын санаачилгаар өөрийн нутаг дэвсгэрийнхээ зарим хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг (ОНТХГН) болгох санал гаргах эрхтэй. ОНТХГН нь ОУБХХ-ны VI зэрэглэл буюу байгалийн нөөцийг зохистой ашиглах шаардлага бүхий тусгай хамгаалалттай газар нутагтай дүйцэх бөгөөд улсын ТХГН-аас ялгаатай нь тэдгээрийн менежмент, хамгаалалтын хугацаа, дэглэмийг тухайн орон нутгийн ИТХ-аар тогтоодог.

2019 оны хоёрдугаар сарын байдлаар орон нутгийн засаг захиргаанаас 24.02 сая га газрыг хамарсан 1118 газрыг байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газрын статустайгаар ОНТХГН-аар албан ёсоор бүртгэжээ. Улмаар, Хүснэгт 2-т үзүүлснээр ОНТХГН нь Монгол Улсын ТХГН-ийн сүлжээний нийт нутаг дэвсгэрийн 15.36 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Он	Газар нутгийн тоо	Талбайн хэмжээ (га)	Нийт ТХГН-т эзлэх хувь	Эх сурвалж
2008	911	16,000,000.0	10.3	Дэлхийн байгаль хамгаалах сангийн Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
2016	1,108	18,837,459.8	12.04	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017
2019	1,118	24,025,601.2	15.36	Ашигт малтмал газрын тосны газар https://cmcs.mrpam.gov.mn/cmcs

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шатны хүрээнд баруун бүсийн зургаан аймагт нийт 7,454,980 га талбай бүхий 207 ОНТХГН хамрагдаж байна.

⁵ Кластер 5 Баянхонгор аймаг, дараах сумд багтана: Баян-Өндөр, Шинэжинст сум. Ховд аймгийн хувьд: Алтай, Булган, Уенч сум. Говь-Алтай аймгийн хувьд: Алтай, Бугат, Эрдэнэ, Тонхил, Цогт сум.

Хүснэгт 3. Баруун бүсийн зургаан аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар

Аймаг	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг		
	Тоо	Нийт талбайн хувь	Газар нутгийн хэмжээ
Баян-Өлгий	24	10.1	46,705
Баянхонгор	21	1.5	174,880
Говь-Алтай	132	24.1	3,217,249
Увс	41	22.5	1,566,120
Ховд	21	9.5	725,765
Завхан	84	20.9	1,724,260
Нийт	323	14.8 (Дундаж)	7,454,980

1.2 Төслийн бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шат нь дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах. Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Монгол улсын баруун хэсэгт байрлах ТХГН-ийн хамгаалалтын асуудал, орчны бүс болон кластеруудыг хамгаалалтын төлөвлөлтийн институтийн тогтолцоог бий болгох ажлыг санхүүжүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн засаг захиргаа, ТХГН-ийн захиргаа болон орон нутгийн бусад оролцогч талуудыг оролцуулсан кластертийн зөвлөлийг байгуулах, мөн кластерийн хүрээнд ТХГН-ийн менежментийг төлөвлөх, оффис, ажилтнууд, байгаль хамгаалагчид шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах, үүнд компьютер, тавилга, дүрэмт хувцас гэх мэт) зэрэг ажлуудыг хийнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжиж, хийгдэх үйл ажиллагаа нь Монгол Улсын ТХГН-ийн сүлжээ, түүний тогтолцоонд үр өгөөжтэй байх тул цаашид улс орны хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой юм.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Орчны бүс нутгийн бизнес төлөвлөгөөнүүд болон менежментийг хэрэгжүүлэх. Энэ бүрэлдэхүүн хэсэгт цаашид батлагдах менежментийн төлөвлөгөөний дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд,

- а) Орчны бүс нутгуудад байгаль хамгаалах (байгалийн нөөцийн менежмент), дасан зохицох, амьжиргааг сайжруулах үйл ажиллагааг (жишээ нь, бэлчээрийн менежментийн хөрөнгө оруулалт, усны нөөцийн менежмент, бичил хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон эдийн засгийн хөгжлийн үйл ажиллагаа гэх мэт) дэмжих;
- б) ТХГН-ийн дэд бүтэц болон менежментийг сайжруулахад (жишээ нь жуулчдын мэдээллийн төв, аялал жуулчлалын дэд бүтэц, байгаль хамгаалагчийн байр гэх мэт) хөрөнгө оруулах;
- в) биологийн олон янз байдлын мониторинг хийх, байгаль орчны боловсролыг дэмжих.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Долоо хүртэлх бие даасан ТХГН-ийн бизнес болон менежментийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх. Үндэсний хэмжээнд чухал ач холбогдолтой төдийгүй жишиг болохуйц төслийн үр дүнг харуулах (жишээ нь, тогтвортой аялал жуулчлал, тогтвортой санхүүжилт гэх мэт) зорилгоор хөрөнгө оруулалт хийх боломжид үндэслэн бие даасан долоон тусгай хамгаалалттай газар нутгийг сонгосон. Эдгээр сонгосон ТХГН тус бүрд ТХГН, түүний орчны бүсийн менежментийн төлөвлөгөө,

тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай дэд төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, амьжиргааг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 4: ТХГН-ийн сүлжээний чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээ авах. Энэ бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд үндэсний стандартыг тогтоох, сайжруулах (жишээ нь, тэмдэг тэмдэглэгээ, ТХГН-ийн байгууламжийн стандартууд), техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн судалгаанууд, ТХГН-ийн санхүүжилт болон байгууллагын тогтолцоонд зарим арга хэмжээг туршиж үзэх (жишээлбэл, байгалийн нөөц ашигласны төлбөр, тээврийн хэрэгсэл нэвтрэх хураамж, ТХГН-ийн орлого бүрдүүлэх механизм болон менежментийн үйл ажиллагаа), мөн ТХГН дах олон нийт, оролцог талуудын чадавхыг бэхжүүлэх, кластерийн тогтолцоо, олон нийтийн сүлжээ, стратеги боловсруулах зэрэг ажлууд багтана.

Төслийн гол зорилтот бүлэг нь кластер нутгийн хөдөөгийн хүн ам, ялангуяа төслийн хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх олон нийт билээ. Хөдөө орон нутгийн иргэд төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох, мөн байгалийн нөөцийн зөв ашиглалт болон ТХГН-ийн сүлжээнд хийгдэх үйл ажиллагааны хүрээнд гарах ажлын байр, мөн хөгжиж буй аялал жуулчлалын салбар зэргээс шууд ашиг хүртэх болно.

Төслийн үйл ажиллагааны санхүүжилтийг төслийн хэрэгжилтийн зөвлөх баг (ТХЗБ) болон төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) дараах тэргүүлэх чиглэлийн дагуу хянан шалгана. Төслийн эцсийн санхүүжилтийн хуваарилалтыг **Өргөтгөсөн удирдах зөвлөлөөр** батална.

- ТХГН-ийн хүрээнд хийгдэх төслийн хөрөнгө оруулалтыг ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэн кластер менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах.
- Кластер нутгууд дах төслийн хөрөнгө оруулалтыг төслийн зорилгуудтай уялдуулан кластерийн менежментийн төлөвлөгөөний тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн байдалд үндэслэх.
- Ой, бэлчээрийн менежментийн жишиг туршилтын ажлыг ой, бэлчээрийн тогтвортой менежментийн суурь судалгаанд үндэслэх.
- Амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн хязгаарлагч хүчин зүйлс байгаа тохиолдолд амьжиргааг сайжруулах үйл ажиллагаанд шаардагдах төслийн хөрөнгө оруулалт нь холбогдох нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон нийгэм эдийн засгийн суурь судалгаанд үндэслэн тодорхойлох.

Хүснэгт 4-т эхний хоёр жилд хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэлийн тоймыг үзүүлэв.

Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаа, 2020-2021

Бүрэлдэхүүн 1: ТХГН-ын менежментийн төлөвлөгөө	
2020	<ul style="list-style-type: none"> • Суурь судалгааны ажлын даалгавар (менежментийн үр дүнтэй байдал (МЕТТ), бэлчээр, ой, нийгэм-эдийн засаг, биологийн олон янз байдал) • Бэлтгэл ба төлөвлөлтийн үе • Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөний үзэл баримтлалыг боловсруулах
2021	<ul style="list-style-type: none"> • Менежментийн үр дүнтэй байдлын суурь судалгаа (23 ТХГН) • Бэлчээрийн тогтвортой менежментийн суурь судалгаа (гурван аймаг, арван сум) • Ойн тогтвортой менежментийн суурь судалгаа (гурван аймаг, найман сум) • Биологийн олон янз байдлын суурь судалгаа (таван кластер нутаг, сонгосон сумд) • Нийгэм, эдийн засгийн суурь судалгаа (таван аймаг, арван найман сум) • Кластер менежментийн төлөвлөгөө боловсруулах • ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх/боловсруулах • Байгаль хамгаалагчдыг улирлын дүрэмт хувцсаар хангах

	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны мэргэжлийн болон бусад ТХГН-ийн захиргааны байгууллагуудад үндсэн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Баруун бүсийн төвийн барилга⁶, ТХГН-ийн захиргааны барилга байгууламжийн концепц, ТЭЗҮ, геологи, геодези судалгаа Баруун бүсийн төвийн барилга⁷, ТХГН-ийн захиргааны барилга байгууламжийн зураг төсөл, зардлын тооцоо
Бүрэлдэхүүн 2: Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээ, дасан зохицох үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх	
2020	<ul style="list-style-type: none"> Бэлчээрийн байгалийн нөөц, даац болон төрлийн зураглал
2021	<ul style="list-style-type: none"> Баруун бүсийн төвийн барилга, ТХГН-ийн захиргааны барилга байгууламжийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) Туулах чадвар өндөр тээврийн хэрэгсэл худалдан авах (байгаль орчны байгууллагууд) Их говийн Б ТХГН-ийн захиргааны барилгын худалдан авах ажлыг эхлүүлнэ
Бүрэлдэхүүн 3: Бие даасан тусгай хамгаалалттай газар нутгийг дэмжих	
2020	<ul style="list-style-type: none"> Долоо хүртэлх бие даасан ТХГН-ийг сонгон авах ажлыг эхлүүлэх
2021	<ul style="list-style-type: none"> Долоо хүртэлх бие даасан ТХГН-ийн сонгон авах ажлыг эцэслэх Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах (долоон ТХГН) Сонгогдсон ТХГН-ийн суурь судалгааг хийх
Бүрэлдэхүүн 4: Байгаль хамгаалах, бодлогын яриа хэлэлцээ хийхэд салбарын хэмжээнд чадавхыг бэхжүүлэх	
2020	<ul style="list-style-type: none"> Сургалт, семинар, хурал, нээлттэй хаалганы өдөр/байгаль хамгаалах өдрүүд зохион байгуулах Худалдан авах ажиллагааны заавар, санхүүгийн зохицуулалт
2021	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөлийн хурал Сэдэвчилсэн семинар Сургалт, семинар, хурал, нээлттэй хаалганы өдөр/байгаль хамгаалах өдрүүд

1.3 Төслийн зохион байгуулалт, үйл ажиллагааны зохицуулалт

БОАЖЯ нь Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газар (БОАЖГ), ТХГН-ийн захиргаа, аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний газар (УЦУОШГ), Сав газрын захиргаа (СГЗ), болон Сум дундын ойн анги (СДОА) зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжүүлэгч агентлагийн үүрэгтэй ажиллаж байна.

Төслийн үйл ажиллагааг “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I болон II/III үе шатны төслийн үндэсний захирал, БОАЖЯ-ны ТХГН-ийн удирдлагын газрын дарга, Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, мөн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга, Германы сэргээн босголт, зээлийн банкны Монгол дах захирал, төслийн хэрэгжилтийн зөвлөх багийн техникийн ахлах зөвлөх, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн газрын дарга, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн биологийн тэнхимийн профессор Болдгив нараас бүрдсэн БОАЖЯ-ны удирдлага доорх Өргөтгөсөн удирдах зөвлөл нь удирдан чиглүүлдэг.

Өргөтгөсөн удирдах зөвлөл нь төслийн хүлээгдэж буй үр дүнгийн хэрэгжилтийг хянах, төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих, мөн хүлээн авсан төслийн саналыг цаг тухай бүрд нь шийдвэрлэх үүрэгтэй. Өргөтгөсөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаа болон худалдан авалтын төлөвлөгөө, мөн бусад холбогдох тайланг төсөл

⁶ БОАЖЯ-ны А/79 (2020) тогтоолын дагуу Баруун бүсийн төвийн байршлыг Ховд аймгийн төв буюу Жаргалант сумын төвд байхаар тогтсон.

⁷ БОАЖЯ-ны А/79 (2020) тогтоолын дагуу Баруун бүсийн төвийн байршлыг Ховд аймгийн төв буюу Жаргалант сумын төвд байхаар тогтсон.

хэрэгжүүлэгч агентлаг болон Германы сэргээн босголт, зээлийн банк руу илгээхээс өмнө хянаж батална.


Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа болон менежментийг төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч хянадаг. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь санхүүгийн ажилтан, хоёр худалдан авах ажиллагааны ажилтан, хяналт шинжилгээ болон үнэлгээ хариуцсан ажилтан, захиргааны ажилтан, байгаль орчин, нийгмийн менежментийн мэргэжилтэн, мөн Ховд, Увс аймаг дахь ТХГН-ийн захиргаанд харилцах, хяналт шинжилгээг хариуцсан хоёр мэргэжилтэн, хуулийн ажилтан, хоёр жолооч гэсэн бие бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Ховд болон Увс аймаг дахь орон нутгийн мэргэжилтэн нь Орчны бүсийн менежментийн зөвлөлийн гишүүний үүрэг гүйцэтгэхээс гадна Орчгы бүс нутгийн бүх оролцогч талуудыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлж, харилцан холбоотой ажиллана.

Нөгөө талаас төслийн ерөнхий менежментийн үйл ажиллагааг техникийн ахлах зөвлөхөөр ахлуулсан байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын зөвлөх, ОБЗ, ТХГН-ийн менежментийн зохицуулагч, орчуулагч болон захиргааны ажилтан, жолооч нарын бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хот дахь төслийн хэрэгжилтийн зөвлөх баг дэмжиж ажилладаг.

Төслийн хэрэгжилтийн зөвлөх баг бүрэлдэхүүнд Ховд аймагт байрлах техникийн зөвлөх, ТХГН болон хөдөөгийн хөгжлийн мэргэжилтэн, орчуулагч болон захиргааны ажилтан, мөн жолооч бүхий орон нутгийн баг хамаарагдана. Төслийн хэрэгжилтийн зөвлөх баг нь төслийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, зааварчилгааг боловсруулах, мөн оролцогч талуудыг чадавхжуулах арга хэмжээг дэмжих үүрэг бүхий техникийн зөвлөхүүд болон олон улсын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын зөвлөх нарын үйл ажиллагааг давхар хянадаг.

ТХГН дахь орчны бүсийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан төслийн хөрөнгө оруулалт хийгдэх боловч төслийн үндсэн зорилго болон ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн менежментийн үйл ажиллагаа болон ТХГН-ийн захиргааны хооронд шууд зохицуулагдана.



Зураг 3. Төслийн удирдлага ба боловсон хүчин

Төсөл хэрэгжиж буй бүс нутагт төслийн хөрөнгө оруулалтыг 10-жилийн Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөөг хөгжүүлэх замаар орчны бүсийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч талууд буюу аймаг, сум, ТХГН-уудийн захиргааны оролцоог хангах, мөн нягт хамтран ажиллахыг үүрэг болгосон санамж бичгийн дагуу орчны бүсийн зөвлөл болон төсөл хэрэгжүүлэх нэгж, мөн төслийн хэрэгжилтийн зөвлөл багийн үйл ажиллагаагаар дамжуулан зохион байгуулна.

Орчны бүсийн зөвлөл нь байгалийн нөөцийн менежментийн үйл ажиллагаанд орон нутгийн оролцогч талуудыг татан оролцуулах зорилгоор өмнө нь байгуулагдсан Орчны бүсийн зөвлөл⁸-ийн бүтцэд тулгуурлан байгуулагдана.

Орчны бүсийн зөвлөл нь төслийн үйл ажиллагааны хүрээнд ландшафтын түвшний аргачлал талаар тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдийг тодорхойлох, мөн байгалийн нөөцийг хамгаалах тулгамдсан асуудлуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэн ажиллана. Орчны бүсийн зөвлөлийн оролцогч талууд нь дараах байгууллагаас төлөөлөлийг орцуулсан байна. Үүнд,

- Тавин сумын засаг дарга болон ИТХ-н дарга
- Таван аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Арван ТХГН-ийн захиргааны дарга
- Увс, Ховд болон Баян-Өлгий гэсэн гурван аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Гурван сав газрын захиргааны дарга
- Арван нэгэн орон нутгийн иргэдийн нөхөрлөл болон төрийн бус байгууллага (ТББ)-ын төлөөлөл
- Ховд их сургууль (хоёр)

1.4 Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын зорилго, арга зүй

Германы сэргээн босголт, зээлийн банкны байгаль хамгаалах салбарт хэрэгжүүлж буй эсвэл дэмжиж буй төслүүд нь ерөнхийдөө байгалийн нөөцийн засаглалыг сайжруулах болон хүний эрхийг дээдлэх замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, мөн хамгааллын арга хэмжээ, нөхөн сэргээх болон экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Гэсэн хэдий ч, эерэг нөлөөллийг гаргахыг зорьж байгаа ч эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед байгаль орчин, орон нутгийн иргэдэд мэдэгдэхүйц нөлөөллийг үзүүлэх болно.

Байгалийн нөөцийн менежмент, байгаль хамгаалах чиглэлийн эдгээр төслүүдэд баримтлах стандартын шаардлагыг холбогдох олон талт төслийн бичиг баримтуудад, тухайлбал байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого (БОНМБ)-оор дамжуулан хэрэгжүүлдэг. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүрээнд уугуул иргэд байхгүй тул уугуул иргэдийн төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй.

Төслийн бэлтгэл ажлын эхний үе шат, нөгөө талаас төслийн бүрэлдэхүүн хэсэг, мөн үйл ажиллагааны талаарх зарим мэдээлэл нь одоогийн байдлаар тодорхойгүй байгаа тул БОНМБ нь төслийн менежментийн холбогдох баримт бичгийг шаталсан аргачлалд тулгуулан боловсруулахад чиглүүлнэ.

⁸Орчны бүсийн зөвлөлүүд нь Төслийн бүс нутаг болох 14 ТХГН-т 50 сумын оролцоотойгоор байгуулагдсан байдаг ч нөөц бололцоо муутай, оролцоо нь тогтмол бус байхаас гадна 50-аас ердөө 9 нь ерөнхий менежментийн төлөвлөгөө боловсруулж байна.

БОНМБ нь Германы сэргээн босголт, зээлийн банкны Тогтвортой байдлын удирдамж, ялангуяа Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 1 (Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба менежмент)-ийн зорилго, шаардлагын хүрээнд төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эрсдэл болон болзошгүй нөлөөллийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх бодлогын баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 1 (Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба менежмент)-ийн зорилго, шаардлагын дагуу, төслийн үйл ажиллагааны эхэн үед байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлох шаардлагатай байдаг.

БОНМБ нь болзошгүй сөрөг нөлөөллийг үр дүнтэй бууруулах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтэн, мөн холбогдох шийдвэр гаргагчид, орон нутгийн иргэд, гэрээт компаниуд зэрэг төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох бүх оролцогч талуудад зааварчлах, мөн байгаль орчин, нийгмийн менежментийг төслийн хүрээнд санхүүжүүлэх болон дэмжих үйл ажиллагааны хөрөнгө оруулалттай уялдуулах зорилготой. Оролцогч талуудын оролцоо, чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү БОНМБ-д тусгасан болно

БОНМБ нь үндсэн бүлэг болон хавсралтаас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, төслийн холбогдох мэдээлэл, нөхцөл болон хууль эрхзүйн шаардлагыг 2 болон 3 дугаар бүлэгт оруулсан бол 4 дүгээр бүлэгт төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй гол эрсдэл, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тусгасан болно. Харин БОНМБ-ын 4, 5, 6 болон 7 дугаар бүлэгт оролцогч талуудын оролцоог хангах, хөдөлмөрийн менежмент болон холбогдох төслийн гүйцэтгэгч нарт тавигдах стандарт, шаардлагуудыг оруулсан болно. БОНМБ-ын 8 дугаар бүлэгт дараагийн шатны үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд эрсдэлийг тодорхойлох механизм, мөн үйл ажиллагааны хүрээнд нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, зайлсхийх, улмаар тодорхойлогдсон байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэргийг төлөвлөх явцад ашиглах арга зүйг тусгасан.

Нөгөө талаас, БОНМБ-ын 9, 10 болон 11 дүгээр бүлэгт байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохицуулалт, захиргаа болон санхүүгийн хариуцлага, мөн хэрэгжилтийн төсөв, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх болон тайлагнах талаар тусгасан.

БОНМБ-ын хавсралтад үйл ажиллагааг хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг оруулсан болно. Үүнд, Эрсдэл багатай үйл ажиллагаанд зориулсан байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНУАД), мөн дунд эрсдэлтэй үйл ажиллагаанд зориулсан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-ний холбогдох мэдээллийг оруулсан. Энэхүү хавсралтууд нь Германы сэргээн босголт, зээлийн банкны худалдан авах ажиллагааны журамтай уялдуулах замаар Германы сэргээн босголт, зээлийн банкны бага хэмжээний барилгын ажилд зориулсан удирдамжид үндэслэн боловсруулсан.

Эрсдэл ихтэй үйл ажиллагааг авч хэлэлцэхээс татгалзах, эсвэл Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) зэрэг нэмэлт мэргэжлийн зөвлөх үйлчилгээний ажлыг шаарддаг. Хэрвээ төслийн үйл ажиллагаа нь иргэдийн амьжиргаанд нөлөөлж байвал нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ННУ)-г боловсруулж, улмаар олон нийтийн оролцооны төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

Энэхүү БОНМБ нь суурин судалгаа болон “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I үе шатны үйл ажиллагааны хүрээнд

хуримтлуулсан туршлагад үндэслэн боловсруулагдсан. Өөрөөр хэлбэл, дараах бичиг баримтуудыг судалж, дүн шинжилгээг хийсэн болно. Үүнд,

- 2017 онд ТЭЗҮ-ийн хүрээнд боловсруулсан Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого.
- Монгол Улсын хууль эрх зүйн орчин.
- 2020 онд хийгдсэн “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I болон II үе шатны эхлэлийн тайлан.
- 2020 болон 2021 оны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I болон II үе шатны жил бүрийн болон улирал тутмын гүйцэтгэлийн тайлан.
- 2019 онд боловсруулсан Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн менежментийн төлөвлөгөө

Ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээр, хязгаарлалтын улмаас энэхүү БОНМБ-ыг төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн хэрэгжилтийн зөвлөх багийн байгаль орчин, нийгмийн болон техникийн мэргэжилтэн нарын хоорондын нягт хамтын ажиллагааны үндсэн дээр боловсруулсан болно.

Энэхүү БОНМБ-ын баримт бичгийг БОАЖЯ-ны Байгаль орчин, үнэлгээ аудитын хэлтэс (БОУАХ)-ийн дарга нь дараа дараагийн шатанд хянан үзэх боломжтой. Төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэхийн тулд энэхүү БОНМБ-ыг Орчны бүсийн менежментийн зөвлөлийн үйл ажиллагааны эхлэлийн хүрээнд төсөл хэрэгжиж буй бүс нутгуудад танилцуулж хэрэгжүүлнэ.

БОНМБ-ын баримт бичгийг цаашид төслийн үйл явцтай уялдуулах зорилгоор төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн хэрэгжилтийн зөвлөх багтай хамтарч тухай бүрд нь шинэчилж байх ёстой. Төслийн бүс нутагт, мөн төслийн нөлөөлөлд өртөх иргэд (ТНӨИ)-тэй хийх зорилтот уулзалтын үеэр уг бодлогын баримт бичгийг олон нийтэд албан ёсны танилцуулгын хийж нээлттэй болгоно.

2. Хууль эрх зүйн шаардлага

Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж, Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нь төслийн бүхий л үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг үнэлж, улмаар тодорхойлогдсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлыг тодорхойлж хэрэгжүүлэх шаардлагатай. Германы сэргээн босголт, зээлийн банкны удирдамж, Монгол улсын хууль тогтоомж, эрхзүйн шаардлагууд өөр байгаа эсвэл зөрчилдөж байгаа тохиолдолд төслийн баг аль өндөр түвшний стандартыг мөрдөж ажиллана. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг хууль тогтоомжийн шаардлагын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, улмаар Германы сэргээн босголт, зээлийн банк руу батлуулахаар хүргүүлнэ.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартын орхигдлын дүн шинжилгээг хавсралт 14-т оруулсан.

Төслийн хүрээнд төлөвлөсөн ихэнх үйл ажиллагаа нь Германы сэргээн босголт, зээлийн банкны эрсдэлийн ангиллын С эсвэл В ангилалд хамаарах бөгөөд эдгээр үйл ажиллагаанд тавигдах шаардлага нь Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой байгаа хэдий ч Германы сэргээн босголт, зээлийн банкны шаардлагын дагуу Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандартуудыг дагаж мөрдөх шаардлагатай юм.

БОНМБ-ын дагуу хийгдсэн төсөл хэрэгжих талбайн үнэлгээгээр цаашид илүү нарийвчилсан үнэлгээ шаардагдах өндөр түвшний нөлөөллийн эрсдэлийг тодорхойлох болно. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгмийн нөлөөллийн эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, үнэлэх аргачлалын тойм мэдээллийг Хүснэгт 5-д үзүүлэв. А ангилалд хамаарагдах аливаа үйл ажиллагааг төслөөс санхүүжүүлэхгүй, гэхдээ уялдуулсан хандлагыг тодорхойлсон.

Төслийн байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний ангиллыг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5. Үндэсний болон Германы сэргээн босголтын зээлийн банкны эрсдэлийн стандартын ангиллын жагсаалт

	Хяналт шалгалт	Тодорхойлолт	Тайлбар
Ангилал С	Нэмэлт үнэлгээ хийх шаардлагагүй	Орон нутгийн иргэд болон байгаль орчинд богино болон урт хугацаанд үзүүлэх нөлөөллийн эрсдэл нь бага	Орон нутгийн иргэд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үр дагавар нь маш бага эсвэл байхгүй. Хэрэгжилт болон үйл ажиллагааны үед ямар нэгэн тусгай хамгааллын арга хэмжээ, нөхөн төлбөр, хяналт-шинжилгээ шаардлагагүй. Үйл ажиллагаанд дараах хэлбэрүүд багтана. Үүнд, Нөлөөллийн үр дагавар байхгүй үйл ажиллагаа (жишээлбэл, бараа худалдан авах, сургалт болон бусад арга хэмжээ) Үйл ажиллагааны энгийн журамтай байх ба энэхүү журам нь ажилчид болон орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал (ХЭААБ)-ын эрсдэлийг бага түвшинд байлгахад чиглэсэн байна.
Ангилал В	Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмэлт үнэлгээнээс	Нөлөөлөл нь богино хугацаанд үргэлжлэх боловч орон нутгийн иргэд	Орон нутгийн иргэд, мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэл дунд зэрэг, өөрөөр хэлбэл төслийн нөлөөллийн цар хүрээ (тухайлбал, нөлөөллийн эрчимшил, орон зай, хугацаа болон давтамж) нь ихээхэн хязгаарлагдмал, нөгөө талаас

	Хяналт шалгалт	Тодорхойлолт	Тайлбар
	хийх шаардлагагүй. Германы сэргээн босголт, зээлийн банкны шаардлагын дагуу төсөл хэрэгжих талбайн хэмжээнд тусгайлсан нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг боловсруулах	болон байгаль орчинд учруулах эрсдэл нь хязгаарлагдмал байна	<p>нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн боломжтой.</p> <p>Бага (-B) ангиллын эрсдэл багатай үйл ажиллагаанд зориулсан байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНУАД)-д тусгасан үйл ажиллагааны шаардлагууд, мөн төсөл хэрэгжих талбайн хэмжээнд тусгайлсан нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон боловсруулах шаардлагатай. Харин их (-B) ангиллын эрсдэлтэй төслийн хувьд байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-г боловсруулж хэрэгжилтийг хангах шаардлагатай.</p> <p>Бага (-B) ангиллын эрсдэл багатай үйл ажиллагааны хувьд:</p> <p>Орон нутгийн иргэд, мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл үүсэх магадлал бага бөгөөд бага хэмжээний нөхөн сэргээлт хийх.</p> <p>Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орон нутгийн иргэд үзэл бодлоо илэрхийлэх, санал хүсэлтээ гаргах, үр өгөөжийг тэгш хүртэх боломжоор хангах.</p> <p>Бага хэмжээний дэд бүтцийн үйл ажиллагаанд цөөн тооны ажилчид шаардлагатай</p> <p>Их (-B) ангиллын эрсдэлтэй үйл ажиллагааны хувьд: Дунд зэргийн хэмжээний өөрөөр хэлбэл нарийн төвөгтэй үйлдвэрлэлийн процессгүй, мөн том хэмжээний биш дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө шаардана.</p> <p>Орон нутгийн иргэд, мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл үүсэх магадлал нь их биш байх шаардлагатай.</p>
Ангилал В+	Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ) ⁹ болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ*) шаардлагатай Германы сэргээн босголт, зээлийн банкны	Нөлөөллийн цар хүрээ нь нэмэгдэх, мөн урт хугацаанд нийгэм болон байгаль орчинд нөлөөлөх боломжтой	<p>Үйл ажиллагааны улмаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ их буюу нөлөөллийн хамрах орон зай их, мөн нөлөөллийн үргэлжлэх хугацаа урт (гэхдээ түр зуурын бөгөөд бууруулах боломжтой) байх эрсдэл бүхий сөрөг үр дагавартай байна.</p>

⁹ Байгаль орчин нийгмийн менежментийн бодлого (БОНМБ) нь Монгол улсын хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ)-тэй дүйцнэ. Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г ашигладаг. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд БОННУ*/БОННУ шаардлагатай үед төсөл нь холбогдох шаардлагад нийцүүлнэ. Иймд, БОНМБ) нь БОНЕУ-тэй дүйцэх төслийн хэрэгжилтийн хувьд Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн дагуу БОННУ-ний шаардлагыг харгалзан үзнэ.

	Хяналт шалгалт	Тодорхойлолт	Тайлбар
	шаардлагын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) болон байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) шаардлагатай		
Ангилал А	Монгол Улсын холбогдох хуулийн дагуу БОНЕУ болон БОННУ* шаардлагатай Германы сэргээн босголт, зээлийн банкны шаардлагын дагуу БОННУ болон БОНМТ шаардлагатай	Нөлөөлөл нь урт хугацааны, хамрах хүрээ том, бууруулах боломжгүй, мөн олон талт бөгөөд өмнө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт ийм төрлийн нөлөөлөл үүсэж байгаагүй	Орон нутгийн иргэд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихтэй. Нөлөөллийн цар хүрээ их хэмжээний (нөлөөллийн хамрах орон зай нь их хэмжээний газар нутгийг хамрах, орон нутгийн иргэдэд нөлөөлөл их, хил дамнасан нөлөөлөл, болон хуримтлагдах нөлөөлөл үзүүлэх боломжтой), мөн үргэлжлэх хугацаа нь урт (урт хугацаанд байнга ажиглагдах, нөлөөллийг бууруулах боломж хязгаарлагдмал), мөн нөлөөлөлд өртөх гаар нутаг нь байгаль орчны хувьд чухал (чухал ач холбогдол бүхий экосистемийн тогтолцоо, чухал амьдрах орчин), үүнээс гадна хүний эрх, газар ашиглалт, нөөц болон уугуул иргэдэд ихээхэн сөрөг нөлөөлөлтэй байхаас гадна ихээхэн хэмжээний газар нутаг нүүлгэн шилжүүлэлтэд өртөх магадлалтай.

Мөн энэхүү БОНМБ-ын баримт бичигт орхигдлын дүн шинжилгээний нэмэлт шаардлагуудыг хавсралт 14-т оруулсан. Үүнд,

- Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөх талаар 7 дугаар бүлэгт дэлгэрэнгүй оруулсан.
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журам эсвэл Дэлхийн Банкны группийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжийн стандартыг дагаж мөрдөх. гэхдээ илүү өндөр стандарт, шаардлагыг мөрдөнө.
- Дэлхийн Банкны байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжийн стандарт эсвэл Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмын аль өндөр стандартыг дагаж мөрдөх.
- Байгаль орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг болох соёлын өвийг төслийн үйл ажиллагааны явцад хамгаалах. Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахдаа хавсралт 12-т заасан санамсаргүй олдворын журмыг тусгана.
- Төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явцад төслийн оролцогч талуудын оролцоог хангаж ажиллана. Төслийн оролцогч талуудын оролцоог хангах стандарт аргазүйг 5 дугаар бүлэгт тусгасан.

2.1 Нийгмийн нөлөөлөл

Төслийн хувьд албадан нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг дэмжихгүй ч зарим төслийн үйл ажиллагаа нь байгаль хамгаалах арга хэмжээг сайжруулахын тулд орон нутгийн иргэдийн байгалийн нөөц ашиглалт, хүртээмжийг хязгаарлах төлөвтэй байдаг. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудад тухайн газарт оршин суугч нь өмчлөх

болон эзэмших эрхтэй тохиолдолд нөхөн олговор олгохоор заасан байдаг. Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 5 (Газар эзэмших, газар ашиглах болон албадан нүүлгэн шилжүүлэлтийг хязгаарлах)-ыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь төслийн үйл ажиллагааг илүү өндөр түвшинд хүргэхэд чиглэдэг.

Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 5-ын дагуу төслийн үйл ажиллагаа эхлэх үед төсөл хэрэгжиж талбайн хэмжээнд нөлөөлөлд өртөх хүмүүс, мөн тэдгээрийн амьдрах орчныг хязгаарлах хүчин зүйлс, үүнээс гадна амьдрах нөхцөл болон амьжиргааны байдлыг сайжруулах үүднээс нөхөн олговор олгох шаардлагатай өрхийг үнэлэх үүднээс нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхийг шаарддаг. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн улмаас нэг ч хувь иргэн, айл өрхөд хохирол учруулахгүй буюу амьжиргааны түвшнийг бууруулахгүй байх, өөрөөр хэлбэл, Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 5-ын зорилгын хүрээнд тодорхой үйл ажиллагааны улмаас тэгш бус байдлаар нөлөөлөхгүй байхын тулд төслийн гол оролцогч талууд болон эмзэг бүлгийн иргэдийг тодорхойлох авч үзэх зайлшгүй шаардлагатай.


3. Төлөв байдлын урьдчилсан үнэлгээ

Энэ бүлэгт төлөв байдлын нөхцөлийг нээлттэй байгаа мэдээллийн хүрээнд холбогдох дүн шинжилгээг хийж оруулав. Төслийн хүрээнд ойн тогтвортой менежментийн суурь судалгаа, бэлчээрийн суурь судалгаа, нийгэм эдийн засгийн суурь судалгаа, мөн ТХГН-ийн менежментийн тогтвортой байдлыг “Менежментийн үр ашгийг хянах аргачлал”-д үндэслэн судлах судалгааны ажлуудыг хийнэ. Мөн энэ бүлэгт холбогдох мэдээллийг нарийвчлан оруулсан бөгөөд эдгээр нь цаашид илүү баяжиж сайрах болно.

Монгол улс далайд гарцгүй орон бөгөөд 1.56 сая км² газар нутагтай, гурван сая гаран нийт хүн амтай бөгөөд нийт хүн амын 2.2 сая нь нийслэл хотод амьдардаг¹⁰. Хөдөө орон нутгийн хүн амын нягтрал 1км² талбайд 0.5 хүн амтай байгаа нь хөдөөгийн амьжиргааны гол хэрэгсэл болох нүүдлийн мал аж ахуй давамгайлж байгааг харуулж байна.

Монгол орны газар зүйн байдал нь хойд болон баруун талаараа уулсаар хүрээлэгдэн далайн түвшнээс дээш 914-1524 м өндөрлөгт оршдог. Монгол орны дундаж өндөрлөг нь далайн түвшнээс дээш 1580 м-т байна.

Алтайн нуруу нь манай орны баруун болон баруун өмнөд хэсгээр үргэлжлэн оршдог бөгөөд Монгол орны баруун хязгаарт орших Хүйтний оргил нь хамгийн өндөр цэг буюу 4375 м юм. Нөгөө талаас, Монгол орны зүүн болон өмнөд тэгш тал, гадаргын хотгор хэв шинжтэй. Мөн Монгол Улсад Азийн хамгийн том цэнгэг устай нууруудын нэг (Хөвсгөл нуур), давст нуурууд, намаг, элсэн манхан, хээр тал, бэлчээр, тайга болон мөнх цаст уул оршдог. Монголын баруун болон хойд хэсэг нь газар хөдлөлтийн идэвхтэй бүс бөгөөд үе үе газар хөдлөлт болдог, халуун рашаан, унтарсан галт уул ихтэй байдаг.



Зураг 4. Монгол орны жилийн дундаж хур тунадас 2020


Монгол Улс нь далайгаас тусгаарлагдсан, хойд болон баруун талдаа өндөр уулсаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дээш дундаж өндөрлөгт өргөгдсөн эх газрын эрс тэс уур амьсгалтай орон юм. Жилийн дундаж температур агаарын температур нь 45°-ын өргөргөөс дээших нутгуудын 2°C-аас доош, харин баруун хойд хэсгээр -4°C-аас доош, говийн өмнөд хэсгээр 6°C-аас дээш байна. Өвлийн дундаж агаарын температур -8°C-аас

¹⁰ Дэлхийн банкны мэдээллийн сан

-32°C хооронд хэлбэлздэг бол зуны агаарын температур 6°C-аас 24°C хооронд хэлбэлздэг.

Жилийн нийт хур тунадас говийн өмнөд хэсгээр 50 мм, нутгийн хойд хэсгээр 450 мм хооронд хэлбэлздэг. Жилийн дундаж хур тунадас нутгийн баруун хэсгээр 300-400 мм, Алтайн төв болон хойд ойт хээрийн бүсэд 250-300 мм, зүүн хээрийн бүсэд 150-200 мм байна (Зураг 4-г харна уу). Боломжит ууршилтын хэмжээ нь Монгол Улсын ихэнх нутгаар 500мм-ээс дээш байна¹¹.

Монгол орны ургамлын хэв шинж нь ерөнхийдөө нутгийн хойд хэсгээс нутгийн өмнөд хэсэг рүү шилжихдээ экологийн таван бүсэд буюу өндөр уулс, ойт хээр, хээр, цөлөрхөг хээр болон цөлийн бүс гэсэн таван ангилалд ерөнхийдөө хуваагддаг (Зураг 5-ыг харна уу). Монгол орны газар нутгийн 9.2 хувийг ой сан бүхий газар нутаг эзэлдэг ба эдгээр нь ерөнхийдөө хойд тайга, ойт хээрийн бүсэд хамаарагддаг. Ойт хээр болон хээрийн бүс нь нийт газар нутгийн талаас илүү хувийг (30 болон 20 хувийг тус тус) эзэлдэг бөгөөд ургамлын биомасс нь харьцангуй өндөр (600-1800 кг/га) учир хүн ам болон малын хамгийн их нягтралтай байдаг. Цөлийн хээр болон цөлийн бүсүүдэд ургамлын биомасс нь багатай (30-400 кг/га) бөгөөд нийт газар нутгийн 37 орчим хувийг эзэлдэг.



Зураг 5. Монгол орны экологийн бүс

Монгол Улсын биологийн төрөл зүйл нь дэлхийн хэмжээний ач холбогдолтой бөгөөд энэ нь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн тодорхойлсон 2000 экологийн бүс нутагт багтсан Алтай-Саян, Дагуурын тал болон 70 шувуудад чухал газар зэрэг дэлхийн хэмжээнд албан ёсоор чухал ач холбогдолтой газруудаар илэрч байна. Монгол орны амьтны аймгийн тооллогын үр дүнгээс үзэхэд дэлхийн хэмжээнд чухал ач холбогдол бүхий ОУБХХ-ны устаж байгаа ангилалд багтах Монгол бөхөн (*Saiga borealis*), Хавтгай


¹¹ Дагвадорж болон бусад. Монгол: Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2009 он, БОАЖЯ 2010 он

(*Camelus bactrianus*), цоохор ирвэс (*Panthera uncia*) болон сэргээн нутагшуулсан тахь (*Equus*) зэрэг популяциуд байдаг.

Зүүн бүс нутаг нь нүүдлийн туурайтан амьтдын хамгийн том популяцын нэг болох цагаан зээр (*Procapra gutturosa*)-ийн чухал амьдрах орчин нь болдог. Монгол Улс нь Зүүн Ази-Австрали ази, Төв Ази, Номхон далайн баруун хэсэг болон Африк-Евроазийн гэсэн нүүдлийн шувуудын дэлхийн дөрвөн том нүүдлийн замын чухал хэсэгт байрладаг. 128 хөхтөн амьтдын 30 хувь нь, 476 зүйлийн шувууны 10 хувь, хэвлээр явагчид болон хоёр нутагтан амьтдын 46 хувь, 148 зүйлийн ашигт ургамлын 89 хувь нь эмзэг, ховордож болзошгүй, устаж болзошгүй ангилалд хамаарагдаж байна¹².

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шат нь Монгол орны баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс, мөн хангайн бүсийн баруун өмнөд хэсгийн Баянхонгор гэсэн зургаан аймгийн орчны бүсэд хамрагдах нийт 50 сум, 31 ТХГН болон 53 орон нутгийн ТХГН-ийг хамарна. Эдгээр газруудад биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон орон нутгийн тогтвортой хөгжлийн загваруудыг дэмжих, орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

2020 оны мал тооллогоор Монгол Улсын хэмжээнд 70.9 сая толгой мал тоолуулсан байна. Нийт малын 45.5 хувийг хонь, 41.2 хувийг ямаа, 6.7 хувийг үхэр, 5.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна. Мал сүргийн сүүлийн 4 жилийн өсөлтийг Зураг 6-д харуулав




Зураг 6. Мал сүргийн тоо 2016-2019, сая толгой

Төсөл хэрэгжиж буй бүс нутагт 17.647,735.3 га талбайг эзэлдэг бөгөөд үүний 7.298,825.1 га нь ТХГН-ийн орчны бүсэд байдаг. Орчны бүсэд 18,906 өрх оршин суудаг бөгөөд нэг өрхөд 16 толгой мал ногдох 314,090 толгой малтай.

¹² <http://www.nationalredlist.org/>

Төслийн зорилтот бүс нутагт хамаарагдах сумдуудад одоогийн байдлаар нийт 63,332 өрхийн 239,190 хүн амьдарч байна. Эдгээр өрхүүдийн нийт 7.171,030 толгой малтай бөгөөд кластер нутгийн дунджаар 100-аас дээш малтай өрхүүд байна.



Эх сурвалж: 2020 оны мал тооллогын дүн

Зураг 7. Аймгуудын мал сүргийн тоо, мянган толгой (2020)

Хүснэгт 6. Аймгуудын мал сүргийн тоо, мянган толгой (2020)

	Ховд аймаг	Увс аймаг	Баян-Өлгий аймаг	Говь-Алтай аймаг	Завхан аймаг	Баян-Хонгор аймаг
Тэмээ	25,700	25,498	5,405	43,900	8,110	55,500
Адуу	134,500	139,338	99,781	122,100	236,695	163,300
Үхэр	187,100	211,498	159,490	75,900	224,980	254,800
Хонь	1,126,300	1,622,664	937,405	945,700	1,798,955	1,156,200
Ямаа	1,821,900	1,410,254	1,022,596	2,100,000	1,338,176	2,219,200

Эх сурвалж: 2020 оны мал тооллогын дүн

Дэлхийн Банкны мэдээлснээр Монгол орны нийт газар нутгийн 82 орчим хувь нь бэлчээрийн бүс нутаг бөгөөд энэ нь дэлхий дээрх үргэлжилсэн бэлчээрийн хамгийн том бүс нутаг юм. Монгол Улсын нийт газар нутгийн ойролцоогоор 27% нь ойт, уулын хээр, 30% нь хуурай хээрийн бэлчээр, үлдсэн 43% цөл хээрийн болон цөлийн бүс ба ойн сан бүхий газар нь ойролцоогоор 9%, газар тариалангийн бүс 1%-г эзэлдэг байна¹³.

Монгол Улсын бэлчээрийн төлөв байдлын талаарх мэдээллийн харилцан адилгүй байдаг. Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй “Ногоон алт” төслөөс бэлчээрийн төлөв байдлын мониторингийн үнэлгээг хийж, улмаар Монгол орны бэлчээрийн 65 хувьд нь ургамлын зүйл бүрдэл харилцан адилгүй хэмжээгээр доройтсон болохыг тогтоосон.

Монгол Улсын 112.1 сая га бэлчээрийг доройтлын түвшингөөр нь ангилахад 2016 оны байдлаар нийт мониторингийн талбайн 42.4 хувь нь доройтолгүй, 13.5 хувь нь бага зэрэг, 21.1 хувь нь дунд зэрэг, 12.8 хувь нь хүчтэй, 10.3 хувь нь ихээхэн доройтсон буюу

¹³ Дэлхийн банк, Монголын газрын нөөц ба тэдгээрийн менежмент, Байгаль орчны хяналт, 2003 он.

цөлжилтийн байдалд орсон. Нийт бэлчээрийн 43 хувь нь 1-р¹⁴ түвшинд, 29 хувь нь 2-р түвшинд, 16 хувь нь 3-р түвшинд, 12 хувь нь 4-р зэргийн нөхөн сэргээх түвшинд байна.

Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 2020-2021 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон ба Монгол Улсын нийт газар нутгийн 32.5 хувь нь 50 хүртэлх хувь буюу бэлчээрийн нөөцтэй, 18.1 хувь нь 1-100 хувийн ачаалал буюу бэлчээр хангалттай, 5, 25 хувь 101-300 хувь буюу 1-3 дахин их ачаалалтай, 6.1 хувь 301-500 хувь буюу 3-5 дахин их ачаалалтай, 18.3 хувь нь 500-аас дээш хувь буюу тав дахин их ачаалалтай байна гэж мэдээлсэн байдаг.

Хүснэгт 7. Төсөл хэрэгжиж буй бүс нутагт хамрагдах аймгуудын ястнууд (хувь)

	Ховд	Увс	Баян-Өлгий	Говь-Алтай	Завхан	Баянхонгор	Үндэстэн
Халх	28.1	13.6	0.9	99.2	99.5	99.6	82.4
Казак	11.2	0.2	91	0.1	0.1		3.9
Дөрвөд	6.5	42.3	-	0.1	0.1		2.8
Баяд	-	34.2	-	0.1	0.1		2.2
Буриад		0.1		-			1.7
Захчин	25.2	0.1	-	0.2	0.1		1.2
Дарьганга	-	-	-	-			1.0
Урианхай	8.3	0.2	5.6	0.1			1.0
Дархад	-	-	-	-			0.8
Өөлд	6.0	0.1	-	-		0.1	0.6
Хотгойд	-	-	-	-			0.6
Торгууд	7.4	-	-	0.1			0.5
Хотон	-	7.0	-	-			0.4
Мянгад	5.3	0.5	5.3	-	0.1		0.3
Тува	-	-	0.8	-			0.2
Илжигэн	-	1.1	-	-			-
Сартуул	-	0.2	-	-		0.1	0.1
Түрэг	-	7.6	-	-			-
Бусад	2.0	2.8	1.6	0.1		0.2	0.3

Эх сурвалж: Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого

Монгол Улсад уугуул иргэдийн тухай албан ёсны бодлого байдаггүй. Монгол Улсын хүн амын дийлэнх Халх үндэстэн бөгөөд бусад ястнуудын нэгэн адил уугуул иргэд гэж тодорхойлогддог. Монгол Улсын хүн амын 2020 оны улсын тооллогоор 25 хувь цөөнх бөгөөд ихэнх халх ястан байна. Монголын цөөнх ястнууд Халхтай ижил төстэй зан заншил, уламжлал, амьдралын хэв маягтай. Нийтлэг гарал үүслээр (овог, овгийн үр удам) тодорхойлогддог бөгөөд төслийн хэрэгжих нутаг дэвсгэрт Казах болон Тува үндэстний цөөнх ястнаас бусад ястнууд нь халх хэлээр ярьдаг. Эдгээр ястнуудын хоорондын гол ялгаа нь хувцасны хэв маяг, хоол бэлтгэх арга барил, хөгжим болон аман зохиолоор дамжин илэрдэг.

Монгол үндэстний дотроос Цаатан (Хөвсгөл нуурын ойролцоо амьдардаг цаатан), Ewenki (Монголын зүүн хэсэгт амьдардаг цаатан) нь амьдралын өвөрмөц онцлогтой тул эмзэг бүлэгт тооцогддог. Казах, Тува, Узбек ястнууд нь баруун бүс нутаг болон улсын хэмжээнд цөөнх болж байгаа ч Баян-Өлгий аймгийн нийт хүн амын 91 хувь, кластер 1 болон 2-д харьяалагдах Ховд аймгийн Ховд сумын хүн амын дийлэнх нь казах үндэстэн юм. Кластер нутгийн аймгуудын хүн амын бүтцийг Хүснэгт 8-д үзүүлэв. Монгол Улсын үндсэн шашин

¹⁴ Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2015.

нь Буддизм боловч 2020 оны хүн амын тооллогоор 40.6 хувь нь өөрсдийгөө аливаа нэг шашинд хамрагддаггүй гэж үзжээ.

Эдгээр аймгийн нийт хүн ам 500,708 бөгөөд Монгол Улсын нийт хүн амын 15 хувийг эзэлж байна. Зургаан аймгийн 50 сумын нутаг дэвсгэрийн зарим хэсэг нь 29091.84 мян/га хамрах бөгөөд буюу нийт нутаг дэвсгэрийн 54 хувь нь төсөлд хамрагдаж байна.

Хүснэгт 8. Хүн ам ба газар нутаг, хамрагдах сум

Аймаг	Хүн ам			Газар нутаг мян/га		
	Нийт	Кластер сум	Хувь	Нийт	Кластер бүс	Хувь
Баян-Өлгий	108,530	36,686	33.8	4,580.55	2,180.32	47.6
Говь-Алтай	57,748	12,229	21.3	14,144.7	7,193.95	50.86
Увс	83,223	83,223	100	6,958.58	5,843.05	83
Ховд	89,712	89,712	100	7,613.3	7,341.7	86
Баянхонгор	88,672	5,087	5.74	11,597.8	2,970.64	25.1
Завхан	72,823	2,267	3.13	8250	325.39	3.9
Нийт	500,708	229,204	45	53,144.89	25,822.05	48

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүн.

3.1 Төслийн бүс нутгийн иргэдийн амьжиргаа

Газар тариалан эрхлэх газар нутаг нь хязгаарлагдмал тул тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа зэрэг мал аж ахуй нь салбар хөдөөгийн иргэдийн дийлэнх олонхын хувьд амьжиргааны эх үүсвэр болж, ач холбогдол нь харьцангуй буурсан хэдий ч нийт хүн амын 40 хувийг ажлын байраар хангадаг.

Монгол орны хувьд бэлчээрийн ургамал ургах хугацаа нь цаг агаарын нөхцөл, хур тунадасны хэлбэлзэл их байдгаас шалтгаалан маш богино байдаг. Бэлчээрийн ургамлын ургах хугацаа нь 5 дугаар сарын дунд үеэс эхлэн 8 дугаар сарын дунд үеэс ихэвчлэн зогсдог бөгөөд энэ зүй тогтол нь уулын бүсэд богино харин говийн бүсэд урт байдаг.

Элсэн цөлөөс эхлээд илүү үржил шимтэй ойт хээр хүртэлх экологийн тогтоц бүхий бүс нутагт мал аж ахуйн нүүдлийн болон хагас нүүдлийн зэрэг амьдралын олон хэв маяг зонхилно. Нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй нь Монгол орны соёл иргэншлийг харьцангуй ижил түвшинд аваачсан ба хүмүүс ижил төстэй амьдралын хэв маягтай болж, бусад ястнуудтай ойртон, нийгэм, соёлын ойр дотно харилцаатай болж ирсэн. Эдгээр өрхүүд ихэвчлэн гэрт амьдардаг бөгөөд энэ нь нүүдэлчин амьдралын хэв маягт тохирдог бөгөөд хүн амын тооллогоос үзэхэд хөдөөгийн нийт өрхийн гуравны хоёр нь гэрт¹⁵ амьдардаг. Малчин өрх нь хонь, ямаа, үхэр болон цөөн тооны сарлаг, адуу болон тэмээ зэрэг мал аж ахуйн эрхэлдэг бөгөөд бөгөөд тэдгээрийн орлого, хэрэглээ нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай байдаг.

Монгол Улс жил бүр мал тооллого явуулдаг. Монгол Улсын хэмжээнд 2020 оны эхээр 70.9 сая толгой мал тоолуулсан. Нийт малын 45.5 хувийг хонь, 41.2 хувийг ямаа, 6.7 хувийг үхэр, 5.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ тус тус эзэлж байна. Бог мал, ялангуяа ямаа нь малчдын аж ахуйн амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэхээс эх газрын эрс тэс уур амьсгал, мөн арчилгаа багатай мал аж ахуйн менежментийн арга барилд сайн зохицсон байдаг. Гэвч, нэг төрлийн мал сүргээс авах ашиг орлого бага учраас малын тоо толгойг өсгөх хандлагатай байдаг.

¹⁵ Нүүдэлчин малчдын хэрэглэдэг зөөрийн дугуй өрхийн байгууламж. Ихэвчлэн модон хаалгатай бөгөөд, төв зуухтай майхан шиг бүтэцтэй.

Малчид нь ТХГН-ийн ойр орчимд амьдарч байх хугацаандаа ахуйн хэрэглээндээ ойн нөөц болон бэлчээрийн зориулалтаар, мөн ургамалан нөмрөгийг ашигладаг. Зарим газарт ан агнах, ховор ургамлын үндэс ухах болон бусад зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа явуулах тохиолдол ажиглагддаг байна.

Малчин өрхүүд нь малаа ноослох, самнах, мөн мал төллүүлэх болон малын хашаа хороо барих, засварлах зэрэг биеийн хүч шаардсан хөдөлмөр эрхэлдэг. Усны эх үүсвэрээ дундаа хэрэглэдэг хот айлуудын хооронд хамтын ажиллагааны зохион байгуулалт байдаг байна (Upton, 2008). Гэсэн хэдий ч энэхүү бэлчээр ашиглалтын уламжлалт арга нь бэлчээрийн доройтолд хүргэдэг нь судалгаагаар тогтоосон¹⁶. Үүнээс гадна хот айлд түшиглэсэн бэлчээрийн менежментийн үр дүн нь амьжиргааны байдалтай нягт холбоотой болохыг саяхан хийсэн судалгаагаар тогтоожээ¹⁷.

Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 2016-2018 онд бага зэрэг буурч 28.4 хувьд хүрсэн ч хүн амын 15 хувь нь ядуурлын түвшин рүү шилжих эрсдэлтэй байна. Нөгөө талаас 2018 онд хөдөөгийн ядуурал 30.8 хувьтай байсан. Малчид уламжлалт байдлаар ядуу хүмүүсийн тоонд багтаж байсан ч амьжиргааны олон талт эх үүсвэр нь нэмэгдсэнээр малчдын ядуурлын түвшин хөдөөгийн дундажтай ойролцоо байна¹⁸.

3.2 Газар ашиглалт

Монгол Улсын газрын тухай хуульд зааснаар газар ашиглалтын төрөл, ангиллыг дараах байдлаар авч үздэг. Үүнд,

- Хөдөө аж ахуйн газар,
- хот, тосгон, бусад суурин газар¹⁹,
- Зам, шугам сүлжээний газар
- Ой сан бүхий газар
- Усны сан бүхий газар
- Тусгай хэрэгцээ газар гэж ангилдаг.

Тусгай хэрэгцээт газар нь ТХГН-ийг хамардаг учир өмчлөх боломжгүй байдаг. Зөвхөн Монгол Улсын иргэн газар өмчлөх боломжтой ба гадаадын аж ахуйн нэгж газар ашиглах гэрчилгээ авч, бэлчээрийг өөр зориулалтаар ашиглаж болно. Хуульд заасны дагуу нийт газар ашиглагч, эзэмшигчид өөрийн зардлаар газрын шинж чанарыг хадгалах, хамгаалах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах үүрэгтэй байдаг.

Бэлчээрийн газрыг хувийн өмчид шилжүүлдэггүй бөгөөд уламжлалт тогтолцооны дагуу ашигладаг. Бэлчээрийн газар нутгийн хэмжээг нь сумын хэмжээнд тодорхойлогддог боловч албан ёсны эзэмшлийн зохицуулалтгүй байдаггүй тул хилийн давхцал, тодорхой бус газар ашиглалтын хэлбэрийг бий болгодог. Энэ нь тухай орон нутгийн малчид болон шилжин ирж буй малчдын хооронд бэлчээрийн ашиглалтыг зохицуулахад тодорхой бэрхшээлтэй тулгардаг. Үүнээс болж хамгийн сайн бэлчээр нутаг, зуслангийн газарт хэд хэдэн малчид бууж улмаар удаан хугацаанд суурьшсан малчид “бэлчээрийн газрыг эзэмшиж” байгаа нь бусад малчдын хувьд бэлчээр ашиглалтын тэгш бус байдлыг бий

¹⁶ Upton. *Нийгмийн Капитал, Хамтын үйл ажиллагаа ба бүлэг бүрэлдэх: Социализмын дараах Монгол дахь хөгжлийн замнал*, (2008) 36, ху 175–188.

¹⁷ Уламбаяр нар. *Монголын тал хээрийн экосистем дэх нөхөрлөлд суурилсан бэлчээрийн менежментийн нийгмийн үр дүн*, 2016 он.

¹⁸ Дэлхийн банк, Монгол Улсын “Ядуурлын дүр төрх” тайлан, 2018.

¹⁹ Суурин газрын хэмжээ нь ерөнхийдөө аймаг бол 50-80,000, харин сум бол 3-10,000, мөн баг бол 500-аас бага байдаг.

болгодог байна. Нөгөө талаас, цөөн малтай өрхүүд мал маллахад илүү хэцүү болж байгаа бөгөөд олон малтай малчдад цалинтай ажиллахаас өөр аргагүйд хүрч байна²⁰

3.3 Засаглал

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өөрөө удирдах болон төрийн төвлөрсөн зарчмыг хослуулах замаар зохион байгуулагддаг. Монгол Улс засаг захиргааны хувьд Улаанбаатар хот, 21 аймагт хуваагддаг. Аймгууд нь сум болон багын засаг захиргааны нэгжид хуваагдана.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд өөрөө удирдах байгууллага нь тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) байдаг бол баг бол хорооны өөрөө удирдах байгууллага нь иргэдийн нийтийн хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг болон хорооны нутаг дэвсгэрт төрийн эрхийг Засаг дарга хэрэгжүүлнэ. Засаг даргад нэр дэвшигчийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ИТХ-аас тодруулна. Засаг даргаар батламжлахад хэрвээ баг, хорооны Засаг даргыг сум, дүүргийн Засаг дарга нь, харин сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга нь, мөн аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд тус тус 4 жилийн хугацаатайгаар баталж томилно.

Засаг даргын эрх, үүргийн тухайд “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймаг, хот, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг эрх нь байгаль орчин, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг оновчтой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр ажиллаж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих юм.

Аймгийн Засаг дарга болон хотын захирагч нь газар өмчлөх, газар түрээслэх, байгалийн ашигт малтмал, баялгийг ашиглах, ашиглахтай холбогдсон асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх бүрэн эрхтэй, харин сум, дүүргийн Засаг дарга нь холбогдох хуулийн дагуу газар олгох болон байгалийн нөөц ашигласны татвар, төлбөрийг төвлөрүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй. Баг, хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа газар тариалангийн талбай, хадлан болон бэлчээр, ан амьтан болон байгалийн нөөцийн хамгаалалт, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих ёстой.

Газрын тухай хуулийн 29 дүгээр бүлэгт зааснаар холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын хамтын ажиллагаа нь дараах байдлаар тодорхойлогдсон байдаг ба өөрөөр хэлбэл, аймаг, хотын Засаг дарга нь төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаагаа уялдуулан ажлыг зохион байгуулна. Салбар болон салбар дундын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага болон Засаг дарга нарын хамтарсан шийдвэр гаргаж болно.

Аймаг бүр нь аймгийн Байгаль орчин Аялал жуулчлалын газартай бол сумуудад Байгаль орчны байцаагч болон хоёроос гурван байгаль хамгаалагч нар байдаг.

Байгаль орчин Аялал жуулчлалын газрын дарга болон сумдын байгаль хамгаалагч нарыг тухайн орон нутгийн Засаг дарга, харин байгаль орчны байцаагчийг тухайн орон нутгийн засаг даргын тамгын газрын дарга нь томилдог.

3.4 Сорилтууд

Монгол Улсад хөдөөгийн газар ашиглах эрх нь бэлчээрийн мал аж ахуйн нөхөрлөлүүдийн хоорондын уламжлалт байдал тулгуулагдаг. Гэсэн хэдий ч энэхүү бэлчээр ашиглалтын

²⁰ World Bank, *Mongolia Land Resources and Their Management, Environment Monitor, 2003 and Fratkin and Mearns, Sustainability and Pastoral Livelihoods: Lessons from East African Maasai and Mongolia, Human Organization, Summer 2003, Vol. 62, No. 2 (Summer 2003), pp. 112-122.*

хэв маяг нь бэлчээрийг хамгаалах, бэлчээрийг тэгш хүртээмжтэй ашиглах үйл ажиллагаа нь мал сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд өртөх, бэлчээрийн эзэмших сонголт, болон бүтээн байгуулалт (уул уурхай, хамгаалалтын арга хэмжээ болон аялал жуулчлал гэх мэт) зэргээс хамаарч ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Нөгөө талаас, малчид төрийн бодлогоос гадуур, мөн эдийн засгийн хувьд ялгаварлалд өртөж байна гэж зарим судлаачид үзсэн байна²¹.

Малын тоо толгой нэмэгдэхийн зэрэгцээ зарим хэсэгт малын нягтал ихдэж, мөн бэлчээрийн нөөц хязгаарлагдмал байдал зэрэг нь олон талт хүндрэлийг дагуулж байна. Эдгээр хязгаарлах хүчин зүйлс нь нэмэгдэж байгаа боловч уламжлалт мал аж ахуй нүүдлийн шинж чанартай байдлаас хамаарч тогтвортой байдлын гэрээг байгуулах зэрэг цөөн хэдэн механизмууд байна. Энэ тухайн орон нутгийн болон отрын малчдын хооронд бэлчээр болон даац, нөөцийн менежменттэй холбоотой зөрчилдөөн үүсэхэд хүргэж байна²².

Бэлчээрийн даац хэтэрснээс үүдэлтэйгээр явагдах газрын доройтол нь ирээдүйд хөрсний доройтол болон бэлчээрийн нөөцийн хомсдолд хүргэхээс гадна зэрлэг ан амьтан болон биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлнө. Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг нь Монгол Улсын хэмжээнд зэрлэг ан амьтдын тоо толгой эрс буурч байгааг тогтоосон байдаг. Тухайлбал, тарваганы тоо толгой 1988-2018 оны хооронд 75 хувиар буурсан байна. Үслэг эдлэлийн худалдааны тоо хэмжээ нь хуулиар зөвшөөрөгдсөн хөхтөн амьдын агнуурын тоо их байна. Жишээлбэл, чоно, цоохор ирвэсийг арьс, баавгайг цөс цөсний хүүдий, халиун бугыг цусан эвэр, хүдрийг заарыг авахын төлөө агнах тохиолдол элбэг байна. Шонхор шувууны хууль бус экспорт газар авч байгаа бөгөөд судалгаагаар идлэг шонхрын тоо толгой сүүлийн 20 жилийн хугацаанд 60 хувиар буурчээ²³. Зэрлэг ан амьдын тоо толгой нь бууралт нь хөдөөгийн ядууралтай холбоотой бөгөөд, мөн Зүүн Ази болон Хятад Улсад зэрлэг ан амьтдын гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ болон ан агнуурт тавих хяналт үр дүн муутай байгаатай холбоотой байна²⁴.

Бэлчээрийн доройтолд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх мэдээлэл нь харилцан адилгүй байгаа ч уур амьсгалын өөрчлөлт, мал сүргийн тоо толгойн өсөлт зэрэг нь гол хүчин зүйлс мөн гэж олон нийтээр хүлээн зөвшөөрдөг байна.

Ялангуяа усны сан бүхий газар, суурин газар, нууруудын ойр орчмын бэлчээрийн газар, мөн зам дагуух мал сүрэг бэлчдэг газрууд нь ихээхэн доройтсон зүй тогтолтой байна.

Төв Азийн уулархаг бүс нутаг дах мал аж ахуй нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртсөн бүс нутгийн нэгд тооцогддог. Малчдын дунд хийсэн саяхны судалгаагаар өвөл оройтож эхэлж огцом шилжилт ажиглагдахын зэрэгцээ зуны улиралд салхитай өдрүүдтэй уялдаж ихэвчлэн сэрүүн, мөн хэт халуун өдрүүд үргэлж байгааг тогтоожээ. Мөн хур бороо баг орж байгаагаас хамаар бэлчээрийн гарц муудаж байгаа талаар малчид ярилцаж байсан байна²⁵.

Бэлчээрийн газрыг өмчлөх эрхгүй учраас урт хугацаанд байгаль орчинд ээлтэй арга хэмжээг авах боломжгүй тул бэлчээрийн газрын эзэмших сонголтыг солонгоруулах нь

²¹ Barcus, Contested Space, Contested Livelihoods: A Review of Mongolia's Pastureland Management and Land-Tenure Reform, *Geographical Review*, 108:1, pp138-157, 2018.

²² World Bank, *Mongolia Land Resources and Their Management*, Environment Monitor, 2003.

²³ Zoological Society of London et. al., *Silent Steppe II: Mongolia's Wildlife Trade Crisis, Ten Years Later*, 2019.

²⁴ Pratt et. al., *Local community attitudes to wildlife utilisation in the changing economic and social context of Mongolia*, *Biodiversity and Conservation* 13, pp591-613, 2004.

²⁵ Mijiddorj et. al., *Traditional livelihoods under a changing climate: herder perceptions of climate change and its consequences in South Gobi, Mongolia*, *Climatic Change* (2020) 162, pp1065-1079.

магадгүй газар ашиглалтыг сайжруулахад түлхэц болох юм. Энэ нь бэлчээрийн газрын хумигдах явц, мөн доройтлыг бууруулахад нөлөөлж болох боломжтой.

төсөл хэрэгжиж буй бүс нутгийн ойн сан бүхий газар нь харьцангуй бага хэдий ч уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, хүний үйл ажиллагааны улмаас доройтолд өртөж байна. Өөрөөр хэлбэл, ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэл, хортон шавжийн нөлөөгөөр доройтож байна. Мөн мал аж ахуй нь газарзүйн байрлалын хязгаарлах хүчин зүйлс бүхий ойт хээрийн бүсэд ихээхэн бөөгнөрлийг үүсэж байна.

Барууны үзэл байгаль хамгаалалтын үзэл баримтлалыг олон зууны турш бэлчээрийн газар нутгийг хамгаалж ирсэн малчид эсэргүүцдэг болохыг зарим судалгаа харуулж байна. Үүнээс гадна, ТХГН-ийн бэлчээрийн ашиглалт, ан агнуурын хязгаарлалт нь Монголчуудын уламжлалтай зөрчилдөж байна²⁶.

Олон талын сөрөг нөлөөллийн улмаас малчдын амьжиргааг урьдчилан таамаглах аргагүй болж байна. Зөвлөлтийн дараах үеийн хурдацтай өөрчлөлтүүд нь ядуурал болон тэгш бус байдлыг улам бүр нэмэгдэхэд хүргэсэн²⁷. Цөөн малтай малчид өөрчлөгдөж буй нөхцөл байдалд илүү өртөмтгий бөгөөд ялангуяа хатуу ширүүн өвөл болох зэрэг гадаад хүчин зүйлсээс хамаарч амьжиргааны орлогын эх үүсвэрээ алдах магадлалтай юм. Нүүдлийн болон хот айл хамтран мал аж ахуй эрхэлдэг уламжлалт арга байдаг²⁸ ч малчид суурин амьдралын хэв маяг, стратегид илүү дасан зохицож байна²⁹.

²⁶ Upton, *Living off the land: Nature and nomadism in Mongolia*, *Geoforum* 41, pp865–874, 2010.

²⁷ Mearns, *Sustaining Livelihoods on Mongolia's Pastoral Commons: Insights for a Participatory Poverty Assessment*, *Development and Change* 35(1), pp107-139, 2004..

²⁸ For example, through the local heading encampments – khot ail – where two to twelve households cooperate on labor intensive tasks (or larger clusters or khot ails).

²⁹ Wang et. al., *Climate adaptation, local institutions, and rural livelihoods: A comparative study of herder communities in Mongolia and Inner Mongolia, China*, *Global Environmental Change* 23 (2013) pp1673-1683.

4. Байгаль орчин, нийгмийн эрсдэл

4.1 Ерөнхий мэдээлэл

Энэ бүлэгт төслийн үйл ажиллагааны хүрээнд зайлшгүй анхаарч үзэх, бууруулах арга хэмжээг авах шаардлагатай байгаль орчин, нийгмийн гол эрсдэлүүдийг тодорхойлсон болно. Нөгөө талаас, энэ бүлэгт судалгаа, сургалт, семинар, хурал, мөн ТХГН-ийн болон кластерийн менежментийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой мэдээллийг оруулаагүй болно. Төслийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл багатай боловч "Оролцогч талууд ба олон нийтийн оролцоо" бүлэгт заасан үндсэн зарчмын дагуу төлөвлөсөн байх ёстой.

Төслийн үйл ажиллагаа нь зөвхөн хэсэгчлэн тодорхойлогдсон байгаа бөгөөд хараахан эцэслэгдэж амжаагүй байгаа тул Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, үндэсний стандарт болон Германы сэргээн босгол, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн дагуу аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах чиглэлээр ерөнхийд урьдчилан таамаглах зорилготой юм.

Ерөнхийдөө төслийн үйл ажиллагаа нь холбогдох удирдах ажилтнууд, төрийн бус байгууллагууд, орон нутгийн иргэд болон тэдгээрийн хооронд байгаль хамгааллын манлайллын чадавхыг бэхжүүлэх замаар байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Төслийн хөрөнгө оруулалт нь тэргүүлэх ач холбогдол бүхий газар нутуудыг хамгаалах, түүнчлэн кластер нутгийн биологийн олон янз байдлын эдийн засгийн үр өгөөжийг сайжруулснаар шууд ажлын байр, шууд бүс үр өгөөжийг хүртэх замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Холбогдох зөв шийдвэр гаргах болон төлөвлөлтийг сайн хангахын тулд төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг сайтар хэрэгжүүлэх шаардлагатай юм. Төлөвлөлтийг боловсруулахын тулд энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тогтвортой амьжиргаанд хөрөнгө оруулалтыг хийх бөгөөд энэ нь кластерийн ландшафтыг хамгаалах тэргүүлэх чиглэлтэй нийцэж байх шаардлагатай юм. Төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд кластер нутгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй байгаль хамгааллын тэргүүлэх чиглэлүүдэд хөрөнгө оруулалт хийнэ. Харин төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд байгаль хамгааллыг сайжруулахын тулд сонгогдсон ТХГН-т тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хийхийн зэрэгцээ төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх хөрөнгө оруулалт нь байгаль хамгаалах салбарт илүү өргөн цар хүрээнд, мөн урт хугацааны төлөвлөлтөд чиглэнэ.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн дагуу "А" ангилалд хамаарагдах аливаа үйл ажиллагаанууд буюу байгаль орчныг доройтлыг нэмэгдүүлэх, нөгөө талаас зээл, тусламж хүлээн авагч улсын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын конвенц, хэлэлцээрийн дагуу хууль бус гэж тооцогдох, эсвэл олон улсын хоригт хамаарах аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагааны үйлдвэрлэл болон худалдаа, мөн орон нутгийн иргэд, тэдгээрийн амьжиргааны түвшинд ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх замаар хэд хэдэн эрсдэлийг арилгах болно. Иймд дараах үйл ажиллагаануудыг төслийн хүрээнд дэмжих, мөн хэрэгжүүлэх боломжгүй. Үүнд,

- Археологи, палеонтологи, түүх, архитектур, шашин шүтлэг, гоо зүйн болон бусад соёлын ач холбогдол бүхий ландшафт, байгалийн өвөрмөц тогтоц, бүлэг байгууламж, бие даасан байгууламжтай газар нутгийг агуулсан соёлын биет болон биет бус өвд

хохирол учруулах магадлалтай үйл ажиллагааг (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 8-ын дагуу).

- Албадан газар чөлөөлөлт болон нөөцийг албадан хязгаарлахыг шаардах үйл ажиллагааг (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 5-ын дагуу).
- Хориотой буюу Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мөрддөг Ia, Ib болон II ангилалд багтсан пестицидийг сурталчлах, ашиглах, хадгалах, түгээх үйл ажиллагааг.
- Хүүхдийн болон албадан хөдөлмөр эрхүүлэх үйл ажиллагааг (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 2-ын дагуу).
- Зэвсэг, сум худалдан авах, худалдаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх (Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн дагуу).
- Үүнээс гадна, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ТХГН-т төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй үйл ажиллагаанд дараах тохиолдолд хамаарахгүй. Үүнд,
 - Ой сан бүхий газар, тусгай хамгаалалттай газар нутаг, амьтдын үүрлэх газар болон бусад төрлийн тодорхойлогдсон болон тогтоогдсон байгалийн амьдрах орчинд хохирол учруулах магадлалтай.
 - Аливаа төрлийн хамгаалагдсан ургамал болон амьтныг устгах мөн ашиглах.
 - ТХГН-т элс, хайрга, дайрга болон субстрат материалыг олборлох.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах хязгаарлалтыг дагаж мөрдөх ёстой: Үүнд,

- Дархан цаазат газрын хувьд,
 - Газар ашиглалтын өөрчлөлтийг шаардах
 - ТХГН-ийн удирдлагын газраас баталсан Менежментийн төлөвлөгөөнд тодорхой заагаагүй барилга, байгууламжийн бүтээн байгуулалтыг багтаах
- Байгалийн цогцолборт газрын хувьд,
 - Батлагдсан бүтээн байгуулалт/барилгын төлөвлөгөөнд тусгаагүй барилга байгууламжийг хамрах.
 - Шууд болон шууд бусаар суурин газрыг сунгах.
- Дурсгалт газрын хувьд,
 - Хөшөөний 3 км талбайд бүтээн байгуулалтыг багтаах.
- Орчны бүсийн хувьд,
 - Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөтэй уялдаагүй бүтээн байгуулалтыг хамрах.

Дээр дурдсан эрсдэлтэй үйл ажиллагаанаас аль нэг үйл ажиллагааг хамрах бол төслийн үйл ажиллагааг дахин төлөвлөх эсвэл татгалзах болно.

4.2 Төслийн үйл ажиллагаа ба тэдгээрийн байгаль орчин, нийгмийн холбогдох эрсдэл

Аймаг, сумдын Засаг дарга нар, ТХГН-ийн захиргаа болон байгаль орчны байгууллагуудын оролцоотойгоор орчны бүсийн менежментийн зөвлөлтэй хийсэн анхны хэлэлцүүлгийн үр дүнд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн холбогдох бүс нутгуудад амьжиргааг сайжруулах анхны арга хэмжээнүүд, мөн ТХГН-ийн болон орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд илүү нарийвчлан тусгагдаж хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж байгаа үйл ажиллагаануудыг болон төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд төлөвлөсөн суурь судалгаануудад тусгагдсан болно.

Төслийн хүрээнд өнөөгийн байдлаар тодорхойлсон боломжит хөрөнгө оруулалтын мэдээллийг төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй гол эрсдэлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийн хамт Хүснэгт 9-д оруулав.

Энэ нь төслийн холбогдох эрсдэлийн урьдчилсан үнэлгээ бөгөөд үйл ажиллагааг төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй нөлөөллийн шинж чанар бол тэдгээрийн цар хүрээнд үндэслэн холбогдох дүн шинжилгээг хийж улмаар холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

Хүснэгт 9. Төслийн тодорхойлсон эрсдэл ба боломжит хөрөнгө оруулалт

	Гол үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Эрсдэл			
Бүрэлдэхүүн хэсэг 1: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах болон бэлтгэл ажил, төлөвлөлтийн арга хэмжээ, мөн зохион байгуулалт	Хамгаалалтын захиргааны дэд бүтцийн барилгын зураг төсөл, хөрс, геологийн судалгаа, зохиогчийн эрхийн хяналт	ТХГН-ийн захиргааны барилга (5)	Нөөцийн үр ашиг, хүртээмж, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал			
		Баруун бүсийн мэдээлэл, сургалтын төв (1)				
		Байгаль хамгаалагчийн байр (20)				
		Байгаль хамгаалагчийн хяналтын байр (40)				
	Суурь судалгаа	Хамгаалалтын захиргааны мэдээлэл, сургалтын төв (20)	БОНМБ-д оролцогч талууд болон олон нийтийн оролцоог хангах нэгдмэл байдлын дутмаг байдал			
		Менежментийн үр ашигтай байдлыг үнэлэх (23 ТХГН-ууд)				
		Бэлчээр (10 сумууд)				
		Ой (8 сумууд)				
	Төлөвлөлтийг дэмжих (ТХГН-ийн боловсруулах болон сайжруулах)	Нийгэм, эдийн засаг (20 сумууд)		Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө (5)		
		ТХГН-ийн төлөвлөгөө (16)				
		Орон нутгийн ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө (7)				
		НМА менежментийн төлөвлөгөө (5)				
	Дүрэмт хувцас	Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө (4)		ТХГН-н захиргаа (1400)	Нөөцийн үр ашиг	
		ТХГН-ийн захиргаа		Аймгийн БОАЖГазар (200)		
	Үндсэн тоног төхөөрөмж, хэрэгсэл (үүнд мэдээллийн технологи, судалгаа, онлайн харилцаа холбоо, гал унтраах төхөөрөмж)	ТХГН-ийн захиргаа		Аймгийн БОАЖГазар		Нөөцийн үр ашиг
		Аймгийн БОАЖГазар		Сав газрын захиргаа		
Сав газрын захиргаа		Ойн нөхөрлөлүүд				
Ойн нөхөрлөлүүд		Аймгийн УЦУОШГазар				
Тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх	Биологийн олон янз байдлыг хамгааллыг сайжруулах, мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт	Цаашид тодорхой болгох, мөн эдгээр үйл ажиллагаанууд нь холбогдох дүн шинжилгээг хийх шаардлагатай				

	Гол үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Эрсдэл
Бүрэлдэхүүн хэсэг 2 : ТХГН-ийн олон талт оролцооны болон орчны бүсийн менежмент мөн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хамгаалалтын захиргааны дэд бүтэц, бүтээн байгуулалт	ТХГН-ийн захиргааны барилга (5)	Ажилчдын болон орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хог хаягдлын менежмент
		Баруун бүсийн мэдээлэл, сургалтын төв (1)	
		Байгаль хамгаалагчийн байр (20)	
		Байгаль хамгаалагчийн хяналтын байр (40)	
		Хамгаалалтын захиргааны мэдээлэл, сургалтын төв (20)	
		Отоглох цэг, нэвтрэх цэг, тэмдэгжүүлэлт, ажиглалтын цамхаг гэх мэт	
	Тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх	Бэлчээрийн менежментийн туршилтын төсөл	Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, мөн нөлөөлөлд өртөх эмзэг бүлгийг авч үзэх
		Ойн менежментийн туршилтын төсөл	
		Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн туршилтын төсөл	
		Аялал жуулчлалын менежментийн туршилтын төсөл	
	Тогтвортой амьжиргааг дэмжих үйл ажиллагаа (хялбаршуулсан сайн арга хэмжээнүүд)	Олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Ажилчдын болон орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хог хаягдлын менежмент Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, мөн нөлөөлөлд өртөх эмзэг бүлгийг авч үзэх
		Хүнсний ногооны зуны хүлэмж	
		Хүнсний ногооны улирлын чанартай хүлэмж	
		Мод үржүүлгийн газар	
		Жимс тарих, хадгалах	
Хүнсний ногооны тариалалт			
Бага оврын усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх			
Арвай, овъёос тариалалт			
Малын тэжээл тариалах, боловсруулах			
Жимс боловсруулах, хадгалах газар (зоорь)			
Хүнсний ногоо, жимс хадгалах, хөлдөөх			
Жижиг хэмжээний боловсруулах цехүүд (малын гаралтай түүхий эд, мах, ноос, сүү сүүн бүтээгдэхүүн, мод, модон бүтээгдэхүүн, ойн дагалт бүтээгдэхүүн)			
Ундны ус цэвэршүүлэх			
Орчны бүсийн сан (орчны бүсийн үйл ажиллагааг сайжруулах сан)	Орчны бүсийн менежментийн санхүүжилт (400'000 евро)	Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, мөн нөлөөлөлд өртөх эмзэг бүлгийг авч үзэх	
	Орчны бүсийн менежментийн санхүүжилт (600'000 евро)		
	Орчны бүсийн менежментийн санхүүжилт (700'000 евро)		
	Орчны бүсийн менежментийн санхүүжилт (700'000 евро)		
	Орчны бүсийн менежментийн санхүүжилт (600'000 евро)		
Орчны бүс болон ТХГН-ийн	Сонгогдсон сумдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх		

	Гол үйл ажиллагаа нийгмийн дэд бүтцийг дэмжих	Үйл ажиллагаа	Эрсдэл
		Сонгогдсон сумдад экологийн боловсролыг дэмжих Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах	
	Тавилга болон тоног төхөөрөмж, хэрэгсэл (тавилга, мэдээллийн технологи болон бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл)	ТХГН-ийн захиргааны барилга (5)	Нөөцийн үр ашигтай байдал
		Баруун бүсийн мэдээлэл, сургалтын төв (1)	
		Байгаль хамгаалагчийн байр (20)	
		Байгаль хамгаалагчийн хяналтын байр (40)	
		Хамгаалалтын захиргааны мэдээлэл, сургалтын төв (20)	
	Тээвэр, логистик	Тээврийн хэрэгсэл (жийп) (29)	
		Тээврийн хэрэгсэл (бусад төрлийн)	
		Мотоцикль	
		Бартаат замын 4 дугуйт мотоцикль	
		Цасны мотоцикль	
		Ариутгах болон хогны машин	
Завь			
Бүрэлдэхүүн хэсэг 3: бие даасан 7 ТХГН-ийн хөрөнгө оруулалт болон төлөвлөлт	Суурь судалгаа	Менежментийн үр ашигтай байдлыг үнэлэх (7 ТХГН-уудад)	Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо
		Бэлчээр (10 сумд)	
		Ой (3 сумд)	
		Нийгэм, эдийн засаг (10 сумд)	
	Төлөвлөлтийг дэмжих (боловсруулах болон сайжруулах)	ТХГН-н менежментийн төлөвлөгөө (7)	
	Барилга	ТХГН-ийн захиргааны барилга	Ажилчдын болон орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хог хаягдлын менежмент
		Байгаль хамгаалагчийн байр	
		Байгаль хамгаалагчийн хяналтын байр	
	Орчны бүсэд байгаль хамгаалах, тогтвортой амьжиргааны арга хэмжээг хамтран санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Туршилтын үйл ажиллагаанууд	Амьжиргаанд сөргөөр нөлөөлөх, оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, нөлөөлөлд өртөх эмзэг бүлгийг харгалзан үзэх
	Тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнүүдэд зөвшөөрсөн	Туршилтын төслүүд (Бэлчээр, ой, биологийн олон янз байдал, аялал жуулчлалын менежментийг сайжруулах)	

	Гол үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Эрсдэл	
	хөрөнгө оруулалтыг хийх			
Бүрэлдэхүүн хэсэг 4 : ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг бэхжүүлэх олон нийтэд таниулах арга хэмжээ	Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сургалтыг зохион байгуулах, төлөвлөх	Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн сургалт Байгаль хамгаалагч, Байгаль орчны улсын байцаагч нарын сургалт Зорилтот бүлгийн сургалт	Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, нөлөөлөлд өртөх эмзэг бүлгийг харгалзан үзэх	
	Орчны бүсүүд болон ТХГН-ын Хамгаалалтын захиргаадын тоног төхөөрөмж болон чадавхыг хөгжүүлэх, дэмжих	Орчны бүсийн зөвлөлийн гишүүд Олон нийт ба хэрэглэгчдийн бүлгүүд Туршлага солилцох		
	Хамтын ажиллагааг дэмжих бодлого болон уулзалт хурал зөвөлгөөн	Сэдэвчилсэн ажлын хэсгүүд Биологийн олон янз байдлын зөвлөл		
	БОАЖЯ-ны ТХБНУГ, Орчны бүсийн зөвлөл, ТХГН-ын хамгаалалтын захиргаадын олон нийтэд таниулан сурталчилах арга хэмжээнүүдийг дэмжих	Тараах материал, товхимол, ухуулах хуудас боловсруулж хэвлүүлэх Телевиз ба медиа (видео, богино хэмжээний кино гэх мэт)		Форум, арга хэмжээ, хурал, семинар
		Байгаль хамгаалал, ТХГН-ийн менежментийн чиглэлээр сургалтын үзэл баримтлалыг боловсруулж, шинэчлэхэд БОАЖЯ-ны ТХБНУГ-т дэмжлэг үзүүлэх.		
		Хяналт шинжилгээ, үнэлгээ		Бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэлийг оролцогч талууд болон орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан зарчмууд (судалгаа, суурь нөхцөл болон төлөвлөлт) болон жижиг дэд бүтцийн (байгаль хамгаалагчийн байр, пост) засвар үйлчилгээ хийх, мөн зураг төсөл боловсруулах, төлөвлөх, барих стандарт журмын шаардлагыг хангах замаар худалдан авалттай холбоотой (дүрэмт хувцас, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гэх мэт) мөн нөөцийн үр ашиг, тогтвортой байдлыг харгалзан үзсэн нийтлэг шаардлага,

аргазүйд үндэслэн тодорхойлж болдог. Гэсэн хэдий ч дараах хоёр төрлийн үйл ажиллагаа нь онцгой анхаарал шаардахаар байна. Үүнд,

Баруун бүсийн шинэ төв, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны барилга, мах, арьс шир боловсруулах цехийн гурван барилгыг төлөвлөх, барих, ашиглалтад оруулах. Эдгээр үйл ажиллагаа нь тухайн төсөл хэрэгжих талбайн хэмжээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), харин бага хэмжээтэй бол тухайн нөхцөлд тохирсон байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө болон байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) боловсруулах шаардлагатай болно.

Бэлчээр, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, ойн менежментийн туршилтын төслүүд. Эдгээр төслүүд нь Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 5-ын зарчмуудын дагуу амьжиргааны түвшнийг хуучин хэвэнд оруулаагүй, эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргаанд харилцан адилгүй нөлөөллийг үзүүлэх, мөн төлөвлөлтөд сайтар тусгагдахгүйн улмаас орон нутгийн иргэдийн амьжиргааг хязгаарлах боломжтой юм. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн иргэдийн амьжиргааг хязгаарлах боломжтой үйл ажиллагаа байгаа тохиолдолд нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийж төслийн төлөвлөлттэй нягт уялдуулах замаар төслийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөл өртсөн иргэдийн амьжиргааг сайжруулж болох өөр хувилбарыг судлан түүнд үндэслэн амьжиргааны түвшнийг доройтуулахгүй байх нөхцөлийг хангах зайлшгүй шаардлагатай юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь нийгмийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх болон бууруулах арга хэмжээг төлөвлөх зэрэг стратегийн үйл явцыг багтаасан байдаг.

Дараах хоёр хэсэгт амьжиргаанд нөлөөлж буй дэд бүтэц, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг нарийвчлан тусгасан болно.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд шууд ашиг хүртэгч нөхөрлөлүүд, хамтын оролцоотой зураглал, төлөвлөлтийн хүрээнд яг ямар загвар үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх эсвэл ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй зайлсхийх зэргийг тодорхойлсноор тухайн төслийн тогтвортой байдал хангагдана. Төслийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах тухай тус тайлангийн 5.1-р хэсэгт тусгаснаар орон нутгийн шийдвэр гаргагч болон үндэсний манлайлагч нарыг заавал оролцуулах ёстой.

4.3 Бага хэмжээний дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II болон III үе шатны хөрөнгө оруулалтын хүрээнд ТХГН-ийн (жишээлбэл, аялал жуулчлалыг дэмжих) болон орчны бүс нутгийн нутаг дэвсгэрт (жишээлбэл, бага оврын боловсруулах үйлдвэр) байрлах бага хэмжээний дэд бүтцийн бүтээн байгуулалт, мөн холбогдох нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хийнэ.

ТХГН нутаг дэвсгэрт барихаар төлөвлөж байгаа дэд бүтцийн байршлыг тухайн ТХГН-ийн чухал ач холбогдолтой газар төлөвлөхгүй байхын тулд анхааралтай сонгох хэрэгтэй бөгөөд нөгөө талаас кластер нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд төлөвлөсөн бүтээн байгуулалтаас өмнө газрын эрхийг баталгаажуулсан байх шаардлагатай.

Шинээр баригдахаар төлөвлөж буй барилга байгууламжийн байршлаас үл хамаарч тухайн хэсэгт **ургамлан нөмрөгийн** талхагдал түр зуурын хугацаанд явагдах бөгөөд газар шорооны ажлын үед өнгөн хөрсний хуулалт хийгдэх боломжтой юм. Энэ нь хөрсний элэгдэл эвдрэлийг мөн **доройтлын** эрсдэлийг үүсгэх боломжтой.

Барилга угсралтын ажлын үед **зэрлэг амьтдын** амьдрах орчин, тэдгээрийн үржлийн газар нутгийг холбогдох зөв арга хэмжээг авахгүй, мөн хамгаалахгүй тохиолдолд нөлөөлөлд өртөх боломжтой юм. Мөн барилга угсралтын ажлын үед ажилчид нь хоол хүнсэнд хэрэглэх үүднээс зэрлэг амьтдыг агнах, мөн урхи тавин барих магадлалтай юм. Хамгаалалтын арга хэмжээ нь ТХГН-ийн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой ажил хэдий ч нэн ховор, уугуул болон гэрийн тэжээвэр амьтдыг газар нутгаас байршлаас үл хамааран аливаа учирч болох эрсдэлээс хамгаалах хэрэгтэй.

Дэд бүтцийн бүтээн байгуулалтын үед хуримтлагдсан хатуу болон шингэн хаягдал болон тэдгээрийг зохих шаардлагын дагуу төслийн талбайгаас зайлуулаагүйгээс болж байгаль орчин, ялангуяа усны сан бүхий газарт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Хог хаягдал нь барилгын хог хаягдал, хатуу болон шингэн химийн гаралтай бодис, мөн ахуйн хог хаягдал болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй үүсэх хаягдал зэрэг байж болно.

Барилга угсралтын ажлын үед шаардлагатай элс, хайрга, чулуу, ул хөрс зэрэг материалыг холбогдох **карьераас** олборлох авч ашиглах үйл ажиллагаанаас амьтад болон тэдгээрийн амьдрах орчинд нөлөөлөх, мөн газрын элэгдэл эвдрэл, шороо тоос, хөрс болон газрын доорх усыг бохирдуулах, түүх, соёлын өвд нөлөөлөх, мөн хог хаягдлыг үүсгэхээс гадна үзэгдэх орчинд нөлөөлөх боломжтой юм.

Мөн барилга угсралтын ажлын үед холбогдох газар шорооны ажил, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, шатах тослох материалын ашиглалтын үед ялгарах бохирдуулагч хий зэргээс агаарт тоос, тоосонцор болон бохирдуулагч хийн ялгарлаас хамаарч **агаарын чанарт** нөлөөлж болзошгүй.

Барилга угсралтын ажлын үед **дуу чимээ болон чичиргээ** үүсэх боломжтой бөгөөд энэ нь ТХГН дах чухал амьдрах орчин болон барилгын ажил явагдаж байгаа газрын ойролцоо оршин суух орон нутгийн иргэдэд нөлөөллийг үзүүлэх боломжтой юм.

ТХГН дах дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлтөд, нөгөө талаас зураг төслийг эцэслэх үе шатанд **үзэгдэх орчны нөлөөллийг** сайтар харгалзан үзэх шаардлагатай. Хэдийгээр эцсийн зураг төсөл нь ТХГН-т нөлөөлөл үзүүлэхгүйгээр төлөвлөгдсөн байх боловч барилга угсралтын үе шатанд тухайлбал төлөвлөлтийн дагуу хийгдээгүй газар шорооны ажил болон барилгын талбайн эмх замбараагүй байдал нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай.

Барилга угсралтын ажлын явцад ажилчдын **хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)** нь шаардлага нь чухал ач холбогдолтой бөгөөд улмаар холбогдох хяналтын арга хэмжээ нь учир дутагдалтай байгаа тохиолдолд холбогдох хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй болох магадлалтай байдаг. Өөрөөр хэлбэл, холбогдох аюулгүй байдлын сургалтыг хангалтгүй хийх, мөн машин механизмын засвар үйл үйлчилгээг цаг тухайд нь хийж бүрэн бүрэн байдлыг хангаагүй тохиолдолд гэмтэж бэртэх цаашлаад хүний амь эрсдэх зэрэг осол аваар гарах шалтгаан болж болзошгүй юм. Үүнээс гадна, **Ковид-19** цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм сахиагүйгээс болж өвчлөл тархах эрсдэлтэй байна. Хөдөлмөрийн гэрээ, цалин хөлс, ажлын цагтай холбоотой **хөдөлмөрийн нөхцөл тааруу байх** нь ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Барилга угсралтын ажлыг төлөвлөлтийн дагуу хийхгүй тохиолдолд **орон нутгийн иргэдийн олон нийтийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн** байдалд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, төслийн талбай дах аюулгүй ажиллагааны зарчим алдагдах, жишээлбэл барилга угсралтын ажил явагдаж байгаа талбайн аюулгүй байдлыг ханган ажиллаагүй, эсвэл гүйцэтгэгч нь хатуу хог хаягдал болон ахуйн бохир усыг зохих шаардлагын дагуу зайлуулахгүй байх зэргээс болж нөлөөллийг үзүүлнэ. Тухайн ажлын

нөхцөл байдал тодорхойгүйгээс үүдэн гаднаас ирсэн ажилчид санаатай болон санамсаргүй алдааг гаргах боломжтой байдаг.

Барилга угсралтын ажлын үед **тээврийн хөдөлгөөн** нэмэгдэж улмаар осол аваар гарах эрсдэлийг нэмэгдүүлэх, мөн барилгын материал тээвэрлэх машины хөдөлгөөнөөс хамаарч зам түүний дэд бүтцийн элэгдэл, эвдрэлд нөлөөлөх магадлалтай.

4.4 Хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой нийгмийн эрсдэл

Сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд хэд хэдэн ТХГН-ийг өргөтгөж улмаар тэдгээрийн нөөцийн ашиглалтад шинэ хязгаарлалтуудын авсан ба үүнээс тав ТГХН нь төслийн кластер нутаг дэвсгэрт оршиж байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Энэхүү шинэчилсэн хамгаалалтын арга хэмжээнээс үл хамаарч уламжлалт эдийн засгийн үйл ажиллагаа нь тухайн орчны байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, мөн хүн амд сөрөг нөлөө үзүүлэхгүй бол хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн байдаг. Үүний нэг жишээ нь бол байгалийн нөөц газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах эрх юм.

"Уламжлалт" үйл ажиллагаанд тооцогдохгүй бусад үйл ажиллагаа нь биологийн олон янз байдлыг хамгаалах, мөн доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хязгаарласан байдаг бөгөөд энэ нь нөгөө талаас байгалийн нөөцийг ашиглагчийн амьжиргааг хязгаарлах болно. Эдгээр асуудлууд энэхүү таван ТХГН-ийн үйл ажиллагаанд авч үзэх шаардлагатай юм. Хамгаалалтын тэргүүлэх чиглэлийг тодорхой газар нутгуудын ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгахын зэрэгцээ бууруулах арга хэмжээний хамт тусгана.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд кластер нутгууд болон байгалийн нөөц газарт сонгогдсон 10 байршилд бэлчээрийн даац хэтэрсэн газрыг нөхөн сэргээж сайжруулах, мөн тогтвортой менежментийг дэмжих зорилгоор одоогийн бэлчээрийн ашиглалтын хэв маягийг өөрчлөн сайжруулахыг зорьж байгаа болно.

Бэлчээрийн доройтлын гол шалтгаан нь бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглах явдал бөгөөд, ялангуяа орон нутгийн нутгийн малчдын бэлчээр ашиглалт, мөн нүүдлийн буюу отрын малчид жилийн тодорхой хугацаанд бэлчээрийн газрыг давхар ашигладаг нь тухайн бэлчээрийн даац хэтрэхэд нөлөөлж байна.

Байгаль орчин, нийгэм болон эдийн засагт үзүүлэх нөлөөллийн олон талт хувилбаруудын үнэлгээг багтаасан бэлчээрийн нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тэргүүлэх ач холбогдолтой газрууд болон сонголтуудыг авч үзнэ. Үүнээс гадна, төслийн холбогдох үнэлгээгээр чухал нөөц газрыг нөхөн сэргээх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ойн сан бүхий газар болон орон нутгийн ТХГН-ийн менежментийн арга хэмжээ нь хязгаарлалтыг үүсгэх боломжтой юм.

Газар ашиглалт болон нөөцийн хязгаарлалтын арга хэмжээ нь **орлогын шууд буурах** замаар **амьжиргааны хэлбэрт сөргөөр нөлөөлж** болохоос гадна **уламжлалт мал маллах амьдралын хэв маягт нөлөөлдөг**. Үүний үр дагавар нь **харилцан адилгүй** байж болох бөгөөд энэ нь ялангуяа цөөн тооны малтай малчдын амьжиргаанд аливаа шинээр авагдсан хязгаарлалтын гол нөлөөлөл нь илрэх эрсдэлтэй. 1 болон 2-р кластер нутагт дах Тува, Урианхай болон Дөрвөд ястны бүлгүүд нь казах хэлээр ярьдаггүй тул эдгээр ястнууд нь мэдээллийг олж авах, мөн төслийн үйл ажиллагаанд оролцоход хүндрэлтэй байж болзошгүй тул эмзэг бүлгийнхэнд тооцогддог. Эдгээр ястнууд нь Баян-Өлгий аймгийн бүх сумуудад болон Ховд аймгийн Ховд сумдад цөөнх бөгөөд одоо байгаа засаглалын бүтцэд төлөөлдөггүй юм.

Хязгаарлалт өөрөөр хэлбэл энэхүү хязгаарлалтын бүсэд дэх нөөцийн хүртээмжээс хамааралтай орон нутгийн иргэдийн амьжиргаанд нөлөөлөхөөс гадна ядуурлыг нэмэгдүүлэх улмаар эдгээр нөлөөлөлд өртсөн өрхүүдэд **сэтгэл санааны дарамт учруулдаг**. Үүнтэй холбоотой хүнсний тогтворгүй байдал, боловсролоос хоцрох, мөн гэр бүлийн зөрчилдөөн болон жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх зэрэг **нийгмийн доройтолд** орно. Нөөцийн ашиглалт болон хуваарилалттай холбоотой зөрчилдөөн үүсэж болзошгүй ба мөн төслийн хөрөнгө оруулалтаас үүдэлтэйгээр нэмэгдэж болзошгүй юм. Мөн үүнээс гадна засгийн газар, мөн нэмэлт хамгааллын арга хэмжээнүүд болон уламжлалт нөхөрлөлүүд буюу газрын даамал нарын хоорондын зөрчилдөөн багтана.

Бэлчээр менежментийн 10 загвар болон ойн менежментийн туршилтын хөрөнгө оруулалт нь дараах зүйлүүдэд нөлөөлөх боломжтой. Үүнд,

- Бэлчээрийн газрын зарим хэсгийг тодорхой хугацаанд чөлөөлөх талаарх гаргасан орон нутгийн шийдвэрийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн удирдлага болон малчдын хооронд зөрчил гарч болзошгүй байдалд.
- Зэрлэг ан амьтдыг нүүдэллэх чухал коридор нутгийг чөлөөтэй байлгах зорилгоор хадлангийн талбайг хашихыг хязгаарласантай холбоотой маргаан гарах байдалд.
- Бэлчээрийг сорчлон ашиглах буюу бэлчээрийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ авах үеэр туршилтын төсөлд хамрагдах малчид болон төсөлд хамрагдахгүй малчдын хоорондын зөрчилдөөн гарч болзошгүй байдалд.
- Менежментийн шинэ арга хэмжээний нөхцөлийн улмаас ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа явуулдаг газарт ойн дагалт баялгийг ашиглах, түлээ бэлтгэх зэрэгт ойн нөхөрлөл болон бусад хүмүүсийн хооронд зөрчилдөөн үүсэж болзошгүй байдалд.

Ой сан бүхий газар болон орон нутгийн ТХГН-ийг сайжруулахад чиглэсэн төслийн хөрөнгө оруулалт нь дараах зүйлүүдэд нөлөөлөх боломжтой. Үүнд,

- Шинэчилсэн менежментийн нөхцөлийн дагуу байгалийн нөөцийн ашиглалтыг хязгаарласантай холбоотой зөрчилдөөнд.
- Менежментийн шинэчлэлтэй холбоотойгоор малын өвөлжөө шинээр барих, мөн улирлын чанартай зусах, намаржих болон хаваржихыг хязгаарласнаас үүдэлтэй үүсэх зөрчилдөөн гарах.
- Дархан цаазат газрын онгон болон хамгаалалтын бүс дэх усны эх үүсвэрийг (байгалийн булаг, шанд) мал услахаас сэргийлсэн арга хэмжээ авснаас үүдэн ТХГН-ийн захиргаа болон малчдын хооронд үүссэн зөрчилдөөнийг нэмэлдэгдүүлэх³⁰.

³⁰ ТХГН-ийн гадна худаггүйгээс малчид гол болон хамгаалалтын бүсэд байгаа байгалийн рашааныг хууль бусаар ашигладаг. Иймд ТХГН-ийн захиргаа, сумдын удирдлагууд Төслийн хүрээнд орчны бүс болон бусад газарт уст цэг гаргахаар төлөвлөжээ.

5. Оролцогч талууд болон олон нийтийн оролцоог хангах

Энэхүү бүлэг нь төсөл хэрэгжүүлэгч, мөн бусад холбогдох байгууллага болон орон нутгийн иргэдийн хоорондын харилцааны үр дүнтэй байдлыг хангах төслийн олон нийтийн оролцоонд суурилсан аргагүйн талаар оруулав. Төслийн үйл ажиллагааны хүрээнд менежментийн төлөвлөлтийн гол оролцогч талуудыг хамруулсан орон нутгийн түвшний оролцоо, мөн хэрэгжилтийг орон нутгийн иргэдэд үр дүнтэй байлгах болон орон нутгийн болон уламжлалт хэв маягийг тусган авахын тулд үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг төлөвлөх, эрэмбэлэхэд орон нутгийн олон нийтийн оролцоог хангах гэсэн хоёр үндсэн арга замаар олон нийтийн оролцоог хангана. Төслийн хүрээнд олон нийтийн оролцоог хангахад дараах зарчмуудыг баримтлах ёстой. Үүнд,

- **Мэдээлэх:** тэнцвэртэй, үнэн зөв мэдээллийг түгээх замаар асуудлууд, хувилбарууд, боломжууд болон шийдлийн талаарх оролцогч талуудын ойлголтыг дэмжих.
- **Зөвлөлдөх:** Төслийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаануудтай холбоотой асуудлаар оролцогч талуудын санал хүсэлтийг хүлээн авах, мөн тэдний санаа зовоосон асуудалд анхаарал хандуулах болон хүсэл эрмэлзлийг сонгох.
- **Оролцоог хангах:** Оролцогч талуудтай шууд хамтран ажиллах замаар тэдний санаа зовнил, хүсэл эрмэлзлийг ойлгож улмаар хувилбаруудыг боловсруулахад харгалзан үзэх. Мөн оролцогч талуудын өгсөн санал, зөвлөмж нь эцсийн шийдвэрт хэрхэн туссан талаар буцааж мэдээлэх.
- **Эрх мэдэл олгох:** Хувилбаруудыг боловсруулах, мөн хамгийн тохиромжтой шийдвэрийг тодорхойлоход зэрэг үйл ажиллагаанд шийдвэр гаргахад оролцогч талуудын оролцоог хангах.

5.1 Орон нутгийн түвшний оролцоо

Орчны бүсийн менежментийн зааварчилгааны дагуу орон нутгийн түвшинд орчны бүсийн менежментийн зөвлөлүүд нь байгуулагдана. Ховд болон Увс аймгийн Засаг дарга нар орчны бүсийн менежментэд туслах үүрэг бүхий ажилтан болон багийн гишүүдийг баталж, ажиллуулна.

Орчны бүсэд түшиглэсэн арга нь ТХГН-ийн захиргаа, аймаг болон сумын захиргаа, орчны бүсийн зөвлөл, мөн аймгийн түвшний байгаль орчны байгууллагууд буюу аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний газар (АУЦУОШГ), Сав газрын захиргаа (СГЗ), болон Сум дундын ойн анги (СДОА) зэрэг тохируулагч агентлагуудын хамтын үйл ажиллагааг дэмждэг бөгөөд АУЦУОШГ нь байгаль хамгаалах, зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан хөдөөгийн хөгжлийн бодлогыг хариуцдаг.

Орчны бүсийн зөвлөл нь орчны бүсийн менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, мөн үйл ажиллагааг бусад орон нутгийн болон үндэсний хэмжээний санаачилгатай уялдуулах гол үүрэгтэй. Орчны бүсийн менежментэд оролцогч гол оролцогч талуудын тоймыг Хавсралт 13-т оруулсан болно.

5.2 Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулах аргачлал

Төслийн үйл ажиллагаа нь нүүдлийн малчдыг багтаасан орон нутгийн иргэдийн шууд оролцоо эсвэл тэдгээрт нөлөөлж байгаа тохиолдолд энэ бүлэгт заасны дагуу олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг бэлчээр, ой, орон нутгийн ТХГН-ийн туршилтын төслүүдэд (Бүрэлдэхүүн хэсэг 1) болон тогтвортой амьжиргааг дэмжих үйл ажиллагаа (Бүрэлдэхүүн хэсэг 2)-ны хүрээнд боловсруулах шаардлагатай бөгөөд үүнээс гадна орон нутгийн иргэдийн ашиг

сонирхол хөндөгдөх эсвэл төслийн үйл ажиллагааны нөлөөллийн бүс дэх орон нутгийн иргэдэд нөлөөлөх үйл ажиллагаанд дүн шинжилгээг хийх шаардлагатай үйл ажиллагаануудад давхар шаардагдана.

Орон нутгийн иргэд, нөхөрлөлийн гишүүдийн оролцоог хангаснаар байгаль хамгааллын талаар илүү их мэдлэг, ойлголтыг олж авах, мөн өмчлөл, хамгаалалтыг дэмжихийн зэрэгцээ асуудал тэдгээрийн шийдлийг тодорхойлоход туслахаас гадна тухайн бүс нутгийн амьжиргааны асуудал болон хөгжлийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангахад ихээхэн ач холбогдолтой. Төлөвлөлтийн үйл явцад олон нийтийн оролцоог маш сайн хангах нь тухайн бүс нутгийн байгалийн баялгийг өдөр тутам ашигладаг орон нутгийн иргэд болон төрийн албан хаагчдын хамтын менежментийн үйл явцыг сайжруулахад ихээхэн чухал юм.

Монгол Улсад байгаль хамгаалахад арга хэмжээнд олон нийтийн оролцоо нь хязгаарлагдмал байдаг тул төслийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийнхнийг дуу хоолойгоо хүргэх, мөн тэдгээрийг үйл явцад оролцох оролцоог хангахын тулд олон нийтийн оролцооны төлөвлөгөөг сайтар төлөвлөх ёстой. Олон нийтийн оролцоог ялангуяа одоогийн байгалийн нөөцийн ашиглалтад хязгаарлалт үүсэж болох газарт сайтар төлөвлөж хийх нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд улмаар амьжиргааг доройтуулж болох албадан хязгаарлалт болон нөлөөллийг байхгүй үүсгэхгүй байхын тулд олон нийтийн оролцооны илүү нарийвчилсан төлөвлөлтийг шаарддаг тул үйл ажиллагааны төлөвлөлтөд холбогдох мэдээллийг уялдуулан авч

Учир нь байгаль хамгаалах үйл ажиллагааг тодорхойлох явцад байгалийн нөөцийг ашиглах, нэвтрэхийг хязгаарлаж болзошгүй тул эдгээрийн хязгаарлалтын талаар орон нутгийн иргэд болон нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдтэй төслийн төлөвлөлтийн үе шатанд (өөрөөр хэлбэл, менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулахаас өмнө) аль болох эртхэн маш сайтар зөвлөлдөх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагааг тодорхойлж, төлөвлөхөөс өмнө оролцогч талуудыг оролцоог тодорхойлоход хяналт тавина. Оролцогч талуудын оролцоог тодорхойлох үйл явц нь оролцогч талуудын ашиг сонирхол, өртөх байдал болон тэдгээрийн үйл ажиллагаанд үзүүлэх боломжит нөлөөлөл зэргийг тодорхойлдог. Энэхүү дүн шинжилгээ нь оролцогч талуудтай харилцах стратегийг боловсруулахад чухал байхаас гадна олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулахад хамгийн анхны чухал алхам болдог.

Хязгаарлалт болон зөвшөөрөлтэй холбоотой тусгайлсан арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд оролцогч талуудын оролцоог тодорхойлох үйл явцад нөлөөлөлд өртөж болзошгүй болон эсвэл ашиг сонирхол нь хөндөгдөх оролцогч талуудыг хооронд ялгах шаардлагатай болдог. Аль ч бүлгийн хүрээнд буюу нөлөөлөлд өртөж болзошгүй болон эсвэл ашиг сонирхол нь хөндөгдөх оролцогч талуудад хамрагдсан ч бай эмзэг байдлаасаа хамаарч тусгай нөхцөл шаардлагатай хувь хүн, иргэдийг тодорхойлж тэдгээрийн оролцоог хангасан эсэхийг заавал баталгаажуулна (жишээлбэл хэлний бэрхшээл³¹, хөгжлийн бэрхшээл, алслагдсан байдал, олон нийтийн хуралд оролцоход цаг

³¹ Халх Монгол хэл нь төрийн албан ёсны хэл бөгөөд бүх шатны төрийн захиргааны байгууллага, сургалтын байгууллагын үндсэн хэл юм. Гэвч Казак ястны зарим бүс нутгийн хөдөөгийн хүн амын 20 хүрэхгүй хувь нь Монгол хэлээр ярьдаг болох нь тогтоогдсон. Тиймээс Казак үндэстэн суурьшсан бүс нутгуудад иргэдийн оролцооны үл ажиллагаанд Казак хэлээр ярьдаг хүмүүст хүртээмжтэй байх нь чухал юм.

хомс гэх мэт). Хүснэгт 10-д олон нийтийн оролцооныг сайтар төлөвлөхөд шаардлагатай оролцогч талуудын оролцооны байдлын жишээг харуулав.

Хүснэгт 10. Оролцогч талуудын оролцооны байдлын жишээ

Оролцогч тал	Онцлог шинж чанар	Ашиг сонирхол	Хязгаарлалт	Хэл	Мэдэгдэл	Нэмэлт хэрэгцээ
Бага насны хүүхэдтэй эмэгтэй	А тосгонд 27 өрх, Б тосгонд 32 өрх	Орлого нэмэгдүүлэх боломж, боловсролын хүртээмж, нийгмийн халамж, Овоог хамгаалах	Иргэдийн амьжиргаанд нөлөөлөх ямар нэг хязгаарлалт байхгүй ч Овоо руу нэвтрэх эрхийг баталгаажуулах ёстой.	Казак	Жагсаалтад үндэслэн цахим шуудан болон мессежээр мэдэгдэх	Олон нийтийн уулзалтын үеэр хүүхэд харах ажлыг зохион байгуулах, уулзалтыг үд дунд хийх нь дээр
Харчин өрхүүд	ТХГН газар нутгийн зэргэлдээ кластерт 52 өрх	Уламжлалт ахуй соёлоо хадгалан авч үлдэх, бэлчээрийг хамгаалах, Овоог хамгаалах	29 өрх мал малладаг бөгөөд өвөлжөө нь ТХГН-ийн, онгон бүсэд хамаардаг	Харчин хэлний орчуулагч хэрэгтэй	Харчин ахлагчаар дамжуулан 10 хоногийн өмнө мессеж түгээнэ.	Тээвэрлэлтээр хангах шаардлагатай.

Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөө нь доорх Хүснэгт 11-д тусгасан загварын ашиглан үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн оролцоог төлөвлөхийн тулд оролцогч талуудын холбогдох мэдээллийг сайтар ашиглах ёстой. Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай. Үүнд,

- Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллагын үүрэг хариуцлага
- Олон нийтийн хэлэлцүүлэг болон мэдээллийг ил тод болгох нь үйл ажиллагаа нь үр дүнтэй байдлаар (уулзалтын жендэрийн байдлыг сайтар хангах, үр дүнтэй арга хэмжээ гэх мэт) төлөвлөгдөж байгаа эсэхийг баталгаажуулахад чиглэнэ. Мөн энэ нь энэ нь оролцогч талуудад мэдээлэл авах боломжийг аль болох эрт олж авах мөн үйл ажиллагааны талаар оролцогч талуудтай үр дүнтэйгээр хэлэлцэх, зөвлөлдөх боломжийг хэрхэн хангах талаар боломжит арга замыг тодорхойлох нь чухал юм.
- Хэлэлцүүлэг болох хугацаа, газар, мэдэгдэл болон холбогдох баримт бичиг.
- Холбогдох төсөв.

Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөө нь зааварчилгааны үйл явцын нэг хэсэг байх ёстой. Энэ тохиолдолд олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөө нь байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм болон байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын нэг хэсгийг бүрдүүлнэ.

Хүснэгт 11. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний загварын жишээ

Оролцогч талууд	Хэлбэр	Урьдчилан таамагласан давтамж	Сэдэв
Бэлтгэл ажил, төлөвлөлт			
Боломжит оролцогч талууд	Радио нэвтрүүлэг (орон нутгийн мэдээ)	2 удаа (ОГНОО)	Үйл ажиллагааны хүрээнд оролцох боломжууд

Оролцогч талууд	Хэлбэр	Урьдчилан таамагласан давтамж	Сэдэв
Олон нийтийн зөвлөл	Олон нийтийн оффисууд	Төлөвлөлтийн үйл явцад хоёр удаа (огноо)	Үйл ажиллагааны төлөвлөлтийн сонголтуудын танилцуулга. Тосгоны хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлэг
Санал болгож бүсийн айл өрх	Олон нийтийн танхимын хурал	Анхны уулзалт, хүлээгдэж буй үр дүнг дагаж мөрдөх.	Хүлээгдэж буй нөлөөллийн тойм. Газар ашиглалтын зураглал болон болзошгүй хязгаарлалт
Байгаль орчны ТББ	Үйл ажиллагааны оффис	Сар бүрийн уулзалтууд	Газар зохион байгуулалтын чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөх. Хүлээгдэж буй байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийн талаарх санал хүсэлт.
Шаардлагатай бол аль болох олон мөр нэмнэ үү			
Барилга/ашиглалт			
Тосгон хөгжүүлэх зөвлөл	Тосгон хөгжүүлэх зөвлөлийн оффис	Сардаа нэг удаа	Нөхцөл байдал болон үйл явцын мэдээлэл
Нөлөөлөлд өртсөн өрхүүд	Олон нийтийн танхимын хурал	Барилгын угсралтын ажлын үед сар бүр	Орсон өөрчлөлт, үлдсэн хугацаа, хүлээгдэж буй нөлөөлөл, гомдол барагдуулах механизм болон санал хүсэлт
Шаардлагатай бол аль болох олон мөр нэмнэ үү			

Төслийг хэрэгжүүлэх нэгж нь бүх оролцогч талуудын санал хүсэлтийг авч, бүртгэх ёстой. Хүснэгт 12-д санал хүсэлтийн жишээ загварыг үзүүлэв. Шууд хариу өгөх боломжгүй тохиолдолд төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын ажилтан санал хүсэлтийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор холбогдох хариу өгөх шаардлагатай.

Хүснэгт 12. Санал хүсэлтийн загвар

Санаа зовоосон асуудал/санал	Оролцогч талууд	Төслөөс ирэх хариу
Хөдөө аж ахуйн ажлын улмаас хүн хүч хүрэлцэхгүй байж болзошгүйг Төсөл анхаарч үзэх хэрэгтэй	Тосгоны төлөөлөгчид	Үйл ажиллагааны хуваарийг зургадугаар сараас наймдугаар сарын хооронд барилга барихгүй байхаар тохируулна
төсөл нь ус хамгаалах байгууллагад бүртгүүлэх шаардалаг	Дүүргийн төлөөлөгчид	Захиргааны хариуцсан байгууллага хурал зохион байгуулан ус зайлуулах зөвшөөрөл олгосон.
Шаардлагатай бол аль болох олон мөр нэмнэ үү		

Төсөл болон төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэгч нь төслийн төлөвлөгөө, үйл ажиллагааны талаар зөвлөлдөх үед дараах мэдээллийг хуваалцана:

- Үйл ажиллагааны зорилго, мөн чанар, цар хүрээ

- Тухайн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа
- Үйл ажиллагааны бүх болзошгүй эрсдэл, нөлөөлөл (техникийн бус хураангуй), нөлөөллийг бууруулах арга хэмжээ, эмзэг болон хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн хүмүүст харьцан адилгүй нөлөөлж болзошгүй эрсдэл болон нөлөөллийг тодруулан тайлбарлах, мөн нөлөөллөөс зайлсхийх, бууруулахын тулд авсан яалгаатай арга хэмжээнүүдийг тайлбарлах.
- Оролцог талуудын оролцоог хангах арга замыг санал болгож буй олон нийтийн оролцоог хангах үйл явцад тодорхойлон тусгах
- Гомдол гаргах, шийдвэрлэх арга замыг тусгах
- Төлөвлөж буй олон нийтийн хэлэлцүүлэг болох хугацаа, байршил, мөн, хурлын талаар мэдээлэх, нэгтгэн дүгнэх болон тайлагнах үйл явцыг тусгах.

Техникийн бус хураангуй нь хамгийн багадаа дээр дурдсан асуудлуудыг тусгасан байх ба төслийн оролцогч талууд болон олон нийтэд нээлттэй байх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх олон нийтийн хэлэлцүүлгийг баримтжуулж улмаар төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хуваалцах ёстой. Энэхүү баримт бичигт оролцогчдын жагсаалт, гол асуудлууд болон төслийн менежментийн үйл ажиллагаанд нэгтгэгдэх шаардлагатай асуудлуудыг багтаасан байх ёстой.

Барилга угсралтын ажлыг төслийн гүйцэтгэгч нь хийж байх үед төсөл хэрэгжүүлэгч нэгж болон төслийн гүйцэтгэгч байгууллагад хамгийн багадаа дараах шаардлагууд тавигдана. Үүнд,

- Шийдвэр гаргагч болон олон нийтийн төлөөлөгчдөд өөрсдийгөө танилцуулах
- Ажилд авах үйл явцыг ил тод, ялгаварлан гадуурхалгүй байлгах ёстой бөгөөд үүнд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад бүлгийг ажиллах хүчинд хамруулах арга хэмжээг тодорхой болгох
- Ажлын үргэлжлэх хугацаа болон хуваарийн талаар мэдээлэл өгөх
- Шаардлагатай ажиллах хүчний талаар мэдээлэл өгөх
- Олон нийтийн холбогдох дэд бүтцийг ашиглах, мөн нэвтрэхэд холбогдох хүсэлтийг гаргах.
- Барилга угсралтын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн талаарх мэдээлэл өгөх
- Төслийн санал хүсэлт болон гомдол барагдуулах механизм талаарх мэдээлэл, хэрхэн санал хүсэлт болон гомдол гаргах талаарх мэдээлэл өгөх

5.3 Гомдол болон санал хүсэлт хүлээн авах механизм

Тус тайлангийн 2 дугаар бүлэгт тодорхойлсон гомдол, маргаантай холбоотой эрсдэл зэргийг харгалзан үзэж улмаар гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх, тэдгээрт хариу өгөх үйл явцтай холбоотой төслийн хүрээнд авагдах механизм нь Монгол Улсын албан ёсны шаардлагад нийцсэн байхын зэрэгцээ аливаа гомдол, маргааныг аль болох анхан шатанд нь үр дүнтэй шийдвэрлэх боломжийг хангасан байх ёстой.

Санал хүсэлт болон гомдол хүлээн авах үйл явцыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд,

1. Төслийн холбогдох мэдээлэл, гомдол барагдуулах механизм, мөн үүнээс гадна байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого болон төслийн техникийн бус хураангуй мэдээлэл болон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг олон нийтэд илд тод, хүртээмжтэй байлгах.

2. Оролцогч талуудын оролцоог хангах, ялангуяа төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг олон нийтийн оролцоонд суурилсан төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцуулах, тухайлбал төслийн тодорхой үйл ажиллагаатай холбоотой санал, асуудал, тэдгээрийг шийдвэрлэх боломжтой үйл ажиллагаанд оролцох боломжийг хангах.
3. Төслийн ажилтнууд улс, аймаг, орчны бүс нутаг болон анхан шатны түвшинд төслийн холбогдох мэдээлэл, мөн гомдол барагдуулах механизмын талаарх мэдээллүүдийг түгээх, ил тод байлгах үүрэгтэй.
4. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед ирсэн гомдлыг бүртгэх, баталгаажуулах, тайлагнах хариуцлагыг ажилтнуудын ажлын даалгаварт тусгаж, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж хариу арга хэмжээ авах зорилгоор төслийн хурлаар тогтмол хэлэлцэнэ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995) нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, мөн гаргасан өргөдөл, гомдлын хариуг авах эрхтэй.

Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ (Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16.1-р зүйл).

Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдлын талаарх шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдол гаргах эрхтэй. Гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана (Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 17-р зүйл).

Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын холбогдох албан тушаалтан нь өргөдөл, гомдлыг барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй бөгөөд салбар хариуцсан сайд болон аймгуудын Засаг дарга нар нь хуульд заасан чиг үүргийн дагууд хамаарах асуудлаар өргөдөл, гомдлын эцсийн хариуг өгч болно. Холбогдох төрийн байгууллагууд болон албан тушаалтан нь харьяаллын дагуу өргөдөл гомдлыг хүлээн авч, гомдолд дурдсан асуудал бүрийг судалж, үндэслэл бүхий шийдвэр гаргах, хянан шийдвэрлэсэн гомдлын талаар харьяа болон анхан шатны байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хянах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан шийдвэрлэсэн гомдлын талаарх мэдээллийг тогтмол мэдээлэх (хувь хүний гомдлын нууцыг хадгалах) үүрэгтэй.

Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно. Байгууллага бүр цахим хаягтай байна (Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 9.1-р зүйл).

Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй

бол бусдаар төлөөлүүлэн зурж болно (Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10.1-р зүйл).


Эдгээр журамд хандах эрх нь үнэ төлбөргүй бөгөөд гомдол гаргагчийн эрхийг хуулиар хамгаалдаг. Тухайн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх явцад гомдол гаргагчид дарамт шахалт үзүүлэхгүй, эрх тэгш, шударгаар хандах хэрэгтэй. 1995 оны Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол барагдуулах механизмаас гадна 2002 оны Иргэний хуульд зааснаар иргэд хууль ёсны эрхээ хамгаалахын тулд засгийн газрын эсрэг хуулийн дагуу арга хэмжээ авах, төрийн байгууллагаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах зэрэг бусад асуудлаар эрхээ эдэлж байна.

Төслийн хүрээнд төрийн байгууллагуудтай холбоотой асуудал төслийн хэрэгжилттэй холбоотой үүсэж болох бөгөөд энэ нь төсөлтэй холбоотой гомдлыг төрийн захиргааны байгууллагын аль ч түвшинд гомдол гаргагч гаргаж болох ба тухайн гомдлыг шийдвэрлэхийн тулд одоо байгаа үндэсний гомдлыг барагдуулах механизмд тулгуурлана.

Орон нутгийн хэмжээнд ирсэн гомдлыг тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа болон сумдын засаг даргын тамгын газарт хүргүүлнэ. Хэрэв гомдлыг орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх боломжгүй бол БОАЖЯ (тухайлбал, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн дээд байгууллага)-д эсвэл аймгийн засаг даргын тамгын газарт (сумдын засаг даргын тамгын газрын асуудал эрхэлсэн дээд байгууллага) -д хүсэлт гаргаж болно. Хэрэв гомдлыг аймаг болон БОАЖЯ-ны хэмжээнд шийдвэрлэх боломжгүй бол төслийн үйл ажиллагааг хариуцсан БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад шилжүүлж болно (Зураг 8-ыг харна уу).

Гэсэн хэдий ч энэхүү гомдол барагдуулах механизм нь төслийн хүрээнд гарч болзошгүй асуудлуудын тодорхой хэсгийг хамардаг бөгөөд төслийн хүрээнд төрийн байгууллагуудтай холбоогүй харин төслийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх асуудлуудыг Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 10-ийг дагуу авч үзэх шаардлагатай болно. Тиймээс төслийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх санал хүсэлт, гомдлыг эхлээд төсөл хэрэгжүүлэгч нэгжид шууд гаргаж болно. Хэрэв төсөл хэрэгжүүлэгч нэгж нь гомдлыг шууд хүлээн авах тохиолдолд дараах үйл явцын хүрээнд явагдана.

- Гомдол нь сум, аймгийн түвшний албан тушаалтны бүрэн эрхэд хамаарагдах төслийн үйл ажиллагаатай холбоотой бол төсөл хэрэгжүүлэгч нэгж нь гомдлыг холбогдох албан тушаалтанд шилжүүлж, төрийн гомдлыг барагдуулах системд оруулах ба төсөл хэрэгжүүлэгч нэгж нь уг гомдлыг хүлээн авсны гомдол барагдуулах механизмын баримт бичгийн системд бүртгэж, улмаар авсан арга хэмжээний талаар гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.
- Гомдол нь 1995 оны хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүрэн эрхэд хамаарагдах төслийн үйл ажиллагаатай холбоотой бол төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульч нь шударгаар, мөн гомдлыг нарийвчилсан судалж үнэлгээ хийсний дараа 30 хоногийн дотор бичгээр хариу өгнө. Хэрэв гомдлыг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хэмжээнд шийдвэрлэх боломжгүй бол төслийн үйл ажиллагааг хариуцсан БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад шилжүүлж болно.



Зураг 8. Төслийн гомдол барагдуулах механизм

Санал хүсэлт, гомдлыг хүлээн авах боломжийг хөнгөвчлөхийн тулд ТХГН, сум, аймаг, төсөл хэрэгжүүлэгч нэгж болон БОАЖЯ нь тус бүр нь гомдол хүлээн авах үүрэгтэй хуулийн хэлтсээс эсвэл төсөл хэрэгжүүлэгч нэгжээс хуульчийг томилон авах хэрэгтэй. Томилогдсон хүний нэр, холбоо барих хаягийг ТХГН-ийн захиргааны байр, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байр, мөн аймаг болон сумын байгаль орчны албаны байрны гадаа мэдээлэх хуудас болон төслийн цахим хуудас (www.bacsr.mn)-д үйл ажиллагааны журмын тайлбарын хамт байршуулж нийтэд мэдээлнэ.

Хүлээн авсан гомдол, тэдгээрийн хариу арга хэмжээний талаарх тайланг сар тутмын тайлангийн хамт төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульч болон байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэнд хүргүүлэх ба хүлээн авсан бүх гомдол, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг улирал тутмын тайлангийн хамтаар төслийн удирдах хороогоор хянуулж тайлагнана.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульчийн хөтөлдөг дотоод, нууц бүртгэл нь гомдлыг хүлээн авсан он, сар, өдрийг бүртгэж, баримтжуулна харин гомдлыг судалж буй төслийн ажилтнууд нь гомдол гаргагчийн нэр, холбоо барих хаяг (нэрээ нууцалсан тохиолдолд), гомдол, гомдлыг барагдуулахын тулд хариуцсан ажилтнуудын хийсэн ажил, гомдлыг шийдвэрлэхэд санал болгож буй шийдлийн арга хэмжээ болон гомдол гаргагчид хариуг илгээсэн он сар өдрийг албажуулна.

Төслийн хүрээнд хүртээмжийг хязгаарлах үйл ажиллагаатай холбоотойгоор төслийн шийдвэртэй гомдол гаргагч нь санал нийлэхгүй байгаатай холбоотойгоор гомдол гаргагч нь хуулийн үйлчилгээ авсан бол төсөл нь энэхүү хуулийн зөвлөлтэй холбоотой зардлыг төлөх үүрэгтэй.

6. Төслийн хүрээнд соёлын өвийн талаар баримтлах бодлого

Төслийн хүрээнд орон нутгийн иргэд болон холбогдох ажилтнуудтай ярилцах, зөвлөлдөх замаар чухал ач холбогдолтой газруудыг урьдчилан тодорхойлон авч улмаар бүх биет болон биет бус соёлыг өвийг хамгаалах болно. Олон нийттэй чухал ач холбогдол бүхий биет бус газруудын талаар зөвлөлдөх нь маш чухал алхам юм. Монгол Улсад гадаадын иргэд төдийлөн мэдээд байдаггүй олон овоо байдаг бөгөөд эдгээр нь соёлын өвтэй чухал холбоотой юм. Овоо нь 2017 онд ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвийн жагсаалтад чухал ач холбогдолтой газруудаар бүртгэгдсэн байдаг. Овоо нь тахилга хийхэд ашигладаг бөгөөд тэнгэр, газар, уулс, байгальтай холбон шүтдэг юм. Иймд, төслийн арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд чухал ач холбогдол бүхий газруудыг тодорхойлох шаардлагатай юм.

Төслийн үйл ажиллагааны үеэр газар шорооны ажил, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг хийхэд санамсаргүй олдворын үйл ажиллагааны журмыг төслийн талбайд ажиллах ажилчдад сануулах мөн худалдан авах арга хэмжээнд тусгах шаардлагатай. Гол зорилго нь түүхийн дурсгалт газар, үлдэгдэл, эд зүйл зэрэг аливаа өвийн олдворыг хадгалж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэдэг. Олдвор илэрсэн тохиолдолд БОАЖЯ, Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгээс авран хамгаалах шаардлагатай үйл явцын талаар зөвлөгөөг өгөх хүртэл олдворын илэрсэн талбайн хэсэгт ажлыг бүрэн зогсоох ёстой.

Төсөл хэрэгжүүлэгчид, мөн төслийн гүйцэтгэгч нарт төслийн талбай дээр ямар нэгэн олдвор илэрсэн тохиолдолд ямар арга хэмжээг авах талаар зааварчилгаа өгөх зорилгоор санамсаргүй олдворын журмыг Хавсралт 12-т оруулсан болно.

7. Хөдөлмөрийн менежментийн талаар баримтлах бодлого

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон журам нь хөдөлмөрийн нөхцөлийн өргөн хүрээг хамрахын зэрэгцээ эрх тэгш, аюулгүй ажлын байрыг шаарддаг бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын шаардлагыг дагаж мөрдөх үүргийг хүлээдэг (хуулийн шаардлагуудыг хянаж, Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжтай нийцүүлэн Хавсралт 14т оруулсан байна). Хүүхдийн болон албадан хөдөлмөр эрхлэлтийг зөвшөөрөхгүй бөгөөд ажлын байран талаарх гомдол гаргах, зохион байгуулах эрхийг хангах ёстой.

Энэ бүлэгт дурдсан хөдөлмөрийн менежментийн заалтууд нь төслийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдах бүх ажил эрхлэлт, мөн олон нийтийн сайн дурын ажилд хүртэл хамрагдана³². Өөрөөр хэлбэл, гэрээт төслийн гүйцэтгэгч байгууллагын гэрээт ажилчид, туслан гүйцэтгэгчид болон үйл ажиллагааны хөрөнгө оруулалтаар бий болсон ажлын байрнууд зэрэг орно.

Гэсэн хэдий ч төсөл нь ТХГН-ийн захиргаанд ажилладаг хэд хэдэн төрийн албан хаагчдад тулгуурлан үйл ажиллагаа явуулна. Энэ бүлэгт дурдсан эдгээр албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний шаардлагыг албан тушаал нь төсөлд шилжүүлэхээс бусад тохиолдолд өөрчлөхгүй.

Аюулгүй ажлын байр, олон нийтийн хамгаалалтыг хангахын тулд төсөл нь бүх ажил олгогчдоос эдгээр заалтыг танилцуулахыг шаардана. Өөрөөр хэлбэл, ажилчдын эрх, үүрэг, мөн тэдгээрийг аюулгүй байдлыг хангах ажилгүй ажиллагааны журмыг багтаахын зэрэгцээ энэ бүлэгт заасан төслийн ёс зүйн дүрэмд гарын үсэг зурсан байх ёстой.

7.1 Ялгаварлан гадуурхалгүй болон тэгш боломжийг хангах

Төслийн хүрээнд ажилд орсон бүх ажилчид буюу төслийн гүйцэтгэгчийн гэрээт ажилчид, тэдний туслан гүйцэтгэгчид нар ажиллаж байх хугацаанд тэгш боломжоор хангагдах, мөн, ижил төрлийн нөхөн олговор (тэтгэмжийг оруулаад)-ыг авдаг байх ёстой бөгөөд тэдний ямар ажил хийж байгаагаас үл хамааран сургалт хамрагдах, шагнагдах боломжтой байх ёстой. Ажлын байрыг олон нийтэд зарлаж байгаа тохиолдолд өргөдөл гаргагчдад өгсөн мэдээлэл нь тэгш боломжийн заалтуудыг агуулсан байх ёстой.

Ажил олгогчид Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн шаардлагын дагуу ажил эрхлэлт болон эдийн засгийн боломжуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангаж байгаагаа баримтжуулах шаардлагатай болно.

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төсөлтэй холбоотой бүх ажил олгогчид сайн дураар ажиллах ахмад настан нарт зориулсан ажлын байраар хангах ёстой. Жирэмсэн эмэгтэй болон гурваас доош насны хүүхэдтэй эцэг, эх нь жирэмсний болон хүүхэд асран хүмүүжүүлэх чөлөө авах эрхтэй. Ажил олгогч нь 50-иас дээш ажилтантай бол Монгол Улсын хуулийн дагуу бүх ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авахыг идэвхтэй эрэлхийлэх үүрэгтэй.

7.2 Хөдөлмөрийн нөхцөл, болзол

Төсөл, төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нь 18-аас доош насны хэнийг ч ямар нэгэн төрлийн ажилд ажиллуулахгүй байх ёстой бөгөөд үүнд сайн дурын ажилтнууд ч хамаарагдана. Сайн дурын ажилтнууд оролцож байгаа тохиолдолд ажил олгогч нь

³² Voluntary work contributions may form part of livelihood investments and will be permitted where such workers will enjoy subsequent benefits from activity investments (e.g., community greenhouses).

тэдгээрийн оролцоог хангахдаа ямар нэгэн албадан хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр сайн дурын үндсэн дээр ажиллаж байгааг баталгаажуулах хэрэгтэй.

Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд заасны дагуу ажилчдын эвлэлдэн нэгдэх эрхийг хангах ёстой. Ажилд орохоос өмнө ажил олгогч болон ажилчин хоёрын хооронд дараах дэлгэрэнгүй мэдээллийг авч, тохиролцсон байх ёстой бөгөөд ажилчинд хөдөлмөрийн холбогдох нөхцөл, болзолтой гэрээний хуулбарыг гаргаж өгөх шаардлагатай. Энэхүү дэлгэрэнгүй мэдээллийг сайн дурын ажилтнуудаас авах шаардлагагүй. Төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нар нь холбогдох баталгаажуулах бүртгэлийг хөтлөх шаардлагатай бөгөөд мөн гэнэтийн төлөвлөгдөөгүй шалгалтад бэлэн байх шаардлагатай. Ажилтан болон ажил олгогч талууд нь тухайн ажлын төрөлд хамаарах хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурах ёстой.

- Ажил олгогчийн нэр
- Ажилтны мэдээлэл
 - Нэр
 - Төрсөн он. сар. өдөр
 - Холбоо барих мэдээлэл
 - Иргэний үнэмлэхний баталгаажуулалт
- Орчны бүсэд амьдардаг эсэх (тийм/үгүй)
- Ажилд орсон он. сар. өдөр

Зөвхөн ажлын хөлс шаардлагатай тохиолдолд дараах зүйлсийг багтаана. Үүнд,

- Ажлын тайлбар (албан тушаал, хийх ажил үүрэг, ажлын нөхцөл /үүрэг хариуцлага)
- Ажлын цаг
- Туршилтын хугацаа
- Жинхлэх хугацаа
- Төслийн үйл ажиллагаа эсвэл ажил эрхлэлттэй холбоотой гомдлыг хүлээн авах талаарх мэдээллийг хүлээн зөвшөөрөх
- Ажлын байрны ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрөх (Хавсралт 9)
- Цалингийн мэдээлэл:
 - Цалин, хөлс
 - Төлбөрийн давтамж (сард хамгийн багадаа хоёр удаа)
 - Төлбөрийн төрөл
 - Холбогдох албан татварын суутал (татвар болон бусад)
- Ажлаас гарах тухай
- Холбогдох бусад тэтгэмж (тэтгэвэр, тээвэр, орон сууц, боловсрол, эрүүл мэнд).

Сайн дурын хөдөлмөр эрхэлж буй хүмүүст дараах зүйл хамаарна. Үүнд,

- Сайн дурын ажлын гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөх

7.3 Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Төслийн хүрээнд хийгдэж буй ажил нь ажилчдыг гэмтэл, өвчин эмгэг, зүй бус аюулд өртөхгүй байхын тулд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХАБЭА) арга хэмжээ авах шаардлагатай. ХАБЭА-н эрсдлийг тодорхойлох, хянах, бууруулах, багасгахад чиглэсэн тусгай арга хэмжээг тодорхойлох нь үйл ажиллагааг хянах, шалгах ажлын хүрээнд хийгдэх ёстой.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажлыг гүйцэтгэж байгаа ажилчдыг гэмтэл, өвчин эмгэг, ажлын байрны осол гэмтэл болон аюулаас сэргийлэхийн тулд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг авах шаардлагатай. Хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн эрсдэлийг тодорхойлох, хянах, бууруулах, багасгахад чиглэсэн төслийн үйл ажиллагааны хүрээнд авах арга хэмжээг тодорхойлох нь төслийн үйл ажиллагааны нэг хэсэг болох хянах, шалгах ажлын хүрээнд хийгдэх ёстой.

Төслийн гүйцэтгэгч нь ажлын байран дах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан мэргэжилтнийг тендерийн баримт бичигт оруулах ёстой бөгөөд туслан гүйцэтгэгч нарт хяналт тавих ёстой. Үүнээс гадна, төслийн гүйцэтгэгчийн тендерийн баримт бичигт тухайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө эсвэл байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагатай арга хэмжээнүүдийг тусгасан байх ёстой. Мөн төслийн гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тендерийн баримт бичигт үнийн саналаа тусгах, мөн төслийн талбайн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнүүдийг тусгана. Эдгээр тодорхойлсон шаардлагууд нь төслийн гүйцэтгэгчийн саналын техникийн үнэлгээг хийхэд ашиглана.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, мөн ослын мэдээлэх (дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн хэсгүүдэд оруулсан) зэрэг ажлын байрны аюулгүй байдлын талаар сургалт, хяналт тавих чадвартай байх ёстой. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь төсөл хэрэгжих талбайн үйл ажиллагааны менежментийг хариуцдаг тул бүх ирсэн зочдод талбай руу нэвтрэх дүрмийг танилцуулж байх ёстой. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь бүх ажилчдыг сургах, мөн дараах шаардлагуудыг тавих ёстой. Үүнд,

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдах
- Талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг сахин хамгаалах. тухайлбал, өөрийн болон бусад ажилчдын үйлдэл, эс үйлдлээс болж хохирч болзошгүй бусад ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг хамгаалах.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох бүх дүрэм, заавар, сургалт, хяналт, мөн аюулгүй байдлын бүхий л заавар зөвлөгөөг дагаж мөрдөх.
- Ажил олгогчоос өгсөн хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зориулалтаар өгсөн аливаа хэрэгслийг гэмтээх, буруугаар ашиглах, аливаа зүйлд хөндлөнгөөс оролцохыг хориглох.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдал, мөн аюулгүй байдлын арга хэмжээ нь эрсдэлтэй байгаа тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд даруй мэдэгдэх.
- Зөвхөн сургалтад хамрагдсан чиглэлд болон өөрийн гүйцэтгэх ёстой ажлыг л хийх.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, удирдамжийг хянах, ажилтнуудад болзошгүй аюулын талаар сэрэмжлүүлэх, эрсдэлийн шинэчилсэн үнэлгээ, эрсдэлийн дараах мэдээллүүдийг бүртгэх, эрүүл мэндийн тандалтын тодорхой зохицуулалтыг хийх, хувийн хамгаалах хэрэгслээр хангах, осол аваар болон ослын үед ажиллах журмыг тодорхой болгон баримтална.

Бүх ажилчдад өгсөн үүрэг, хариуцлагыг харилцан тэнцвэртэй байлгахын тулд аюулгүй байдлын сургалт болон давтан сургалтыг зохион байгуулах хэрэгтэй. Хувийн хамгаалах хэрэгслийг зайлшгүй ашиглах шаардлагатай ажилчид нь хэрхэн зөв ашиглах талаар холбогдох сургалтад заавал хамрагдсан байх ёстой. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуйн мэргэжилтэн нь ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах сургалтад хамруулсан болон ажилчдад хувийн хамгаалах хэрэгслийг хүлээлгэн өгсөн талаарх бүртгэлийг хөтлөх шаардлагатай.

Ахлах мэргэжилтэн болон 25 ажилтан тутмын нэгээс доошгүй ажилтан нь анхны тусламжийн сургалтад хамрагдсан байх ёстой. Анхны тусламжийн хайрцгууд хүртээмжтэйгээр байлгах, мөн шууд ашиглах болох газруудад байрлуулсан байх шаардлагатай. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь анхны тусламжийн хайрцгуудыг ашигласны дараа түүний бүрэн бүтэн байдлыг буюу холбогдох шаардлагатай хэрэгслээр ханган ажиллах шаардлагатай. Анхны тусламж үзүүлсэн тохиолдлуудыг бүртгэн авах шаардлагатай.

7.4 Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ

Ковид-19 халдвар авсан хүнээс тус халдвар нь агаар дуслын замаар цааш амархан халдварладаг тул төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд цаашид нөлөөлсөн хэвээр байх магадлалтай. Халдвар авсан олон хүмүүст халдварын шинж тэмдэг даруй илрэхгүй тул төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг бууруулахын тулд сайн туршлагыг нэвтрүүлэх замаар боломжит бүхий л урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Эрүүл мэндийн суурь асуудалтай болон 60 ба түүнээс дээш насны хүмүүст Ковид-19 халдвар авах эрсдэл өндөр байгаа тул төслийн үйл ажиллагааны хүрээнд эрсдэлт бүлэгт хамрагдах ажилчдыг тодорхойлох, мөн цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах шаардлагатай. Үүнд гэрээсээ удаан хугацаагаар ажиллах ажилчдын асуудал бас багтах ёстой.

Төслийн үйл ажиллагааны явцад Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын нөлөөлөл бага байлгахын тулд Монголын Улсын Засгийн Газраас цар тахлын үеийн дэглэмийг бууруулах арга хэмжээг авахын тулд энэхүү цар тахалтай холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх ёстой болно. Харилцаа холбоо, олон нийтийн оролцоо, мөн төслийн гүйцэтгэгчийн менежменттэй холбоотой нэмэлт шаардлагыг Хавсралт 4-д тусгасан болно.

7.5 Осол аваарыг бүртгэх үйл явц

Төслийн удирдлага, гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчид нь нийгэм, ажил эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй байдал болон байгаль орчны ослын талаарх мэдээллийг бүртгэх, тайланг хөтлөх үүрэгтэй бөгөөд цаашид аливаа эрсдэл давтагдахаас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авахад ихээхэн ач холбогдолтой. Осол аваарын талаарх нарийвчилсан бүртгэл, тайлан болон холбогдох судалгаа нь цаашид сайжруулах шаардлагатай анхаарах асуудлуудыг болон явцыг тодорхойлох боломжийг олгодог.

Төслийн гүйцэтгэгчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь сар бүрийн тайланг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэнд тогтмол гаргаж өгнө.

Мэргэжилтэн нь аливаа бага зэргийн осол асуудлыг он сар өдөр, байршлыг мөн холбогдох авсан арга хэмжээний хагас жил тутмын явын тайланг Германы сэргээн босголт, зээлийн банканд гаргах өгнө. Гэсэн хэдий ч төсөлтэй холбоотой аливаа ноцтой осол аваарын талаар мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэнд нэн даруй мэдэгдэх буюу тухайн үеийн анхан шатны мэдээллийг тусгаж, осол аваар гарснаас хойш 24 цагийн дотор аль болох түргэн мэдэгдэх

шаардлагатай. Улмаар холбогдох мэргэжилтэн нь энэхүү мэдээллийг 72 цагийн дотор Германы сэргээн босгол, зээлийн банканд дамжуулна. Осол аваарын бүртгэх талаарх нарийвчилсан журмыг Хавсралт 7-д тусгасан болно.

7.6 Төслийн гүйцэтгэгчийн ажилчдын ёс зүйн дүрэм

худалдан авалтын шаардлагын нэг хэсэг болох Төслийн үйл ажиллагааны хүрээнд төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нараас төслийн гүйцэтгэгчийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхийг шаарддаг. Төслийн гүйцэтгэгчийн ёс зүйн дүрэм нь байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын заалтууд болон бизнесийн шударга харилцааны гол асуудлуудыг хамардаг.

Төслийн гүйцэтгэгч нь ажилтнуудаа боловсруулсан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Төслийн гүйцэтгэгч нь нийцлийн үнэлгээнд зориулж ёс зүйн дүрмийг боловсруулан ирүүлэх эсвэл эсвэл Хавсралт 9-д заасан төслийн гүйцэтгэгчийн ажилтнуудад зориулсан төслийн ёс зүйн дүрмийг ашиглаж болно. Энэхүү ёс зүйн дүрэм нь төслийн гүйцэтгэгчийн харилцааны нэг хэсэг бөгөөд тус тайлангийн 7.2-т хэсэгт заасан нөхцөл, болзлын хүрээнд ажилчдыг ажилд авах үед гарын үсэг зурсан байх ёстой.

7.7 Ажлын байрны талаар асуудлыг дэвшүүлэх

Төслийн хүрээнд төслийн гүйцэтгэгчид болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчийн ажилчдад нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой санал хүсэлт, гомдол гаргах боломжийг олгох журамтай байх ёстой (өмнөх хэсгийг үзнэ үү). Энэ шаардлагыг худалдан авах ажиллагааны журмаар тогтооно. Ажилчид мөн гомдол барагдуулах механизмаар дамжуулан төслийн холбогдох мэргэжилтэнд санал хүсэлтээ өгч болно (дараагийн хэсгийг үзнэ үү).

Төслийн үйл ажиллагааны хүрээнд ажил олгогч гомдлыг үндэслэлтэйгээр шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Ийм хөдөлмөрийн маргааныг холбогдох шатны Засаг даргад уламжилж, хөдөлмөрийн маргаан таслах комисст хянуулахаар шилжүүлнэ. Засаг дарга болон маргаан таслах комисс асуудлыг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын давж заалдах журмаар явагдана.

Ноцтой осол гэдэг нь

Төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болохуйц аливаа нийгэм, ажил эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй байдал болон байгаль орчны осол аваар. Аливаа ажилтан эсвэл сайн дурын ажилчдад нь хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэдэг аливаа осол аваар. Ноцтой ослын тохиолдлууд буюу гал түймэр, асгаралт болон ажлын байрны осол зэрэг нь ноцтой буюу олон талт осол, их хэмжээний бохирдолд хүргэх байдал.

7.8 Харуул хамгаалалтын ажилтан

ТХГН-ийн хамгаалалтын алба хаагчид нь магадгүй эвдэн сүйтгэх, хил зөрчих болон зэрлэг ан амьтдыг хулгайгаар агнаж болзошгүй юм. Монгол Улсын хууль тогтоомж болон Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн шаардлагын дагуу аюулгүй байдлын ажилтнууд хүний эрх, нэр төрийг хүндэтгэх, хамгаалах болон хүч хэрэглэхийг тэвчих шаардлагатай. Ажилтан дараах үйлдлүүдийг хийж болохгүй.

- **Айлган сүрдүүлэх эсвэл дарамтлах.** Ажилтан нь өөрийн албан тушаал бол хамгаалалтын зориулалтай зэвсгээр олон нийт, иргэдийг айлган сүрдүүлэх, дарамтлах хэрэгсэл болгон ашиглаж болохгүй.

- **Үндэслэлгүй цагдан хорих.** Ажилтан нь хүмүүсийг ямар ч үндэслэлгүйгээр, эсвэл хүлээн зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд удаан хугацаагаар саатуулж болохгүй.
- **Зүй бус хүч хэрэглэх.** Ажилтан нь хүч хэрэглэн, эсвэл албадах процедурын журмаас гадуурх, эсвэл хууль бус шалтгаанаар (гэмт хэргийн сэдэлтэй үйл ажиллагаа гэх мэт)
- **Халдлага, эрүү шүүлт.** Ажилтан нь хоригдож буй хүнд халдаж, бие болон сэтгэл санааны хохирол учруулахыг хориглоно.

Хүснэгт 13-т тусгай хамгаалалттай газар нутагт хэрэглэгдэх саатуулах арга хэмжээнүүдийг нэгтгэн оруулав.

Хүснэгт 13. Аюулгүй байдлын арга хэмжээ

Идэвхгүй арга хэмжээ	
Хандалтын хяналт	Тусгай хамгаалалттай газар нутаг руу хууль бусаар нэвтрэх, нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хашаа, хаалга, тэмдэглэгээ, хяналтын систем.
Харагдах байдал	Орох, гарах хөдөлгөөний зохицуулахаар нэвтрэх цэгүүдийг ажилтнууд хянах, мөн ТХГН-ийг хэмжээнд эргүүлийн үүргийг гүйцэтгэж хараа хяналт тавих.
Ажиглаж, мэдээлэх	Ажилтан нь үйл ажиллагааг ажиглах, мэдээлэх, бүртгэх.
Идэвхтэй арга хэмжээ	
Амаар зааварчилгаа, сэрэмжлүүлэг, нэвтрүүлэх болон оруулахаас татгалзах	Аюулгүй байдлын ажилтан нь хамгаалалтын арга хэмжээг тойрч гарахыг оролдсон эсвэл заналхийлж буй хүмүүст амаар анхааруулга өгнө. Анхааруулгад нэмэлт хамгаалалтыг дуудаж байгаа тухай мэдэгдлийг агуулах хэрэгтэй.
Цагдан хорих	Аюулгүй байдлын ажилтан хууль бусаар нэвтрэсэн, хулгайн ан хийсэн гэж сэжиглэгдсэн хүмүүсийг экологийн цагдаа ирж, хариуцлага хүлээх хүртэл л саатуулж болно.
Хурцадмал байдал	
Амь насанд халдах (бие хамгаалах)	Галт зэвсэг авч явах зөвшөөрөлтэй хамгаалалтын ажилтнууд холбогдох хуулийн хүрээнд хүний амь насанд аюул заналхийллээс хамгаалахын тулд бие хамгаалах хамгаалах зорилгоор ашиглаж болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд (1994) байгаль хамгаалагч нь зэвсэг хэрэглэхийг тодорхойлсон байдаг. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн хэрэглэх зэвсэг, хэрэгслийн төрөл, тэдгээрийг хэрэглэх журмыг төрийн захиргааны төв байгууллага цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн тогтооно. Байгаль хамгаалагчид үүргээ гүйцэтгэж байхдаа дараах тохиолдолд зэвсэг хэрэглэж болно (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32 дугаар зүйл).

- байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд гэмт этгээд хохирол учруулж болзошгүй байдал бодитоор бий болсон;
- байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэрлэг амьтан довтолсон.

Аюулгүй байдлын ажилтан хүч хэрэглэх болон болон хүмүүсийг баривчлах тохиолдолд төслийн үйл ажиллагааны хүрээнд үүнийг осол аваарыг бүртгэх журмын дагуу бүртгэж авах шаардлага тавигдана.

8. Үйл ажиллагааны эрсдэлийн менежментийн удирдамж

Энэ бүлэгт төслийн үйл ажиллагааг тодорхойлох, бэлтгэх, батлах, хэрэгжүүлэх болон хяналт тавих үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд төслийн үйл ажиллагаанд хэрэглэх удирдамжийн хүрээнд байгаль орчин, нийгмийн асуудлуудыг зохих ёсоор тодорхойлж, шийдвэрлэх алхмуудыг тодорхойлсон байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх удирдамжийг тусгасан болно.

Байгаль орчин, нийгмийн сайн менежментийн гол зарчим бол аливаа үйл ажиллагааг төлөвлөхдөө эрсдэлийг бууруулах зарчмуудад үндэслэн үлдэгдэл нөлөөллийг урьдчилан тооцоолох, мөн зайлсхийх, багасгах, нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох болон зохицуулахад чиглэсэн байдаг. Төсөл боловсруулах үе шатанд үйл ажиллагааг төлөвлөх, ялангуяа орон нутагт хийгдэх төлөвлөхдөө байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын зарчмуудыг эртхэн хэлэлцэх, зөвлөлдөх үйл явц нь эрсдэл ба нөлөөллийн менежментийг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой анхны алхам болдог. Дараах гол зарчмууд нь төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүнийг удирдан чиглүүлдэг. Үүнд,

- Төслийн үйл ажиллагаанд бүхий үе шатанд олон нийтийн оролцоог маш сайн хангах ба үүнд, байгаль, нийгмийн менежментийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мөн санал хүсэлт, гомдол гаргах боломжийг хангасан байх шаардлагатай. Оролцогч талууд нь үйл ажиллагааны анхан шатны эрсдэл, нөлөөллийг тодорхойлоход оролцох эсвэл саналаа өгөх ёстой.
- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь байгаль орчин, нийгмийн нийцлийг шалгах ажлын хүрээнд тус тайлангийн 2 дугаар бүлэгт заасны дагуу санал болгож буй үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой эсэхийг баталгаажуулах ёстой.
- Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад төсөл нь төсөл хэрэгжих талбайн тусгайлсан менежментийн төлөвлөгөөний дагуу (хэрэглэх боломжтой бол) арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар байгаль орчин, нийгмийн бүрдэлдэхүүн хэсгийн аливаа үлдэгдэл эрсдэл болон нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг авч байх шаардлагатай.
- Төсөл хэрэгжих талбайн тусгайлсан менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийг бууруулах арга хэмжээг төслийн гүйцэтгэгчтэй холбоотой бүх худалдан авалтад тусгаж, үйл ажиллагааны төсвийн нэг хэсэг болгон холбогдох зардлыг хангалттай тусгасан шаардлагатай.
- Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад тодорхойлсон эрсдэл болон нөлөөллийг сайтар хянаж байх ёстой.

ТХГН-ийн болон орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг үзүүлэхгүй тул төлөвлөгөөнд дараах хэсгүүдэд заасан алхмуудын дагуу эрсдэлийн үнэлгээ хийхгүй. Гэсэн хэдий ч дээрх зарчмуудын дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь эрсдэлээс зайлсхийх, бууруулах талаар зааварчилгаа өгөхийн тулд боловсруулалтад оролцох ёстой. Төслийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлж байгаа бие даасан төлөвлөгөөний хүрээнд хийгдэх үйл ажиллагааг дараах 1-6-р алхмын дагуу хянан үзэх болно.

Хүснэгт 14-д төслийн үйл ажиллагааны төрөл болон тодорхойлсон эрсдэлээс хамаарч хэрэгжүүлэх үе шатуудын тоймыг харуулав³³. Төслийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ихэнх нь бага (-B) ангилалд багтах магадлалтай байна. Гэсэн хэдий ч мах боловсруулах болон захиргааны барилга байгууламжийн барилга угсралтын ажлын үе шатанд боломжит эрсдэл, нөлөөллийн цар хүрээ илүү их байх магадлалтай байгаа тул их (-B) ангиллын үйл ажиллагаанд хамрагдах боломжтой юм. Бэлчээрийн менежментийн загварууд болон ТХГН-ийн нөөцийн хамгаалах арга хэмжээнд тодорхой хязгаарлалтуудыг агуулдаг эдгээр нь байгаль орчинд хамгийн бага нөлөө үзүүлэх боловч малчдыг бэлчээр ашиглах боломжийг хэсэгчлэн хязгаарлах тул нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай болно.

Хүснэгт 14: Хүлээгдэж буй үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хэрэгжилтийн тойм

Үйл ажиллагаа	Төрөл	Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох	Бууруулах арга хэмжээ
Бага хэмжээний дэд бүтэц	Бага (-B)	Хавсралт 1-д байгаа байгаль орчин, нийгмийн анхан шатны дүн шинжилгээний загварыг ашиглаж гол асуудлуудыг тодорхойлох	Хавсралт 3-д байгаа байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэмтэй тодорхойлсон эрсдэл, нөлөөллийг уялдуулах
Баг, дунд хэмжээний дэд бүтэц	Их (-B)	Хавсралт 1 ба 2-т байгаа байгаа байгаль орчин, нийгмийн анхан шатны дүн шинжилгээний загварыг ашиглаж гол асуудлуудыг тодорхойлох	Тодорхойлсон эрсдэл, нөлөөлөлтэй уялдуулан Хавсралт 5-д байгаа байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах
Одоогийн нөөцийн ашиглалтыг хязгаарлах хамгаалалтын арга хэмжээ	B	Хавсралт 1 ба 2-т байгаа байгаа байгаль орчин, нийгмийн анхан шатны дүн шинжилгээний загварыг ашиглаж гол асуудлуудыг тодорхойлох	Хавсралт 6-ын дагуу Нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах

8.1 Алхам 1: Байгаль орчин, нийгмийн стандартын эрсдэлийн үнэлгээ болон нөлөөллийг бууруулах журмыг тусгах нь

Хүснэгт 15-д үйл ажиллагааны төрлөөс үл хамааран төслийн үйл ажиллагааны хүрээнд стандарт болгон баримтлах байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын журмыг тоймлон харуулав.

Хүснэгт 15. Төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын нэгдмэл байдал

Асуудал	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын холбоотой бүлэг
Олон нийтийн хурал/үйл ажиллагааны тодорхойлолт	Сонгох шалгуур, 2-р бүлэг Олон нийтийн оролцоо, 5.2-р бүлэг Гомдол, санал хүсэлтийг хүлээн авах журам, 5.3-р бүлэг
Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө/ үйл ажиллагааг тодорхойлох	Сонгох шалгуур, 2-р бүлэг Орчны бүсийн оролцогч талуудын оролцоо, 5.1-р бүлэг Гомдол, санал хүсэлтийг хүлээн авах журам, 5.3-р бүлэг

³³ Хүснэгт 6-д заасны дагуу: Үндэсний болон Германы сэргээн босголт, зээлийн банкны эрсдэлийн ангиллыг уялдуулах.

Асуудал	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын холбоотой бүлэг
Ажилчдыг ажиллуулах болон Төслийн ажилчид	Хөдөлмөрийн менежмент, 7-р бүлэг (бүх дэд хэсэг)
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох	Хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлага, 2-р бүлэг, Хавсралт 14 Олон нийтийн оролцоо, 5.2-р Бүлэг Соёлын өвийн журам, 6-р бүлэг
Осол аваар	Осол аваарыг бүртгэх журам, 7.5-р бүлэг, Хавсралт 7
Төслийн гүйцэтгэгчтэй гэрээ хийх үйл явц	Хөдөлмөрийн менежмент, 7-р бүлэг (бүх дэд хэсэг) Олон нийтийн оролцоо, 5.2-р бүлэг Соёлын өвийн журам, 6-р бүлэг Бага хэмжээний дэд бүтцийн хувьд: Германы сэргээн босголт, зээлийн банкны стандартын худалдан авах ажиллагааны баримт бичгийн VII хэсгийг байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлохтой уялдуулан тохируулах.

8.2 Алхам 2: Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн анхан шатны дүн шинжилгээ

Төслийн үйл ажиллагааг батлах ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгж болон байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь эрсдэлийн урьдчилсан ангиллыг гаргаж, улмаар үйл ажиллагаа бүрийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн анхан шатны дүн шинжилгээг хийнэ. Дунд зэрэглэлийн эрсдэлтэй үйл ажиллагаанд энэхүү анхан шатны дүн шинжилгээг Хавсралт 1 болон Хавсралт 2-д тусгасан маягт, шалгах хуудсыг ашиглан хийнэ.

Байгаль орчин, нийгмийн төлөвлөлтийг оновчтой болгохын тулд цаашид нэмэлт үнэлгээг хийхээс өмнө нь зайлсхийх эсвэл багасгах боломжтой аливаа нөлөөллийг тодорхойлох зорилгоор анхан шатны дүн шинжилгээг холбогдох техник эдийн засгийн үндэслэлтэй зэрэгцүүлэн хийж болно. Анхан шатны дүн шинжилгээний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь дараах зүйлийг тодорхойлох шаардлагатай. Үүнд,

- Үйл ажиллагааны мөн чанар, хамрах хүрээ.
- Шаардлагатай үйл ажиллагаа.
- Ашиглалтын үе шаттай холбоотой үйл ажиллагаа.
- Төслийг татан буулгахтай холбоотой төлөвлөсөн мэдээлэл.

Хавсралт 1 болон Хавсралт 2-д тусгасан маягт, шалгах хуудсыг төслийн үйл ажиллагаа явагдах газарт хээрийн судалгаа, ажиглалт хийж байгаль орчин, нийгмийн гол эрсдэлийг тодорхойлох үед ашиглана. Холбогдох мэдээллийг цуглуулах үйл ажиллагаа нь зөвхөн төсөл хэрэгжих талбайгаар хязгаарлагдахгүй бөгөөд тус талбайн эргэн тойрны газруудад хээрийн судалгаа ажиглалтыг хийх ёстой. Төслийн талбай болон төслийн үйл ажиллагаа явагдах газар нутагт мөн ойрхон оршин суудаг иргэн, олон нийттэй зөвлөлдөж холбогдох ярилцлагыг хийх нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн холбогдох үнэлгээнд ашиглах мэдээлэлд чухал эх сурвалж болдог.

Талбайн анхны шатны үнэлгээний явцад ямар нэгэн өндөр эрсдэл илэрсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төсөл хэрэгжүүлэгч агентлаг эсвэл Германы сэргээн босголт, зээлийн банкны байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал хариуцсан газрын мэргэжилтнүүдэд цаашид холбогдох арга хэмжээг авахын тулд нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

8.3 Алхам 3: Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн менежмент

Нөлөөллийн анхан шатны дүн шинжилгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагааны тусгай төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлийн ангиллыг ашиглана. Энэхүү ангилал нь Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийг дагаж мөрддөг бөгөөд холбогдох шаардлагууд нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай нийцсэн байна (Монгол Улсын холбогдох шаардлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 14-т тусгасан болно).

- **Ангилал С** хэсэгт хамрагдах үйл ажиллагаа нь нэмэлт нөлөөллийн менежментийг шаарддаггүй бөгөөд харин Хүснэгт 15-д заасан стандарт журмыг хэрэгжүүлэх шаардлагатай.
- **Ангилал В:**
 - Бага (-В) хэсэгт хамрагдах үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэмд заасан холбогдох стандарт эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэглэх шаардлагатай (нарийвчилсан шаардлагыг Хавсралт 3-т тусгасан болно).
 - Их (-В) хэсэгт хамрагдах үйл ажиллагаа нь төсөл хэрэгжих талбайн хэмжээнд хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай (дэлгэрэнгүй шаардлагыг Хавсралт 5-д тусгасан болно).
- **Ангилал В+** хэсэгт хамрагдах үйл ажиллагаа нь цаашдын хамрах хүрээг тодорхойлж, ерөнхий БОННУ боловсруулах шаардлагатай бөгөөд үүнийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Германы сэргээн босголт, зээлийн банкаар нь хянуулах ёстой.
- **Ангилал А** хэсэгт хамрагдах үйл ажиллагаа нь цаашид хамрах хүрээг тогтоох, нарийвчилсан БОННУ боловсруулах шаардлагатай бөгөөд энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Германы сэргээн босголт, зээлийн банкаар нь хянуулах ёстой. Гэсэн хэдий ч энэхүү төслийн хүрээнд ангилал А хэсэгт хамрагдах ямар ч үйл ажиллагаа зөвшөөрөхгүй бөгөөд санхүүжилт олгохгүй юм.

Ангилал С болон В-д хамрагдах үйл ажиллагаануудын холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь тодорхойлох болно. Ангилал В+ буюу түүнээс дээш ангилалд хамрагдахаар тодорхойлогдсон аливаа үйл ажиллагааны хувьд БОННУ (анхан шатны дүн шинжилгээний үр дүнгээс хамаарч ерөнхий эсвэл нарийвчилсан БОННУ)-г боловсруулах шаардлагатай бөгөөд тус БОННУ-г хийх зөвлөх багт зориулсан ажлын даалгаврыг бэлтгэнэ.

Төслийн үйл ажиллагааны анхан шатны дүн шинжилгээгээр байгалийн нөөцийн ашиглалт болон хүртээмжийн асуудалд хязгаарлалтыг үүсгэх тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тус тайлангийн 5 дугаар бүлэгт тодорхойлсон олон нийтийн оролцооны журмыг дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд мөн орон нутгийн эмзэг бүлэгт³⁴ үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд зохих арга хэмжээг тохиролцож, авах арга хэмжээнүүд нь зөвшөөрөгдсөн байдлаар олон нийтийн шийдвэр гаргах үйл явц нь хангалттай бөгөөд сайн дурын, мэдээлэлд тулгуурласан зөвшилцлийг тусгасан байдалд Германы сэргээн

³⁴ World Bank Environmental and Social Standard 5: Land Acquisition, Restrictions on Land Use and Involuntary Resettlement, footnote 9.

босголт, зээлийн банкны³⁵ тогтоосон шаардлагад нийцсэн үнэлгээ хийнэ. Энэ нь Хавсралт 6-д тусгасан нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал, удирдамжийн дагуу хийгдэнэ. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь дараах зүйлийг агуулах ёстой.

- Олон нийтийн шийдвэр гаргах үйл явцыг зохистой байлгах.
- Нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ялангуяа амьжиргааны эх үүсвэр болон түвшинд нь харилцан адилгүй сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй иргэн, өрхөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн холбогдох арга хэмжээг төслийн үйл ажиллагааны хүрээнд тодруулах.

8.4 Алхам 4: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг эрсдэл түүний нөлөөллийг жигд тодорхойлж бэлтгэсэн эсэхийг баталгаажуулах, мөн зөвлөх багын боловсруулсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд хяналт тавина. Ажилтнууд нь үйл ажиллагааны менежментийн салшгүй нэг хэсэг болох байгаль орчин, нийгмийн бүх төлөвлөгөө болон үнэлгээг нэгтгэхэд хяналт тавина. Үүнд байгаль орчны үйл ажиллагааны журам, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон орчны бүсийн менежментийн төлөвлөгөө зэрэг багтана. Төслийн гүйцэтгэгчдийг татан оролцуулах тохиолдолд шаардлагатай байгаль орчин, нийгмийн менежмент нь Германы сэргээн босголт, зээлийн банкны худалдан авалтын стандарт баримт бичигт үндэслэн худалдан авах ажиллагааны баримт бичгийн³⁶ нэг хэсэг болно.

8.5 Алхам 5: Удирдлага болон хяналт шинжилгээ

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн байгаль орчин нийгмийн үйл ажиллагааны удирдлага болон хяналт шинжилгээ хийхдээ дараах зүйлсэд анхаарлаа хандуулна

- Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг төслийн бүхий л үйл ажиллагаанд нэвтрүүлсэн эсэх нийцлийн шалгалт.
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь нөлөөллөөс зайлсхийх, бууруулахад тохиромжтой эсэх.
- Германы сэргээн босголт, зээлийн банк болон Монголын бүх шаардлагыг хангасан эсэх.
- Шаардлагатай баримт бичиг, бүртгэлийг нотлох баримт болгон хадгалах .

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах бүх арга хэмжээг төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч, мөн бусад холбогдох төсөл хэрэгжүүлэгч нарыг дагаж мөрдөхийг шаардана. Хэрэгжилтэд хяналт тавихын тулд стандарт маягыг Хавсралт 10-д өгсөн болно.

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд шаардлагатай үед хэрэгжилтийн хяналтыг сар бүр хийнэ. Барилга угсралтын ажилтай холбоотой аливаа ажлын хувьд төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин,

³⁵ For the purposes of the Project, the Bank is KfW.

³⁶ KfW Standard Bidding Documents and Contracts, <https://www.kfw-entwicklungsbank.de/International-financing/KfW-Development-Bank/Publications-Videos/Publication-series/Guidelines-and-contracts/>

нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь талбайн инженерүүдтэй нягт холбоотой байж, үндсэн асуудлуудад өдөр тутмын хяналт тавина.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь газар дээр нь очиж танилцсаны дараа шаардлагад нийцсэн байдал болон цаашид шаардлагатай засаж залруулах арга хэмжээг тодорхойлно.

Зөрчилдөөн илэрсэн тохиолдолд тус тайлангийн 8.5 дугаар бүлэгт заасан заалтын дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь Хавсралт 7-д тусгасан тайлангуудыг тохиролцсон журмын дагуу явуулж, хүргүүлэх ажлыг ханган ажиллах шаардлагатай.


8.6 Алхам 6: Тайлан мэдээлэх

Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн хэрэгжилтийг хянах зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагааны явцын талаар сар тутмын төслийн менежментийн багт, мөн Германы сэргээн босголт, зээлийн банканд (Хавсралт 11) хагас жил тутмын төслийн явцын талаар тайланг хүргүүлнэ. Эдгээр тайланд хяналт шинжилгээний үр дүн, шаардлагатай засаж залруулах арга хэмжээ, санал хүсэлт болон гомдлын төлөв зэрэг багтана. Ажилтан нь шалгалтын бүртгэлийг үнэн зөв хөтлөх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн хэрэгжилтийг хянах зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь үйл ажиллагаа, үр нөлөөг хянахын тулд байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг хагас жил тутмын явцын тайлангийн хүрээнд хянана. Энэхүү хянах үйл явцын зорилго нь тулгарч байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг дагаж мөрдөхөд тулгарч буй бэрхшээл, мөн сургамжийг тодорхойлоход чиглэх бөгөөд улмаар цаашид байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хэрэгжилтийн гүйцэтгэлийг сайжруулахад оршино.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд нь дээр дурдсан ангилал В+ хэсэгт хамрагдах аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх тохиолдолд хэрэгжилтэд хяналт тавихаар бие даасан зөвлөхийг татан оролцуулж болно. Ийм зохицуулалтыг тухайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгана.

9. БОНМБ-ыг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц



Зураг 9. Төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого (БОНМБ)-ыг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц

Төслийн хэрэгжүүлэгч агентлаг нь төслийн хэрэгжилтийн хяналтыг хийх төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран үйл ажиллагааны бүхий л үе шатанд төслийн байгаль орчин, нийгмийн бүх эрсдэл, нөлөөллийг үнэлэх, удирдах, хянах үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтний дэмжлэгтэйгээр хэрэгжилтийн үндсэн хяналтыг хариуцна. Эдгээр гурван ажилтан байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, түүнээс зайлсхийхийн тулд ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг багтаасан төслийн төлөвлөлтөд байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын голчлон нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тал дээр нягт хамтран хяналт тавина.

Орчны бүс болон ТХГН-ийн хэмжээнд ТХГН-ийн харилцаа холбоо, хяналтын хоёр ажилтан оролцогч талууд болон олон нийтийн оролцоонд өдөр тутмын хяналт тавина. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульч нь төслийн талаарх санал хүсэлт, гомдолтой холбоотой бүх асуудалд хяналт тавина. ТХГН-ийн харилцаа холбоо, хяналтын хоёр

ажилтан болон төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульч (гомдол барагдуулах механизмтай холбоотой асуудлаар) ажлын төлөвлөгөө боловсруулж, явцын тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэнд тайлагнана.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч өдөр тутмын мэдээллийг тайлагнах ба төсөл хэрэгжүүлэх агентлаг болон төслийн удирдах хороонд тогтмол мэдээллийг өгнө.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн БОНБУ-ийн ажилтан нь цаашид аливаа Төсөл, үйл ажиллагааны төлөвлөлтийг улсын шаардлагад нийцүүлэхийн тулд аймгийн БОАЖГ-ын ажилтнуудтай харилцах үүрэгтэй. Энэ нь тус бүрээр төлөвлөсөн байгаль орчин, нийгмийн арга хэмжээг хянаж, зохицуулах зорилготой.

10. БОНМБ-ын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ

Орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд ТХГН-ийн менежмент болон кластерийн зохицуулалт нь өнгөрсөн хугацаанд нөөцийг хамгаалах, мөн тулгарч буй үндсэн асуудлыг шийдвэрлэхэд техникийн болон санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байсан. Гэсэн хэдий ч тус төслийн үйл ажиллагааны хүрээнд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд нөөцийг ашиглана.

Одоогийн байдлаар Германы сэргээн босголт, зээлийн банкны санхүүжилттэй төслийн хүрээнд шаардлагатай нийцлийн талаарх шалгалтын туршлага хязгаарлагдмал байгаа бөгөөд ТХГН-ийн менежмент болон кластерийн ландшафт нь нэгдмэл бус байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь кластерийн ерөнхий үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх боловч цаашид хэрэгжүүлэх ТХГН-ын менежментийн төлөвлөгөөний нэг хэсэг болгон байгаль орчин, нийгмийн нийцлийн шалгалтыг нэгтгэхээр төлөвлөж байгаа тул байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын холбогдох сургалтад ТХГН-ийн одоо байгаа журамтай нийцүүлнэ.

Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хэрэгжилтийн эхний жилд хэд хэдэн түвшний чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд холбогдох мэдээллийг Хүснэгт 16-д илүү нарийвчлан тусгав.

Тус чадавхыг бэхжүүлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэнүүд нь төслийн кластер нутгуудад байгаль орчин, нийгмийн нийцлийн хяналтыг бий болгох зорилгоор чадавхыг бэхжүүлэх арга хэмжээний дутагдалтай байдлыг үнэлгээг хийнэ.

Хүснэгт 16: Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хүрээнд чадавх бэхжүүлэх байдлын тойм

Бүлэг	Сургалтын сэдвүүд	Сургагчид	Хугацаа
Төсөл хэрэгжүүлэх нэгж	Байгаль орчин, нийгмийн бодлого болон хууль эрхзүйн шаардлага Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын системийн менежмент, тайлагнах журам Худалдан авах үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн асуудлуудыг нэгтгэх зэрэг байгаль орчин, нийгмийн нэгдсэн төлөвлөлт.	Төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтнүүд	Хагас өдрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн танилцуулга Хагас өдрийн удирдлагын системийн семинар (холбогдох ажилтнууд)
БОАЖЯ-ны мэргэжилтнүүд	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын үйл явц Үндэсний болон олон улсын арга хэмжээг уялдуулах Ажлын практик зохицуулалт, тойм, цаг хугацаа	Төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтнүүд	Нэг өдрийн семинар
Орчны бүсийн зөвлөлийн гишүүд	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын танилцуулга, олон нийтийн оролцоо Төлөвлөлтөд байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг нэгтгэх	Төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн	Таван удаагийн хагас өдрийн сургалт Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй байнгын

	Орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох	Бодлогын мэргэжилтнүүд	уялдаа холбоотой сургалтууд
ТХГН-ийн захиргаа	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын танилцуулга, олон нийтийн оролцоо Төлөвлөлтөд байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг нэгтгэх ТХГН-ийн үйл ажиллагаанд оролцох	Төслийн хэрэгжилтийн зөвлөх багын байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтнүүд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн	Нэг өдөр Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй байнгын уялдаа холбоотой сургалтууд
Нөлөөлөлд өртсөн /болон үйл ажиллагаанд оролцсон олон нийт	Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын танилцуулга, Төслийн үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн оролцоог хангах журам Санал хүсэлт, гомдол гаргах журам	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн	Нэг цагийн ерөнхий танилцуулга Нэмж хэлэхэд, цаашид тодорхойлогдох болно: а. Анхан шатны дүн шинжилгээ, нөлөөллийн менежмент б. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах с. Нөлөөллийн менежмент

11. ТӨСӨВ

Энэхүү байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогод заасан байгаль орчин, нийгмийн холбогдох үйл ажиллагааны төсөв нь байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн, хагас цагийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хуульч, түүнчлэн кластерт суурилсан ТХГН-ийн харилцаа холбоо/хяналтын ажилтны хоёр ажилтнуудыг оролцуулах замаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүжилтэд суусан болно. Төслийн хэрэгжилтийн зөвлөх баг нь үндэсний болон олон улсын байгаль орчин, нийгмийн менежментийн зөвлөхүүдээр дамжуулан төсөл хэрэгжүүлэх нэгжид дэмжлэг үзүүлнэ.

Оролцогч талууд болон олон нийтийн оролцоонд шаардлагатай зардлыг төслийн нэгдсэн төсөвт багтаасан байдаг боловч байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын дагуу жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгах ёстой.

Төсөл хэрэгжих газрын анхан шатны дүн шинжилгээ болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай зардлыг батлуулах үед үйл ажиллагааны хэсэгт нэгтгэн тооцсон байх хэрэгтэй. Энэхүү зардалд зөвлөх багаар хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлыг давхар тооцсон байна. Гэсэн хэдий ч байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын төсөвт үндэслэлтэй боловч нэмэлт зардал, түүний дотор ковид-19 тахалтай холбоотой хувийн хамгаалах хэрэгслийн зардлыг нөхөхийн нэмэлт төсвийг олгоно.

Мөн төсөвт холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд (ТХГН-ийн захиргааны барилга болон түүнтэй адилтгах арга хэмжээ), мөн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (дунд хэмжээний дэд бүтэц) болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүдэд (жишээ нь, бэлчээрийн менежментийн туршилтын ажилчид) шаардлагатай төсвийг давхар тусгасан болно.

Хүснэгт 17. Шаардлагатай байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны төсөв

БОННМ-ийн нарийвчилсан төсөв		
Үйл ажиллагаа	Төсөв (EUR)	Зарцуулах хугацаа
ББТССТ-ийн болон бусад барилга байгууламжийн БОННУ болон БОНМТ боловсруулах	20,000.00	2022-2023
ХАБ-ын давтан сургалт зохион байгуулах	30,000.00	2023-2025
Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх давтан сургалт зохион байгуулах	30,000.00	2023-2025
ХХХ болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	20,000.00	2023-2025
Төслийн үр шимийг хүртэгсэд болон ОБЗ-ын гишүүдэд чадавхжуулах сургалт зохион байгуулах	40,000.00	2023-2025
БОНМБ-ыг хэрэгжүүлэх, нийцлийн хяналт мониторинг хийх	25,000.00	2022-2026
Хурал /зөвлөлөгөөн/ чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ	40,000.00	2022-2026
БОНМБ-ын талаарх гарын авлага боловсруулах, ХАБ-ын талаарх өнгөт хуудас хэвлэх	20,000.00	2022-2026
Бусад зардал	25,000.00	2022-2026
Нийт төсөв	250.000	

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II/III үе шатны зардал, санхүүжилтийн төлөвлөгөөнд тохиролцсоны дагуу Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон хяналт тавихад нийт 1,390,562 евро төсөвлөсөн. Энэ дүн нь Германы талаас Санхүүгийн төлөвлөгөөний дагуу оруулсан хэмжээ нь 1,090,562 евро бөгөөд нөгөө талаас Монгол Улсын талаас оруулсан хэмжээ нь 300,000 евро (2,800.00 төгрөг/1 еврогийн тохиролцсон ханшаар 840 сая төгрөгтэй тэнцэнэ). Төсвийг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд нийцүүлэн шинэчлэх ёстой.

ХАВСРАЛТ

Хавсралт 1 : Байгаль орчин болон нийгмийн анхан шатны үнэлгээний загвар

Төслийн бүхий л үйл ажиллагаанд Хүснэгт 5-д заасны дагуу эрсдэлийн үнэлгээ өгнө. Ангилал В ба түүнээс дээш ангилалд багтсан бүхий л үйл ажиллагааны шинж чанарыг баримтжуулах зорилгоор А хэсгийг бөглөх шаардлагатай. Энэхүү А хэсгийг төслийн талбайд очихоос өмнө болон шаардлагатай үед бөглөсөн байх хэрэгтэй. А хэсгийг төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн бөглөж, хянасан байх хэрэгтэй.

А – Үйл ажиллагааны мэдээлэл	
Үйл ажиллагааны нэр :	
Үйл ажиллагааны талбайн байршил :	Сум, дүүрэг, бүс нутаг, улс
Төсөл хэрэгжүүлэгч :	Санхүүжилт хүлээн авч буй байгууллага/ хяналт тавих үйл ажиллагаа
Гүйцэтгэгч байгууллага :	Барилга угсралтын гүйцэтгэх гэрээт байгууллага(хэрэв шаардлагатай бол)
Үйл ажиллагааны тайлбар: Үйл ажиллагааны зорилго хэрэгцээ шаардлага : Үйл ажиллагааны онцлог :	<p>Тайлбар:</p> <ul style="list-style-type: none"> - Энэ үйл ажиллагаанд баригдах дэд бүтцийн төрөл, тэдгээрийн байршил - Гүйцэтгэх үйл ажиллагаа (барилга, ашиглалт, татан буулгах) - Шаардлагатай ажилчдын тоо - Ашигласан машин механизмын төрөл - Хүлээгдэж буй үйл ажиллагааны байгаль орчин нийгмийн гол эрсдэл, нөлөөлөл - Үндэсний хууль тогтоомжид заасан байгаль орчин, нийгмийн зохицуулалтын төрөл (жишээ нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ) - Байгууллагын бүтэц болон үүрэг хариуцлага <p>Шаардлагатай тохиолдолд байршлын газрын зургийг оруулна уу. Тоон мэдээллийг (эзлэхүүн, урт, зорилтот хүн ам гэх мэт) боломжтой бөгөөд хамааралтай байдлаар өгөх</p> <p>Үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө, үйл ажиллагаанд хамрагдсан оролцогч талууд</p>
Энэхүү үйл ажиллагаа нь В ангиллын эрсдэлийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг та баталж чадах уу (Хүснэгт 5-г үзэх)?	
<input type="checkbox"/> В ангиллын бага эрсдэл <input type="checkbox"/> В ангиллын их эрсдэл <input type="checkbox"/> бусад (тайлбар)	
<hr/>	
Үйл ажиллагааны үе шат:	<input type="checkbox"/> төлөвлөлт <input type="checkbox"/> барилга <input type="checkbox"/> ашиглалт

Энэ үйл ажиллагаатай холбоотой авах зөвшөөрлүүд:

Тухайн үйл ажиллагааг явуулахад Монгол улсын засгийн газраас авах шаардлагатай бүх зөвшөөрлийг жагсаалт тухайн баримт бичгийн төлөв байдал (хүчинтэй, хүчингүй), хэрэв шаардлагатай бол тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвшөөрөл авахын тулд авах арга хэмжээний тухай мэдээлэл

Баримт бичиг	Төлөв байдал	Авах арга хэмжээ
Ус зайлуулах зөвшөөрөл	Зөвшөөрөл авсан	Шаардлагагүй
Хог хаягдлын менежментийн зөвшөөрөл	Хүлээгдэж байгаа	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө хүсэлт гаргах хэрэгтэй.

Оролцогч талуудын оролцоо

Үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх явцад дараах зөвлөгөөнүүдийг хийсэн байна.

Оролцогч талууд	Огноо	Агуулга
Хэн? Сумын хөгжлийн зөвлөл	Хэзээ? 10.02.2019	Юу? Үйл ажиллагааны төлөвлөлтийн сонголтуудын танилцуулга. Сумын оруулсан хувь нэмрийн тухай танилцуулга.
Дүүргийн төлөөлөгчид	15.01.2019	Үйл ажиллагааны танилцуулга
Шаардлагатай тохиолдолд аль болох олон мөр нэмж болно.		

Барилгын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад дараах хэлэлцүүлгийг зохион байгуулна:

Оролцогч талууд	Урьдчилан таамагласан давтамж	Агуулга
Хэн? Сумын хөгжлийн зөвлөл	Хэзээ? Сард нэг удаа	Юу? Мэдээллийн төлөв байдал
Шаардлагатай тохиолдолд мөр нэмж болно.		

Оролцогч талуудын оролцоог хангах явцад ирсэн асуудал, санал болон зөвлөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгч болон түүний төслийн гүйцэтгэгчид тодорхойлон авч үзнэ

Асуудал/ Санал, зөвлөмж	Оролцогч талууд	Төсөл хэрэгжүүлэгчийн хариу
Юу ?	Хэн ?	Үүнд үйл ажиллагаа хэрхэн хариу үзүүлэх вэ?
Хөдөө аж ахуйн ажлын улмаас хүн хүч хүрэлцэхгүй байж болзошгүй тул үйл ажиллагааны хүрээнд анхаарч үзэх хэрэгтэй.	Тосгоны төлөөлөгчид	Үйл ажиллагааны хуваарьт зургаадугаар сараас наймдугаар сарын хооронд барилга барихгүй байхаар тохируулна.

Үйл ажиллагааг ус хамгаалах байгууллагад бүртгүүлэх шаардлагатай	Дүүргийн төлөөлөгчид	Байгууллагатай холбогдох уулзалтыг зохион байгуулж, ус зайлуулах зөвшөөрлийг авсан байх.
Шаардлагатай тохиолдолд мөр нэмж болно.		
<p>Ажил эхлэхийн өмнө үйл ажиллагааг төслийг хэрэгжүүлэгч (хэрэв шаардлагатай бол төслийн гүйцэтгэгч) нь хамгийн багадаа дараах ажлыг хийх: Үүнд,</p> <p>Удирдах түвшний болон олон нийтийн ахлагчид өөрсдийгөө танилцуулах</p> <p>Ажлын үргэлжлэх хугацаа, хуваарийн талаар мэдээлэл өгөх</p> <p>Шаардлагатай ажиллах хүчний талаар мэдээлэл өгөх</p> <p>Ажилд авах үйл явцыг тодорхойлох</p> <p>Олон нийтийн дэд бүтцэд нэвтрэх, ашиглах хүсэлт гаргах,</p> <p>Барилгын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн талаарх мэдээллийг өгөх .</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь дараах зүйлсийг хангана:</p> <p>Гомдол барагдуулах механизмыг бий болгох,</p> <p>Хөдөлмөр эрхлэлт нь ил тод, ялгаварлан гадуурхалгүй байгах</p> <p>Эмзэгтэйчүүдийг ажилд авах ажлыг дэмжих.</p> <p>(Оролцогч талуудын оролцооны бүртгэлийг хавсаргаж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтантай хуваалцана)</p>		
Хяналтын бөглөсөн:	хуудсыг	Нэр, огноо, гарын үсэг

Ангилал В хэсгийн бага эрсдэлтэй ангиллын хувьд дараах зүйлийг бөглөж, үйл ажиллагааны бүртгэлийн нэг хэсэг болгон хадгалах ёстой:

- Б хэсэг. Хувийн хамгаалах хэрэгслийн заавар.
- Үйл ажиллагааны хэрэгжилтэд хамаарах байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (Хавсралт 2)-ийн холбогдох хэсгүүдийг тодорхойлох. Холбогдох байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрмийн хэсгүүд нь холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг хамруулсан байх ёстой бөгөөд төслийн гүйцэтгэгч нар болон бүх төслийн хэрэгжүүлэгч шатны хүмүүсийг заавал биелүүлэх шаардлагыг хангана.

Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын дагуу **ангилал В хэсгийн эрсдэл их** ангилалд хамрагдахаар үнэлэгдсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг хийх хэрэгтэй.

- Хэсэг В. Хувийн хамгаалах хэрэгслийн заавар.
- Хэсэг С. Анхан шатны дүн шинжилгээний шалгах хуудас
- Хавсралт 3-т тусгасан заалтын дагуу төсөл хэрэгжих талбайд хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг (өөрөөр хэлбэл, анхан шатны дүн шинжилгээгээр шаардлагатай гэж тодорхойлогдсон тохиолдолд) боловсруулах.

Их хэмжээний эрсдэлтэй/Ангилал В+ буюу түүнээс дээш хэсэгт үнэлэгдсэн үйл ажиллагааны эрсдэл, нөлөөллийг ангилал В хэсэгт хамрагдах үйл ажиллагаатай ижил

аргаар үнэлнэ. Гэхдээ, **ангилал В+** хэсэгт үнэлэгдсэн үйл ажиллагаа нь Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу **ерөнхий эсвэл нарийвчилсан байгаль орчны үнэлгээ/байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах шаардлагатай болно.**

Нарийвчилсан ажлын даалгаврыг боловсруулах шаардлагатай бөгөөд тус төслийн хүрээнд төсөл хэрэгжих газарт зориулсан болон нарийвчилсан үнэлгээг хийх нэг буюу хэд хэдэн зөвлөх мэргэжилтнийг хамруулна. **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ/байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ** нь төслийн гүйцэтгэгчдийн шаардлагыг багтаасан төсөл хэрэгжих газарт зориулсан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг багтаасан байх ба Хавсралт 3- т заасан шаардлагуудыг хангасан байх шаардлагатай.

Хэсэг В-д төсөл гүйцэтгэгч болон сайн дурын ажилчдад шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн тодорхойлсон байна. Тухайлбал, ковид-19 цар ахлын үед ашиглах ёстой хувийн хамгаалах хэрэгслийн төрөл, хэмжээг тодорхойлсон байх ба энэ нь үйл ажиллагааны нэг хэсэг болгон холбогдох зардлыг тооцож оруулсан байх шаардлагатай.

В – Хувийн хамгаалах хэрэгслийн заавар	
<p>Үйл ажиллагаа бүрд хувийн хамгаалах хэрэгсэл шаардлагатай³⁷. Гэсэн хэдий ч ашиглах хувийн хамгаалах хэрэгслийн төрлийг тухайн үйл ажиллагааны төрөл, холбогдох эрсдэлээс хамаарч шийднэ.</p> <p>Ажил эхлэхийн өмнө төсөл хэрэгжүүлэгч агентлаг дараах зүйлийг баталгаажуулна.</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн гүйцэтгэгчид тэдний үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг үнэлэх • Шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн төрлийг тодорхойлох • Ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр, худалдан авах, хангах <p>Ажил гүйцэтгэх явцад төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч нь дараах зүйлийг хангана.</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалах хэрэгслийг ашигласан байх мөн • Хувийн хамгаалах хэрэгслийг гэмтсэн тохиолдолд солино. <p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч нь холбогдох хувийн хамгаалах хэрэгслийг сонгохдоо дараах удирдамжийг³⁸ ашиглана.</p>	
Хувийн хамгаалах хэрэгслийн заавар	
Болзошгүй аюул	Хувийн хамгаалах хэрэгсэл
Өндөр газраас объект унах	Хамгаалалтын малгай, хамгаалалтын гутал
Тоостой орчинд ажиллах	Тоосны маск
Ковид-19 цар тахлын үед ажиллах	Маск, бээлий гар ариутгагч (түүнчлэн зай барих, ам зайлах, биеийн температурыг шалгах арга хэмжээ - Хавсралт 2.1-ийг үзнэ үү)
Хийн орчинд ажиллах	Хорт хийн шүүлтүүртэй маск

³⁷ Хувийн хамгаалах хэрэгсэл нь зөвлөлийн 89/686/ЕЕС тоот удирдамжийн дагуу Европын комиссын бүтээгдэхүүний тохирлын тунхаглалтай нийцэж, мөн ЕК тэмдэглэсэн оныг агуулах хэрэгтэй.

³⁸ Энэ нь хувийн хамгаалах хэрэгслийг сонгоход заавал дагаж мөрддөггүй ерөнхий удирдамж гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үйл ажиллагаатай холбоотой тодорхой эрсдэлийг үнэлсний дараа үйл ажиллагаа бүрт хэрэглэх хувийн хамгаалах хэрэгслийн төрлийг сонгох шаардлагатай.

Дуу чимээтэй орчинд ажиллах	Чихний бөглөө, дуу тусгаарлагч
Хүнд металл, тоног төхөөрөмж унах	Хамгаалалтын гутал
Гулгамтгай газар	Халтирдаггүй гутал
Гагнуураас үүдэлтэй металл оч үсрэх	Нүүрний хамгаалалтын баг, хамгаалалтын нүдний шил
Гагнуураас үүдэлтэй хортой гэрэл,	Гагнуурын нүүрний хамгаалалтын баг, гагнуурын шил
Цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах	Хамгаалалтын нүдний шил, нүүрний хамгаалалт, хамгаалалтын малгай, цахилгаанд тэсвэртэй гутал, арьсан хамгаалагчтай тусгаарлагч бээлий, тусгаарлагч ханцуйвч, галд тэсвэртэй хувцас

Ангилал В болон түүнээс дээш их эрсдэлтэй байж болох үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн төрлийг тодорхойлоход ангилал С хэсгийг ашиглана. Шалгах хуудасны гурав дах баганад байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний загвар маягыг оруулсан. Тиймээс шалгах хуудасны асуултууд нь байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний гол анхаарах асуудлыг тодорхойлж болох бөгөөд эдгээрийг төслийн гүйцэтгэгч нь холбогдох шаардлагын дагуу мөрдөж ажиллах шаардлагатай.

- "ТИЙМ" гэж хариулсан аливаа асуултын хувьд, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд хамааралтай байх бөгөөд төслийн үйл ажиллагаанд хүрээнд санал болгож буй арга хэмжээг авч үзэх шаардлагатай.
- "ҮГҮЙ" гэж хариулсан аливаа асуултын хувьд, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд шууд хамааралгүй тул дагаж мөрдөх шаардлагагүй.
- "ТОДОРХОЙГҮЙ" гэж хариулсан аливаа асуултын хувьд, эдгээр үйл ажиллагааны хүрээнд боломжит, мөн үндэслэлтэй хариултыг олох шаардлагатай. Хариулт нь оновчтой байхын тулд байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд эдгээр асуудлууд нь хамааралгүй гэдгийн нотлох хүртэл холбогдох хэсгүүдийг авч үзэх хэрэгтэй

Хариултад үндэслэсэн мэдээллийг баримтжуулахын тулд аль болох "Зөвлөмж" гэсэн баганыг ашиглана уу.

Энэхүү шалгах хуудсыг бөглөсний дараагаар байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө загвар маягт (Хавсралт 3) руу буцаж, энэ шалгах хуудсаар илэрсэн гол анхаарах асуудлуудад тулгуулан үйл ажиллагааны холбогдох үзүүлэлтүүдийн хүснэгтийг өөрчилж сайжруулах шаардлагатай.

Хавсралт 2: Төслийн талбайн үнэлгээний шалгах хуудас

Ангилал С- Төслийн талбайн үнэлгээний шалгах хуудас

Хэсэг 1- Төсөл хэрэгжих газрын төлөв байдал

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
Төслийн талбай нь налуу газар байрладаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	В.19 – хөрсний элэгдлийн эсрэг арга хэмжээ	Налуу газар нь хөрсний элэгдэлд нөлөөлж болох хүчин зүйл юм.	Асуудлыг тодруулах: Үнэлгээнд шаардлагатай нарийвчилсан мэдээлэл Дутуу хэсгүүд Нотлох баримт бичиг Авч үзэх боломжтой арга хэмжээ/ бууруулах арга хэмжээ .
Үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжих газарт ургамлан нөмрийг цэвэрлэх/ устгах шаардлагатай байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	В.17 – ургамлан нөмрөг цэвэрлэх В.20 – талбайн нөхөн сэргээлт	Ургамлан нөмрөгийг устгах, цэвэрлэх арга хэмжээ нь байгаль орчинд хор хөнөөлтэй бөгөөд, биологийн олон янз байдал, амьтны амьдрах орчинд нөлөөлж болно.	
Үйл ажиллагааны бүс нь шуурга, гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгийн нөлөөнд өртөмтгий юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	С.31 – Онцгой байдлын урьдчилан сэргийлэлт	Үйл ажиллагааны хүрээнд байгалийн гамшгийн нөлөөллийг харгалзан үзэж, тэдгээрийн нөлөөллийг багасгах арга хэмжээ авах шаардлагатай.	
Үйл ажиллагааны бүс нь далайн түвшин нэмэгдэх, ган, халуун зэрэг уур амьсгалын	<input type="checkbox"/> Тийм	С.31 – Онцгой байдлын	Үйл ажиллагааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан үзэж, эдгээр нөлөөллийг	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
<p>өөрчлөлтөөс үүдэлтэй нөлөөлөлд өртөх хандлагатай юу?</p>	<p><input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>урьдчилан сэргийлэлт</p>	<p>багасгах арга хэмжээ авах шаардлагатай.</p>	
<p>Төсөл хэрэгжих талбай нь орон сууцны хорооллын ойролцоо (50 м-ээс багагүй) байрладаг уу? эмнэлэг, сургууль / боловсролын байгууллага эсвэл барилгын үйл ажиллагаа (дуу чимээ, тоос шороо, үнэр, замын хөдөлгөөн) эсвэл талбай руу нэвтрэх хэлбэрээс шалтгаалж нөлөөлж болзошгүй зэрэг хэлбэрээр өртөж болзошгүй барилга байгууламж гэх мэт нийтийн барилга.</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>B.10 – ойролцоох газар нутгийг хамгаалах D.47 – олон нийтийн харилцаа</p>	<p>Барилга угсралтын үйл ажиллагааны улмаас олон нийт болон нөлөөлөлд өртөгч иргэдэд тодорхой нөлөөллийг учруулж болзошгүй. Тиймээс энэхүү нөлөөллийг нөлөөллийн эх үүсвэр дээр нь багасгах хэрэгтэй. Хэрвээ энэ нь боломжгүй бол нөлөөллийг багасгах чиглэлээр ажилчид нь холбогдох арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй. Ямар ч тохиолдолд хамгийн сайн шийдлийг олохын тулд олон нийттэй харилцах шаардлагатай.</p>	
<p>Төслийн талбай дах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бохир ус (цэвэрлэгдээгүй бохир ус, химийн бодис гэх мэт) аар бохирдож болзошгүй усны сан бүхий (гол мөрөн, цөөрөм, нуур гэх мэт) газрын ойр орчимд (<100 м) байрладаг уу?</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>B.12 – бохирдлоос урьдчилан сэргийлэх B.13 – бохир ус</p>	<p>Барилга угсралтын үйл ажиллагаа нь усны сан бүхий газрыг бохирдуулах, улмаар ургамал, амьтан болон нийгэмд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Бохирдлыг үүсгэж болзошгүй барилга угсралтын үйл ажиллагаанаас зайлсхийх, багасгах, мөн бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.</p>	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
Үйл ажиллагааны бүсэд газрын доорх усны болон ундны усны нөөц байгаа эсэх ?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	В.12 – бохирдлоос урьдчилан сэргийлэх В.13 – бохир ус D.47 – олон нийтийн харилцаа	Орон нутгийн иргэд болон үйл ажиллагаа хоорондын усны нөөцийн ашиглалтын талаарх өрсөлдөөн. Барилга угсралтын болон ашиглалтын явцад ахуйн бохир усаар бохирдох.	
Үйл ажиллагааны бүс нь үндэсний болон олон улсын хэмжээнд ач холбогдох бүхий байгалийн хамгаалалттай газар нутгийн дотор эсвэл хэсэгчилсэн байдлаар эсвэл түүний газар нутгийн зэргэлдээ байрладаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	В.18 – Экологийн хувьд чухал ач холбогдол бүхий газар нутаг	Хамгаалалтын хэлбэр болон үйл ажиллагааны төрлөөс хамааран барилгын угсралтын үйл ажиллагаа нь тусгай хамгаалалттай газар нутагт шууд нөлөөлөх эсвэл хамгаалагдсан нөөцөд шууд бусаар нөлөөлж болно. (жишээ нь, ажилчдын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор түр хугацаагаар эсвэл урт хугацаанд байнгын замын хөдөлгөөн нэмэгдсэний улмаас).	
Төслийн талбай нь сүүдэр, салхинаас хамгаалах байгууламжгүй, ил задгай байна уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	С.40 – Байгууламжаар хангах	Хэрвээ төслийн талбай нь цаг агаарын эрс тэс, халуун нөхцөл нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй тул ажилчдын амрах цагаар хамгаалах байраар хангах шаардлагатай.	
Үйл ажиллагаа нь булш, ариун дагшин газар, шашны дурсгалт газар, түүх, археологийн	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	D.47 – олон нийтийн харилцаа	Соёлын дурсгалт газруудад нэвтрэхэд хязгаарлалт тавих, мөн нөлөөлөх зэрэг төслийн үйл ажиллагааг хүлээн	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
дурсгалт газрууд зэрэг соёл, шашны дурсгалт газрууд руу нэвтрэх замд нөлөөлөх эсвэл хязгаарлах уу?	<input type="checkbox"/> Тодорхойгүй	D 51 – санамсаргүй олдвор	зөвшөөрөхөд хүндрэлтэй байж болзошгүй. Үүнийг зураг төсөл болон төлөвлөлтийн үе шатанд авч үзэх шаардлагатай.	
Барилгын угсралтын үйл ажиллагааны улмаас түр зуурын болон байнгын нөлөөлөлд өртөх газарт нь тухайн орон нутгийн байгалийн нөөцөд түшиглэн үйл ажиллагаа явуулдаг иргэдийн (жишээ нь газар тариалангийн талбай, усан болон ойн сан бүхий газар гэх мэт) нутаг дэвсгэрт байдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа D.49 – газар эзэмших	Хэрэв үйл ажиллагаа нь байгалийн нөөцийн хүртээмжийг хязгаарлавал нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд тогтвортой амьжиргааг бий болгох шаардлагатай.	
Төслийн үйл ажиллагааны хүрээнд “цөөнх” (үндэсний цөөнх) гэж үздэг нийгэм соёлын бүлгүүд байдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа	Нийгэм соёлын цөөнх бүлгүүд тодорхой тодорхой хүрээнд эмзэг байдалтай байж болно. Үйл ажиллагааны улмаас эдгээр бүлгүүдэд нөлөөлөхгүй байхын тулд тодорхой хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатай.	
Төслийн талбайд нэвтрэх зам нь иргэдийн сууриныг дайрч өнгөрдөг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа	Тухайн газарт нэвтрэх эрхийг хязгаарлах нь тухайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхөд нөлөөлөх мөн тээврийн хэрэслийн хөдөлгөөн	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
		D.50 – замын хөдөлгөөний удирдлага	ихэссэнээс иргэдийн аюулгүй байдал эрсдэл учруулж болзошгүй юм.	
Өмчлөлийн хэлбэр болон одоогийн газар ашиглалтын байдал тодорхой байна уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа D.49 – газар эзэмших	Дээд хэсгээс үзнэ үү	
Газар чөлөөлөлтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хамгаалах байр, орон сууцны газар (байнгын эсвэл түр) алдагдах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа D.49 – газар эзэмших	Дээд хэсгээс үзнэ үү	
Газар чөлөөлсний улмаас орлогын эх үүсвэр (үр тариа, мод гэх мэт хөрөнгө), амьжиргааны эх үүсвэр (байнгын эсвэл түр зуурын) алдагдах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа D.49 – газар эзэмших	Дээд хэсгээс үзнэ үү	
Орон нутгийн иргэдийн ашигладаг зам тээвэр, барилга байгууламжид барилгын угсралтын үйл ажиллагаа нөлөөлж байна уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.50 – тээврийн хэрэгслийн менежмент	Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлд олон нийт өртөхөөс зайлсхийх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа шаардлагатай.	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд / зааварчилгаа	Зөвлөмж
Ойролцоох орон нутгийн иргэд төслийн талбайгаар байнга нэвтэрдэг эсвэл ашигладаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.48 – хүмүүс болон эд хөрөнгийн хохирол		
Нийгмийн жендэрийн тэгш бус байдал нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөмтгий юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	A.7 – ёс зүйн дүрэм D48. Хүмүүс болон эд хөрөнгийн хохирол	Эмэгтэй ажилчид болон эмэгтэйчүүдийн бэлгийн дарамт, хүчирхийллийн эрсдэлийг харгалзан үзэх, улмаар холбогдох хамгааллын арга хэмжээг (байгууламж, ажлын зохион байгуулалт, гомдол барагдуулах механизм) хангах. Үйл ажиллагааны хүрээнд хүйсээр ялгаварлан гадуурхах асуудлыг гарахгүй байх.	

Хэсэг 2- үйл ажиллагааны онцлог

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
Усны хэрэглээнд төслийн үйл ажиллагааны талбай дах гадаргын болон газрын доорх усны нөөцөөс ус ашиглахаар төлөвлөж байна уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа	Төслийн үйл ажиллагаа болон орон нутгийн иргэдийн хооронд усны нөөцийн ашиглалтын талаарх өрсөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
Төслийн үйл ажиллагааны талбайн доторх байгалийн нөөцийг (жишээлбэл мод, ус, элс, карьер) барилгын ажилд ихээхэн хэмжээгээр ашиглах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа	Төслийн үйл ажиллагаа болон орон нутгийн иргэдийн хооронд усны нөөцийн ашиглалтын талаарх өрсөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.	
Төслийн талбайд нэвтрэх шороон зам байгаа юу? Эсвэл барилга угсралтын ажилд зориулж түр зуурын шороон зам тавих уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	B.14 – машинаас ялгарах хаягдал хий болон тоос D.50 – замын хөдөлгөөний удирдлага	Хатуу хучилттай зам барих үед хорт хий ялгарах мөн хүн амд нөлөөлж болзошгүй.	
Үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудаас аль нэгийг нь хийхээр төлөвлөж байна уу? <ul style="list-style-type: none"> • Газар шорооны ажил , • Газар шорооны ажил/ өнгөн хөрс хуулалт, • Түүхий эдээр хангах газар , • Овоолго , • Хадгалах байгууламж (агуулах, танк). 	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	B.11 – Түүхий эдээр хангах газар, овоолго B.13 – бохир ус B.19 – хөрсний элэгдэл болон зөөгдөл D.51 – Олдвор/археологийн санамсаргүй олдвор		
Барилга угсралтын үйл ажиллагааны хүрээнд	<input type="checkbox"/> Тийм	B.16 – хог хаягдлын менежмент	Холбогдох шаардлагын дагуу зайлуулаагүй нь улмаас байгаль	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
тусгайлсан, мөн дахин боловсруулалт болон зайлуулах арга хэмжээ шаардлагатай хог хаягдлууд гарах эсэх?	<input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй		орчны бохирдол болон нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулах боломжтой. Жишээ нь савлагааг дахин ашиглах	
Барилга угсралтын ажлын үед, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулж болзошгүй бодисыг (жишээлбэл, аюултай материал, бохирдуулагч, шатах тослох материал) хадгалах (жишээ нь, танк, цэнэглэх станц), тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаа байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	<p>А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт</p> <p>В.12 – бохирдлоос урьдчилан сэргийлэх</p> <p>В.13 – бохир ус</p> <p>В.16 – хог хаягдлын менежмент</p> <p>С.24 – ослын талаар мэдээлэх</p> <p>С.28 – хувийн хамгаалах хэрэгсэл</p> <p>С.31 – онц байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ</p>	Химийн бодистой зүй бусаар харьцсанаас үүдэн хүрээлэн буй орчныг бохирдуулж, хүний эрүүл мэндэд аюул учруулах эрсдэлтэй	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
		С.33 – анхны тусламж		
Барилга угсралтын ажлын үр дүнд хаягдал бохир ус гарах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	В.13 – бохир ус	Холбогдох шаардлагын дагуу зайлуулаагүй нь улмаас байгаль орчны бохирдол үүсэх эрсдэл.	
Төслийн үйл ажиллагааны талбайд нүх, цөөрөм, суваг, шуудуу гэх мэт аюултай байж болзошгүй зүйлсийг барихаар төлөвлөж буй байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	С.24 – ослын талаар мэдээлэх С.33 – анхны тусламж D.48 – төслийн талбайн аюулгүй байдал	Төслийн үйл ажиллагааны талбайд нэвтэрч буй олон нийт болон орон нутгийн иргэд (жишээ нь хүүхдүүд)-ийн аюулгүй байдлыг хангах (хальтах, унах) хэрэгтэй	
Барилга угсралтын ажил олон нийтийн хөл хөдөлгөөн ихтэй газар байрладаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа С.24 – ослын талаар мэдээлэх С.33 – анхны тусламж	Барилгын талбайд орон нутгийн иргэд нэвтэрснээр осол гарах эрсдэлтэй. Төслийн үйл ажиллагааны талбайд харуул хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгээр хангасан эсэхийг шалгах	
Барилга угсралтын үйл ажиллагааны үед талбай дээр хамгаалалтын ажилтнууд байрлах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	А.7 – ёс зүйн дүрэм А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал,	Хамгаалалтын ажилтнуудыг зохих ёсоор бэлтгээгүй тохиолдолд орон нутгийн иргэдтэй зүй бусаар харьцах эрсдэлтэй.	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
		<p>эрүүл ахуйн сургалт</p> <p>C.40 – Эрүүл ахуй, ажилчдын байр, хоол хүнс</p> <p>D.48 – иргэд болон эд хөрөнгийн хохирол</p>		
<p>Төслийн ажилчид тухайн орон нутагт байрлаж ажиллах уу?</p>	<p><input type="checkbox"/> Тийм</p> <p><input type="checkbox"/> Үгүй</p> <p><input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>A.7 – ёс зүйн дүрэм</p> <p>D.47 – олон нийтийн харилцаа</p>		
<p>Үйл ажиллагаа нь газар нь газар чөлөөлөх шаардлагатай юу?</p> <p>Хэрвээ газар чөлөөлөх бол аль нь хэрэгжих вэ?</p> <ul style="list-style-type: none"> • хамгаалах байр, орон сууцны газрыг алдах (Байнгын болон түр зуурын хугацаанд) • амьжиргааны (үр тариа, мод гэх мэт) орлогын эх үүсвэрээ (байнгын болон түр зуураар) алдагдах 	<p><input type="checkbox"/> Тийм</p> <p><input type="checkbox"/> Үгүй</p> <p><input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>D.47 – олон нийтийн харилцаа</p> <p>D.49 –газар эзэмших</p>	<p>Төслийн үйл ажиллагаатай холбоотой газар чөлөөлөх болон газар ашиглалтыг хязгаарлах нь орон нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг алдагдуулснаас үүдэн ихээхэн сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй бөгөөд энэ нь орон нутгийн иргэд үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхөд ихээхэн нөлөөлнө.</p>	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
<ul style="list-style-type: none"> Байгалийн нөөцийн хүртээмж алдагдах Олон нийтийн үйлчилгээний байгууламж тэдгээрийн үйлчилгээ алдагдах Дээрхийн аль нь ч биш 				
Үйл ажиллагаа нь сайн дурын газраа эзэмшүүлэхийг шаардах эсэх?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.47 – олон нийтийн харилцаа D.49 – газар эзэмших	Энэхүү газар эзэмшүүлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр мөн ямар ч албадлагагүй байх хэрэгтэй.	

Хэсэг 3- Ажлын нөхцөл

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
Төслийн хүрээнд тухайн үйл ажиллагаанд ажиллаж байгаа хүмүүст дараах шаардлагад нийцүүлэн ажиллуулж байна уу? Үүнд, жинхэнэ ажилчид болон гэрээт ажилтнууд багтах бөгөөд үндэсний ажлын цагийн хуваарийн дагуу ажилладаг эсэх?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.42 – хөдөлмөрийн стандартууд	Ажлын цаг нь өдөрт 8 цаг, мөн долоо хоногт 48 цагаас илүүгүй байна.	
Төслийн хүрээнд тухайн үйл ажиллагаанд ажиллаж байгаа хүмүүст дараах шаардлагад нийцүүлэн ажиллуулж байна уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	D.42 – хөдөлмөрийн стандартууд	Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар 18.	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
Үүнд, жинхэнэ ажилчид болон гэрээт ажилтнууд багтах бөгөөд ажиллаж буй иргэд хөдөлмөрийн насны доод хязгаараас дээш байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тодорхойгүй		Насны хяналтын тавих систем (ID шалгах) нь бүх худалдан авалтын нэг хэсэг байх ёстой.	
Төслийн хүрээнд тухайн үйл ажиллагаанд ажиллаж байгаа хүмүүст дараах шаардлагад нийцүүлэн ажиллуулж байна уу? Үүнд, жинхэнэ ажилчид болон гэрээт ажилтнууд багтах бөгөөд ажиллаж буй иргэд нь аливаа албадлагын дагуу бус, мөн үнэ төлбөргүй ажиллуулж байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	D.42 – хөдөлмөрийн стандартууд	Ажил олгогч нь цалин, тэтгэмж, эд хөрөнгө, бичиг баримтыг өөртөө авч үлдэж болохгүй бөгөөд ажилчид ажиллах хугацаа дуусгасны дараа ажлын байраа орхих эрхтэй байх ёстой.	
Сайн дурын байгууллагын гишүүд үйл ажиллагаанд оролцдог уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	A.7 – ёс зүйн дүрэм D.42 – хөдөлмөрийн стандартууд D.43 – орон нутгаас ажиллах хүчнээ авна. D.44 – тээвэр D.47 – олон нийтийн харилцаа D.48 – иргэд болон эд хөрөнгийн хохирол	Олон нийтийн ажлыг зөвхөн сайн дурын үндсэн дээр болон ажилчдын талаар мэдээлэлтэйгээр зөвшилцсөний үндсэн дээр хийх боловч зөвшөөрлийг цуцлах боломжтой байх Ажлын цагийг орон нутгийн ажил, ялангуяа хөдөө аж ахуйн ажил эсвэл амьжиргаатай холбоотой бусад улирлын чанартай үйл ажиллагааг харгалзан үзэх шаардлагатай.	
Төслийн талбай дээр ажилчдын түр байр барих уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	C.33 – анхны тусламж C.40 – байр сууц	Ажилчдын байрлах байрыг ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, амар тайван байдлыг хангах мөн түүний дотор нийгэм,	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
	<input type="checkbox"/> Тодорхойгүй	С.40 – эрүүл ахуй, байр хоол хүнс С.41 –мансууруулах бодис D.48 хүмүүс болон эд хөрөнгийн хохирол	соёлын хэрэгцээг харгалзан зохих бодлогоор зохицуулах шаардлагатай.	
Барилга угсралтын үйл ажиллагаанаас гадна нэмэлтээр 20 ба түүнээс дээш иргэдийг ажиллуулах тооцоотой байна уу? Эсвэл 50 гаруй ажилчдыг нэг дор дайчлах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	А.7 – ёс зүйн дүрэм С.40 – эрүүл ахуй, байр, хоол, сууц D.42 – хөдөлмөрийн стандартууд D.43 – орон нутгийн ажиллан хүчин D.44 – Тээвэр D.47 – олон нийтийн харилцаа D.48 – хүмүүс болон эд хөрөнгийн хохирол	Төслийн хүрээнд олон нийт, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хамгаалах шаардлагатай.	
Үйл ажиллагаа нь өндөрт (1м-ээс дээш дээвэр, тулгуур барих, мод огтлох, шат барих гэх мэт) явагдах уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй	А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт С.24 – осол мэдээлэх С.31 – онцгой байдлын урьдчилан сэргийлэлт	Өндөрт ажиллах үед гарах эрсдэлийг зохих хувийн хамгаалах хэрэгслийг ашиглан ажиллах замаар (бэхэлгээгээр) багасгах шаардлагатай.	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
		С.33 – анхны тусламж		
<p>Үйл ажиллагаанд 1м-с доош гүнд (суваг шуудуу, нүх ухах гэх мэт) хийгдэх ажил байгаа эсэх</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт С.24 – осол мэдээлэх С.31 – онцгой байдлын урьдчилан сэргийлэлт С.33 – анхны тусламж</p>	<p>Хөрс нурах, ажилчид нурангид дарагдах эрсдэлээс сэргийлэхийн тулд ямар ч ажилтан ганцаараа ажиллахыг зөвшөөрч болохгүй.</p>	
<p>Барилга угсралтын ажилд хүнд машин механизм (экскаватор, кран, ачааны машин, домкрат) ашиглах уу?</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт В.12 – Бохирдлоос урьдчилан сэргийлэх В.15 – дуу чимээ болон чичиргээ С.24 –осол мэдээлэх С.28 – хувийн хамгаалах хэрэгсэл С.33 – анхны тусламж С.31 – онцгой байдлын урьдчилан сэргийлэлт</p>	<p>Гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд ямар ч ажилтан ганцаараа ажиллах ёсгүй бөгөөд зохих сургалтад хамрагдах шаардлагатай.</p>	

Асуулт	Хариулт	БОНМТ тайлбар	Анхаарч үзэх шаардлагатай болзошгүй эрсдэлүүд	Тайлбар
<p>Үйл ажиллагааны үед нүх, септик танк зэрэг хязгаарлагдмал орон зайд хийх үйл ажиллагаа багтах уу?</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт С.24 –осол мэдээлэх С.33 – анхны тусламж С.31 – онц байдлын урьдчилан сэргийлэлт</p>	<p>Гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд ямар ч ажилтан ганцаараа ажиллах ёсгүй бөгөөд холбогдох сургалтад хамрагдах шаардлагатай.</p>	
<p>Үйл ажиллагаа нь аюултай материал/бохирдуулагчтай харьцахтай холбоотой юу?</p>	<p><input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>	<p>А.8 – байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт С.24 –осол мэдээлэх С.33 – анхны тусламж С.31 – онцгой байдлын урьдчилан сэргийлэлт</p>	<p>Гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд ямар ч ажилтан ганцаараа ажиллах ёсгүй бөгөөд холбогдох сургалтад хамрагдах шаардлагатай.</p>	

Хавсралт 3: Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНУАД)

Байгаль орчин, нийгмийн стандартын үйл ажиллагааны дүрэм (БОНУАД) нь төслөөр дэмжигдсэн үйл ажиллагаанд хамаарах стандарт журмыг тухайлан нарийвчлан тусгасан болно. Ангилал С (бага эрсдэлтэй) гэж үнэлэгдсэн үйл ажиллагаанд энэ заалтуудыг ашигладаг бөгөөд төслийн үйл ажиллагаанаас хамаач магадгүй ангилал В (дунд зэргийн эрсдэлтэй) хамаарах тохиолдолд нөлөөллийг бууруулах арга хэмжээнд ихэвчлэн ашиглаж болно. Иймд, БОНУАД-ийг байгаль орчин, нийгмийн боломжит нөлөөллийг анхдагч судалгаа, үйл ажиллагаанаас үүсэх нөлөөлөл нь хязгаарлагдмал, төсл хэрэгжих газрыг хамарсан, мөн холбогдох стандарт арга хэмжээний дагуу нөлөөллийг бууруулах боломжтой байх үйл ажиллагаанд хэрэглэж болно. Тухайлбал, ерөнхийн нөлөөллийн хэлбэр, төрөл нь барилгын хог хаягдал, тоос шороо болон дуу чимээ, мөн олон нийтийн аюулгүй байдал, ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал зэрэг байж болно. БОНУАД-ийн урьдчилсан заалтууд нь бага зэргийн эрсдэлтэй барилгын ажлын үед гарах ерөнхийн сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн байгаль орчин, нийгэм, мөн олон нийтийн аюулгүй байдал, ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сайн туршлагыг илэрхийлдэг, тухайлбал дараах жишээг татаж болох боловч үүгээр хазаарлагдахгүй болно. Үүнд,

- Нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх,
- Хог хаягдлыг цуглуулах (аюултай хог хаягдлаас бусад),
- Барилга байгууламжийг сэргээн засварлах (зөвхөн барилгын доод давхрын),
- Хөдөө орон нутгийн жижиг замуудыг сэргээн засварлах (том машин механизмгүйгээр),
- Зам дагуух жижиг ус зайлуулах сувгийг цэвэрлэх, солих, усалгааны бага оврын сувгийг шинэчлэх,
- Жижиг ус, ариун цэврийн байгууламж эсвэл эрүүл ахуйн дэд бүтэц (жишээ нь сургуулийн ариун цэврийн байгууламж, гар худаг, жижиг худаг, булаг шандыг сайжруулах, хашаа барих),
- Тодорхой нөлөө үзүүлэхгүй барилга байгууламжийг сэргээн засварлах, шинэчлэх, барих,
- Хөрсний элэгдэл, эвдрэлээс урьдчилан сэргийлэх энгийн байгууламжууд (хөрсний хил хязгаар),
- Бусад жижиг дэд бүтцийг сэргээн засварлах.

Хэрэв үйл ажиллагаа нь цахилгаан, эрчим хүчний дэд бүтэц, 150 см-ээс дээш гүнтэй шуудуу, өндөрт эсвэл хязгаарлагдмал орон зайд ажиллах шаардлагатай бол эрсдлийг жигд тодорхойлсон төсөл хэрэгжиж газрын хэмжээнд хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Тухайн үйл ажиллагаа нь одоогийн амьжиргааны эх үүсвэрийг хязгаарлах эсвэл бусад холбогдох эдийн засгийн нөлөөллийг багтаасан тохиолдолд байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд заасан журмын дагуу БОНУАД-д амьжиргааг сайжруулах төлөвлөгөөг хавсаргах ёстой.

Үйл ажиллагааны холбогдох арга хэмжээнүүдийг байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд заасан бөгөөд Хавсралт 1-д дэлгэрэнгүй тайлбарласны дагуу хамрах хүрээг тодорхойлох болон анхан шатны дүн шинжилгээний үед тодорхойлогдох болно. Төслийн гүйцэтгэгч нь үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр оролцож байгаа тохиолдолд БОНУАД нь худалдан авах ажиллагааны баримт бичгийн нэг хэсэг байх ёстой.

АГУУЛГА	Болно	Болохгүй
<p>Биологийн олон янз байдал (Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа)</p>	<ul style="list-style-type: none"> • Түр овоолгын ойр орчим болон төсөл хэрэгжих талбайг цэвэрлэх үед ургамлан нөмрөгийг хамгаалахад анхаарах. • Төслийн үйл ажиллагааг явуулах байршлууд болон барилгын түүхий эд бэлтгэх (элс хайрганы карьер) газрыг сонгохдоо амьдрах орчинд нөлөө үзүүлэхгүй байхад анхаарах. • Барилга угсралтын болон засвар үйлчилгээний үед амьтдыг санамсаргүйгээр гэмтээхгүйн тулд хязгаарлалт тавьж ажиллах (хашаа хашлага, тэмдэг тэмдэглэгээ хийх). • Амьтан түүн дотор хөхтөн, шувуу, могой, сээр нуруугүй амьтдыг гэмтээж, устгаж болохгүй. • Амьтдыг барих, хордуулах, буудахыг хатуу хориглоно. • Үйл ажиллагааны талбайд ямар ч гэрийн тэжээвэр амьтан, мал оруулахыг хориглоно. • Хашаа барих замаар барилгын талбай руу ан амьтдыг санамсаргүйгээр орохоос урьдчилан сэргийлэх. • Тусгай хамгаалалттай газарт амьтдыг гэмтээхгүйн тулд хурдаа багасгах (хурдны хязгаарыг үргэлж дагаж мөрдөх) • Хязгаарласан ажлын талбайгаас гадна ямар ч ургамлан нөмрөгийг талхлахгүй байх. • Түлээний мод бэлтгэхийг хориглох. • Барилгын талбайн гадна аливаа амьтныг санамсаргүй байдлаар гэмтээх, үхэх болон байгалийн ургамлан нөмрөгийг (төслийн хэрэгжих талбайгаас гадна) устгах зэрэг хор хөнөөл ихтэй осол, аваарын тохиолдлуудыг төсөл хэрэгжүүлэх нэгж болон аймаг сумын Засаг даргад мэдээлэх. • Барилга угсралтын болон засвар үйлчилгээний явцад ургамлан нөмрөгийг хамгаалах талбайг зааглаж тодорхойлон талбайн төлөвлөгөөнд тусгасан байх 	<ul style="list-style-type: none"> • ТХГН-т мал болон гэрийн тэжээвэр амьтан оруулахгүй байх • Байгалийн ямар ч объектыг будах, баллах (сүйтгэх) болон тэмдэглэгээ тавьж болохгүй. (жишээ нь мод, чулуулгийн тогтоц)
<p>Ёс зүйн дүрэм</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн талбайд ажилчдын болон олон нийттэй харилцах ёс зүйн дүрэм боловсруулах • Төслийн гүйцэтгэгч, ажилтнуудад төслийн хүрээнд хийгдэх ажилтай холбоотой байгаль орчин нийгмийн эрсдэлийг хамарсан ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл өгч баталгаажуулна. Энэхүү мэдээлэлд ажилчдын хөдөлмөрийн 	<ul style="list-style-type: none"> • Төслийн хүрээнд баримтлах ёс зүйн дүрмийг зөвшөөрөөгүй тохиолдолд ажилчдыг ажиллуулахгүй байх

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<p>аюулгүй байдал, эрүүл ахуй мөн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг эрсдэлт хүчин зүйлүүд багтана (Хавсралт 7-г харна уу).</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн гэрээний дагуу ажилчдад ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхийг үүрэг болгох. 	
<p>Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</p>	<ul style="list-style-type: none"> • Барилгын талбайн ойр орчимд амьдарч буй орон нутгийн иргэдийн гомдол барагдуулах механизмыг бий болгох • Барилга байгууламжийг архитектур, инженерийн практикт нийцүүлэн боловсруулахын тулд Монгол улсын Барилгын тухай хууль, түүнд холбогдох журам, стандарт, тавигдах шаардлагыг ашиглан барилга байгууламжийг барьж, засварлана. • Төслийн талбайг тусгаарлах зурвас хашаа, хана, хаалга, түр гүүр болон бүхий л ажлын талбайд замын хөдөлгөөний зохицуулалт, хаалт, тэмдэг тэмдэглэгээ мөн анхааруулах гэрлээр зохих ёсоор хамгаалах. • Барилга барих мөн төслийн үйл ажиллагаа явагдах талбай руу иргэд ялангуяа хүүхдүүдийг зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд суурин газрын ойролцоох хэсэгт зохих хил заагийг тогтоож, нэвтрэхэд хяналтыг бий болгох (жишээ нь, суурин газрын ойр орчмын барилгын хэсгийг хаших). Нээлттэй суваг шуудууг өндөр харагдахуйц түр хашаагаар тусгаарлах мөн бороо орсны дараа хяналт тавих, суваг шуудуу үерт автахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй. • Газар доорх болон газрын дээрх цахилгааны шугам, цэвэр усны шугам, дулааны шугам сүлжээ зэрэг инженерийн шугам сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэх. • Газар хөдлөлт, салхи, үер, гал түймрийн улмаас үүсэх байгалийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд байршил, аюулгүй байдлын инженерийн шалгуур үзүүлэлт ханган үйл ажиллагааг явуулах • Усны эх үүсвэр, түүний чанар, хүртээмжийг хамгаалах. • Усаар дамжих халдварт өвчин болон живэх эрсдэл мөн ил задгай тогтоол усыг хуримтлуулахаас зайлсхийх 	<ul style="list-style-type: none"> • Барилгын болон ашиглалтын үе шатанд орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл ахуйд учирч болзошгүй нөлөөллийг үнэлэхгүйгээр аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх. • Тодорхой тэмдэглэсэн тэмдэглэгээ, бат бөх хашаа хашлагагүйгээр аливаа нүх, цооногийг орхихгүй байх
<p>Олон нийтийн оролцоо</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн бүх үйл ажиллагаа болон холбогдох нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлоход олон нийтийн оролцоог сайтар хангах • Хэлэлцүүлэг хийх болон шийдвэр гаргах үйл явцад эмзэг бүлгийг оролцуулахад тусгай арга хэмжээ авах. 	<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн санаа бодлыг үл хүндэтгэсэн нэг талыг барьсан гэрээг хийхгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн иргэд болон ажилчдад зориулан гомдол барагдуулах механизмыг бий болгох. 	<ul style="list-style-type: none"> Санал хүсэлт болон гомдлоо илэрхийлж буй иргэдийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх хэрэггүй.
Соёлын өв	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны төлөвлөлтийн явцад сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд соёлын биет өв болон биет бус өвийн зураглалыг гаргах. Малтлагын явцад хүний шарил, археологийн олдвор (тухайлбал, яс, олдвор гэх мэт) эвдэрсэн, эсвэл ил гарсан тохиолдолд бүх ажлыг даруй зогсоож, санамсаргүй олдворын журмын дагуу арга хэмжээг авна. Төсөл хэрэгжих нэгжийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл хариуцсан мэргэжилтэн нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх Ухааны академи, Археологийн хүрээлэнгээс зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр олдворыг палеонтологич/археологичид шалгаж, шаардлагатай тохиолдолд авран хамгаалах арга хэмжээг хийх ажлыг зохион байгуулна. 	<ul style="list-style-type: none"> Соёлын өв, булшийг хөндөхгүй байх. Ач холбогдол бүхий газруудад аливаа нөлөөллийг учруулахгүй байх. Шашны өмчид халдахгүй байх. Археологийн дурсгалт газар, археологийн материалыг устгах, гэмтээх, малтлага хийх, өөрчлөх, эвдэх нь хууль бус юм.
Агаар болон тоосжилт	<ul style="list-style-type: none"> Аль болох тээврийн хөдөлгөөн болон хурдыг багасгах . Барилга угсралтын ажлын явцад хэт их тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах Талхадсан газар, материалын овоолгыг салхинаас хамгаалах холбогдох арга хэмжээ авах. Овоолгоос салхитай өдөр өнгөн хөрс нь хийсэхээс хамгаалж хучиж хадгалах. Элэгдэл, эвдрэлд өртсөн хөрснөөс үүсэх тоосжилтыг хамгийн бага байлгахын тулд зөвхөн салхи ихтэй үед (усны нөөцийг хамгаалахад анхаарах) усаар шүршиж хамгаалах Сургууль, эмнэлэг, орон сууцны хороолол зэрэгт ойрхон ажиллаж байгаа бол шороон замыг усаар шүршиж тоосжилтыг багасгах, агаар цэвэршүүлэх арга хэмжээ авах Үйл ажиллагаа дуусмагц талхлагдсан газрыг дахин ургамалжуулах. Тоосжилт үүсгэхгүйн тулд хурд багатай жолоодох. 	<ul style="list-style-type: none"> Цемент, элс, хайрга буюу барилгын түүхий эд материалыг бүрээсгүй болон хамгаалах байргүйгээр ил задгай хадгалж болохгүй. Шаардлагагүй бол ургамлын нөмрөгийг устгаж болохгүй. Талбайн цэвэрлэгээний хог хаягдал (мод, хөл ургамлууд), барилгын хаягдал материалыг шатааж болохгүй.
Ажил эрхлэлт ба хөдөлмөрийн эрх	<ul style="list-style-type: none"> Шударга, ил тод хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төслийн үйл ажиллагаанд оролцож буй ажилчдад тэдний эрхийн талаарх мэдээллийг эх хэлээр нь тодорхой, ойлгомжтой өгөх Бүх орон нутгийн сайн дурын ажилчдыг албадлагагүйгээр татан оролцуулж байгаа эсэх дээр хяналт тавих. 	<ul style="list-style-type: none"> Ажилчид болон ажил горилогчдыг хүйс, гэр бүлийн байдал, үндэс угсаа, нас, шашин шүтлэг болон бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүүхдийг (18-аас доош насны) ажилд авахгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөөний дагуу ажилчдын бүртгэлийг хөтлөхдөө дараах зүйлсийг багтаана. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Ажил олгогчийн нэр • Ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл <ul style="list-style-type: none"> ○ Нэр ○ Төрсөн огноо ○ Холбоо барих мэдээлэл ○ Иргэний үнэмлэхийн баталгаажуулалт • Ашиг хүртэгч нутгийн оршин суугч эсэх (тийм/үгүй) • Ажилд орсон огноо <p>Зөвхөн цалинтай ажил эрхэлж буй хүмүүст дараах зүйл хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын байрны тодорхойлолт (албан тушаал, гүйцэтгэх ажил болон үүрэг, нөхцөл, хариуцлага) • Ажлын цаг • Туршилтын хугацаа • Мэдэгдэл өгөх хугацаа • Төсөл ба ажил эрхлэлттэй холбоотой гомдлыг хүлээн авах тухай мэдээллийг хүлээн зөвшөөрсөн эсэх • Ажлын байрны ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн байдал (Хавсралт 7) <ul style="list-style-type: none"> ○ Цалингийн гэрээ: ○ Цалин ○ Цалин олгох давтамж (сард хамгийн багадаа хоёр удаа) ○ Цалин олгох хэлбэр ○ Шаардлагатай суутгалууд (татвар, бусад) • Чөлөө авах эрх • Холбогдох бусад тэтгэмж (тэтгэвэр, тээвэр, орон сууц, боловсрол, эрүүл мэнд) <p>Сайн дурын хөдөлмөр эрхэлж буй хүмүүст дараах зүйл хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Сайн дурын гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байдал 	<ul style="list-style-type: none"> • Албадан хөдөлмөр эрхлүүлэхгүй байх.
Одоо байгаа дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны явцад одоо байгаа дэд бүтцийн бүрэн бүтэн байдлыг үйл ажиллагааны хүрээнд хамгаалах ёстой. 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа дэд бүтцийг гэмтээхгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> Аливаа дэд бүтцэд учирсан эвдрэл гэмтлийг хариуцагч тал арилгуулна. Хохирлыг барагдуулсны дараа төсөл хэрэгжүүлэгч нэгжээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. 	
<p>Гал түймрээс урьдчилан сэргийлэх, хянах</p>	<ul style="list-style-type: none"> Гал гарч болзошгүй эрсдэл, түүний эх үүсвэрийг тодорхойлох. Үйл ажиллагааны улмаас гал түймэр гарч болзошгүй тул бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах. Шатамхай материалыг гал гарахаас сэргийлсэн мөн галын тархалтыг хязгаарлах нөхцөлд хадгална. Төслийн талбай дээр гал түймэртэй тэмцэх анхан шатны холбогдох хэрэгслээр хангах (өвс, бут бүхий талбайд ажиллахдаа эсгий, резинэн цохиур, гагнуур болон бусад "халуун" нөхцөлд үйл ажиллагаа явуулах үед дор хаяж нэг төрлийн гал унтраагч гэх мэт). тамхины зориулалтын цэгт тамхи татахыг зөвшөөрөх бөгөөд тус цэг нь тамхины хогны аюулгүй сав, холбогдох тэмдэг, тэмдэглээгээтэй байх Бүх барилгуудын эргэн тойронд (түр зуурын барилгын талбайг оруулаад) галын хамгаалалт суурилуулах. Тусгай хамгаалалттай газар нутагт гал түймрийн бүх менежментийг ТХГН-ийн галын менежментийн төлөвлөгөөний дагуу хийх. Яаралтай тусламжийн үед холбоо барих мэдээллийг ажлын талбайд тодорхой харагдахуйц хэлбэрээр байршуулах. Гал түймрийн эрсдэл болон гал гарсан тохиолдолд гал түймэртэй хэрхэн тэмцэх талаар бүх ажилчдаа сургах. 	<ul style="list-style-type: none"> Шалтгаангүйгээр ил гал асааж болохгүй, мөн хог шатааж болохгүй. Тамхиныхаа ишийг ил задгай хаяж болохгүй.
<p>Аюултай материалын менежмент</p>	<ul style="list-style-type: none"> Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудас (MSDS) нь үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй аюултай материалаас гоожих, цацраг туяа ялгаруулах, шатах зэрэг тодорхой аюул үүсэж болзошгүйг тодорхойлдог. Асгаралтын хяналт, урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалт хийх журам боловсруулах, боловсон хүчнийг сургах замаар хариу арга хэмжээ авах. Аюултай хог хаягдлыг хоёрдогч агуулах ашиглан хадгалж, аюултай хог хаягдлын агуулах руу нэвтрэх эрхийг хязгаарлаж, барилгын ажилчид, байгаль орчин, ард иргэдэд хохирол учруулахгүй байх. Бохирдсон хөрс (шатах тослох материалын асгарснаас үүдэлтэй гэх мэт), шаардлагагүй цементийн уут, бетон зуурмагийн төхөөрөмжийг угаахад 	<ul style="list-style-type: none"> Аюултай материал бүхий газрын ойролцоо тамхи татаж болохгүй.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<p>ашигласан ус зэрэг нь аюултай хог хаягдал гэж үзэх тул зөвшөөрөгдсөн аюултай хог хаягдлын цэгт зайлуулах ёстой.</p> <ul style="list-style-type: none"> • Түлш, шатах тослох материал, химийн бодис болон бусад аюултай материалыг зохих хэмжээтэй, ус үл нэвтрэх, бэхэлсэн суурь бүхий агуулахад хадгалах. • Тухайн материалыг зөөх болон хадгалах, мөн дуусах хугацаа, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх тодорхой мэдээллийг савны гадна наах болон тэмдэглэх. • Тоног төхөөрөмжийг түлшээр дүүргэх, засвар үйлчилгээ хийх (жишээ нь тос солих) үед тосгуур ашиглах. • Аюултай бодис хадгалах талбайнуудад зохих анхааруулах тэмдэг байрлуулж, хаалгыг түгжиж, эрх бүхий ажилтнуудын нэвтрэх эрхийг хязгаарлах. • Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг (тээвэрлэх, харьцах, хадгалах, устгах) хэрэгжүүлэх. 	
<p>Ажилчдын байр</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн холбогдох ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажлыг хянахын тулд бүх нэвтрэх замууд болон төлөвлөгдсөн бүтээн байгуулалтын газруудын гэрэл зургийн бүртгэлтэй байх ёстой. • Ажилчдын байр, агуулах, ажлын талбайг сонгохдоо аль болох эвдрэлд өртсөн газрыг сонгох. • "Орох хориотой" газруудыг (тариалангийн талбай, мод, ногоон байгууламж, зэрэг аливаа байгаль орчны чухал газрууд) тодорхой ялган тэмдэглэх. • Бетон болон цемент бэлтгэх үйл ажиллагааг байгаль орчны чухал газруудад явуулахыг хориглох, мөн нүцгэн хөрс буюу хөрсний нэвчилт сайтай газар дээр холих бэлтгэх үйл ажиллагааг хориглох • Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгах мөн төслийн үйл ажиллагааны талбайг өдөр бүр цэвэрлэх. • Унах эрсдэлтэй сул материалыг бэхлэх. • Барилга угсралт болон засвар үйлчилгээний явцад ашиглах материалыг зөвхөн зөвшөөрөгдсөн тэмдэгжүүлсэн талбайд хадгалах. • Шаардлагатай тохиолдолд ажлын цар хүрээтэй холбоотой үйл ажиллагааны аргачлалын талаар дараах мэдээллийг өгөх ёстой. Үүнд, <ul style="list-style-type: none"> ○ Хадгалах материалын төрөл, тоо хэмжээ. ○ Шатах тослох материалаар бохирдсон болон агуулсан тоног төхөөрөмж хадгалагддаг эсэх. 	<ul style="list-style-type: none"> • Зөвшөөрөлгүйгээр ажлын талбай, бүс рүү орж болохгүй. • Аливаа айл өрх болон холбогдох барилга байгууламж, тариалангийн талбай, жимсний мод болон бусад орлогын эх үүсвэрийг гэмтээхгүй байх. • Ажлын талбайн зурвасаас гадна ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг хориглох, мөн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа талбайн гадна байршуулах. • Барилгын талбайн гадна мод огтолж, ургамлыг устгаж болохгүй. • Барилгын материалыг нэвтрэх зам дагуу, нөлөөлөлд өртөөгүй ургамлан нөмрөг дээр хадгалж болохгүй.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> ○ Материалыг холбогдох агуулахын талбайд хэрхэн (ямар төрлийн тээврийн хэрэгсэл шаардагдахыг оруулаад) газар дээр нь хүргэх. ○ Аливаа материал болон химийн бодис асгарах, тархах эрсдэл байгаа газар, мөн эрсдэл болон асгаралтыг хэрхэн бууруулах талаар ● Гудамж, шат, гарц, зөөврийн шат гэх мэт хэсгүүдийг саад учруулж болзошгүй кабель, утас, хоолой гэх мэт материал, эд зүйлээс ангид байлгах. ● Барилгын материалуудыг газар шорооны ажил явагдах талбай, суваг шуудуу, дээвэр гэх мэт газраас зайтай хадгалах. ● Ил задгай суваг, нүх болон бусад онгорхой зүйлсийг таглаж бэхлэх мөн ажлын талбайд тогтоол ус үүсгэхээс сэргийлэх. ● Бүхий л эвдэрсэн газрыг нөхөн сэргээх хэрэгтэй. Ингэхдээ тухайн нутгийн ургамлыг ашиглах хэрэгтэй. 	
Осол, аваарыг мэдээлэх	<ul style="list-style-type: none"> ● ХАБЭА хариуцсан ажилтан аливаа аюул, осол, гэмтэл, бэртэл зэргийг бүртгэж, мэдээлэх ёстой. ● Ноцтой осол гарсан тохиолдолд 24 цагийн дотор төсөл хэрэгжүүлэгч нэгж болон ,аймаг сумын удирдлагад мэдээлэх ёстой (Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль (2008)). ● Осол гарсан тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх, цаашид гарахаас зайлсхийхийн тулд нэмэлт арга хэмжээг тусгах. 	<ul style="list-style-type: none"> ● Осол гарсан түвшнээс үл хамааран орон нутгийн иргэн, ажилчдад учирсан аливаа аюул, гэмтэл, ослыг үл тоомсорлож болохгүй.
Тусгай хамгаалалттай газар нутгийн хөдөлмөрийн менежмент	<ul style="list-style-type: none"> ● Бүх ажилчид болон тоног төхөөрөмж нь үргэлж тэмдэглэгдсэн ажлын талбайд байх ёстой. ● Ажилтан эсвэл тоног төхөөрөмжийг зөвшөөрөгдсөн ажлын талбайгаас гадагш гаргахаас өмнө ТХГН-ийн захиргааны захирлаас зөвшөөрөл авах ёстой. ● Ажлын цагийн хуваарь болон ажлын ойрын хугацаанд зөвшөөрөл аваагүй тохиолдолд бүх нэмэлт ажилчид ажлын бус цагаар төслийн талбайгаас гадуур байх ёстой. 	<ul style="list-style-type: none"> ● Ажилтнууд ажлын байрнаас гадуур зорчихыг хориглоно. ● Ажилчдыг ажлын цаг дууссаны дараа ажлын байранд дээр байхыг хориглоно.
Газар ашиглалт	<ul style="list-style-type: none"> ● Ажилчдын байр, агуулах, цех, ажлын талбайн зориулалтаар эвдэрсэн газрыг илүүтэй ашиглах. ● "Орох хориотой" газруудыг (таримал газар эсвэл жимсний мод, намгархаг газар, оршуулгын газар, зэрэг эмзэг орчныг) тодорхой ялган тэмдэглэх. ● Сургууль, эрүүл мэндийн байгууллага, эмзэг бүлгийн өрхүүдтэй ойрхон байршил сонгохоос зайлсхийх. ● Ажлын талбайг цэвэрлэж, талбайг анхны байдалд нь оруулах. 	<ul style="list-style-type: none"> ● Зөвшөөрөл, батлахгүйгээр ажлын талбай, бүс рүү орж болохгүй. ● Аливаа айл өрх болон холбогдох барилга байгууламж, тариалангийн талбай, жимсний мод болон бусад орлогын эх үүсвэрийг гэмтээхгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> • Зөвшөөрөгдсөн ажлын талбайн гаднах бүх түр зам, тээврийн зам болон бусад эвдэрсэн газрыг анхны байдалд нь оруулах. 	<ul style="list-style-type: none"> • Ажлын талбайн зурвасаас гадна ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг хориглох, мөн тээврийн хэрэгслийг төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа талбайн гадна байршуулах.
<p>Дуу чимээ</p>	<ul style="list-style-type: none"> • Дуу чимээний түвшнийг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах. • Засвар үйлчилгээ, барилга угсралт, нураах ажлыг ердийн ажлын цагаар хязгаарлаж, амралтын өдрүүдэд хийхийг хориглоно. Дуу чимээтэй үйл ажиллагааг төвөг багатайгаар явуулахын тулд тухайн олон нийттэй зөвшилцөн үйл ажиллагаагаа төлөвлөх. • Сургууль, эмнэлэг, оршин суугчид, шашны байгууллага гэх мэт газруудын ойр дуу чимээ ихтэй үйл ажиллагаа явуулах ажлын цагийг хязгаарлах. • Ердийн ажлын цагаар барилгын материалын тээвэрлэлтийг нийтийн эзэмшлийн талбайгаар тээвэрлэхийг багасгах. • Амьдрах орчны дуу чимээний нөлөөллийг багасгахын тулд үйл ажиллагаа явуулж буй талбай болон орон сууцны хорооллын хооронд дуу чимээ саармагжуулах бүс (ил задгай талбай, эгнээ мод, ургамалжуулсан газар гэх мэт)-ийг бий болгох. • Дуу чимээний түвшин нь тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байх ёстой бөгөөд хүрээлэн буй орчинд нөлөөлөх, мөн зочдын сөргөөр нөлөөлөхгүй байх ёстой. • Хашаа, хаат гэх мэт дуу чимээг тусгаарлах (шатаах хөдөлгүүрийн дуу намсгах төхөөрөмж гэх мэт) гэх мэт аргыг ашиглах. • Ашиглахгүй, түр зогссон байгаа бол машины хөдөлгүүрийг унтрах. 	<ul style="list-style-type: none"> • Шөнийн цагаар дуу, чимээтэй үйл ажиллагаа явуулж болохгүй. • Шаардлагагүй тохиолдолд дуу чимээ гаргахгүй байх.

<p>Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</p>	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, ХАБЭА-н нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох. • Төслийн бүх ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалт явуулж, тэдний үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн талаар ажилчдад танилцуулах. • Хувийн хамгаалах хэрэгслээр хангаж, бүх ажилчдаа үүнийг тогтмол ашиглаж байгаа эсэхийг шалгах, хяналт тавих. • Хувийн хамгаалах хэрэгслийг сайн нөхцөлд хадгалж, эвдэрч гэмтсэн тохиолдолд солих. • Мөн зочдод зориулсан хамгаалалтын хувцас (хамгаалалтын хантааз, дуулга) байх ёстой. • Согтууруулах ундаа, хууль бус мансууруулах бодис хэрэглэхийг хориглох. • Жингийн хязгаар, завсарлага, ажлын ээлжийг зааж өгснөөр материал, тоног төхөөрөмжийг өргөх, зөөхдөө эргономикийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх. • Үйл ажиллагаандаа тохирох хэрэгслийг ашиглах. • Хэрэв та дээш авирах шаардлагатай бол эвдрээгүй, бүрэн бүтэн шатыг ашиглах. • Бүүдрэх, халтирах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд дотоод цэвэрлэгээг сайтар хийх. • ХАБЭА-н бүх шаардлагуудыг үргэлж дагаж мөрдөх. Үүнд хийх ёстой ажилдаа тохирсон хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах, хамгийн багадаа хамгаалалтын гутал, бээлий, нүдний хамгаалалт зэрэг багтана. Хамгаалах ажилтай холбоотой аюулгүй байдлын эрсдэлд үндэслэн хувийн хамгаалах хэрэгслийн холбогдох шаардлагыг тодорхойлно³⁹. • Эрүүл мэнд, аюулгүй байдлын хавтаст бүртгэл нь ажлын өрөөнд байх ёстой бөгөөд ямар ч үед шалгах боломжтой байх ёстой. Аюулгүй байдал, хамгаалах хэрэгслийг тарааж, ашигласан тухай бүртгэх ёстой. Талбайн ажилтнуудад өгсөн хувийн хамгаалах хэрэгслийг ашиглаагүй ажилтнуудыг ажлын талбайд ажиллуулахыг хориглоно. • Ажил эхлэхийн өмнө эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар өдөр бүр ажилчдад зааварчилгаа өгч/ярилцлага хийх. • Үйл ажиллагаа эхлэхээс өмнө бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулна. • Ажилчдыг шаардлагатай хэмжээний ундны усаар хангана • Эмэгтэй, эрэгтэй ажилчдад тусад нь ариун цэврийн өрөөгөөр хангах, засвар үйлчилгээ хийх. • 25 ажилтан тутамд нэг сургагдсан анхны тусламжийн ажилтан, хүрэлцэхүйц хэмжээний анхны тусламжийн хэрэгслээр газар дээр нь хангах. • Ажлын байрны аливаа аюул, осол, гэмтлийг бүртгэх, мэдээлэх журмыг ашиглан мэдээлэх. 	<ul style="list-style-type: none"> • Хэрэв та зөвшөөрөлгүй бол эвдэрсэн тоног төхөөрөмж, машин механизмыг засах гэж бүү оролдоорой. • Хувийн хамгаалах хэрэгсэлгүйгээр ажил хийхгүй байх. • Ганцаараа эсвэл тусгаарлагдмал орчинд ажиллахгүй байх. • Согтууруулах ундаа, хууль бус мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.
---	---	--

АГУУЛГА	Болно	Болохгүй
<p>Эрүүл ахуй</p>	<ul style="list-style-type: none"> • Бүх ажилчдыг ариун цэврийн шаардлага хангасан бие засах байгууламжаар хангагдсан эсэхийг хянах. 15 хүн тутамд ажлын байрны байршил бүрд дор хаяж хүйсээр тусгаарласан бие засах газартай байх ёстой. • Гүйцэтгэгчид ажлын талбай дээр зөөврийн бие засах газар өгөх шаардлагатай байж магадгүй. Энэ тохиолдолд: <ul style="list-style-type: none"> ○ Зөөврийн бие засах газрын засвар үйлчилгээг тогтмол хийж бохир гоожихоос сэргийлнэ. ○ Ариун цэврийн байгууламжийг салхинд хийсэхээс урьдчилан сэргийлж сайтар бэхэлж мөн хаалга, түгжээг суурилуулсан байх. • Тохиромжтой септик танкны зөв дизайныг сонгох, септик танкны засвар үйлчилгээг сайжруулах. Септик танкны загвар нь бохир усны чанар, засвар үйлчилгээний хийхэд хялбар амар байх. • Септик танкны өтгөн, шингэн хаягдлыг системтэй, тогтмол зайлуулах • Зориулалтын машин ашиглаж зайлуулах. • Септик танкны өтгөн, шингэн хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажлыг хялбар байлгах, цэвэрлэгдээгүй өтгөн, шингэн хаягдлыг байгаль хаяхгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Усны эх үүсвэрийн дэргэд ариун цэврийн байгууламжийг байрлуулах, барихыг хориглох. • Ямар ч тохиолдолд задгай газар эсвэл ойр орчмын бутыг ариун цэврийн байгууламж болгон ашиглаж болохгүй.

³⁹ Ажил эхлэхийн өмнө тохирох хувийн хамгаалах хэрэгслийг тодорхойлж, тогтмол хэрэглэж, засвар үйлчилгээ хийх, ашиглалт, засвар үйлчилгээнд хяналт тавих шаардлагатай.

- Нисдэг тоосонцор, хайлсан металл, шингэн химийн бодис, хий эсвэл уур, гэрлийн цацрагаас нүд, нүүр хамгаалах: хажуугийн бамбай бүхий хамгаалалтын шил, хамгаалалтын сүүдэр
- Унах объект, өндрийн зай хангалтгүй, цахилгааны утаснаас хамгаалах толгойн хамгаалалт: дээд болон хажуугийн цохилтоос хамгаалсан хуванцар дуулга
- Дуу чимээнээс сонсголын хамгаалалт: чихний бөглөө эсвэл чихэвч
- Унах, өнхрөх, үзүүртэй зүйл, идэмхий болон халуун шингэнээс хамгаалах хөлийн хамгаалалт: хамгаалалтын гутал, гутал
- Аюултай материал, зүсэлт, зүсэлт, чичиргээ, хэт өндөр температураас гар хамгаалах: резин эсвэл синтетик материал (неопрен), арьс, ган, тусгаарлагч материалаар хийсэн бээлий
- Тоос, манан, утаа, манан, хий, утаа, уураас амьсгалын замын хамгаалалт: тоос арилгах, агаар цэвэршүүлэхэд зориулагдсан зохих шүүлтүүр бүхий нүүрний маск

АГУУЛГА	Болно	Болохгүй
<p>Хөрс хамгаалал</p>	<ul style="list-style-type: none"> • Хөрс хамгаалах арга хэмжээ авах, налууг тогтворжуулах, зохих ус зайлуулах хоолойгоор хангах замаар хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх. • Элэгдэл эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээхийн тулд бүрхэвч, өвс эсвэл нягтруулсан хөрсийг ашиглах. • Шимт хөрстэй болгоомжтой харьцах мөн булж болохгүй эсвэл цаашид ашиглахад боломжтой (жишээ нь, шороотой холих гэх мэт) байлгах ёстой бөгөөд шаардлагагүй хөрс хуулалт, нягтруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. • Усны эх үүсвэртэй ойр ямар ч газраас барилгын материал авч болохгүй. • Хөрсний овоолгыг хамгийн бага үзэгдэх орчны нөлөөлөлтэй байхаар хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн улмаас элэгдэлд оруулахааргүй байршилд хадгалах нь зүйтэй. Шимт хөрсний овоолгын өндөр нь 1.5 м-ээс хэтрэхгүй байх нь хамгийн тохиромжтой. • Ажлын явцад зайлуулсан өнгөн хөрсийг дахин дүүргэх буюу газар дээр нь тэгшлэх мөн өнгөн хөрсөөр хамгийн сүүлд нь хучих шаардлагатай. • Овоолго болон агуулахад зориулсан талбайнуудыг барилгын ажил хийгдэх ойрын бүсэд буюу аль хэдийн эвдрэл өртсөн газарт байршуулах замаар нөлөөллийг бага байлгах хэрэгтэй. • Овоолгын байршлыг газар шорооны ажил эхлэхээс өмнө байгаль орчны ажилтантай зөвлөлдөж тохирно. Ухсан шороог хаяж болохгүй. Илүүдэл шороог төслийн гүйцэтгэгчид заасан газарт л зайлуулна. • Хэрвээ боломжтой бол газар шорооны ажлыг хоёр хоногоос урт хугацаагаар хийлгүй тухайн өдөртөө ухсан нүх ухашаа булж хаах нь зүйтэй. Ухашыг ямар ч тохиолдолд долоо хоногоос илүү нээлттэй байлгаж болохгүй. Ухсан нүхэнд ан амьтан хүн унаж эрсдэх эрсдэлтэй тул тухайн газруудыг тодорхой зааглаж, хамгаалсан байх ёстой. • Илүүдэл өнгөн хөрсийг байгалийн газрын гадаргатай зохицсон байдлаар талбайд жигд тараана. • Ажил дууссаны дараа өнгөн хөрсийг хучиж, талхлагдсан газрыг дахин ургамалжуулах (өвс, хурдан ургадаг ургамал, бут, мод). • Элэгдлээс сэргийлэхийн тулд борооны ус, үерийн урсцыг хянах арга хэмжээг авах. Шаардлагатай тохиолдолд их хэмжээний үерийн урсцын чиглэлийг өөрчлөх, тухайн талбайг элэгдэлд оруулахгүйн тулд далан суваг байгуулж болно. 	<ul style="list-style-type: none"> • Хөрс хамгаалах нарийн арга хэмжээний төлөвлөлтгүйгээр үйл ажиллагаа явуулахгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> • Хөрсний элэгдэл эвдрэлийн аль болох хурдан нөхөн сэргээх шаардлагатай. • Ухсан нүх, суваг шуудууг аль болох ойр орчмын байгалийн нөхцөл, гадаргуугийн онцлогт тохируулан гүйцэтгэнэ. • Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн анхаарах шаардлагатай газрын налуу тогтооно. 	
<p>Тээврийн хөдөлгөөний менежмент</p>	<ul style="list-style-type: none"> • Шатах тослох материал, тосолгооны материал, гидравлик шингэний асгаралт, нэвчилтээр хөрс бохирдох эрсдэлийг багасгахын тулд бүх машин, тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөлийг сайтар хангах, мөн газар шорооны ажилын тулд бүх тээврийн хэрэгслийг тогтмол, стандарт горимын засвар үйлчилгээг сайн хийх. • Тээврийн хэрэгсэл бүрийг анхны тусламжийн хэрэгслээр хангах. • Жолооч нар зохих ёсоор сургагдаж, жолооны эрх авсан эсэхийг шалгах (мөн жолооч үргэлж хүчинтэй хугацаа бүхий үнэмлэхээ биедээ авч явах). • Бүх жолооч нарын аюулгүй байдлын бэлтгэлтэй байлгах хэрэгтэй. Аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээ, замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөхийг онцлон сануулах. • Бүх тээврийн хэрэгсэл нь холбогдох тэмдэг, тэмдэглэгээ суурилуулсан ажлын талбарт ажиллах шаардлагатай. • Төслийн бүх тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг хэрэгжүүлэх. • Тээврийн хэрэгслийг ухрах дохиогоор тоноглох. Ухрах, буулгах, ачих үед ачааны машины жолооч нар тугчин эсвэл харуулын хамт байх ёстой. • Тохиромжтой газруудад туг далбаа ашиглаж, тод, харагдахуйц тэмдэглэгээг байршуулаалах. • Үзэгдэх орчин хязгаарлагдмал муруй, уулзвар, эгч налуу дагуух нарийн замаар явахаас зайлсхийх • Талбайгаас гарах замыг хог хаягдал, барилгын материалаас ангид чөлөөтэй байлгах. • Орон нутгийн замын хөдөлгөөний тэмдэглэгээг ашиглаж, орон нутгийн засаг захиргаа, олон нийттэй хамтран ажиллах.. • Хүүхдүүд сургууль руугаа явах, буцах цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцохгүй байх. 	<ul style="list-style-type: none"> • Жолооны үнэмлэхгүйгээр жолоо барьж болохгүй. • Жолоо барьж байхдаа гар утас ашиглахгүй байх. • Зориулалтын замаас өөр газраар машин жолоодож болохгүй. • Зэрлэг ан амьтдад аюул учруулахгүй байх.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> • Барилга угсралтын ажил болон бусад үйл ажиллагаатай холбоотой материалыг ачиж буулгахад ашигладаг газруудад зохих тэмдэглэгээг суурилуулж, тэмдэглэх. • Тээвэрлэлтэд хүнд машин механизмаар орох шороон замыг тасралтгүй ашиглах, мөн тээврийн ачаалал ихсэх хандлагатай үед замын эвдрэл гэмтлийг сайтар хянаж улмаар тогтмол зэрэглэл тогтоох шаардлагатай. • Аюулгүй замыг ашиглаж, тээвэрлэлтийн үргэлжлэх хугацааг зохих ёсоор хязгаарлах. Үзэгдэх орчин хязгаарлагдмал муруй, уулзвар, эгч налуу дагуух нарийн замаар явахаас зайлсхийх. • Тодорхой бөгөөд харагдахуйц зааварчилгаа өгөхийн тулд харагдахуйц тэмдэг, тугуудыг ашиглах. • Хүүхдүүд сургууль руугаа явах, буцах цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцохгүй байх. 	
<p>Үзэгдэх нөлөөлөл орчны</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн зарим үйл ажиллагааг жуулчид үзэж боломжтой бол тухайн үед болж буй үйл ажиллагааны талаар мэдээлэх самбаруудыг төслийн гүйцэтгэгч байршуулах хэрэгтэй. • Байгалийн объектыг будах, тэмдэглэхийг хориглоно. Судалгааны болон бусад зорилгоор тэмдэглэгээг зөвхөн шон, дохионы тусламжтайгаар хийнэ. • Тухайн тэмдэглэгээ хийж буй материал нь байгаль орчинд тохирсон байх хэрэгтэй. 	<ul style="list-style-type: none"> • ТХГН-ийн байгалийн ландшафтыг алдагдуулах, саад учруулах аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх.
<p>Хог хаягдал</p>	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, багасгах, дахин ашиглах, боловсруулах, дахин боловсруулах, зайлуулах, устгах журам болон байгууламжийг санаачлан зохион байгуулах. Дахин боловсруулалтыг хялбаршуулахын тулд хог хаягдлыг ангилан тусад нь савлах хэрэгтэй. Үйл ажиллагаанд оролцож буй бүх холбогдох хүмүүст зориулсан хог хаягдлын менежментийн журмыг тогтоож, тодорхой мэдээлэл өгөх. • Хог хаягдлыг холбогдох хуулийн шаардлагын дагуу тээвэрлэх, устгах чиглэлээр орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах. Хог хаягдлыг хог хаягдлын менежментийн дагуу зөвшөөрөгдсөн байгууламж буюу ландфиллын талбайд зайлуулах, ялангуяа усаар дамжин гадаргын болон газрын доорх усны чанарт нөлөөлж болзошгүй хог хаягдал, материалыг зайлуулах анхаарах ёстой. Зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаясан тухай бичгээр нотлох баримтыг авч байгаль орчны ажилтанд өгнө. 	<ul style="list-style-type: none"> • Ямар ч төрлийн хог хаягдлыг шатааж болохгүй. • Зөвшөөрөгдөөгүй газар, ялангуяа усны сан бүхий газарт хог хаяж болохгүй. • Барилгын талбайн ойролцоо амьдарч буй хүүхдийн анхаарлыг татахуйц хурц, аюултай зүйл (хутга, таслагч, хайч, хагархай шил гэх мэт)-ийг орхиж болохгүй.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын менежментэд хяналт тавьж зохих залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх. • Хог хаягдлыг шингэн, органик, барилгын болон аюултай хог хаягдал зэргээр дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг газар дээр нь ангилан тус бүрээр нь зайлуулах арга хэмжээг тодорхойлох. • Ажлын байр, хоолны газар цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, эмх цэгцтэй байх ёстой. • Хогийн савнууд эвдрэлгүй мөн гоожихгүй бүрэн бүтэн байх. Мөн борооны ус хуримтлуулахгүй, хог салхинд хийсгэхгүй мөн амьтад хог тараахаас сэргийлэн тагтай байх хэрэгтэй. • Ухсан хөрсийг дахин дүүргэлт хийх, тохижуулалт хийх болон шаардлагатай бусад үйл ажиллагаанд аль болох дахин ашиглах хэрэгтэй. • Гадаа харгалзах хүнгүйгээр ямар ч хоол хүнс үлдээж болохгүй, ямар ч хүнсний бүтээгдэхүүнийг хонуулж болохгүй. Хүрээлэн буй орчиндоо хоол хүнс хаяхыг хориглоно. 	
<p>Ус</p>	<ul style="list-style-type: none"> • Холбогдох зөвшөөрлөөр заагаагүй бол төслийн бүхий л үйл ажиллагаа усны сан бүхий газраас 50 метрээс багагүй зайд явуулна. • Усны сан бүхий газарт тээврийн хэрэгсэл зорчихыг хориглоно. • Усны сан бүхий газраас ямар ч зорилгоор хөрс хуулалт хийж болохгүй. • Хэрэв барилгын талбай гол горхи, цөөрөм, ус зайлуулах суваг зэрэг эмзэг газруудын хажууд байрлаж байгаа бол хашаа барих • Барилгын талбайн болон эвдэрсэн газарт ус урсаж орж ирэхээс сэргийлэн суваг шуудуу ашиглан урсцын гольдролыг өөрчилнө. • Угаалгын газар нь ус бага зарцуулдаг төхөөрөмжтэй байх, мөн угаасан усыг нөөцлөх байгууламжтай байх ёстой . • Угаалгад ашигласан усыг боломжтой бол дахин ашиглах. • Нийтийн болон хувийн эзэмшлийн ундны усны эх үүсвэрийг агаарт дэгдэх тоос тоосонцор, бохир ус, шатах тослох материал, аюултай бодис, хог хаягдлаас ямагт хамгаалж байх ёстой. • Төслийн үйл ажиллагаа нь ундны усны эрүүл ахуй болон хүртээмжийг алдагдуулах ёсгүй. • Байгалийн усны урсцыг хааж, өөр чиглэлд шилжүүлэхгүй байх, энэ нь голын голидролыг ширгээх, суурин газрыг үерлэх аюултай. 	<ul style="list-style-type: none"> • Холбогдох байгууллага, орон нутгийн удирдлагуудын зөвшөөрөлгүйгээр байгалийн усны нөөцийг (жишээ нь, булаг шанд, горхи, нуур гэх мэт) усны хэрэглээг аар хангахад бүү ашигла. • Аюултай бодис, химийн бодис, барилгын материал, хог хаягдлыг усны урсгал, цөөрөм, ус зайлуулах системд хаяж боохгүй. • Усны урсгалыг хааж болохгүй.

АГУУЛГА	Болно	Болохгүй
	<ul style="list-style-type: none"> Урсгал уснаас үүдэн гарах нөлөөллийг хязгаарлахын тулд барилгын ажлын явцад тусгаарлах арга техникийг ашиглах. 	

Хавсралт 4: Ковид-19 халдварын нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ковид-19 цар тахлыг бууруулах эдгээр урьдчилан сэргийлэх алхмууд нь ДЭМБ, Германы сэргээн босголт, зээлийн банкны сайн туршлагад суурилсан бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан шинэчлэгдэж болно. Төслийн менежментийг цаг үеийн мэдээлэлтэй уялдуулж, Эрүүл мэндийн яамны зөвлөмжийн дагуу явуулна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд авагдах холбогдох арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл өгөх мөн Ковид-19 цар тахлын олон нийтийн сэрэмжлүүлэг бүхий мэдээллийг төслийн гол оролцогчдод хүргэх замаар Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллана.

Энэхүү олон нийтийн харилцаа нь төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэх бөгөөд үүнд төслийн ажилчид, төслийн гүйцэтгэгчид, туслан гүйцэтгэгчид болон орон нутгийн иргэд, мөн төслийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог гол оролцогч талуудыг хамруулна. Төслийн баримтлах гол зарчим нь бол төслийн бүх оролцогч талуудад учирч болзошгүй ноцтой эрсдэл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэх, үнэн бодит мэдээллийг хүргэх, буруу ташаа мэдээлэлтэй тэмцэх явдал юм. Үүнд,

- Хоёрдмол утгагүй маш тодорхой мэдээллийг өгөх. Үүнд, (а) өндөр эрсдэлийг бууруулах чухал үйл явц, (б) хэрэв хүмүүс Ковид-19 цар тахлын халдвар авсан байх магадлалтай бол юу хийх тухай, (в) төслөөс хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон тэдгээрийг яагаад хийх тухай багтана. Мөн оролцогч талуудтай холбоотой дараах зүйлсийг багтаана.
 - Төслийн үйл ажиллагаанд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн байдал.
 - Цар тахлын үеийн төслийн үйл ажиллагааны ерөнхий үзэл баримтлал, тэдгээрийг аюулгүй хэрэгжүүлэх арга хэмжээ (жишээлбэл, оролцогч талуудын оролцоонд хийсэн зохицуулалт, дэлгэрэнгүйг мэдээллийг дараагийн хэсгээс үзнэ үү).
 - Төслийн ажилчдыг гэрээсээ ажиллах нөхцөлийг дэмжих.
 - Ажлын байранд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах (ариутгал халдваргүйжүүлэлт, хүн хоорондын зай барилт, таниулан сурталчлах гэх мэт).
 - Ажилчдын эрх, өвчний чөлөө, цалин/төлбөр.
 - Халдвар авсан, өвчилсөн хүн бүрийг мэдээлэх бөгөөд 14 хоногийн тусгаарлалтад заавал хамруулна.
- Олон нийт, ажилчдын талаарх ойлголт, цуурхал, санал хүсэлтийг найдвартай харилцааны сувгуудаар дамжуулан хянаж, хариу арга хэмжээ авах, ялангуяа нийгмийн гутаан доромжлол, ташаа мэдээллийг тодруулж авах хэрэгтэй.

Ковид-19 цар тахлын үед төслийн оролцогч талуудын оролцоотой зарим үйл ажиллагааг зохион байгуулах боломжгүй болох юм. Иймд, төслийн үйл ажиллагааны хүрээнд дараах журмыг дагаж мөрдөнө. Үүнд,

- Олон нийтийн сонсгол, семинар, иргэдийн уулзалт гэх мэт олон нийтийг хамарсан цугларалтаас зайлсхийх
- Ковид-19 цар тахлын онцгой үед төлөвлөсөн бүхий л уулзалтыг хойшлуулах буюу уулзалтын товыг дахин төлөвлөх.

- Хэрэв жижиг хэмжээний уулзалтуудыг эрсдэлгүй хийх боломжтой, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд тухайн уулзалтыг оролцогч талуудыг бүлэгт хувааж зохион байгуулах.
- Оролцогчид эрсдэлгүй, аюулгүй уулзах боломжгүй тохиолдолд цахим уулзалтын платформуор (Google Meet, Microsoft Teams, WhatsApp, Zoom, Skype гэх мэт цахим платформуудаар) дамжуулан тухайн уулзалт, санал хүсэлтийг хэрхэн хийх, зохион байгуулах талаар авч хэлэлцэх .
- Зурагт хуудас, эвхмэл материал бүхий тараах материалыг боловсруулж, тараах.

Төслийн гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Ковид-19 цар тахлын үед төөл хэрэгжүүлэгч нь төслийн гүйцэтгэгч байгууллагаас Ковид-19 цар тахлаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахыг шаардах бөгөөд энэхүү төлөвлөгөөг төслийн гүйцэтгэгчийн ХАБЭА-н ажилтнуудын хянан хэрэгжүүлэх ёстой. Ковид-19 цар тахлаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө нь энэхүү төслийн хүрээнд оролцож буй төслийн гүйцэтгэгч талын ажилчид, төсөл хэрэгжүүлэгчээс талбайд ажиллах хүн, мөн төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөлөлд өртөх ойр орчмын олон нийт зэргийг хамгаалахад чиглэсэн байх шаардлагатай. Ковид-19 цар тахлаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд долоо хоног бүр зардал гарах бөгөөд тус төлөвлөгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байх үед зардлыг төслийн гүйцэтгэгч хариуцна. Ковид-19 цар тахлаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байх хэрэгтэй. Үүнд,

- Ковид-19 тахлыг бууруулах бүх арга хэмжээний бүртгэл.
- Аюулгүй байдлын талаарх өдөр тутмын мэдээлэл.
- Ажилчдын халууныг тогтмол шалгаж байх (төслийн ажлын талбайд нэвтрэхээс өмнө).
- Ажлын ээлжээр солигдон ажиллах менежмент.
- Хувийн хамгаалах хэрэгслийн хангалт (амны хаалт, нүдний хамгаалалт, бээлий болон бусад).
- Нүд, хамар, аманд хүрэхээс сэргийлж гараа тогтмол угаах, амьсгалын замын эрүүл ахуйг сахих талаар идэвхжүүлэн сурталчилж, хэрэгжүүлэх. Гар ариутгагч эсвэл гарын саванг ариун цэврийн өрөө болон бусад холбогдох газруудад (жишээлбэл, нэвтрэх хэсэг, үдийн хоол идэх заал гэх мэт) үргэлж бэлэн байгаа эсэхийг шалгаж байх.
- Хүн хоорондын зай барилтын зөвлөмжийг мөрдөж, нэг газарт зөвшөөрөгдсөн хүмүүсийн тоог бууруулах (ажлын багийн хүмүүсийн тоог бууруулах, талбайд байнга ажиллах ажилчдын тоог хязгаарлах, ажлын ээлжийн өөрчлөлт, ажлын горимд дасан зохицох, зарим талбайг хаах гэх мэт).
- Сургалт, мэдээллийн нэмэлт арга хэмжээ зохион байгуулах, жишээлбэл, ДЭМБ - аас гаргасан зурагт мэдээллийн хуудас ашиглах гэх мэт.
- Ажлын байрны цэвэрлэгээ, эрүүл ахуй (жишээлбэл, ариутгалын бодисын тогтмол хэрэглэх).
- Хэрэв хэн нэгэн өвдөх үед орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой, тухайлбал Ковид-19 цар тахлын шинжилгээ хийх боломжтой газрын мэдээллийг тодруулах.
- Ажлын байран дээр өвдсөн ажилчдыг нэн даруй тухайн ажлаас нь шилжүүлэх арга хэмжээ авах.

- Халдвар авсан эсвэл шинж тэмдэг илэрсэн ажилчдыг дор хаяж 14 хоногийн турш тусгаарлалтын дэглэмд байх шаардлагатайг танилцуулах.
- Ажилтнуудад өвчтэй байхдаа мөн халуурах, ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй зэрэг шинж тэмдэг илэрч байвал эмчид хандах, гэрээсээ гарахгүй байх тухай танилцуулах.
- Сэжигтэй тохиолдлын талаар Эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх.
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн тойрны ажилчдад хүргэх, болзошгүй үр дагаврыг мэдээлэх (ойлгомжтой, тодорхой давтамжтай, баримтад суурилсан мэдээллийг хүртээмжтэй байдлаар өгөх).

Хэрэв тухайн ажлыг түр зогсоох, ажилчдыг түр эсвэл бүрмөсөн цомхотгох шаардлагатай гарсан үед төслийн гүйцэтгэгч нь Олон Улсын Санхүүгийн корпорацын баримталдаг сайн туршлагыг дагаж мөрдөх ёстой⁴⁰. Үүнд,

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнө ажилчидтай болон ажилчдын төлөөллүүдтэй зөвлөлдөх.
- Ажлыг түр зогсоох эсвэл цомхотгох боломжит хувилбаруудыг авч үзэх.
- Цомхотгож болох ажлын байрны тоог цөөлж тухайн байгууллагын хувь хүн, бүлэг, ажилтнуудад үзүүлэх нөлөөллийг бууруулах замыг эрэлхийлэх (жишээлбэл, ажил зогсох үед нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цагийн ажлын төлбөр, урьдчилсан үйлчилгээ үзүүлэх).
- Бүх ажилчид өртөөгүй тохиолдолд тухайн нөлөөлөлд өртсөн ажилчдыг шударга, ил тод байдлаар сонгож авсан эсэхийг шалгах. Тодорхой нэр бүхий ажилчдыг ялгаварлан гадуурхахыг төслийн хувьд хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд цаашдын хамтын ажиллагааг зогсоох боломжтой.
- Төслийн гүйцэтгэгч болон ТХГН-аас өгсөн ажилчдын гомдлын механизмыг ашиглах, мөн асуудлыг сонсох, шийдвэрлэх журамтай танилцах боломжийг харилцан ойлголцох.
- Түр хугацаагаар цомхотголд орсон эсвэл ажил нь түр зогссон ажилчидтай харилцаа холбоог тогтоох боломжийг хангах, тэдний нөхцөл байдлын талаар тогтмол мэдээлэл авах төлөвлөгөөг гаргах.

⁴⁰ КОВИД-19 тахлын контекстэд буулгасан эрсдэлийг багасган удирдах талаарх ОУСК-ийн сайн туршлагын тэмдэглэл, Коронавирусын халдвар (КОВИД-19) -тай холбоотой Байгаль орчин, Нийгмийн эрүүл мэнд, Аюулгүй байдлын (БОННМ) эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийн хуудас, 2020 оны 4-р сар.

Хавсралт 5: Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний загвар

Энэхүү хавсралтад В ангиллын дунд эрсдэлтэй буюу төслийн үйл ажиллагааны хүрээнд авч үзэх шаардлагатай байгаль орчин, нийгмийн ердийн нөлөөлөл болон холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний (БОНМТ) гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тоймлон авч үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь төслийн гүйцэтгэгчтэй хамтран энэхүү баримт бичгийг удирдамж болгон ашиглах бөгөөд талбайн үнэлгээний аргачлалаар тодорхойлогдсон төслийн тодорхойлолт, шинж чанар, эрсдэлд нэмэлт өөрчлөлт оруулна. Иймд энэхүү БОНМТ-ний загварыг төслийн хүрээнд “энэ хэвээр нь” ашиглаж болохгүй бөгөөд харин төслийн талбай дээр анхан шатны дүн шинжилгээ хийх явцад тодорхойлсон байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, холбогдох эрсдэлтэй уялдуулан БОНМТ-г боловсруулна. Анхан шатны дүн шинжилгээний явцад хамааралгүй гэж тодорхойлсон асуудлыг цаашид авч үзэх шаардлагагүй. Гэсэн хэдий анхан шатны дүн шинжилгээний үр дүнгээс үл хамааран БОНМТ-нд **тодруулсан болон доогуур нь зурж тэмдэглэсэн** зүйлсийг үргэлж анхаарч үзэж байх шаардлагатай.

Иймд төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь энэхүү хавсралтад үзүүлсэн загварын дагуу БОНМТ-тэй холбоотой тайланг гаргаж өгөх шаардлагатай. БОНМТ нь байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого (БОНМБ)-д заасан стандарт журмыг үндэсний болон олон улсын стандартын дагуу баталгаажуулах бөгөөд үүнд дараах зүйлс орно.

- Төслийн гүйцэтгэгчийн ажилтны ёс зүйн дүрэм: БОНМБ-ын Хавсралт 7.
- Санал хүсэлт гомдлын механизм .
 - Төслийн оролцогч талуудад: БОНМБ-ын 5 бүлэг.
 - Төслийн ажилчдын хувьд: БОНМБ-ын 7 бүлэг.
- Гэнэтийн ослын тайлан: БОНМБ-ын 7, 5 бүлэг Хавсралт 5
- Санамсаргүй олдворын менежмент: БОНМБ-ын 6 бүлэг болон Хавсралт 10.

БОНМБ-ийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэмд тусгасан **БОЛНО** мөн **БОЛОХГҮЙ** (Хавсралт 2-ыг харна уу) зааварчилгаа нь (барилга угсралт) ажлын явцад ашиглах ерөнхий туршлагын талаарх мэдээллийг өгдөг. Эдгээр зөвлөмжийг БОНМТ-ийн агуулгаас үл хамааран ашиглах бөгөөд хавсралтад оруулах шаардлагатай.

1. БОНМТ-ийн агуулга бүтэц

1.1. Танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч агентлаг (ТХА) <ТХА –ийн нэр> барихаар төлөвлөж байгаа <хөндлөнгийн оролцох байгууллагын нэрийг, жишээ нь сургууль, ус түгээх систем гэх мэт.> (“үйл ажиллагаа”). Үйл ажиллагаа явагдах барилгын талбай <байршил/ сум, тосгон/ аймаг>. Барилга угсралтын ажлыг гүйцэгч байгууллагаар хийгдэх тул (төслийн гүйцэтгэгч) <төслийн гүйцэтгээгч байгууллагын нэр> болон туслан гүйцэтгэгч байгууллага: <хэрвээ тодорхой болсон бол туслан гүйцэтгээгч байгууллагын нэр>. Барилга угсралтын ажил нь төслийн хэрэгжилтийн зөвлөх баг <хэрвээ тодорхой болсон бол хэрэгжилтийн зөвлөхийн нэр>.

Энэхүү Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөний (БОНМТ) зорилго нь төслийн барилгын угсралтын үе шатанд хамаарах байгаль орчин, нийгмийн (БОН⁴¹) чиглэлд хийхээр амласан арга хэмжээнүүдийн хураангуйг хамарна.

Энэхүү арга хэмжээнүүд нь байгаль орчин (агаарын бохирдол, биологийн олон янз байдал, байгаль орчны бохирдол гэх мэт), мөн нийгмийн асуудлууд (хүний эрхийг хамгаалах, орон нутгийн оролцогч талуудтай харилцах, ажилчид болон олон нийтийн аюулгүй байдал гэх мэт)-д анхаарлаа хандуулдаг. Энэхүү БОНМТ-д тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ системтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд байгаль орчин, нийгмийн менежментийн системийн дагуу хэрэгжүүлэх бөгөөд үүнд төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн хэрэгжилтийн зөвлөх баг болон төслийн гүйцэтгэгч хоорондын үүрэг, хариуцлагыг багтаасан болно.

Энэхүү БОНМТ-д оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах, мөн аливаа байгаль орчин, нийгмийн талаарх мэдээллийг тусгах үүднээс төслийн төлөвлөлт болон барилга угсралтын явцад БОНМТ-г цаг тухайд нь шинэчилж байна.

1.2. Үйл ажиллагааны тайлбар

Үйл ажиллагааны тайлбарыг нэмнэ үү. Энэхүү тайлбар нь дараах зүйлсэд үндэслэсэн байх ёстой. Үүнд,

- a) *Шаардлагатай бичиг баримт (жишээлбэл, техникийн зураг төсөл, одоо байгаа төслийн тодорхойлолт, газрын зураг, агаарын зураг) болон*
- b) *Төсөл хэрэгжих газрын ерөнхий байдлыг ойлгох, мөн чухал ач холбогдол бүхий байршилыг тогтоохын тулд төсөл хэрэгжих газрын талбай дээр ажиллах. Газар өмчлөл, газар ашиглалт, орон нутгийн боломжит нөөц (нийгэм, соёл, эдийн засаг, экологийн төлөв байдал зэрэг), хязгаарлалтыг тогтоохын тулд (хэрэв байгаа бол) орон нутгийн иргэдтэй уулзалт ярилцлага хийх хэрэгтэй.*

Доор дурдсан гарчигт хамааралтай байж болох сэдвүүдийг оруулан үйл ажиллагааны талаар тодорхой мэдээллээр бөглөнө үү.

1.3. Анхан шатны дүн шинжилгээний мэдээллийн хураангуй

- *Байгалийн унган төрхөөрөө байгаа газар (хүний нөлөөлөлд өртөөгүй) эсвэл талхлагдсан газрын (өмнө нь хүний нөлөөлөлд өртөн газар) бүтээн байгуулалт уу?*
- *Газар өмчлөлийн хэлбэр нь ямар байна вэ? Ашиглагдах газар нь хэний өмч вэ? (үүнд албан бус болон уламжлалт хэрэглэгчид мөн газар эзэмших эрх эсвэл зөрчилтэй газрын нэхэмжлэл гэх мэт),*
- *Одоогоор газар хэрхэн ашиглагдаж байгаа вэ? (газар тариалан, бэлчээр, ой, ашиглагдаагүй газар, эсвэл хоосон сул газар гэх мэт)*
- *Байгаль орчин болон нийгмийн суурь үзүүлэлт, мэдэгдэж байгаа болзошгүй нөлөөллийн талаар товч тайлбар өгнө үү. Ойролцоо тусгай хамгаалалттай газар нутаг, соёлын ач холбогдолтой газар байгаа юу? Энэ нутагт үндэстний цөөнх амьдардаг уу? Хамгийн ойрын сууринаас хэр хол байдаг вэ?*
- *Ойролцоо өөр барилга угсралтын ажил хийгдэж байгаа эсэх?*

⁴¹ Хялбар байх үүднээс энэхүү баримт бичигт БОН товчлолыг ашигласан боловч энэ товчлолыг байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний эрх, хөдөлмөрийн асуудал гэж тайлбарлах нь зүйтэй.

- *Үйл ажиллагаа явагдаж байгаа газар, мөн холбогдох дэд бүтэц (жишээлбэл, ус дамжуулах шугам хоолой) байрладаг газрыг хамарсан төслийн нөлөөллийн бүс нь ямархуу байх вэ? Боломжтой бол нөлөөллийн бүсийг газрын зурагт үзүүлэх.*
- *Холбогдох нэмэлт мэдээллийг өгнө үү.*

1.4. Төслийн үйл ажиллагаа

- *Үйл ажиллагааны төрлийг тодорхойлох, жишээлбэл: барилга (жишээ нь, орон сууц, сургууль, эрүүл мэндийн төв, эмнэлэг), дэд бүтэц (ус дамжуулах хоолой, худаг, мал услах цэг), жижиг усалгааны далан, жижиг усалгааны дэд бүтэц гэх мэт.*
- *Бэлтгэл болон барилга угсралтын ажлын явцад хийгдэх ажлуудыг тодорхойлох, жишээ нь. талбайг тэгшлэх, газар шорооны ажил хийх, хуучин барилгуудыг нураах, хүнд даацын техник ашиглах, нэвтрэх зам барих, цахилгаан хангамж гэх мэт.*
- *Боломжтой бол төлөвлөлтийн газрын зургаар (техникийн зураг) хангах.*

1.5. Оролцогч талууд

Олон нийтийн оролцоонд зориулсан БОНМБ-ынн журмын дагуу холбогдох оролцогч талуудын зураглалыг гаргаж, БОНМБ-ийн 5-р бүлэгт заасан хүснэгтийн загварын дагуу бөглөнө үү. Үүнд,

- *Үйл ажиллагаанд оролцож буй хууль ёсны байгууллага /эрх бүхий баригчид/ яамдын нэрийг оруулна.*
- *Орон нутгийн бусад оролцогч талуудыг тодорхойлох, жишээ нь. одоогийн газар эзэмшигчид, мөн ашиглагчид, үйл ажиллагааны талбайн ойролцоох орон нутгийн иргэд, орон нутгийн шийдвэр гаргагчид, бусад удирдагчид (уламжлалт эсвэл албан ёсны).*

1.6. Үүрэг хариуцлага

Доорх гарчгийн дагуу төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч нарын хариуцлагыг тодорхойлно уу.

Төсөл Хэрэгжүүлэгч Агентлаг

Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн хэрэгжилтийн зөвлөх баг нь төслийн үйл ажиллагааны барилга угсралтын үе шатанд байгаль орчин, нийгмийн менежментийг бүхэлд нь хариуцна. Үүнд дараах үүрэг хариуцлагууд орно:

- Холбогдох хууль тогтоомжийн нийцэл, мөн энэхүү БОНМТ-д тусгагдсан байгаль орчны хяналт, нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах
- Зураг төсөл, төслийн төлөвлөлт нь үндэсний шаардлага болон олон улсын сайн туршлагад нийцүүлсэн эсэхийг баталгаажуулах.
- Ажиллах хүч, хангамж, үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллаж буй төслийн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих (хяналтын заалтыг харна уу).
- Оролцогч талууд болон олон нийттэй зөвшилцөх санал хүсэлт гаргахад холбох ажлын үүргийг гүйцэтгэх.
- Барилгын ажилчдыг байгаль орчин, нийгмийн талаарх ойлголтыг сайжруулах болон БОНМТ-ийн ерөнхий хэрэгжилтийн талаарх мэдээллийг өгөх сургалт явуулах .

Төсөл хэрэгжүүлэгч агентлагийн доторх хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. Энэхүү БОНМТ-ийн хэрэгжилтийг хэн хариуцах вэ? Хэн хяналт тавих үүрэгтэй

вэ? Төслийн гүйцэтгэгч байгууллагын БОНМТ-ний хэрэгжилт, мөн байгаль орчин, нийгмийн менежментийн гүйцэтгэлд хэн хяналт тавих вэ?

Хэрэв боломжтой бол байгууллагын танилцуулга бүдүүвчийг үзүүлнэ үү.

Төслийн гүйцэтгэгч

Төслийн гүйцэтгэгч нь энэхүү БОНМТ-д хүлээсэн үүргээ биелүүлэх мөн туслан гүйцэтгэгч нар БОНМТ-г хэрэгжүүлэхийг баталгаажуулах шаардлагатай. Үүнд,

- БОНМТ-ийн хэрэгжилтийг шалгахын тулд мониторинг судалгаа хийх, мөн төслийн талбай дээр нь аудит хийж (Хяналтын заалтыг харна уу) улмаар төсөл хэрэгжүүлэгч агентлагт үр дүнгийн талаар тайлан мэдээ гаргаж өгөх.
- Байгаль орчинтой холбоо ямар нэгэн асуудал гарах, мөн болсон үйл явдлын талаар тухай бүрд нь төсөл хэрэгжүүлэгч агентлагт нэн даруй мэдэгдэх.
- БОНМТ-ийн ерөнхий хэрэгжилтийн хүрээнд байгаль орчин, нийгмийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд барилгын ажилчдыг сургахад төсөл хэрэгжүүлэгч агентлагийг дэмжих.

Төслийн гүйцэтгэгчийн дотоод үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. Энэхүү БОНМТ-ний хэрэгжилтийг хэн хариуцах вэ? Хэн хяналт тавих үүрэгтэй вэ? Байгаль орчин нийгмийн менежмент болон энэхүү БОНМТ-ийн хэрэгжилтийн талаар туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэлд хэн хяналт тавих вэ?

Хэрэв боломжтой бол байгууллагын танилцуулга бүдүүвчийг үзүүлнэ үү.

Бусад хуулийн этгээд

Төслийн хамтрагч талуудад (төрийн байгууллагууд) БОНМТ-ийн талаар мэдээлэл өгч, түүнийг хэрэгжүүлэхэд хамтран оролцоно. Мөн эдгээр эрх бүхий байгууллагын хариуцлагыг тодорхойлно.

Сургалт

Төсөл хэрэгжүүлэх агентлаг нь үйл ажиллагаа эхлэхийн өмнө төслийн хэмжээнд ажиллаж буй нийт ажилчид болон төслийн гүйцэтгэгчийн ажилтнуудад танилцуулга сургалтыг зохион байгуулна. Энэхүү сургалтыг төслийн үйл ажиллагаа эхэлсний дараа буюу барилга угсралтын ажлын үед ажилд орсон бүхий ажилчдыг хамруулна. Энэхүү танилцуулга сургалтын зорилго нь төсөл хэрэгжүүлэгч агентлагийн ажилтнууд болон төслийн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нарт дараах мэдээллийг өгөхөд оршино.

- Энэхүү БОНМТ-д тусгасан нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тэдгээрийг талбай дээр хэрхэн хэрэгжүүлэх, мөн холбогдох үүрэг хариуцлагын талаар.
- Төслийн барилгын болон ашиглалтын үе шатанд тухайн талбайд байх чухал ач холбогдол бүхий байршил.
- Барилгын талбай дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм (жишээлбэл хувийн хамгаалах хэрэгсэл, үйл ажиллагааны дүрэм, анхны тусламж)
- Төслийн гомдол барагдуулах механизм ба ажиллаж буй ажилчдын үндсэн эрхүүд. (БОНМБ-ын 1.1-р бүлэг)
- Олон нийтээс ирсэн (орон нутгийн иргэдээс ирсэн асуулт) гомдлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
- Барилгын талбайн ойролцоо амьдарч буй иргэдтэй харилцах дүрэм (ёс зүйн дүрэм) мөн талбай руу зөвшөөрөлгүй нэвтэрсэн иргэдтэй хэрхэн харилцах талаар.
- Урьдчилан таамаглаагүй үйл явдал, онцгой байдлын үед хэрхэн ажиллах вэ?.

- Төсөл хэрэгжүүлэгч агентлаг, төслийн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон ажилчдын хүрээнд байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой үүрэг, хариуцлага.
- БОНМБ-ийн бүлэг 7.4 болон Хавсралт 2.1-ийн дагуу ковид-19 халдварын эрсдэлийг бууруулах.

Төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь сургалтын бүртгэлийг хөтөлж явуулна. Мөн барилга угсралтын ажлын явцад шаардлагатай үед сургалтыг давтан хийнэ.

Сургалт нь хамгийн багадаа дээрх сэдвүүдийг багтаасан байх ёстой. Шаардлагатай тохиолдолд сургалтад сэдэв нэмэхийн тулд дээрх текстийг засаж болно. Танилцуулга сургалт дууссаны дараа давтан сургалт хийх шаардлагатай байж болно. Ялангуяа барилгын ажилчдад зориулсан сургалтын нарийвчилсан төлөвлөгөө гаргах нь төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч нарын үүрэг юм.

Оролцогч талуудын оролцоо, санал хүсэлт, гомдол

Төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь оролцогч талуудтай харилцах ажилтныг томилж төслийн төлөвлөсөн үйл ажиллагаа, цаг хугацаа, тооцоолсон нөлөөлөл мөн харилцааны сувгуудын талаар орон нутгийн иргэдэд төслийн эхний үе шатанд мэдээлэх хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь мөн үйл ажиллагааны талаар олон нийтээс санал хүсэлтийг авах хэрэгтэй. Олон нийттэй харилцах үйл явцынхаа нэг хэсэг болох төсөл хэрэгжих агентлаг нь оролцогч талуудын бүх санал, санал, эсэргүүцлийг хүлээн авч, харгалзан үзэхийн тулд гомдол барагдуулах механизмыг санаачлан хэрэгжүүлнэ. Энэ нь нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд болон ажилчид санал хүсэлтээ төсөл хэрэгжүүлэгч агентлагт шууд илэрхийлэх боломжийг олгодог. Холбоо барих хаяг, журмын талаарх мэдээлэл, тэр дундаа гомдлын маягтыг орон нутгийн иргэдэд тараана.

Бүх санал, гомдлыг төсөл хэрэгжүүлэгч агентлагаас шалгаж, шаардлагатай бол зохих арга хэмжээг авна. Бүх гомдол, үйл ажиллагааны бүртгэлийг газар дээр нь хөтөлнө.

Төслийн олон нийтийн оролцооны төлөвлөгөө болон БОНМБ-д тусгагдсан санал хүсэлт, гомдол барагдуулах механизмын лавлагааг оруулна уу. Энэхүү БОНМТ-ийг боловсруулах ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь үйл ажиллагааны бүсэд очиж, хөрш зэргэлдээх олон нийттэй (хэрэв байгаа бол) ярилцлага хийх ёстой.

Байгаль орчин, нийгмийн асуудлын бүртгэл

Энэ хэсэгт ихэвчлэн бага, дунд хэмжээний барилга байгууламж, дэд бүтцийн төслүүдэд хэрэглэгдэх сайн туршлагын арга хэмжээг тусгасан болно. Бүс нутгийн нөхцөл байдал, улирлын шинж чанар, төслийн техникийн үзүүлэлтүүдээс шалтгаалан доорх хэсэгт болон БОНМТ-ийн загвар хүснэгтэд дурдсан бүх асуудал, нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь төсөл бүрд хамааралгүй байж болно. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хасахдаа нарийн үндэслэлтэй байх ёстой. Мөн шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ БОНМТ-д нэмж болно.

Төслийн загвар болон төлөвлөлт

Энэхүү үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч агентлаг дараах үндсэн асуудлуудыг харгалзан төлөвлөнө. Үүнд,

- Иргэдийн хувийн газрыг авах болон нүүлгэн шилжүүлэлт хийхээс зайлсхийх
- Ой мод, тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн чухал ач холбогдол бүхий газраас зайлсхийх

- Соёлын хувьд чухал ач холбогдол бүхий газруудаас (жишээ нь мөргөлийн газар, шүтээн мод г.м) зайлсхийх
- Үйл ажиллагааны төлөвлөлтөд анхаарах асуудлууд. Үүнд,
 - Голлох болон ерөнхий засвар үйлчилгээ болон үйл ажиллагаанууд нь олон нийт болон ашиг хүртэгчид нар хэрэгжүүлэх боломжтой эсэхийг баталгаажуулах.
 - Барилгын зураг төсөлд засвар үйлчилгээ бага шаарддаг шийдлийг ашиглах, жишээ нь орон нутгийн ижил төрлийн бусад барилгуудад үндэслэх.
 - Барилгын агааржуулалтын систем нь цаг агаар болон байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байдлыг харгалзан үзэх
 - Төслөөс ашиг хүртэж буй хүмүүстэй хамтран засвар үйлчилгээний төлөвлөгөө гаргах.
- Орон нутгийн нөөцийг ашиглахдаа барилга угсралтын үйл ажиллагаанаас үүсэх замын хөдөлгөөн түүнтэй холбоотой олон нийтэд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх.
- Үйл ажиллагааг төлөвлөхдөө байгалийн нөөцийн (түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, газар) ашиглалтыг аль болох бага байлгах үүднээс үйл ажиллагаагаа төлөвлөх.
- Нүүрстөрөгчийн ул мөрийг багасгах, барилга угсралтын ажлын нөлөөллийг бууруулахын тулд үйл ажиллагааг уур амьсгалд ээлтэй байдлаар төлөвлөх .
- Үйл ажиллагааны талбайн эргэн тойронд амьдарч буй хүмүүсээс (ойр орчимд амьдардаг иргэд болон нутгийн удирдлагууд) төслийн төлөвлөлтийн үед болон барилга угсралтын ажлын явцад баригдахаар төлөвлөгдөж буй барилгын талаар мэдээлэх болон түүнчлэн болзошгүй (хамгаалагдсан газар, мөргөл үйлддэг ариун газар, шүтээн мод гэх мэт) нөлөөлөлд өртөмтгий байдлын талаар санал хүсэлтийг нь авах. Зураг төсөл боловсруулах болон төлөвлөх үе шатанд төслийн талбайтай танилцаж орон нутгийн иргэдтэй ярилцах шаардлагатай. Төлөвлөлтийн үе шатанд ажилчид болон олон нийтэд зориулсан гомдол барагдуулах механизмыг боловсруулах.
- Орон нутгийн нийгмийн хөгжлийг дэмжихийн тулд төсөл хэрэгжиж буй орон нутгаас мэргэжлийн болон мэргэжлийн бус ажилчдыг ажилд авах.
- Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө энэхүү БОНМТ-д заасны дагуу ажилчдад зориулсан танилцуулга сургалт явуулах
- Төлөвлөлтийн үе шатанд гол байгаль орчин, нийгмийн үндсэн журмыг бий болгосон байх хэрэгтэй. Үүнд:
 - Гэнэтийн осол аваарыг мэдээлэх (үхэлд хүргэсэн, эмнэлгийн тусламж авсан, анхны тусламж авсан тохиолдлууд болон хязгаарлагдмал орчны гэмтэл, мөн ойр дотнын хүмүүс, гэмтэл байгаль орчны эрсдэлүүд)
 - Гомдол барагдуулах механизм (ажилчид болон олон нийтэд зориулсан хосолсон механизм).
 - Удахгүй баригдах барилга угсралтын үе шатанд ажилчдыг ажилд авах журам.
 - Дээр дурдсан сургалтын журам болон сургалтын материал (ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мөн орон нутгийн иргэдийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны мэдрэмтгий байдал)
 - Ажлын талбай буюу барилгын талбайн эрсдэлийн үнэлгээ ба холбогдох барилгын ХАБЭА-н төлөвлөгөө.

Төслийн хэрэгжилт

БОНМТ-ийн ерөнхий загвар хүснэгтэд төслийн үйл ажиллагааны явцад төслийн гүйцэтгэгч нь Төсөл хэрэгжүүлэгч агентлагийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэх байгаль орчин нийгмийн хариуцлага, холбогдох амлалтыг тодорхойлсон.

Хүснэгт нь дараах бүтэцтэй байна.

- A – Байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн ерөнхий шаардлага,
- B – Байгаль орчны хамгаалал,
- C – Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- D – Хөдөлмөр эрхлэлт ба орон нутгийн иргэдтэй харилцах харилцаа

Хүснэгт дэх дугаарлалт нь үргэлжилсэн биш учир нь энэ нь Германы сэргээн босголт, Зээлийн банкны тендерийн баримт бичгийн байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын зүйлд хамаарна. : <https://www.kfw-entwicklungsbank.de/International-financing/KfW-Development-Bank/Publications-Videos/Publication-series/Guidelines-and-contracts/>

Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
А. Байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн ерөнхий шаардлага				
<u>A1Хариуцлага болон үүрэг</u> ⁴²	Бүх ажилчид, ханган нийлүүлэгчид болон туслан гүйцэтгэгчид энэхүү Байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага болон БОНМТ-ний техникийн үзүүлэлтүүдийн талаар мэдээлэлтэй байгаа эсэх, дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах	Анхан шатны сургалтыг хийж бүртгэсэн байх . Төслийн гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчид гэрээ байгуулсан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Сургалтын бүртгэл хөтлөх Үйл ажиллагаанд шаардлагуудыг багтаасан эсэхийг баталгаажуулахын тулд гэрээг хянан үзэх.
	Энэхүү БОНМТ-г тодорхой үйл ажиллагаанд тохируулан, хяналтын үйл явцын давтамжийг тодорхойлон төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон Германы сэргээн босголт, зээлийн банканд мэдээлнэ. Цаашид Менежментийн төлөвлөгөөг бэлтгэх шаардлагатай эсэхийг тодорхойлох.	Төслийн үйл ажиллагааны талбайд зориулан БОНМТ боловсруулах.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагааны онцлогт тохирсон БОНМТ-г дуусгахаас өмнө хянан шалгах.
<u>A4. Байгаль орчин нийгмийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн менежментэд нөөцөд зориулсан төсөв</u>	Байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг хариуцах ажилтнуудыг ⁴³ томилон хариуцлагыг тодорхойлох мөн оролцогч талуудтай харилцах үүрэгтэй олон нийттэй харилцах ажилтан томилох.	Төслийн талбайд зориулсан БОНМТ Байгаль орчин нийгэм, аюулгүй байдал болон эрүүл ахуйн хариуцлагын талаар холбогдох байгууллагад мэдээлэх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагааны онцлогт тохирсон БОНМТ-г дуусгахаас өмнө хянан шалгах.

⁴² Төсөл хэрэгжих гарзны үнэлгээний үр дүнгээс үл хамааран БОНМТ-ний тод, доогуур зураастай зүйлсийг үргэлж анхаарч үзэх хэрэгтэй.

⁴³ Ихэнх улс оронд 50 ба түүнээс дээш ажилчинтай газар дээр байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер шаардлагатай байдаг

A6. Тайлан мэдээлэх	Осол аваар, ойрын аюул болон төслийн үйл явцын талаар мэдээлэх	Төслийн талбайд зориулсан БОНМТ Байгаль орчин нийгэм, аюулгүй байдал болон эрүүл ахуйн ослын талаар мэдээлэх, тэмдэглэл хөтлөх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагааны онцлог тохирсон БОНМТ-г дуусгахаас өмнө хянах
A7. Ёс зүйн дүрэм	Хууль тогтоомжийг харгалзан аюулгүй байдлын дүрэм, мансууруулах бодис хэрэглэх, хүрээлэн буй орчны нөлөөлөлд өртөмтгий байдал, халдварт өвчин болон жөндөрийн асуудал мөн орон нутгийн иргэдийн итгэл үнэмшил, ёс заншлыг хүндэтгэн олон нийтийн харилцааг зохицуулах ёс зүйн дүрмийг бий болгох.	Ажилчдад хамаарах ёс зүйн дүрэм (БОНМБ-ийн хавсралт 7-г харна уу)	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Ёс зүйн дүрмийн танилцуулгыг хянах Шударга бус болон шийтгэсэн үйлдлийн талаар мэдээлэх Гомдол барагдуулах механизмыг хянах
A8. Байгаль орчин нийгэм, аюулгүй байдал болон эрүүл ахуйн сургалт	Үйл ажиллагаанд хамрах хүрээнд тохируулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны сургалт олгох.	Сургалт зохион байгуулж бүртгэсэн байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Сургалтын бүртгэлийг хянаж үзэх
В. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ				
В10. Ойролцоох газар нутгийг хамгаалах	Хур тунадас ихтэй үед газар шорооны ажил хийхгүй байх. Мөн хур тунадасны усруу химийн бодис, тос асгарах эрсдэлийг бууруулахын тулд түр зуурын бэхэлгээг ашиглах.	Хур бороо ихтэй үед газар шорооны ажил хийхгүй.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Газар шорооны ажил эхлэхээс өмнө цаг агаарын урьдчилсан мэдээ болон талбайн нөхцөл байдлыг шалгах
	Ухсан нүхэнд ус хуримтлуулахгүйн тулд шуудуу ухах	Ухсан нүхэнд ус орохгүй байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх

			төслийн гүйцэтгэгч	
	Ажлын талбайн доторх ургамлууд, хөрс, гүний болон гадаргын ус, биологийн төрөл зүйл, байгалийн урсац болон усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл бууруулах арга хэмжээр хангах. Нөлөөллийг аль болох бууруулах барилга угсралтын арга барилууд ашиглах.	Ойролцоох бүсэд ямар нэгэн нөлөөлөл илрэхгүй байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагааны бүсийн ойролцоох байгалийн нөөцөд хяналт тавих.
	Барилга угсралтын бүхий л үйл ажиллагаа нь тухайн бүсийн дотор явагдах ёстой бөгөөд анх төлөвлөгдсөн төлөвлөгөөний дагуу байхаар хангах.	Ажлын талбайн хил заагийг анхааруулах тэмдэглэгээ ашиглан тэмдэглэх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө төслийн талбайд хяналт тавих
	Төслийн талбайг Намгархаг газраас хол байхаар хангах	Барилгын угсралтын өмнөх шатанд тухайн талбай нь ус намгархаг газар эсэхийг шалгах.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбай сонгох явцад
	Усны эх үүсвэр болон үерт автдаг газар мөн хотын нөлөөлөлд өртөмтгий барилга байгууламж (эмнэлэг, сургууль, хүн амын ундны усны эх үүсвэр), орон сууцны хорооллоос зайлсхийх	Ажлын талбайн хил заагийг өгөгдсөн хязгаарын дагуу анхааруулах тэмдэг ашиглан тэмдэглэх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө төслийн талбайд хяналт тавих.
	Барилгын ажил дууссаны дараа талбайг тогтвортой, цаашид урт хугацаанд ашиглах боломжтой мөн байгалийн жамаар нөхөн сэргэх боломжтой болгох.	Үзэгдэх орчныг хянах, мөн зэргэлдээх нөлөөлөлд өртөөгүй газартай харьцуулах.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Байнгын хяналт

	Үзэгдэх орчны нөлөөллийг бууруулах.	Үзэгдэх орчныг хянах, мөн зэргэлдээх нөлөөлөлд өртөөгүй газартай харьцуулах.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах
B11. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох болон овоолгын талбай руу нэвтрэх замыг сонгох	Дүүргэлтийг материалыг олборлох талбайг сонгох түүний овоолгын байршлыг тогтоох үед нэвтрэх зам шаардлагатай тохиолдолд засах	Сонгосон зориулалтын бүсүүд	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайг сонгох үед нэг удаа хянах
	Мод нь тоос тоосонцрын бохирдлоос хамгаалдаг тул овоолгын талбайг модтой газруудад сонгох.	Сонгосон зориулалтын бүсүүд	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайг сонгох үед нэг удаа хянах
	Барилга угсралтын үйл ажиллагаанд хэрэглэсэн дүүргэлтийн материалыг орон нутгийн удирдлагуудын зөвшөөрсөн газарт хадгалах	Сонгосон зориулалтын бүсүүд	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайг сонгох үед нэг удаа хянах
	Хогийн цэгийг нөлөөлөлд өртсөн газарт байршуулах (сонгох)	Сонгосон зориулалтын бүсүүд	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайг сонгох үед нэг удаа хянах
B12. Бохирдлоос урьдчилан сэргийлэх	Үйл ажиллагааны бүхий л хугацааны туршид гүйцэтгэж буй бүх ажлын (шингэн хаягдал, дуу чимээ болон чичиргээний менежмент, агаарын бохирдол, тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн сонголт түүний засвар үйлчилгээ, түлш тос мөн химийн бодисыг	Болзошгүй бохирдуулагч бодисыг нөлөөлөлд өртөмтгий хүлээн авагчдаас (ялангуяа усны урсцын хэсэг) 50м дотор	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд байнга хяналт тавих Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах

	хадгалах, боловсруулах) нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах аар хангах .	хадгалахгүй байх, түүнийг баталгаажуулах.		
B13. Бохир ус	Барилга угсралтын ажлын үе гарсан бохир ус болон ариун цэврийн байгууламжийн бохирыг зохих ёсоор хадгалах мөн цэвэрлэгдээгүй бохир усыг гадагшлуулж болохгүй.	Бохир усыг цэвэрлэхгүйгээр гадагшлуулахгүй байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд байнга хяналт тавих Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах
B14. Хийн ялгаралт ба тоос тоосонцор	Тээврийн хэрэгслийг боломжтой техникийн нөхцөлд ашиглах мөн утаа ялгаруулалтыг багасгах төхөөрөмжөөр хангах (жишээ нь шүүлтүүр)	Техникийн тодорхойлолтын хуудас	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд үйл ажиллагаа эхлэхийн өмнө болон шинээр тоног төхөөрөмж тээврийн хэрэгсэл ашиглах бүрд хянах Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах Тогтмол харж шалгаж байх
	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тухайн орон нутагт хэрэглэгдэж байгаа хүхрийн агууламж багатай түлш хэрэглэх.	Техникийн тодорхойлолтын хуудас	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Шаардлагатай баримт бичгийг тогтмол шалгаж байх.
	Ашиглаагүй буюу шаардлагагүй үед тээврийн хэрэгслийг унтрааж байхыг жолооч нарт анхааруулах	Хөдөлгүүр унтарсан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайн хяналтаар
	Хуурай салхитай тээвэрлэлтийн үед тоосжилтоос сэргийлэх сайн туршлагыг ашиглах жишээ нь зохих овоолго хийх, усалгаа хийх гэх мэт.	Усалгаа тогтмол хийж, тоосжилт үүсээгүй байх мөн ажилчдаас ямар нэг гомдол гараагүй байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд байнга хяналт тавих Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах

	Хурдны хязгаарын тогтоож жолооч нарт анхааруулах	Хурдны хязгаарын тэмдэглэгээ байршуулах Сургалт хийж бүртгэл явуулах. Осол аваарын тайлан мэдээ	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах Осол аваарын тайлан мэдээг хянах Сургалтын бүртгэлийг хянах
B15. Дуу чимээ ба чичиргээ	Шөнийн цагаар тээврийн хэрэгсэл ажиллуулах болон үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	Оройны 22 цагаас өглөөний 07 цагийн хооронд ажил хийгдэж болохгүй Гомдол санал хүсэлт ирэхгүй байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах Осол аваарын тайлан мэдээг хянах Сургалтын бүртгэлийг хянах
	Хурдны хязгаарын тогтоож жолооч нарт анхааруулах	Хурдны хязгаарын тэмдэглэгээ байршуулах Ажлын анхан шатны сургалтын нэг хэсэг болох жолоочийн сургалтын тэмдэглэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах Осол аваарын тайлан мэдээг хянах Сургалтын бүртгэлийг хянах
	Суурин тоног төхөөрөмжийг (цахилгаан үүсгүүр гэх мэт) ойролцоох хүлээн авагчаас (ажилчдын амрах газар, хүн амын суурьшлын бүс, байгаль орчны нөлөөлөлд өртөмтгий бүс) аль болох хол байрлуулах. Тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслээс гарах чуу	Тоног төхөөрөмж болон хүлээн авагчдын хоорондох зайг тогтоох	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө нэг удаа хянах Тоног төхөөрөмж ашиглаж байгаа тохиолдолд дуу чимээний түвшнийг хянаж байх

	чимээний түвшин 120дБ-ээс хэтрэхгүй байх ёстой.			Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах
B16. Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын байгууламж болон хог хаягдлын менежментийн төслийн гүйцэтгэгчийг тодорхойлох. Хог хаягдлыг боловсруулах, зайлуулах, дахин боловсруулах төрөл тус бүрээр тусгай зөвшөөрөлтэй төслийн гүйцэтгэгчээр дамжуулан устгана.	Боломжтой бол тусгай зөвшөөрөлтэй төслийн гүйцэтгэгчээр дамжуулан хог хаягдлын менежмент хийх Хог хаягдлын менежментийн гэрээ Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Хог хаягдлын менежментийн байгууламжуудыг шалгах. Төслийн гүйцэтгэгчийн гэрээг хянах Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэлийг хянах
	Үйл ажиллагаанаас гарсан бүхий л хог хаягдлыг зохих ёсоор цуглуулж, ангилж, хадгалах, тээвэрлэх, цэвэрлэх хэрэгтэй,	Хог хаягдал цуглуулах талбай нь хангалттай нөөцтэй байх Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Хог хаягдлын хэмжээг хянах Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэлийг хянах
	Хог хаягдлын аль болох багасгах	Хог хаягдлын бүртгэл хөтлөх Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө Сургалт явуулж, бүртгэл хөтөлсөн байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын хэмжээг хянах (жишээ нь сар бүр) Сургалтын бүртгэлийг хянах
	Хог хаягдалтай холбоотой (хог хаягдлын төрөл, хэмжээ гэх мэт) бүхий л үйл ажиллагааг баримтжуулах.	Хог хаягдлыг хадгалах тээвэрлэх, боловсруулах үйл явцыг баримтжуулах Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Хог хаягдлын хэмжээг хянах Хог хаягдал шилжүүлсэн тэмдэглэлийг хянах

		Хог хаягдлын хэмжээ		
	Түлш, барилгын материал зэрэг асгаралт үүсэж болзошгүй аливаа материалыг (жишээ нь эрчим хүчний үүсгүүрийн батарей) зохих аюулгүй газарт хадгалах.	Материалыг аюулгүй газарт хадгалах Асгаралт үүсэн тохиолдолд авах хариу арга хэмжээ Асгарсан үед хариу арга хэмжээ авах болон түүнийг арилгах тоног төхөөрөмжийг байрлуулах .	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх
B17. Ургамлын нөмрөгийн талхагдал	Ургамлан нөмрөгийн талхагдлыг төслийн талбайд зайлшгүй шаардлагатай хэсэгт хийнэ.	Ургамлан нөмрөгийн талхагдлыг хамгийн бага байх Ажлын талбайн хилийн заагийг тэмдэглэх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө талбайд хяналт тавих .
	Ургамлын талхагдлыг бууруулах, хамгаалах арга хэмжээг тайлбарлах. Жишээ нь химийн бодис, пестицид хэрэглэхгүй бөгөөд ургамлан нөмрөгийг шатаахгүй байх гэх мэт. Үйл ажиллагааны үед ургамлан нөмрөгийн талхагдлыг 2 сар түүнээс дээш хугацаанд үүсгэж болохгүй.	Төслийн талбайд ургамлан нөмрөгийг шатаах болон химийн материал хэрэглэхгүй байх. Төслийн үйл ажиллагааны талбайд ажлын хилийг бий болгох Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ ашиглах	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө төслийн талбайд хяналт тавих Ургамлан нөмрөгийн талхагдлын явцад төслийн талбайд хяналт тавих
	Нас гүйцсэн мод болон ховор зүйлийг устахаас зайлсхийх .	Нас гүйцсэн модыг талхагдал нөлөөлөлд өртүүлж болохгүй.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө төслийн талбайд хяналт тавих

			төслийн гүйцэтгэгч	
B18. Биологийн олон янз байдал.	Экологийн чухал ач холбогдол бүхий газруудаас аль болох зайлсхийх.	Экологийн чухал ач холбогдол бүхий газруудаас зайлсхийсэн байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайг сонгохоос өмнө үнэлгээ хийх Экологийн чухал ач холбогдол бүхий газрын үнэлгээг шаардлагатай тохиолд хийх
	Амьдрах орчныг сүйтгэхээс зайлсхийх.	Ямар ч амьдрах орчин сүйтгээгүй байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Барилга угсралтын үйл ажиллагаанд хяналт тавих.
B19. Элэгдэл үүсэхээс зайлсхийх	Хэрэв барилга угсралтын ажил налуу гадаргууд явагдаж байгаа тохиолдолд элэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр хангах бөгөөд (жишээ нь мод болон ургамлан нөмрөгийг хамгаалах төлөвлөгөө, зам болон ус зайлуулах шугам сүлжээнд байгалийн хүрээг ашиглах) хэрэглэх.	Элэгдлээс урьдчилан сэргийлэх түр зуурын болон байнгын арга хэмжээг хэрэгжүүлэх Техникийн болон биологийн нөхөн сэргээлт	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх
	Шимт хөрсийг хуулахдаа зохих ёсоор хадгалан барилга угсралтын ажил дууссаны дараа тухайн газрын биологийн нөхөн сэргээлтэд шимт хөрсийг ашиглана. Шимт хөрсийг дод давхаргын хөрстэй хольж болохгүй тул тусад нь хадгалах хэрэгтэй.	Шимт хөрсийг хадгалж нөхөн сэргээлтэд дахин ашиглана.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Шимт хөрсийг зохих ёсоор хуулж, хадгалж байгаа эсэхэд хяналт тавих.
	Овоолгын хамгийн тохиромжтой өндөр, хэлбэр	Овоолгын өндрийн хязгаар	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх

			төслийн гүйцэтгэгч	
B20. Төслийн үйл ажиллагааны талбайн нөхөн сэргээлт	Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа боломжтой бол тухайн нутгийн төрөл зүйлээр талбайг нөхөн сэргээх мөн ургамалжуулалтыг хангах.	Ургамалжуулах ажил дууссан байна.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа нэг удаагийн хяналт тавих
	Нөхөн сэргээлт хийсэн газрууд нь аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг (нүх, цөөрөм) үүсгэхгүй байхыг хангах .	Нөхөн сэргээх үйл ажиллагаа дууссан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа хяналт тавих Хүчтэй цас болон борооны дараа мөн хяналт тавих.
	Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа тухайн талбайг боломжит хамгийн сайн байдлаар нөхөн сэргээсэн байх.	Нөхөн сэргээх үйл ажиллагаа дууссан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа хяналт тавих Хүчтэй цас болон борооны дараа мөн хяналт тавих.

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
С. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй				
<u>C22. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө</u>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөг сайжруулах	Талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөг хянах

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
C24. Осол мэдээлэх	Төслийн үйл ажиллагааны талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой бүхий л гэнэтийн ослыг бүртгэж, мөн осол аваар мэдээлэх журмыг дагаж мөрдөх. (БОНМБ Хавсралт 5 – осол аваар мэдээлэх журмыг харна уу)	Гэнэтийн ослыг бүртгэх үйл явц	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Гэнэтийн осол аваарын бүртгэлийг шалгах
C28. Хувийн хамгаалах хэрэгсэл	Ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах (үйл ажиллагааны төрлөөс хамааран хамгаалалтын малгай, маск, хамгаалалтын шил гутал гэх мэт).	Төслийн үйл ажиллагааны талбайд бүх ажилчид хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах Сургалт зохион байгуулж, бүртгэл явуулсан байх	Төслийн гүйцэтгэгч болон төслийн үйл ажиллагааны талбайн менежер	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Сургалтын бүртгэлийг хянах
C31. Онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх	Барилга угсралтын үйл ажиллагааны дараа асгаралт үүсэн газрыг нэн даруй цэвэрлэж, мөн бохирдсон газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаагаар хангах	Ажилчдыг сургасан байх Яаралтай тусламжийн баг талбай дээр ажиллаж байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Асгаралт үүссэн тохиолдлын дараа төслийн үйл ажиллагааны талбайд хяналт шалгалт хийх Барилга угсралтын үйл ажиллагаа дууссаны дараа хяналт тавих Сургалтын бүртгэлийг хянах Яаралтай тусламжийн багийг хянах

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	Онцгой нөхцөл байдалд яаралтай хариу арга хэмжээ авахын тулд холбогдох дүрэм журмын дагуу урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж болон багийг газар дээр бэлэн байхаар хангах жишээ нь: гал түймэр, дэлбэрэлт, үер мөн байгалийн аюул гэх мэт	Урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж бэлэн байх мөн баг ажиллаж байх Сургалт зохион байгуулж, бүртгэл явуулсан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайн байнгын хяналт Тоног төхөөрөмжийн жагсаалтыг шалгах Яаралтай тусламжийн багийг хянах Сургалтын бүртгэлийг хянах
	Төслийн үйл ажиллагааны талбайн ажлын байрны аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах. Барилгын материал, хөнгөн тоног төхөөрөмжийг зохих ёсоор хадгалах.	Төслийн талбай дээр аюулгүй байдал сайн хангагдсан байгаа эсэхийг шалга	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх
С31.а. химийн хорт болон аюултай бодисын устгал	Ажил эхлэхийн өмнө химийн хорт болон аюултай материалын цэвэрлэх/устгал ажлыг дуусган баталгаажуулсан байна. Химийн хорт болон аюултай бодис илэрсэн тохиолдолд яаралтай тусламжийн бэлэн байдлын талаар олон нийт болон ажилчдад сургалт ёстой.	Устгалын ажлын тэмдэглэл Сургалтын тэмдэглэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Ажлын тэмдэглэл болон сургалтын тэмдэглэлийн хянаж үзэх хэрэгтэй.
<u>С33. Анхны тусламж</u>	Төслийн үйл ажиллагааны талбай дээр анхны тусламжийн хэрэгслээр хангах (Анхны тусламжийн иж бүрдэл зохих ёсоор бэлтгэгдсэн байх, зохих тооны анхны тусламж	Төслийн талбай дээр зохих тооны анхны тусламжийн иж бүрдлээр хангасан байх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг	Анхны тусламжийн хэрэгсэлд тогтмол хяналт тавих Анхны тусламжийн гэрчилгээг хянах

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	үзүүлэх ажилтнууд болон анхны тусламж үзүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгөх)	Бүх ээлжид анхны тусламж үзүүлэх ажилтны бэлэн байдлыг хангасан байх Анхны тусламжийн гэрчилгээ	болон төслийн гүйцэтгэгч	Орон нутгийн хууль тогтоомжид заасан анхны тусламжийн тоог хянах
C37. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж	Ажиллах хүчнийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг газар дээр нь авах, эмийн жороор болон вакцинжуулалтаар хангах.	Эрүүл мэндийн үйлчилгээг газар дээр нь авах боломжтой Эмнэлгийн үзлэг хяналтын бүртгэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах Эмнэлгийн үзлэгийн бүртгэлийг шалгах (хэрэв нууц биш бол)
	Төслийн талбай дээр 35-с дээш ажилтанд эмнэлгийн тусламж шаардлагатай тохиолдолд 45 минутын дотор эмнэлэг, эрүүл мэндийн төв рүү очих боломжтой эсэхийг тодорхойлох.	Төслийн талбайн ойролцоо эмнэлгийн төвүүд	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө талбайн ойролцоо эмнэлгийн төвүүд байгаа эсэхийг тодорхойлох.
C40. Эрүүл ахуй, байр болон хоол хүнс	Төслийн талбайг аюулгүй байл ба эрүүл ахуй болон ариун цэврийн байгууламж түүний дотор угаалгын өрөө, хувцас солих өрөө, ундны ус мөн сүүдэрт байрлах ажилчдын талбайгаар хангах. Ариун цэврийн өрөө, хувцас солих өрөөг эрэгтэй ажилчдын дунд тусгаарлан хангах.	Төслийн үйл ажиллагааны талбайн нь аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Ажилчдын байрлахаас өмнө ажилчдын байрыг хянах Тогтмол хяналт тавих. Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах.

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	Холбогдох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм хэм хэмжээний дагуу тохиромжтой орон зай, ундны усаар хангах, бохир ус хаягдлыг зайлуулах систем мөн хэт халуун, хүйтэн, чийг, өвчин тээгч амьтдаас хамгаалах хэрэгсэл, ба ариун цэврийн болон угаалгын хэрэгсэл, талбайн гэрэлтүүлэг эмнэлгийн анхан шатны үйлчилгээгээр хангана.	Үйл ажиллагааны талбай дээр ажилчдад тохирсон нөхцөл бий болгох.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Ажилчдын байрлахаас өмнө зуслангийн газрыг хянах Тогтмол хяналт тавих. Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах.
	Ажилчдын дунд халдварт өвчин (БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэ, гепатит В, С). Ажилчдыг мэдрэг байдал	Халдварт өвчний бүртгэл Сургалт хийж, бүртгэл хөтлөх	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Өвчний бүртгэл болон боломжтой бол өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй танилцах. Сургалтын бүртгэлийг хянах

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
D. Орон нутгийн иргэдтэй харилцах болон хөдөлмөр эрхлэлт				
D42. Ажлын нөхцөл	ОУХБ-ын дүрэм журмын дагуу хууль ёсны хөдөлмөрийн доод стандартыг (хүүхэд/албадан хөдөлмөр эрхлэлт, бэлгийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломж, ажлын цаг мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ) хангаж байгаа эсэхийг баталгаажуулах.	Гомдол барагдуулах механизмын бүртгэл Сургалт зохион байгуулж, бүртгэл хөтөлсөн байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Хяналт шалгалтын тайланг шалгах (мөн хөдөлмөрийн эрх бүхий байгууллагаас) Гомдол санал хүсэлтийн бүртгэлийг хянах. Сургалтын бүртгэлийг хянах

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	<p>Шууд болон шууд бусаар ажиллаж буй ажилчид ажлын байртай холбоотой гомдлоо нэрээ нууцлан гаргаж болох тухай Гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэлтэй байх боломжоор хангах</p> <p>(БОНМБ-ийн хавсралт 6 гомдлын маягтыг харна уу)</p>	<p>Гомдол барагдуулах механизмын дагуу гомдлын бүртгэл хөтөлх</p> <p>Сургалт зохион байгуулж бүртгэл хөтөлсөн байх.</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч</p>	<p>Гомдол барагдуулах механизмыг хянах</p> <p>Сургалтын бүртгэлийг хянах</p>
	<p>Бүх ажилчдыг тэгш эрхээр хангах.</p>	<p>Төслийн талбай дээр ялгаварлан гадуурхахгүй байх бодлого</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч</p>	<p>Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх</p> <p>Гомдол барагдуулах механизмыг хянах</p>
D43. Орон нутгийн ажиллах хүчин	<p>Хэрвээ боломжтой бол ажилтнуудад бараа үйлчилгээ ханган нийлүүлэгчдээр орон нутгийн иргэдийг илүүд үзэх.</p>	<p>Орон нутгийн худалдан авалт болон хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл.</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч</p>	<p>Худалдан авалт, хөдөлмөр эрхлэлтийн дүрэм, бүртгэлийг хянах</p> <p>Гомдол барагдуулах механизмыг хянах</p>
D44. Тээвэр	<p>Шаардлагатай үед ажилчдыг тээвэрлэх зориулалттай машин/ автобусаар тээвэрлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Ашигласан машин автобус</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч</p>	<p>Гомдол барагдуулах механизмыг хянах</p>
<u>D47. Олон нийтийн харилцаа</u>	<p>санамсаргүй олдвор болон газар эзэмших асуудлаар мөн барилгын талаар орон нутгийн ард удирдлага, ард иргэдтэй зөвшилцөнө.</p>	<p>Уулзалтын хугацаа</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон</p>	<p>Гомдол барагдуулах механизмыг хянах</p>

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	Үүнд мөн олон нийтийн татан оролцуулж мэдээлэл агна.	Гомдол барагдуулах механизм	төслийн гүйцэтгэгч	Зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл
	Нөлөөлд өртсөн хүмүүст санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг олгохын тулд Гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх	Төслийн талбайд Гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх, гомдлыг бүртгэсэн байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Гомдол барагдуулах механизмыг хянах
	Нутгийн ард иргэд болон нөлөөлөлд өртөж болзошгүй өрхүүдтэй хамтран тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгож, үйл ажиллагаагаар дамжуулан амьжиргааны эх үүсвэрт учирч болзошгүй хохирлыг тодорхойлох (жишээлбэл, бэлчээр авах, усны хүртээмжгүй болох гэх мэт). Хэрэв газар чөлөөлөх нь зайлшгүй шаардлагатай бол нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст цаг тухайд нь, шударга нөхөн олговор олгох ёстой юу?	Уулзалтын хугацаа Гомдол барагдуулах механизм Газар чөлөөлөх, шаардлагатай бол нөхөн олговор олгох менежментийн төлөвлөгөө (Хавсралт F-ийг үзнэ үү)	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Гомдол барагдуулах механизм болон уулзалтын хугацааг хянах
D48. Хүмүүс болон эд хөрөнгийн хохирол	Бүхий л төслийн гүйцэтгэгч буюу ажил олгогч нар мөн ажилчдыг төслийн үйл ажиллагааны талаарх ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхийг баталгаажуулах. (Үүнд: аюулгүй байдлын дүрэм, мансууруулах бодисыг үл тэвчих, тухайн бүс нутгийн байгаль орчны нөлөөлөлд өртөмтгий байдал, бэлгийн замын халдварт өвчин ХДХВ/ДОХ-ын аюул, жендерийн тэгш байдал, бэлгийн дарамт мөн ерөнхийдөө хүн	Ёс зүйн дүрэм (хавсралт А-г харна уу) Гомдол санал хүсэлтийн тэмдэглэл.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Ажилчдын ярилцлага, Гомдлын санал хүсэлтийн бүртгэлийн тойм

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	амын итгэл үнэмшил, зан заншил мөн олон нийтийн харилцааг хүндэтгэх			
	Төслийн талбайд зохих хамгаалалт, хашлага, тэмдэглэгээ, гэрэлтүүлэгтэй байлгах. Хүүхэд болон бусад эмзэг бүлгийн хүмүүс мөн төсөлд ажилддаггүй иргэд нэвтрэхээс хамгаалан тэмдэг/мэдэгдэл/ саадыг ашиглах.	Төслийн үйл ажиллагааны талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөлт хийгдсэн байх Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хашаа хашлага байршуулсан байх.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Үйл ажиллагаа явуулахын өмнө шалгалт хийх. Төслийн талбайд төлөвлөгөөт бус шалгалт хийх Гомдол барагдуулах механизмыг хянах
D49. Газар чөлөөлөлт болон газар авах	Албадан нүүлгэн шилжүүлэлтээс аль болох зайлсхийх. Хэрэв газрыг авах нь гарцаагүй бол албадан нүүлгэх шаардлагагүй. Тухайн газар луу нэвтрэхээс өмнө газар эзэмшигчдэд нөхөн олговор олгох ёстой. Газар өмчлөл, газар ашиглалтыг орон нутгийн иргэдэд ойлгуулахын тулд иргэдтэй хамтран ажиллана.	Гомдол барагдуулах механизм Газар чөлөөлөх, шаардлагатай бол нөхөн олговор олгох менежментийн төлөвлөгөө (Хавсралт F-ийг үзнэ үү)	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Талбайг сонгохдоо нэг удаа хянана. Гомдлын бүртгэлийг хянах Газар чөлөөлөх/ нөхөн олговрын үйл явцыг дагаж мөрдөх
D50. Замын хөдөлгөөний менежмент	Үйл ажиллагааны үед жолооч нарын аюулгүй жолоодлогыг хангах. (жишээ нь анхан шатны болон танилцуулах сургалт)	Анхан шатны сургалтын нэг хэсэг болох жолоочийн сургалт түүний бүртгэл	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Сургалтын бүртгэлийн хяналт

Хэсэг	Нөлөөллийг бууруулах, менежмент, сайжруулах арга хэмжээ	Баталгаажуулах хэрэгсэл	Хариуцагч	Хяналт хийх үйл явцын журам
	Нийтийн эзэмшлийн зам талбайн ойр орчмын болон барилга байгууламжийн талбай зэрэг өндөр эрсдэлтэй хэсэгт замын хөдөлгөөний болзошгүй аюулын талаарх олон нийтэд мэдээлэл өгч, тэмдэг тэмдэглэгээ, сурталчилгааны үйл ажиллагаа.	Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ Уулзалтын хугацаа	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Замын хөдөлгөөнийг хянах мөн гомдлын бүртгэлийг хянах
D51. Олдвор / Археологийн санамсаргүй олдворын менежмент	Археологи, түүхийн дурсгалт газрууд, санамсаргүй олдворууд, олдворуудыг хамгаалах тусгай журмыг бий болгох. Соёлын өвийн бүх олдворыг (булш, хуучин шаазан эдлэл, хуучин барилгын үлдэгдэл гэх мэт) холбогдох байгууллагад нэн даруй мэдээлж, санамсаргүй олдворын ойр орчимд малтлага хийхээс зайлсхийж, санамсаргүй олдворыг хашиж, эрх бүхий байгууллагаас өгсөн зааварчилгааг хүлээх хэрэгтэй.	Холбогдох байгууллагад мэдэгдсэн бүртгэл Сургалтын бүртгэл, Санамсаргүй олдворын бүртгэл.	Төсөл хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн гүйцэтгэгч	Төслийн талбайн хяналт

Хавсралт 6: Нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Төслийн БОНМБ-ийн дагуу төслийн хүрээнд санхүүжүүлсэн аливаа үйл ажиллагаа нь одоо байгаа амьжиргааны эх үүсвэрийг хязгаарласан тохиолдолд нийгмийн нөлөөллийн үнэлгээ (НҮҮ) хийх шаардлагатай. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний зорилго нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийг тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөхөд тэдний оролцоог хангах, мөн нөлөөлөлд өртсөн аливаа хүмүүст бодитойгоор амьжиргааг нь сайжруулахад туслах арга хэмжээний хүрээнд төслөөс хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь амьжиргааны хязгаарлалтад өртсөн хүмүүсийн болзошгүй аливаа зөрчлийг шийдвэрлэхэд шаардлагатай төслийн аливаа арга хэмжээг тодорхойлоход чиглэх ёстой.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь үүсэх болзошгүй нөлөөллийг жигд байдлаар дараах зүйлсийг агуулна:

1. Үйл ажиллагааны тодорхойлолт.
2. Үйл ажиллагааны бүсийн нөлөөлөлд өртсөн иргэд, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлоход нийгэм эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох.
3. Үйл ажиллагааны олон нийтийн оролцооны төлөвлөгөө (БОНМБ-ийн 5-р бүлэг)
 - а. Үйл ажиллагааны онцлогт тохирсон гомдол санал хүсэлтийн журам
4. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ.
5. Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг сайжруулах буюу нөхөн сэргээхэд чиглэсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний санал.
 - а. Төсөв .
 - б. Үүрэг хариуцлага.
6. Хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх.

Үйл ажиллагааны тайлбар

Үйл ажиллагааны тодорхойлолт заавал багтах ёстой:

- Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны тойм, түүний үндэслэл.
- Амьжиргааны эх үүсвэрийг хязгаарлах арга хэмжээ.
- Төслийн нөлөөллийн бүс.
- Нөлөөллөөс зайлсхийх эсвэл түүнийг бууруулах хувилбарууд (жишээлбэл, өөр газар болон хүртээмж)
- Үйл ажиллагааны загварыг тодорхойлохоос өмнө уулзалт арга хэмжээ.

Нийгэм эдийн засгийн суурь үзүүлэлт

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь нөлөөлөлд өртсөн иргэдийн оролцоотойгоор төслийн үр өгөөжийг хүртэх, нөхөн олговор хуваарилахын тулд нөлөөлөлд өртсөн орон нутгийн бүх өрх, хувь хүмүүст тооллого явуулж тасалбар болох хугацааг тодорхойлох, энэ нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргааг одоо байгаа түвшинд нь хүртэл сайжруулах буюу сэргээх арга хэмжээ зорилготой. Судалгаагаар дараах зүйлсийг тодорхойлно:

- Нөлөөлөлд өртсөн иргэд, айл өрхүүдийн тоо.
- Одоогийн газар ашиглалтын хязгаарлалтын бүсэд буй нөлөөлөлд өртсөн иргэдийг тодорхойлох.
- Нөлөөлөлд өртсөн иргэд, айл өрхүүдийн онцлог түүний дотор үйлдвэрлэлийн хэлбэр, төрөл мөн амьжиргааны түвшний холбогдох суурь мэдээлэл
- Гарч болзошгүй алдагдлын хамрах хүрээ.
- Онцгой анхаарал хандуулах ёстой эмзэг бүлгийн хүмүүс эсвэл бүлгийн талаарх мэдээлэл

Олон нийтийн оролцооны үйл ажиллагааны төлөвлөгөө.

Нөлөөлөлд өртсөн олон нийттэй харилцах харилцаанд дараах зүйлийг багтаасан байх ёстой бөгөөд БОНМБ-ын 4-р бүлэгт заасан олон нийтийн оролцооны журмаар дамжуулан мэдээлэлтэй байх ёстой. Үүнд,

- Төсөл болон холбогдох үйл ажиллагааг тоймлох
- Талбайн ашиглалтын талаар ойлголттой болж, нэвтрэх эрхээ алдах ба эсвэл амьжиргаагаа алдах магадлалтай байдлыг тодорхойлох.
- Газар ашиглалтын өөр хувилбаруудыг дэвшүүлэх (жишээ нь бэлчээр). Хэрэв өөр хувилбар байхгүй эсвэл газар тариалан зэрэг тогтмол хэрэглээтэй бол нөлөөлөлд өртсөн нутгийн гишүүдтэй хамтран нөлөөллийг бууруулах өөр арга хэмжээг судлах.
- Төслийн үйл ажиллагааны талбайг хамгаалахын тулд хамгаалалтын арга хэмжээ, хориглох болон ашиглалтын талаарх түгээмэл асуулт хариултын жагсаалтыг хэрэглэгчдэд өгөх.
- Төлөвлөсөн үйл ажиллагаа буюу хамгаалалтын арга арга хэмжээний байршлыг харуулсан газрын зургаар хангах.
- Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой асуудлыг хэлэлцэх.
- Төслийн нөлөөлөлд өртсөн ард иргэдэд төслийн хүрээнд хэрэгжиж буй санал хүсэлт, гомдлын арга хэмжээний талаар тайлбарлан дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.

Бүхий л санал, гомдлыг төсөл хэрэгжүүлэгч нэгжээс БОНМБ-ын санал хүсэлт, гомдлын механизмын дагуу шалгаж, шаардлагатай бол зохих арга хэмжээг авна. Бүх гомдол, санал хүсэлт мөн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний бүртгэлийг газар дээр нь хөтөлнө.

Нийгэм эдийн засгийн нөлөөллийг үнэлэх

Нөлөөллийн үнэлгээг олон нийтийн төлөвлөгөөний үр дүнд үндэслэн, өөр хувилбаруудыг авч үзсэний үндсэн дээр хийнэ. Үнэлгээ нь тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд төслөөс бууруулах ёстой нөлөөллийн мөн чанарыг, тухайлбал бэлчээрийн талбайн цэвэр алдагдал, сүргийн хэмжээ, нөлөөлөх хугацаа (жил бүр) зэргийг тодорхойлох ёстой.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг орон нутгийн эрх бүхий байгууллагуудтай баталгаажуулж, санал болгож буй аливаа нөлөөллийг бууруулах арга хэмжээг, ялангуяа одоо байгаа газар ашиглалтыг үндэсний хууль тогтоомжийн дагуу хууль бус гэж үзсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёстой. Тиймээс сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг шаардлагатай тохиолдолд өөрчлөх, мөн үр дүнд хүрэхийн тулд тухайн арга хэмжээг хэд хэдэн удаагийн давтамжтай хэрэгжүүлж болно гэдгийг оролцогч талууд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Амьжиргаанд зориулсан төслийн хөрөнгө оруулалтыг нөлөөллийг бууруулах зорилгоор бэлчээрт ашиглах боломжтой газар эсвэл нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг дэмжихэд зориулж болно. Нөлөөлөлд өртсөн иргэд болон айл өрхүүд өөр нөхөн олговрын хувилбаруудаас сонгох боломжтой.⁴⁴ Газар ашиглалтын хувилбаруудыг газрын зурагт оруулан баталгаажуулж оролцогч талуудад тайлбарлаж оролцоог хангана.

⁴⁴ Анхаарах нийтлэг хувилбарууд:

- Асуудалтай байгаа нөөцийг тогтвортой хуваалцах найдвартай, шударга арга замыг боловсруулах. Өмчийн тэгш эрхийг хангах эсвэл илүү үр ашигтай хувилбарт анхаарлаа хандуулах нь нөөцөд нөлөөлөх нөлөөллийг мэдэгдэхүйц бууруулж чадна.
- Альтернатив нөөц эсвэл функциональ орлуулагчид хандах боломжийг олж авах.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь төслийн хөрөнгө оруулалтын үр дүнд ямар ч айл өрх, иргэд хохиролгүй байх ёстой бөгөөд үүний тулд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсний дараах үлдэгдэл нөлөөллийг үнэлэх ёстой. Энэ нь эмзэг бүлгийн иргэд айл өрхөд нэмэлт арга хэмжээг авах шаардлагатай байж магадгүй.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээг эцэслэхийн тулд тухайн орон нутгийн удирдлагууд, олон нийтийн төлөөллүүд баталж, нөлөөлөлд өртсөн өрх болон иргэд гарын үсэг зурж баталгаажуулсан байх хэрэгтэй.

Нөлөөллийг бууруулах бүхий л арга хэмжээг төслийн үйл ажиллагааны төлөвлөлттэй салшгүй холбоотой гэж үзэх хэрэгтэй. Тиймээс, төсөл хэрэгжүүлэх нэгж нь нөлөөллийг бууруулах бүх арга хэмжээг хэрэгжүүлэх тодорхой төсөв болон үйл ажиллагааны тодорхой хуваарьтай байх ёстой. Мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд тухайн холбогдох байгууллагуудын хариуцлагыг тодорхойлох ёстой.

Хяналт шинжилгээ ба үнэлгээ

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь төслийн хөрөнгө оруулалтын үр дүнд амьжиргаанд нөлөөлөл үзүүлэхгүйн тулд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тодорхой үзүүлэлтүүдийг тогтмол хянаж байх ёстой. Үзүүлэлтүүдэд нь:

- Малчдын тоо ба түүний өөрчлөлт
- Малчдын нөхцөл байдлын өөрчлөлт.
- Орлогын өөрчлөлт.
- Газар ашиглагчидтай зөрчилдсөн тохиолдол.
- Газар ашиглалттай холбоотой өргөдөл гомдол.

• Орон нутгийн оршин суугчдыг өөр амьжиргааны эх үүсвэрээр хангах, эсвэл нөөцийг орлох нөөцийг худалдан авах арга хэрэгслээр хангахын тулд төрийн болон хувийн хэвшлийн ажил эрхлэлт (эсвэл санхүүгийн татаас) авах.

• хязгаарлалтын бүсээс гадуур нөөцийг ашиглах боломжийг олгох.

Хавсралт 7: Ноцтой гэнэтийн ослын үед осол мэдээлэх үйл явц

Төслийн удирдлага, төслийн гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчид гэнэтийн ослын талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн БОНМБ-ын мэргэжилтэнд 24 цагийн дотор мэдээлэх бөгөөд улмаар энэхүү Хавсралтын маягтыг ашиглан 72 цагийн дотор Германы сэргээн босголт, зээлийн банканд мэдэгдэх үүрэгтэй.

Алхам 1: Суурь мэдээлэл цуглуулах/ авах. Суурь мэдээлэл нь тодорхой, ямар нэгэн хоёрдмол утгагүй мөн бодитой байх ёстой. (жишээ нь ямар нэг тайлбараас ангид). Хяналт шалгалтын үед мэдээллийн дутмаг байдлыг тодорхойлсон байх шаардлагатай (Алхам 2)

- Он сар өдөр, цаг, цаг агаарын нөхцөл / орчны гэрэлтүүлэг
- Баримт нотолгоо.
- Нас барсан, бэртэл гэмтэл, хохирол, шууд хохирлын дэлгэрэнгүй мэдээлэл
- Гэрчүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Тухайн орчныг хамгаалалтад авсан эсэх/зураг авсан эсэх дэлгэрэнгүй мэдээлэл
- Туршилт хийсэн/дээж авсан/шинжилгээнд илгээсэн зэрэг тухайн орчноос авсан аливаа зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Хяналт шалгалтыг удирдаж буй хүний талаарх мэдээлэл
- Осол гарснаас хяналт шалгалт дуусах хүртэлх хугацаа
- Яаралтай авсан арга хэмжээ

Алхам 2: Хяналт шалгалт. Хяналт шалгалтын ажиллагаа нь баримт, гэрч, холбогдох хувь хүн/гуравдагч этгээд, цаг хугацааны хуваарийг дагаж мөрдөх ёстой бөгөөд тухайн хэрэг явдал/ ослын үйл явдлаар тусгаарлагдах ёсгүй. Тухайн үйл явдлын талаарх нийтлэл мэдээллүүд гарсан тохиолдолд тайланд хавсаргана (жишээ нь сонин сэтгүүлийн нийтлэл, цахим мэдээ, радио, телевизийн мэдээлэл гэх мэт).

- Тухайн үйл явдлыг тодруулахад хэрэг явдал/ осол гарахад байсан мөн түүнтэй холбоотой мэдээллийг өгөх хувь хүн, баг, мөн гуравдагч этгээд (жишээ нь төслийн гүйцэтгэгч) зэргийг тодорхойлсон ярилцлага явуулах шаардлагатай.
- Гэрчүүд болон холбогдох хүмүүсээс найдвартай нарийн асуулга авч цаг хугацаа болон тухайн үйл явдлыг тодруулах нь хяналт шалгалтын ажлыг урагшлуулдаг. Ярилцлагын тэмдэглэлийг хавсаргах хэрэгтэй.

Алхам 3 Дүн шинжилгээ хийх. Дүн шинжилгээ нь хяналт шалгалтын явцад ямар ч тохиолдолд хатуу чанд байх ёстой. Гуравдагч этгээдийн гэрчилснээр тухайн асуудлын үнэн бодит гол шалтгаан буюу үндэслэлийг тодорхойлох хэрэгтэй. Дүн шинжилгээ нь үндэслэлийг тогтоохдоо ашигласан аргуудыг (жишээ нь ярилцлага, бичиг баримт, газар дээр нь очиж үзэх, цагдаагийн тайлан гэх мэт) мөн тодорхой тайлбарлах ёстой.

Үндсэн мэдээллийг буюу ярилцлагын ярилцлагын үр дүн, мөн тухайн цаг үед болсон мэдээлэл зэргийг ашиглаж дараах зүйлсийг тодорхойлно.

- Шууд шалтгаанууд.
- Суурь шалтгаанууд (урьд нь илрүүлээгүй аюултай нөхцөл/ үйлдлүүдийн шалтгаан буюу үүсгэгч).
- Үндсэн шалтгаанууд (ерөнхийдөө зохион байгуулалт удирдлагын алдаа , зарим тохиолдолд шууд бусаар байршил цаг хугацаа осолд нөлөөлөх).
- Тухайн үйл ажиллагаанд байгаагүй, хангалтгүй, амжилтгүй, болон ашиглагдаагүй эрсдэлийг тодорхойлох, жишээлбэл: удирдлага болон хяналтын арга хэмжээ, холбогдох үндэсний хууль тогтоомж, олон улсын стандартын мэдээллийн дутмаг байдалд дүн шинжилгээ хийх

- Тухайн үйл явдалтай холбоотой үүрэг, хариуцлагын тодорхойлолт, үүнд эрх бүхий байгууллагын оролцоо зэрэг.
- Хохирогчид, түүний гэр бүл, олон нийт, түүнчлэн орон нутгийн, үндэсний, болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг үйл явдалд ямар хариу үйлдэл үзүүлсэн тухай тайлбар.
- Тухайн осол аваарын үндсэн шалтгаан, үндсэн шалтгаануудын дүгнэлт, дүгнэлтийн хураангуй.

Алхам 4 Хүрэх үр дүн

- Гол шалтгаан, суурь шалтгаан мөн үндсэн шалтгаануудын хувьд засаж залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай (энэ нь хоорондоо уялдаа холбоотой хэд хэдэн арга хэмжээ байж болно.)
- Авах арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх ажилтан байх хэрэгтэй бөгөөд тодорхой хуваарьт үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Мөн энэхүү томилогдсон ажилтан нь зохих цаг хугацаанд нь хуваарьт ажлаа тайлагнах ёстой.
- Бүх үйлдлүүд нь дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ гэдгийг баталгаажуулахын тулд одоогийн эрсдэлийн үнэлгээ холбогдох журмууд нь шинэчлэгдсэнийг нотлох шаардлагатай.
- Хяналт шалгалтын явц, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хуримтлуулсан туршлага зэргийг багтаасан товч тойм мэдээллийг оролцогч талуудтай хуваалцах
- Тухайн үйл явдалд шууд болон шууд бусаар нөлөөлөлд өртсөн хүмүүст үзүүлсэн дэмжлэг, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл

Гэнэтийн осол аваарын шуурхай мэдээлэх хуудас					
1.Осол аваарын дэлгэрэнгүй мэдээлэл					
Байгууллага		Осол аваар болсон он сар өдөр			
		Осол аваарын болсон цаг			
Осол аваарын болсон байршил		Осол аваарын төрөл	Байгаль орчны	<input type="checkbox"/>	
			Гэмтэл	Ажиллах хүчин	<input type="checkbox"/>
				Олон нийт болон орон нутгийн иргэд	<input type="checkbox"/>
			Нийгмийн осол аваар (жишээ нь хөдөлмөрийн хүчирхийлэл, үймээн самуун)	<input type="checkbox"/>	
2. Болсон үйл явдал					
Үйл явдлын товч тайлбар					

3. Гэмтсэн ажилчид						
Ажилтан төслийн гүйцэтгэгч / Хүйс	Нас	Ажлын байрны тодорхойлолт/ албан тушаал	Ажилласан хугацаа	Шалтгаан	Гэмтлийн төрөл (том хэмжээний / үхэлд хүргэх)	

4. Гэмтсэн олон нийт, иргэдийн мэдээлэл						
Нэр	Хүйс	Нас	Орон нутгийн иргэд	Оршин суугаа хаяг	Шалтгаан	Гэмтлийн төрөл (том хэмжээний / үхэлд хүргэх))

5. Байгаль орчны холбогдолтой осол аваар			
Төрөл (Асгаралт / Хийн ялгаралт)	Нийт алдагдал (литр/кг)	Шалтгаан	Гэмтэл

6. Осол аваарын гэрч			
Нэр	Хүйс	Оршин суугаа хаяг	Үйл явдлын тайлбар

7. Бусад холбогдох мэдээлэл				
Удирдлагуудад мэдэгдсэн эсэх?	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй	<input type="checkbox"/>
<i>Нэмэлт мэдээлэл өгнө үү</i>				
Хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байгаа эсэх?	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй	<input type="checkbox"/>

<i>Нэмэлт мэдээлэл өгнө үү</i>					
Ажлын талбайгаас гадуур ямар нэгэн нөлөө үзүүлэх үү?		Тийм	<input type="checkbox"/>	Үгүй	<input type="checkbox"/>
<i>Нэмэлт мэдээлэл өгнө үү</i>					
Зураг авсан эсэх?		Тийм	<input type="checkbox"/>	Үгүй	<input type="checkbox"/>
<i>Тайланд хавсаргана уу</i>					
Он сар өдөр					
Ослын дараа яаралтай ямар хариу арга хэмжээ авсан бэ? Хэн?					
<i>Ослын улмаас ажлын зохион байгуулалт, процесст өөрчлөлт орсон эсэх, тодорхой тоног төхөөрөмж авсан, хамгаалалтын арга хэмжээ авсан, ажил зогссон гэх мэтийг энд бичнэ үү.</i>					
Маягтыг бөглөсөн хүн:					
Нэр, албан тушаал					
Холбоо барих мэдээлэл:	Утас		Цахим шуудан		

Хавсралт 8: Гомдол санал хүсэлт гаргах маягт

Төслийн оролцогч талууд эсвэл төслийн нөлөөлөлд өртсөн иргэд гомдол гаргах хүсэлтэй байгаа тохиолдолд дараах мэдээллийг цуглуулж төсөл хэрэгжүүлэх нэгжийн хуульчид илгээнэ. Хэрэв өөрөөр тохиролцоогүй бол гомдлын бүртгэл нууц байх бөгөөд бүртгэлийг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хуульч хөтөлж, гомдол гаргагчтай харилцах, шаардлагатай бол эрх бүхий байгууллагад шилжүүлэхэд хяналт тавина.

Гомдол хүлээн авсан Он. Сар. Өдөр	
Гомдол гаргагчийн нэр (гомдол гаргагч нэрээ нууцлахыг хүсэж байгаа эсэхийг тодруулах)	
Гомдол гаргагчийн хаяг	
Гомдол гаргагчийн холбоо барих хаяг (холбоо барих хамгийн тохиромжтой аргыг заана уу)	
Гомдол хүлээн авсан	
Гомдлын агуулга	
Төслийн ажилтнууд холбогдох асуудал болон төлөвлөсөн хариу арга хэмжээг судлах үүрэгтэй.	
Залруулах арга хэмжээ авахад шаардлагатай арга хэмжээ	
Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (харилцаа холбоо, санал хүсэлтийг бүртгэх)	Он. Сар. Өдөр
1.	
2.	
3.	

Хавсралт 9: Төслийн гүйцэтгэгчийн ажилтнуудын ёс зүйн дүрэм

[Дэлхийн Банкны худалдан авах ажиллагааны стандарт баримт бичигт үндэслэж бага зэргийн өөрчлөлт оруулсан болно.]

Бид төслийн гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг оруулна уу] бид [Захиалагчийн нэрийг оруулна уу]-тай [ажлын тайлбарыг оруулна] гэрээ байгуулж байна. Гэрээнд тусгагдсан ажлыг [ажил явуулах талбай болон бусад газруудын байршлыг оруулна] -д хийж гүйцэтгэнэ. Бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг эрсдэлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг арилгах арга хэмжээг авахыг манай гэрээнд заасан болно.

Тендерт оролцогчийн тэмдэглэл:

Захиалагчийн боловсруулсан ёс зүйн дүрмийн маягтын агуулгыг өөрчилж болохгүй. Гэсэн хэдий ч тендерт оролцогч нь гэрээд хамаарах асуудал, эрсдэлийг харгалзан зохих шаардлагыг нэмж оруулж болно.

Тендерт оролцогч нь тендерийн материалд ёс зүйн дүрмийн маягтыг хавсаргана.

Энэхүү ёс зүйн дүрэм нь төслийн ажилтнуудтай холбоотой учирч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шийдвэрлэх арга хэмжээний нэг хэсэг юм. Энэ нь төслийн бүхий л ажилчид буюу зохион байгуулагчид төслийн үйл ажиллагааны талбай болон бусад хэсэгт ажиллаж байгаа түр болон байнгын ажилтнуудад хамаарна. Үүнд төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нарын ажилтнууд мөн ажлыг гүйцэтгэхэд бидэнд тусалж буй сайн дурын ажилтнуудад мөн хамаарна. Эдгээр хүмүүсийг **“төслийн гүйцэтгэгчийн боловсон хүчин”** гэж нэрлэх бөгөөд энэхүү Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

Энэхүү ёс зүйн дүрэм нь бүх шатны төслийн гүйцэтгэгчийн ажилчдаас шаарддаг ёс зүйн хэм хэмжээг тодорхойлдог.

Манай ажлын байр нь ямар нэг доромжлол, хүчирхийлсэн зан үйлийг үл тэвчих бөгөөд бүхий л хүмүүс (ажилчид) аливаа дарамтгүйгээр санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлж байх ёстой аюулгүй бүс байх юм.

Шаардах ёс зүй

Төслийн гүйцэтгэгчийн ажилтнууд нь:

1. Өөрийн хариуцаж буй ажлаа бүрэн гүйцэт чанартай гүйцэтгэнэ.
2. Төслийн гүйцэтгэгчийн ажилтнууд нь ажилтнуудын болон бусад хүмүүсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сайн сайхан байдлыг хамгаалах шаардлагыг багтаасан энэхүү ёс зүйн дүрэм мөн холбогдох бүхий л хууль тогтоомж, дүрэм журам шаардлагуудыг дагаж мөрдөх хэрэгтэй.
3. Аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх. Үүнд,
 - a. Ажилтан бүр өөрсдийн хариуцдаг ажлын байр, машин механизм, тоног төхөөрөмж болон үйл ажиллагаа нь эрүүл ахуйн эрсдэлгүй аюулгүй байдлыг хангасан байх хэрэгтэй.
 - b. Шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийг зүүх/өмсөх;
 - c. Хими, физик, биологийн гаралтай бодистой холбоотой зохих арга хэмжээг авах.
 - d. Мөн яаралтай ажиллагааны гормыг дагаж мөрдөх.

4. Тухайн ажилтан нь өөрийн ажлын байраа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, түүний амь нас эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна гэж үзвэл тухайн нөхцөл байдлын талаар мэдээлж ажлын байраа орхиж болно.
5. Бусад хүмүүст хүндэтгэлтэй хандаж, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаач ажилчид, хүүхдүүд гэх мэт тодорхой бүлгүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх.
6. Төслийн гүйцэтгэгч эсвэл захиалагчийн ажилтнуудад бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн дур хүслээ хангах хүсэлт гаргах, бэлгийн харилцааны шинж чанартай үг хэллэг, бие махбодийн бусад үйлдлүүдийг хийхгүй байх.
7. Бэлгийн мөлжлөгтэй холбоотой үйл ажиллагаанд оролцохгүй. Үүнд, бусдын бэлгийн мөлжлөгөөс мөнгө, нийгэм, улс төрийн ашиг олох гэх мэт мөн бусдын сул дорой байдлыг ашиглан эрх мэдэл, итгэлцлийн албан тушаалаа бэлгийн зорилгоор урвуулан ашиглах гэсэн аливаа бодит оролдлогыг хэлнэ.
8. Бэлгийн хүчирхийлэл үйлдэхгүй байх, энэ нь хүчирхийлэлд өртөхгүй байх, энэ нь бэлгийн хүчирхийллийн шинж чанартай бие махбодийн халдлагыг хүчээр эсвэл тэгш бус, албадлагын нөхцөлд хийхгүй байх.
9. Өмнө нь гэрлэж байснаас бусад тохиолдолд 18 нас хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохгүй байх.
10. Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд мэдэгдэх.
11. Энэхүү Ёс зүйн дүрмийг зөрчсөн тухай Захиалагч эсвэл бидэнд мэдээлсэн, эсвэл төслийн гүйцэтгэгчийн ажилтны гомдол барагдуулах механизм эсвэл Төслийн Гомдол барагдуулах механизмыг ашигладаг аливаа хүнд хариу арга хэмжээ авахгүй байх.

Тулгамдаж буй асуудлууд

Хэрэв хэн нэгэн энэхүү ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзвэл мөн тухайн асуудал өөрт нь хамааралтай байвал тэрхүү асуудлыг яаралтай мэдэгдэх хэрэгтэй. Үүнийг дараах аргуудын аль нэгийг ашиглан илэрхийлж болно. Үүнд,

- Төслийн гүйцэтгэгчийн төлөөлөгчдөд гомдол гаргах.
- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төслийн хуультай холбогдох.

Тухайн үйл ажиллагаанд хяналт тавьж, гомдол, асуудлыг шийдвэрлэхийн тулд гомдол гаргагчийн нэрийг шаардана. Төсөл нь тухайн хүний хувийн мэдээллийг нууцлах болно гэдгийг батлах хэрэгтэй. Гэсэн хэдий ч нэрээ нууцалсан гомдол, мэдэгдлийг мөн гаргаж болох бөгөөд зохих ёсоор нь авч үзэх болно. Бид зөрчил гаргасан бүх мэдээллийг нухацтай авч үзэж, шалгаж, зохих арга хэмжээг авах болно.

Энэхүү ёс зүйн дүрмээр хориглосон аливаа зан үйлийн талаар сайн санааны үүднээс анхаарал хандуулж буй хүний эсрэг ямар нэг арга хэмжээ авахгүй. Хэрэв үүнд эсрэг хариу арга хэмжээ авсан тохиолдолд ёс зүйн дүрмийг зөрчсөн хэрэг болно.

Ёс зүйн дүрмийг зөрчсөнөөс гарах үр дагавар.

Төслийн гүйцэтгэгчийн ажилтнууд энэхүү ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл гаргавал хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, хуулийн байгууллагад шилжүүлэх зэрэг ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Төслийн гүйцэтгэгчийн боловсон хүчин нь.

Би энэхүү ёс зүйн дүрмийн миний ойлгодог хэлээр бичсэн хуулбарыг хүлээн авлаа. Хэрэв надад энэхүү ёс зүйн дүрмийн талаар асуух зүйл байвал [холбогдох туршлагатай төслийн

гүйцэтгэгчийн холбоо барих хүний нэрийг оруулна уу] холбогдож тайлбар авах боломжтой гэдгийг би ойлгож байна.

Төслийн гүйцэтгэгч байгууллагын ажилтны нэр: [нэр бичнэ үү] Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн гарын үсэг: ИТГЭМЖЛЭГДСЭН

Гарын үсэг :..... Гарын үсэг:.....

Огноо (өдөр, сар, жил):..... Огноо (өдөр, сар, жил):.....

Хавсралт 10: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин болон нийгмийн хяналтын хуудас

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь БОНМБ, БОНМТ болон БОНУАД-ийн хэрэгжилттэй холбоотой бүх тайланг хянана. Ажилтан нь доорх хяналтын хуудсыг ашиглан хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаанд нийцлийн шалгалтыг тогтмол хийх бөгөөд төсөл хэрэгжих талбайн хэмжээнд тусгайлан боловсруулсан БОНМТ-д заасан шаардлагуудыг шаардлагатай үед жагсаалтад нэмж оруулж баталгаажуулах хэрэгтэй. Тухайн үйл ажиллагаа нь байгаль орчны болон нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагын дагуу хэрэгжээгүй тохиолдолд ажилтан залруулах арга хэмжээ, дуусгавар болох хугацааг тодорхойлох ёстой бөгөөд үүнийг үйл ажиллагааг дэмжигчтэй зөвшилцсөний үндсэн дээр тэмдэглэнэ.

Газар ашиглалт					Дараах байдлаар тэмдэглэх			
Нэр ба байгууллага:	Шалгаж буй үйл ажиллагаа	Байршил	Огноо	Гарын үсэг	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Ажил эхлэхийн өмнө зөвшөөрөл авах шаардлагатай юу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тухайн үйл ажиллагаа нь зөвхөн зөвшөөрөгдсөн ажил явуулах талбайгаар хязгаарлах уу (үйл ажиллагааны бүсээс гадуурх аливаа асуудлаар тайлбар өгөх үү)?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчдын байр, агуулах, цех, ажлын талбайг сонгохдоо нөлөөлөлд өртсөн газрыг илүүд үзсэн үү?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тариалангийн талбай, жимсний мод, намгархаг газар, булшны газар эсвэл аливаа байгаль орчин, нийгмийн эмзэг газар/бүс нутаг нөлөөлөлд өртсөн эсэх (ямар нэгэн халдлагын асуудлаар тайлбар өгөх)					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Төслийн тоног төхөөрөмж ажлын талбайн гадна зогсоолд байрладаг уу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үйл ажиллагаа дууссаны дараа газрыг цэвэрлэж, нөхөн сэргээсэн үү?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хэрэглэгчийн эрхийн маргаан бий юу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү.								
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:								

Дуу чимээ					Дараах байдлаар тэмдэглэх			
Нэр ба байгууллага:	Шалгаж буй үйл ажиллагаа	Байршил	Огноо	Гарын үсэг	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Төслийн хүрээнд нийтийн эзэмшлийн замуудыг ашиглаж байна уу? Хэрэв тийм бол эдгээр замд хурдны хязгаарлалт буурсан уу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үйл ажиллагааны явцад чимээ шуугианаас үүдэлтэй саад болохуйц үйл ажиллагааны талбайн ойролцоо (сургууль, эмнэлэг, оршин суугчид, мөргөлийн газар гэх мэт) мэдрэмтгий нөлөөлөлд өртөгч байдаг уу? Хэрэв тийм бол нөлөөлөлд өртөгчийг харгалзан ажиллах цаг хязгаарлагдмал уу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Шөнийн цагаар чимээ шуугиантай үйл ажиллагаа явуулдаг уу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Шаардлагагүй үед асаалттай хөдөлгүүр байна уу?					<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү.								
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:								

Агаарын чанар ба тоосжилт		Дараах байдлаар тэмдэглэх			
		Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Тоног төхөөрөмж, машин механизмаас хэт их утаа ялгаруулж хар утаа гарч байна уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тоос ялгаруулах материалыг тээвэрлэж буй ачааны машинууд хучилт хэрэглэсэн үү?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Барилгын тоосжилт ихтэй материалын (цемент, элс гэх мэт) агуулахууд хучигдсан байдаг уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тоосжилтын хяналтыг хангалттай хийж чадаж байна уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү					
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:					

Ус	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Түлш цэнэглэх үйл ажиллагаа нь ус гол горхи, ил шуудуунаас 30 м-ийн зайд хийгдэж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ус гол горхи, шуудууны ойролцоо аюултай бодис хадгалагдаж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ус гол горхи, ус зайлуулах суваг, цөөрөм гэх мэт хэсэгт бохирдлын шинж тэмдэг байна уу?	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Голын татам нугад ямар нэгэн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үйл ажиллагааны улмаас байгалийн урсац тасалдах шинж тэмдэг байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тухайн үйл ажиллагаанд ашигласан усны нөөцийн талаар орон нутгийн удирдлагууд болон орон нутгийн удирдлагуудаас зөвшөөрөл авсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Хог хаягдлын менежмент	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Хог хаягдлыг шатаах шинж тэмдэг байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бүх хог хаягдлыг зориулалтын агуулахад хадгалдаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Аюултай болон энгийн хог хаягдлыг ангилан ялгадаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хог хаягдлын савнаас асгарсан / гоожиж байгааг нотлох баримт байгаа юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хог хаягдлыг хадгалах саванд зэврэлт, гэмтлийн шинж тэмдэг илэрч байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хог хаягдлыг амьтад хөглөрүүлж тараахгүй тулд найдвартай хадгалдаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хог хаягдлын савыг тодорхой тэмдэглэсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Аюултай хог хаягдлыг ус үл нэвтрэх, найдвартай хайрцагт хадгалдаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Газар шорооны ажил байгаа юу? (тийм бол өнгөн хөрсийг нөхөн сэргээх зорилгоор тусгаарласан уу)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үйл ажиллагааны талбай болон түүний эргэн тойронд (ялангуяа ойролцоох суурин газруудад) хурц үзүүртэй, аюултай объект, органик хог хаягдлын шинж тэмдэг байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Хог хаягдлын менежмент	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Орон нутгийн удирдлагуудтай зөвшилцсөний үндсэн дээр бүх төрлийн хог хаягдлыг тээвэрлэж, зайлуулж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн эрх	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Хөдөлмөр эрхлэлтийн үйл явц нь шударга, ил тод байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Орон нутгийн ажиллах хүчнийг урьтал болгосон уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Эмэгтэйчүүд цалинтай хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангагдсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажиллах хүчин нь гомдол гаргасан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчид БОНМБ-д заасан гэрээ хийсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчид эрхийнхээ талаар мэддэг үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлт байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ёс зүйн дүрэм гэж байдаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Төслийн гүйцэтгэгч нь гарын үсэг зурсан ёс зүйн дүрмийн бүртгэл хөтөлдөг үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилтнууд ёс зүйн дүрмийн агуулгыг мэддэг үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Гомдол санал хүсэлт	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Олон нийт болон ажилчдын аль алинд нь гомдол гаргах механизм бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Гомдлыг бүртгэж, бүртгэлийг төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хуваалцдаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Гомдол санал хүсэлт	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Гомдол гаргаж буй хүнд хүлээн зөвшөөрөгдсөн хугацаанд хариу өгсөн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Орон нутгийн иргэдийн аюулгүй байдал	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Бүх жолооч нарыг тосгон, туслах зам дагуу жолоодох мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт явуулсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Осол гарах эрсдэлийг бууруулахын тулд аюултай зам мөн өдрийн цагаас зайлсхийж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Орон нутагт замын хөдөлгөөний тэмдэг байрлуулсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Барилга, үйл ажиллагааны талбай руу, ялангуяа хүүхдүүдийг зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд суурин газрын ойролцоох талбайн хил хязгаар, нэвтрэх хяналт тавих шаардлагатай бөгөөд хангалттай байгаа эсэх (жишээ нь, суурин, нөхөрлөлийн ойролцоох барилгын хэсгийг хаших)?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Явган зорчигч болон бусад хүмүүсийг зөвшөөрөлгүй цэгт оруулахгүй байхын тулд хангалттай гарц (тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн гарц) бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажлын талбайг аюулгүй болгож, түр гүүр, замын хөдөлгөөнийг зохицуулахын тулд хаалт, тэмдэг болон анхааруулах гэрлээр хангасан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Тээврийн хөдөлгөөний менежмент	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Хурдны хязгаарлалтыг хэрэгжүүлэхийг бүх ажилчдад мэдэгдсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бүх жолооч нар хүчинтэй жолооны үнэмлэхтэй юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Тээврийн хөдөлгөөний менежмент		Дараах байдлаар тэмдэглэх			
		Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Машин арын дохиотой юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ачааны машинууд ухрах, ачих, буулгах үед тугчин эсвэл харуул ашигладаг уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Төслийн тээврийн хэрэгслээр болгоомжгүй жолоодлоготой холбоотой тохиолдол бий юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Жолооч нар жолоо барьж байхдаа гар утас хэрэглэж байна уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Төслийн үйл ажиллагааны улмаас замд эвдрэл гэмтэл гарсан уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хангалттай тооны хаалт, тэмдэг, анхааруулах гэрэл байгаа юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үзэгдэх орчин хязгаарлагдмал, эрсдэлтэй газруудад туг баригч байдаг уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү					
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:					

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй		Дараах байдлаар тэмдэглэх			
		Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Бүх ажилчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургаланд хамрагдсан уу ?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Коронавируст халдвар (COVID-19)-ийн нөлөллийг бууруулах арга хэмжээг хэрэглэж байна уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бүхий л сургалтын бүртгэлийг төсөл хэрэгжүүлэгч нэгжид өгсөн үү?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тухайн үйл ажиллагаанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан байдаг уу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Өдөр тутмын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудлаар тогтмол ярилцлага хийдэг үү?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бүх ажилчид өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой эрсдлийн талаар мэддэг үү?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажлын байрны аюул, осол гэмтлийг бүртгэж мэдээлсэн үү?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчдад олгосон хувийн хамгаалах хэрэгслийн бүртгэл, жагсаалт байгаа юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бүх ажилчид зохих хувийн хамгаалалтын хэрэгсэлтэй юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хувийн хамгаалах хэрэгсэлд гэмтэл учруулсан шинж тэмдэг байгаа юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тоног төхөөрөмж машин механизмыг ашиглаж болно, ашиглаж болохгүй гэсэн заавар, тэмдэг тэмдэглэгээ байгаа юу?		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Тухайн ажил буюу үйл ажиллагаанд тохирох хэрэгслийг ашигладаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Эрх бүхий ажилтнууд багаж хэрэгслийг тогтмол шалгадаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Багаж хэрэгсэл машин механизмд гэмтэл гарсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Эрэгтэй, эмэгтэй хүмүүст тусад нь бие засах газар буюу ариун цэврийн байгууламж хангалттай байгаа юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчдыг ундны усаар хангадаг (ялангуяа халуун цаг агаарт) уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хангалттай тооны анхны тусламжийн хэрэгсэл, анхны тусламжийн үзүүлэх ажилтан байгаа юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тогтоол ус бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ил задгай суваг шуудуу бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ил задгай суваг шуудууны эргэн тойронд хашаа барьсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Гал унтраах шаардлагатай хэрэгсэл байгаа юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажилчид гал түймэр гарсан тохиолдолд хэрхэн ажиллахаа мэддэг үү? Сургалтанд хамрагдсан уу, түүний бүртгэл бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Ажиллах орчин	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Ажиллах орчин цэвэрхэн, эмх цэгтэй байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Унах магадлалтай сул материалыг бэхэлсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Гудамж, шат, гарц зэрэгт саад тотгор, материал, кабель, хоолой гэх мэт зүйл байхгүй байсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Аливаа материалыг суваг шуудуу, дээвэр, ухсан нүх зэргээс хол байлгасан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Агуулхын талбайд хашлага хийж цоожтой хаалгаар хамгаалсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ажлын өдрийн төгсгөлд өдөр тутмын цэвэрлэгээг хийдэг үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				

Ажиллах орчин	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Химийн хорт болон аюултай бодис	Дараах байдлаар тэмдэглэх			
	Тийм	Үгүй	Хамааралгүй	Тайлбар
Шатахуун, тос, тосолгооны материал, химийн бодис болон бусад аюултай материалыг зохих хэмжээтэй ус үл нэвтрэх, бэхэлсэн суурьтай газар хадгалж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хадгалах талбай, чингэлэгт агуулга, хэрхэн харьцах, хадгалах, дуусах хугацаа, аюулгүй байдал эрүүл ахуйн талаархи мэдээллийг тодорхой бичсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Шатахуун цэнэглэх, засвар үйлчилгээ хийх явцад дуслын тавиур ашиглаж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Тамхи татахыг хориглодог уу? Анхааруулах тэмдэг байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэмэлт ажиглалтын бичнэ үү				
Хариуцлага, хугацаа зэргийг багтаасан нөхөн сэргээх арга хэмжээг бүртгэх:				

Хавсралт 11: Тайлан мэдээлэх стандарт журам

Сар тутмын тайлан

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын мэргэжилтэн нь төсөл хэрэгжих газар нутагт хийсэн хяналт шалгалт болон хэрэгжилтийн талаарх мэдээлэл, холбогдох тайланд үндэслэн төслийн менежментийн багт нийцлийн ман холбогдох сайжруулах арга хэмжээний хураангуй мэдээллийн тайланг сар бүр өгнө. Үүнд, орон нутгийн иргэдийн төлөвлөлт, санал хүсэлт болон гомдол, мөн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ, мөн тэтгэмжийг эрх тэгш хүртээмжтэй байлгахад анхаарна.

Тухайн сарын тайланг дараа сарын дөрөвний өдрийн дотор өгөх шаардлагатай бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн хоцрогдол болон тулгамдсан асуудал зэргийг тусгана. Тайланд дараах асуудлуудын товч тоймыг тусгах бөгөөд ингэхдээ хүснэгтэлсэн хэлбэрээр танилцуулж болно. Үүнд,

- Тайлант хугацаанд хийгдсэн шинэ бүтээн байгуулалтуудын авч үзэж байгаа болон хэрэгжиж байгаа үйл ажиллагааны товч мэдээллийг өгөх бөгөөд үүнд,
 - Үйл ажиллагааны хамрах хүрээ, анхан шатны дүн шинжилгээ, болон БОНУАД-ийн хэрэглээ, БОНМТ боловсруулахтай холбоотой үндсэн тоон мэдээлэл
 - Хөдөлмөрийн эрхлэлтийн менежмент (баримт бичиг, хувийн хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н арга хэмжээ, олон нийтийн аюулгүй байдал)
 - Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэл, сайжруулах арга хэмжээ
 - Худалдан авалтад БОНУАД/БОНМТ шаардлагыг тусгах
 - Ковид-19 цар тахлын үед авах арга хэмжээ
 - Эмзэг бүлгийн хамруулах
 - Газар, газар бэлэглэх, тохируулах журмын баримт бичиг
- Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаа, баримт бичиг
- Осол гарсан болон холбогдох байдал мэдээлэл
- Санал хүсэлт, гомдолтой холбоотой гол асуудлууд

Улирлын явцын тайлан

Улирлын явцын тайланг Германы сэргээн босголт, зээлийн банканд хүргүүлэх бөгөөд төслийн хүрээнд тулгарч буй гол бэрхшээл, боломжуудыг багтаасан үйл ажиллагааны төлөвлөх мөн хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаарх тоймыг агуулсан байх ёстой. Мөн үүнд хамрах хүрээ, анхан шатны дүн шинжилгээ, худалдан авалт, хөдөлмөр эрхлэлтийн менежмент, оролцогч талуудын оролцоо (санал хүсэлт болон гомдол хүлээн авах) болон газрын менежменттэй холбоотой асуудлуудыг мөн тусгах ёстой.

Энэхүү тайланд дараах зүйлсийг тусгах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа тус бүрийн тоймыг хүснэгтэлсэн хэлбэрээр танилцуулж болно.

- Үйл ажиллагааны нэр/байршил
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэгчид
- Төслийн гүйцэтгэгчийн ажлууд
- Төсөл хэрэгжих талбайн байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хариуцах үүрэг хүлээсэн хүмүүс. Үүнд, БОНУАД/БОНМТ-д ерөнхийд нь тодорхойлсон ХАБЭА арга хэмжээ, хөдөлмөрийн эрхлэлтийн менежментийн бүртгэл, оролцогч талуудын оролцоо болон байгаль орчин, нийгмийн менежмент зэргийг харуулна
- БОНУАД/БОНМТ-д нийцсэн байдал, үүнд (холбогдох тохиолдолд):
 - Төслийн гүйцэтгэгчид дараах зүйлсийг дагаж мөрдөнө. Үүнд,

- Хөдөлмөр эрхлэлтийн менежмент (баримт бичиг, хувийн хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н арга хэмжээ, орон нутгийн иргэдийн аюулгүй байдал)
- Ковид-19 цар тахлын үеийн шаардлага.
 - Сайжруулах шаардлагатай арга хэмжээ, хугацаа
- Газрын зөвшөөрөл бүхий баримт бичиг
- Эмзэг бүлгийн хамруулах
- Осол гарсан болон холбогдох байдал мэдээлэл
- Байгаль орчин, нийгмийн нийцлийн гол асуудлуудыг тусгахын тулд Хангалттай, Дунд зэрэг хангалттай, Дунд зэрэг хангалтгүй, Хангалтгүй гэсэн дөрвөн боломжит үнэлгээг ашиглан үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ. Хэрэгжилт нь хангалтгүй гэж үнэлэгдсэн тохиолдолд гүйцэтгэлийг сайжруулахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Хавсралт 12: Санамсаргүй олдворын журам

Төслийн хүрээнд газар шорооны ажил зэрэг аливаа ажлын худалдан авах ажиллагааны журамд урьд өмнө тодорхойгүй байсан соёлын өвийг илрэх эрсдэлтэй тул санамсаргүй олддох журмыг тусгана. Эдгээр журмын зорилго нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн шинжээчид дүгнэлт гаргаж, шаардлагатай арга хэмжээг тогтоох хүртэл аливаа соёлын өвийн олдворыг хөндөхгүй байхад чиглүүлнэ.

Санамсаргүй олдвор олдсон тохиолдолд мэдээлэхгүй бол мөнгөн торгууль ногдуулна. Түүх, соёлын өвийг хэн нэгэн санаатайгаар гэмтээсэн бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээс тогтоосон олдворын үнэлгээний дагуу төслийн гүйцэтгэгч нөхөн төлбөр төлнө.

Хэрэв ажилтан газар шороо ажил болон барилгын ажлын явцад археологи болон түүхийн дурсгалт газар түүний үлдэгдэл, эд өлгийн зүйл, хүний шарилын үлдэгдэл, оршуулгын газар зэрэг биет соёлын өв олж илрүүлсэн тохиолдолд төслийн гүйцэтгэгч тухайн эд өлгийн зүйлийг хулгайлах, дээрэмдэх, гэмтэхээс хамгаалах үүрэгтэй бөгөөд дараах арга хэмжээг авна.

1. Эдгээр олдворыг хадгалах шийдэл олтол, эсвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академиас зөвлөгөө авах хүртэл олдворын ойролцоох бүх ажлыг зогсооно.
2. Төслийн үйл ажиллагааны талбайн менежер нэн даруй мэдэгдэх. Талбайн менежер нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээс зохих зөвшөөрлийг авсан тохиолдолд палеонтологич/ археологичид ирж шаардлагатай бол малтлага хийх ажлыг зохион байгуулан төсөл хэрэгжүүлэгч нэгжийн БОНМБ-ийн ажилтанд мэдэгдэх ёстой.
3. Төслийн үйл ажиллагааны талбайн менежер нь ослын тайланд олдворын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичиж, олдворын зургийг авах ёстой. Тайланг Германы сэргээн босголт, зээлийн банкны хүргүүлэх улирлын явцын тайланд тусгана.
4. Төслийн үйл ажиллагааны талбайн менежер нь объект илэрсэн талбайд хамгааллын зурвас гаргах ямар нэгэн эвдрэл гэмтэл үүсэх, зөөврийн объектыг алдахаас сэргийлнэ. Тухайн талбайн менежер нь олдворыг үнэт болон эмзэг үлдэгдэл гэж үзвэл тухайн газарт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академиас хамгаалалтад авах хүртэл харуул хамгаалалтыг байрлуулна.
5. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээс олдворын ач холбогдлыг тодорхойлохын тулд шуурхай үнэлгээ хийж, зохих арга хэмжээг төслийн үйл ажиллагаанд тусгаж, улмаар хэрэгжүүлэлтийг хангуулна.
6. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээс бичгээр зөвшөөрөл авсны дараа л талбай дээрх ажлыг үргэлжлүүлж болно.

Төсөл болон төслийн үйл ажиллагаанд хамрагдаж буй аливаа төслийн гүйцэтгэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн удирдамжийг дагаж мөрдөж, олдворын зохион байгуулалт, хадгалалт, хадгалалт, сэргээн босголт, олдворыг аврах зэрэгт өөрчлөлт оруулах аливаа шаардлагыг ханган ажиллах ёстой.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өгсөн бүх зураг, холбоо барих мэдээлэл, албан шийдвэрийн хуулбарыг хадгалах ёстой.

Санамсаргүй олдворын яаралтай мэдээлэх:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам	ШУА-ийн Археологийн хүрээлэн,
Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2	Шинжлэх ухааны академийн I байр, Энхтайваны өргөн чөлөө гудамж,
Улаанбаатар хот – 15160, Чингэлтэй дүүрэг,	Улаанбаатар хот – 1330, Монгол улсын Баянзүрх дүүрэг
Утас. +976 (51) 261 966	Утас. +976 (11) 452 894
Вэб: www.mne.mn . Цахим хаяг: webmaster@mne.gov.mn	Вэб: www.ac.mn/archaeology . Цахим хаяг: archaeology@mas.ac.mn

Хавсралт 13: Төслийн оролцогч талууд

	Холбогдох талууд	Оролцогч талуудын тодорхойлолт /байршил, хэмжээ, байгууллагын чадавх гэх мэт/	Хариуцлага
Бодлого боловсруулагчид ба зохицуулагчид	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	<ul style="list-style-type: none"> Орчны бүсэд багтсан 5 аймагт 	<ul style="list-style-type: none"> Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийг баталж, хуваарилна Хэрэгжилтэд хяналт тавина Бодлого, шийдвэрээр дэмжинэ
	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	<ul style="list-style-type: none"> Орчны бүсэд багтсан 50 суманд 	<ul style="list-style-type: none"> Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө, сумын ЗДТГ-ын төсвийг баталж, хуваарилах Хэрэгжилтэд хяналт тавих Бодлого, дүрэм журам боловсруулах Байгалийн нөөцийг ашиглах, хамгаалахтай холбоотой шийдвэр гаргах
	Аймгийн ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Гол асуудлыг 5 аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хариуцна Олон нийтийн байгууллага, сумын ЗДТГ удирдана 	<ul style="list-style-type: none"> ИТХ-аас баталсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ Төслийн хэрэгжилт, бараа, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах Талуудын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулна Техникийн шинэчлэлд идэвхтэй байх. Энэ чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.
	Сумын Засаг дарга, сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Сумын Засаг дарга Сумын Засаг дарга тус бүр 10 гаруй ажилтантай 	<ul style="list-style-type: none"> Орчны бүсийн менежментийн зөвлөлд сумдыг төлөөлнө. Байгалийн нөөцийн судалгаа, тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулна. Байгалийн нөөцийг тогтоосон хэмжээ, хязгаар, төлөвлөгөөний дагуу ашиглах зөвшөөрөл олгох. Иргэдийн нөхөрлөл, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих, зохицуулах, зохион байгуулах.

	Холбогдох талууд	Оролцогч талуудын тодорхойлолт /байршил, хэмжээ, байгууллагын чадавх гэх мэт/	Хариуцлага
	Орчны зөвлөл бүсийн	<ul style="list-style-type: none"> • ТХГН бүр Орчны бүсийн зөвлөлтэй байна • Орчны бүсийн зөвлөл тус бүр нь сумдын Засаг дарга, ТХГН-ийн болон байгаль орчны байгууллагын дарга нар, төсөлд хамрагдсан бүс нутагт хамрагдах иргэдийн төлөөлөл зэрэг нийт 19-25 гишүүдээс бүрдэнэ. 	<ul style="list-style-type: none"> • Орчны бүсэд оролцогч талуудын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн заалтуудыг хэрэгжүүлнэ • Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна • Сумын хэмжээнд орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талууд болон олон нийтийн оролцоог хангана. • Тус суманд тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөлийг удирдан зохион байгуулж, оролцоог сайжруулж, бэхжүүлэх. • Орчны бүсийн зөвлөлийн дүрмийг боловсруулж хэрэгжүүлэх. • Орчны бүсийн сан байгуулж, сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
Байгаль орчны байгууллагууд	Аймгийн БОАЖГ	<ul style="list-style-type: none"> • Төсөлд хамрагдсан 5 аймагт үйл ажиллагаа явуулдаг. Тус бүр нь 10 орчим ажилтантай бөгөөд аймгийн бүх сумдын БОМТ болон байгаль хамгаалагчидтай Байгаль орчны мэдээлэл бүхий заавар зөвлөгөө өгнө. • Аймгийн хэмжээнд байгаль орчны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, хяналт тавих, сумдыг мэргэжлийн чиглүүлэгчээр хангах. 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг ашиглахад технологийн шинэчлэл хийж, нэвтрүүлэх. • Байгаль орчны төсөл боловсруулж хэрэгжүүлэх. • Орчны бүсийн зөвлөлд зааварчилгаа өгч, удирдан чиглүүлэх. • Орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг аймгийн байгаль орчны бодлого, хөтөлбөртэй уялдуулах. • Сумдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон байгаль хамгаалагчдыг сургаж, чадавхжуулах. • Аймгийн хэмжээнд байгалийн нөөцийн судалгаа, тооллогыг зохион байгуулна. • Байгалийн нөөц ашиглалтын хэмжээ, хязгаарыг тогтоож, төлөвлөх.

	Холбогдох талууд	Оролцогч талуудын тодорхойлолт /байршил, хэмжээ, байгууллагын чадавх гэх мэт/	Хариуцлага
	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	<ul style="list-style-type: none"> • 5 аймгийн нийт 10 ТХГН-ийн захиргаа байдаг. 	<ul style="list-style-type: none"> • ТХГН-ийн болон орчны бүсийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах • Ойролцоох байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газруудыг хамгаалах • ТХГН-ийн менежментийг хэрэгжүүлж, аялал жуулчлалын үйл ажиллагааг удирдан зохицуулах • Бусад талуудад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх
	Сав газрын хамгаалалтын захиргаа	<ul style="list-style-type: none"> • Төсөл хэрэгжиж буй бүс нутагт нийт дөрвөн Сав газрын захиргаа байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх. • Сав газрын менежментийн төлөвлөгөөг ТХГН болон Аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах. • Сав газрын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, байгууллагад усны нөөцийг зохистой ашиглах талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулна. • Сумын үйл ажиллагааг Усны сав газрын зөвлөлөөр дамжуулан зохицуулна. • Усны хэмнэлттэй, цэвэршүүлэх технологи нэвтрүүлэх талаар талуудад зөвлөгөө өгөх.
	Сум дундын ойн анги	<ul style="list-style-type: none"> • Төсөл хэрэгжиж буй бүс нутагт нийт дөрвөн Сум дундын ойн анги байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Сумын ойн судалгаа, тооллого, ойн талаар мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. • Ойн ашиглалт, хамгаалах бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина. • Ойн нөөцийн лиценз олгох, хяналт тавих. • Ойн менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн нөхөрлөлд туслах.
	Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв (УЦУОШТ)	<ul style="list-style-type: none"> • Төсөлд хамрагдсан аймгуудын УЦУОШТ-үүд мөн оролцдог. 	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээллээр хангах • Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах • Байгалийн өөрчлөлтийг тогтвортой хянах

	Холбогдох талууд	Оролцогч талуудын тодорхойлолт /байршил, хэмжээ, байгууллагын чадавх гэх мэт/	Хариуцлага
ИНБ/ТББ -ууд	Орчны бүсийн зөвлөл	<ul style="list-style-type: none"> Сум бүр орчны бүсийн зөвлөлтэй байна. ТХГН-ын орчны бүсийн сум бүр орчны бүсийн зөвлөлтэй байх ёстой ч зарим сумдад ОБЗ-ийн үйл ажиллагаа тогтворгүй байна. 	<ul style="list-style-type: none"> Сумын түвшинд кластерийн оролцогч талуудын хооронд байгуулсан санамж бичгийн заалтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог зохион байгуулна. Сумын хэмжээнд орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэдээллээр хангах, иргэдийн оролцоог хангах, оролцоог зохион байгуулах. Сумын хэмжээнд ТХГН-ийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Орчны бүсийн байгалийн нөөцийг зохистой ашиглах үйл ажиллагааны дүрмийг боловсруулж хэрэгжүүлнэ. Орчны Бүсийн санг байгуулах, зузаатгах, удирдах, хэрэгжүүлэх.
	Орон нутгийн иргэдийн бүлгүүд		<ul style="list-style-type: none"> Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, залуучуудын эрхийг хамгаалах Таниулан сурталчлах Байгаль орчноо хамгаалах, зүй зохистой ашиглах Тодорхой газар нутгийг хамгаалах үүрэгтэй Амьжиргааг дээшлүүлэх өөр төрлийн орлогын эх үүсвэрийг санаачлан нэвтрүүлэх Байгаль орчныг нөхөн сэргээхэд туслалцаа үзүүлэх
хандивлагч	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	<ul style="list-style-type: none"> Тусламжийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна 	<ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлэхэд нь орон нутгийн засаг захиргаанд техникийн туслалцаа үзүүлэх Орчны бүсийн бодлого, журмыг боловсронгуй болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх, тогтвортой амьжиргааг дэмжих чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулах талаар зөвлөгөө өгөх.

	Холбогдох талууд	Оролцогч талуудын тодорхойлолт /байршил, хэмжээ, байгууллагын чадавх гэх мэт/	Хариуцлага
Бусад	Дэлхийн байгаль хамгаалах сан	<ul style="list-style-type: none"> Ховд аймагт хоёр ажилтантай салбартай. 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчныг хамгаалах, нөөцийн зохистой хэрэглээг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд ТХГН-ийн судалгаа, мониторингийн чадавхыг бэхжүүлэх Иргэдийн бүлгээр дамжуулан тогтвортой амьжиргааг хөгжүүлэхийг дэмжинэ

Ховд аймгийн орон нутгийн ажилтнуудтай холбоо барих мэдээлэл

	Байгууллагын нэр	Удирдлагын нэр	Утасны дугаар	Цахим шуудан
1	Ховд аймгийн Засаг дарга	Э.Болормаа		Khovdgovern@Khovd.gov.mn Contact@Khovd.khural.mn
2	Аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын газар	Л.Батбаяр	99172645, 88880411	Lkham.Batbayar@yahoo.com
3	УЦУОШ төвийн дарга	А.Энхзаяа	70432307, 99037017	info@namem.gov.mn Zaya_www1@yahoo.com
4	Хар Ус нуурын БЦГ	Ч.Батмөнх	99138579	Kharuslake@mpa.gov.mn
5	Мянган угалзатын нурууны БЦГ	Т.Лхагвадорж	99285472	1000ugalzat@mpa.gov.mn
6	Мөнххайрхан уулын БЦГ	М.Одхүү	99474141	Munkhkhairkhan@mpa.gov.mn
7	Хар нуур, Ховд голын сав газар	Р.Энхсүрэн	99439837	R_enkhsuren@yahoo.com
8	Үенч, Бодонч, Булган голын сав газар	Б.Батзориг	94003196	bzorig62@yahoo.com
9	Сум дундын ойн анги	Ц.Даваахүү	99064478	Davaakhuu@yahoo.com

Увс аймгийн орон нутгийн ажилтнуудтай холбоо барих мэдээлэл

	Байгууллагын нэр	Удирдлагын нэр	Утасны дугаар	Цахим шуудан
1	Увс аймгийн Засаг дарга	Ч.Чимэд	99452008 70452002	miniivvs2020@gmail.com
2	Аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын газар	Б.Энхтуяа	99459929	Enkhtuya_06@yahoo.com
3	УЦУОШ төв	Б.Пүрэвсүрэн	99459543	Puje29@yahoo.com
4	Хан хөхийн нурууны УТХГН-н хамгаалалтын захиргаа	Б.Цэлмэгдалай	99225228	Khankhukhii@mpa.gov.mn Tselmegdalaib@gmail.com
5	Увс нуурын ай савын УТХГН-н хамгаалалтын захиргаа	Б.Одсүрэн	99339078	Uvsbasin@mpa.gov.mn
6	Увс нуур, тэсийн голын сав газрын захиргаа	М.Анхбаяр	70454766, 99459366	M.Anhaa88@yahoo.com
7	Сум дундын ойн анги /Малчин сум/	Ч.Бат-Эрдэнэ	91524747	baagii_1220@yahoo.com
8	Сум дундын ойн анги /Түргэн сум/	М.Дээшин	99536362	
9	Сум дундын ойн анги /Өндөрхангай сум/	Т.Бямбажаргал	95119254, 96700700	byambaa_700@yahoo.com

Баян-Өлгий аймгийн орон нутгийн ажилтнуудтай холбоо барих мэдээлэл

	Байгууллагын нэр	Удирдлагын нэр	Утасны дугаар	Цахим шуудан
1	Баян-Өлгий аймгийн Засаг дарга	Д.Баурижан	99422200 70422545	Aumin_db@yahoo.com
2	Аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын газар	Ш.Марат	99423066	KEREI_2009@yahoo.com
3	Монгол алтайн нурууны УТХГН-н хамгаалалтын захиргаа	С.Медухан	99428858	medeukhan@yahoo.com
4	Хөх сэрхийн нурууны УТХГН-н хамгаалалтын захиргаа	Х.Сандигүл	70426669 99418109	Khukhserkh@mpa.gov.mn H.Sandigul@yahoo.com
5	УЦУОШ төв	П.Жанаргүл	70422799, 99425504, 99425263	Janargul1212@gmail.com
6	Сум дундын ойн анги	С.Эрболат	94054224	S.erbolat@yahoo.com

Хавсралт 14: Байгаль орчин, нийгмийн асуудлын эрх зүй, байгууллагын хүрээ

Энэхүү хавсралт нь төслийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн менежментийг удирдан чиглүүлэх эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог тоймлон харуулсан болно. Монгол Улсын Засгийн Газар болон Германы сэргээн босголт, зээлийн банкны хооронд байгуулсан төслийн санхүүжилтийн гэрээний дагуу төслийг хэрэгжүүлэхдээ Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжид⁴⁵ заасан шаардлагыг биелүүлэхийн тулд байгаль орчин, нийгмийн сайн туршлагын үндэсний болон олон улсын тогтолцоог чиглэл болгоно. Удирдамж нь төслийн менежментэд дараах зарчмуудыг баримтлах үүрэг хүлээдэг.

- Байгаль орчны хохирол, түүний дотор уур амьсгалд нөлөөлөх ялгаралт, бохирдол болон байгаль орчны бохирдлоос зайлсхийх, багасгах, хязгаарлах.
- Биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой менежмент хийх.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжийг ашиглах зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй болон урьдчилан таамаглаж болох нөлөөллийг авч үзэх⁴⁶
- Орон нутгийн иргэд, ялангуяа уугуул иргэд болон бусад эмзэг бүлгийн амьдралын нөхцөл байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх, мөн уугуул иргэдийн эрх, амьдралын нөхцөл, үнэт зүйлийг баталгаажуулах.
- Иргэд болон тэдгээрийн амьдрах байдал болон эд хөрөнгийг хүчээр хураах, мөн албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, аль болох бага байлгах, түүнчлэн газар ашиглалтын өөрчлөлтийн улмаас нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөлөлд өртсөн хүн амын өмнөх амьдрах нөхцөлийг сайжруулах.
- Германы сэргээн босголт, зээлийн банкны санхүүжүүлсэн арга хэмжээний хүрээнд ажлын байран дах эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, дэмжих.
- Албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихгүй, хөдөлмөр эрхлэлтийн талаар ялгаварлан гадуурхахыг хориглох; эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй байх, мөн хамтын хэлэлцээр хийх эрхийг дэмжих.
- Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах,
- Хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд байгаль орчин, нийгэм, уур амьсгалд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг тооцож түүнд хяналт тавих.

Удирдамж нь олон улсын дараах үндсэн стандартуудыг дагаж мөрдөхийг шаарддаг. Үүнд,

- Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын хүрээнд тодорхойлогдсон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 1-10.⁴⁷
- Дэлхийн Банкны Байгаль орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн, зааварчилгаа⁴⁸ ба үйлдвэрлэлийн тусгай заавар.⁴⁹

⁴⁵ KfW Development Bank, *Sustainability Guideline Assessment and management of Environmental, Social, and Climate Aspects: Principles and Procedures*, 2021.

⁴⁶ In this context climate change is understood as climate variability and long-term climate change.

⁴⁷ The World Bank, *Environmental and Social Framework*, 2017.

⁴⁸ The World Bank Group/IFC, *General EHS Guidelines*, 2007.

⁴⁹ The World Bank Group/IFC, *Environmental, Health, and Safety Guidelines*, various dates – latest updates on: www.ifc.org/ehsguidelines

- ХБНГУ-ын хоёр талын техник, санхүүгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн саналд жендэрийг оролцуулан хүний эрхийн стандарт, зарчмуудыг тусгах тухай удирдамж.⁵⁰
- Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 2-оос гадна хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудын хувьд холбогдох Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) үндсэн стандартууд.⁵¹
- Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 5-аас гадна газар эзэмшихтэй холбоотой асуудлуудын Газар, загасны аж ахуй, ойн эдэлбэрийн хариуцлагатай удирдлагын тухай сайн дурын удирдамж.⁵²
- Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 4-өөс гадна хууль хэрэгжилттэй холбоотой асуудлуудын хувьд холбогдох НҮБ-ын хууль сахиулах албан тушаалтны ёс зүйн дүрэм⁵³, хууль сахиулах байгууллагын албан тушаалтны⁵⁴ хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд.

Хавсралтын агуулга нь дараах байдалтай байна. Үүнд,

1. Энэхүү баримт бичгийн эхний хэсэгт төсөлтэй холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бодлогын тоймыг оруулсан болно.
2. Хоёр дах хэсэг нь энэхүү байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогыг боловсруулахад баримталдаг суурь материал болон Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн шаардлагатай стандартуудын тоймыг агуулсан болно.
3. Төгсгөлийн хүснэгтэд гол талууд, орхигдлын дүн шинжилгээ, санал болгож буй төслийн арга барилын тоймыг оруулсан болно.

1. Үндэсний эрх зүйн зохицуулалт, бодлогын хүрээ

Монгол Улсын Үндсэн хууль (1992 онд 3 удаа шинэчлэгдсэн, хамгийн сүүлд 2019 онд батлагдсан) нь иргэд хуулийн өмнө тэгш эрхтэй байх, үндсэн эрх (үг хэлэх, шашин шүтэх эрх чөлөө гэх мэт) болон үүрэг (татвар төлөх гэх мэт) зэргийг заасан байдаг. Уг хуульд тусгагдсанаар үндсэн эрхүүдэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй (16.2-р зүйл) багтана. Үүрэгт Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. (17.2-т). Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар Засгийн газраас арга хэмжээ авахыг Үндсэн хуульд заасан (38.2.4-т).

Мөн Үндсэн хуульд Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн

⁵⁰ Federal Ministry for Economic Cooperation and Development, *Guidelines on Incorporating Human Rights Standards and Principles, Including Gender, in Programme Proposals for Bilateral German Technical and Financial Cooperation, 2013.*

⁵¹ International Labour Organisation, *Fundamental Conventions*: <https://www.ilo.org/global/standards/introduction-to-international-labour-standards/conventions-and-recommendations/lang-en/index.htm#:~:text=The%20ILO%20Governing%20Body%20has,forced%20or%20compulsory%20labour%3B%20the>

⁵² Food and Agriculture Organization of the United Nations, *Voluntary Guidelines on the Responsible Governance of Tenure of Land, Fisheries and Forests in the Context of National Food Security, 2012.*

⁵³ United Nations Human Rights Office of the High Commissioner, *Code of Conduct for Law Enforcement Officials*, Adopted by the General Assembly 34/169 of 17 December 1979.

⁵⁴ United Nations Human Rights Office of the High Commissioner, *Basic Principles on the Use of Force and Firearms by Law Enforcement Officials*, Adopted by the Eight United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, Cuba, 27 August to 7 September 1990.

амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно хэмээн заасан байдаг. (6.4-р зүйл).

Байгаль орчны хамгаалах

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуульд⁵⁵ байгаль орчныг эдүгээ болон хойч үедээ хамгаалах, байгалийн нөөцийг ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах Үндсэн хуулийн байгаль орчны заалтуудыг тусгажээ (1 дүгээр зүйл). Гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй хэмээн шаарддаг (4.1.1).

Байгалийн баялгийг арилжааны зорилгоор ашиглагчид Байгаль орчны үнэлгээ (БОУ)-ээ өөрөө хийнэ гэж хуульд заасан (7-р зүйл). БОУ-г санал, хөтөлбөр боловсруулах, түүнчлэн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээг ашиглах, эхлүүлэх, өргөтгөх гэрээ байгуулах зорилгоор явуулна (9-р зүйл).

6-р зүйлд байгалийн баялаг, газрыг иргэдэд өмчлүүлээгүй бол өмчлөх эрхийг төрийн өмч гэж тодорхойлсон. Байгалийн баялгийг аливаа гэрээ, тусгай зөвшөөрөл, лицензийн дагуу төлбөр төлж ашиглаж болно⁵⁶. Засгийн газар байгаль орчныг хамгаалахад хяналт тавьж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг өмчийн хэлбэрээс үл хамааран хориглож болно (14 дүгээр зүйл).

Хууль нь аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байгаль орчныг хамгаалах ажлыг төлөвлөх, төсөвлөх, хяналт тавих, хэрэгжүүлэх эрх, тэр дундаа орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) байгуулах эрхийг олгосон (16 дугаар зүйл). Мөн байцаагч өөрийгөө хамгаалах зэвсэг авч явахыг хуульд заасан (29.2-р зүйл).

26, 27, 28 дугаар зүйлд хувийн хэвшлийн бүтээн байгуулалтад байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг төсөвлөх, хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагад хяналт тавих Байгаль орчны хяналтын улсын байцаагчийг томилж, эрх мэдлийг нь олгохоор заасан (29.1-д). Хувийн компаниуд байгаль орчныг хамгаалах, нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээхэд эдийн засгийн дэмжлэг үзүүлж болох (31-р зүйл) тухай заасан.

Монгол Улсын Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай хууль (2003) (Энэ хуулийг хүчингүй болсонд тооцож, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын асуудлыг Хог хаягдлын тухай Монгол Улсын хуулиар (2017) зохицуулсан бөгөөд төрийн хог хаягдлын менежментийн захиргааны хариуцлага, төлбөр авах эрх хэмжээг (9-р бүлэг) тодорхойлсон). Уг хуульд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах зэрэг бүх төрлийн хог хаягдлыг зохицуулах цогц арга барилыг тусгасан.

Бүх хог хаягдлыг зохих газруудад хаях ёстой бөгөөд ихэнх хөдөөгийн оршин суугчдын хувьд хогоо булах цэгт хаядаг бол үйлдвэрлэлийн хог хаягдлыг тусгай байгууламжид ашиглах ёстой (16-р зүйл). Аюултай хог хаягдлыг дахин ашиглах зөвшөөрөл шаардлагатай хэдий ч хог хаягдлыг дахин ашиглахыг зөвшөөрнө (37-р зүйл). Хог хаягдлын цэгийг хаана байрлуулахыг хуульд заасан байдаг (17-р зүйл).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль⁵⁷ нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэргүй байдлаас урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг ашиглах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, төсөл эхлүүлэх шийдвэр гаргахтай

⁵⁵ Approved in 1995 and amended more than 20 times, most recently in 2019.

⁵⁶ In accordance with Article 20, adhering to regulation on environmental carrying capacity set by the standardisation organisation.

⁵⁷ The law was repealed and revised version approved in 2012, after that it amended twice in 2015 and 2017.

холбогдсон харилцааг зохицуулах зорилготой (1-р зүйл). Энэ нь төсөл хэрэгжүүлэгчдээс төслийн тодорхойлолт болон холбогдох баримт бичгийг ирүүлэхийг шаардаж, байгаль орчны эрсдэл, нөлөөллийг тодорхойлох төслүүдийг шалгах үйл явцыг тодорхойлсон.

Хуулийн дагуу шинээр санал болгож буй төсөл, төслийн өргөтгөлүүдийг төслийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэлийг ирүүлсний дараа Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) эхний шатны шалгалтад хамруулдаг. Тус хуулийн 4-р зүйлд зааснаар төсөлд тавигдах шаардлагад дараах төрлийн үнэлгээнүүд байж болно. Үүнд,

- байгаль орчны стратегийн үнэлгээ⁵⁸
- байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
- байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
- хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ⁵⁹

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ шаардлагатай төслүүдийн хувьд хуульд (7-р зүйл) зааснаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг тус тус шаарддаг байна.

Хүснэгт А1-д байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ шаардлагатай эсэхийг тодорхойлон авч үзэх хэрэгтэй төслийн онцлог шинжүүдийг тоймлон харуулав. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ шаардлагатай тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нь төслийн тодорхойлолт, техник эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, мөн төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг Даргын бичгээр гаргасан санал дүгнэлтийн хамт Хүснэгт А1-д тодорхойлсон төслийн төрлөөс хамаарч аймаг, нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар эсвэл БОАЖЯ-д хянуулахаар хүргүүлнэ. Холбогдох байгууллага нь ажлын 14 хоногийн дотор төслийн нарийвчилсан мэдээллийг хянаж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ шаардлагатай тохиолдолд БОАЖЯ нь хуульд заасан шаардлагын дагуу үнэлгээ хийх шинжээчдийг томилно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний А-117 тоот Сайдын тушаалаар батлагдсан аргачлал нь нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэхийг шаарддаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмаар орон нутгийн иргэд, мөн төслийн нөлөөлөлд өртсөн иргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Иймд, төслийн үйл ажиллагаа, хэрэгжилттэй холбоотой байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд орон нутгийн нийт иргэд оролцох үүргээ ухамсарлах нь чухал юм. Удирдамжийн 9 дүгээр зүйлд⁶⁰ заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нь хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй. Мөн удирдамжид хамгаалах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн 50-иас доошгүй хувийг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнаж байхаар заасан.

**Хүснэгт А1: Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүд
(БОНБУ тухай хуулийн хавсралт дах холбогдох төслүүд)**

⁵⁸ Required for ministries proposing policies, programs and (sector) plans.

⁵⁹ The state central administrative organization in charge of nature and environment shall conduct the assessment [...] to analyse the effects on a region and basin from various projects implemented by individuals and business entities with due inputs from a licensed professional entity.

⁶⁰ Except for mineral exploitation, concentrators, processing plants and chemical plant projects.

Тайлбар	Хариуцагч этгээд	
	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Аймаг Нийслэлийн ЗДТГ
3.Хөнгөн, хүнсний үйлдвэрийн төсөл	Улсын чанартай томоохон үйлдвэр	орон нутгийн жижиг, дунд үйлдвэр
4.Хөдөө аж ахуйн төсөл	-усан сан -усжуулалтын систем -атар газар эзэмших үйл ажиллагаа	-орон нутагт хэрэгжих ойжуулалтын төсөл -ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн -газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талбайд
5.Дэд бүтцийн хөгжлийн төсөл	-1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц -35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам -дулааны шугам -усан цахилгаан станц -төмөр зам -нисэх буудал -улс, хот хоорондын зам -улс хот хоорондын холбоо -нефтийн бүтээгдэхүүний агуулах	-1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц -35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам -тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам -орон нутгийн чанартай зам, холбоо -шатахуун түгээх станц
6.Үйлчилгээний салбарын төсөл	-50 ор хоногоос дээш хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар	-50 хүртэл ор хоногийн хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар - аялал, жуулчлал эрхлэх
8.Биологийн төрөл зүйлийн төсөл	-улсын чанартай томоохон загасны аж ахуй -ан амьтан, ургамал нутагшуулах, ашиглах болон бусад үйл ажиллагаа	-ан агнуурын болон ойн аж ахуй, ангийн отог -тухайн дэвсгэр нутгийн хүн амын хэрэгцээг хангах зориулалттай загасны аж ахуй
11.Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах үйл ажиллагаа	Улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсэд явуулах үйл ажиллагаа ⁶¹	-орон нутгийн хамгаалалтад авсан газар нутагт явуулах үйл ажиллагаа

⁶¹ The Buffer Zone Law clarifies that the following activities in buffer zones shall conduct a Detailed EIA: commercial logging, hunting, establishment of hunters' camps, exploration and mining of minerals, establishment of water reservoirs, construct floodwalls or dams.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн хэлэлцүүлэг болон оролцоог хангахыг шаарддаг. Төсөлтэй холбоотой мэдээлэл болон холбогдох байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны цахим хуудсанд байршуулдаг. Орон нутгийн иргэд санал хүсэлтээ ажлын 30 хоногийн дотор бичгээр болон амаар гаргаж болно. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай төслүүдийн хувьд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах явцад олон нийтийн хэлэлцүүлгийг хийх замаар орон нутгийн засаг захиргаа, мөн нөлөөлөлд өртсөн иргэд болон орон нутгийн оршин суугчдаас албан ёсоор санал авах ёстой.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18-аар зүйлд зааснаар олон нийтийн оролцооны журмыг БОАЖЯ нь батлахаар тусгасан байдаг бөгөөд БОНХЯ (хуучин нэрээр)-ны сайдын 2014 оны тушаалаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийг оролцоог хангах тухай журамд холбогдох шаардлагыг сайтар тусгасан байдаг. Тус тушаалд орон нутгийн захиргааны байгууллага болон БОАЖЯ нь аливаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд төслийн мэдээллийг ашиглахыг шаарддаг. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэгчид нөлөөллийн оролцооны үнэлгээнд хамрагдаж, нөлөөллийг тодорхойлох, тооцоолох болон үнэлэх үе шатанд олон нийтийн хэлэлцүүлгийг хийхийг заасан байна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгийг тухайн орон нутгийн баг, хороогоор⁶² хэлэлцүүлэн саналыг авах шаардлагатай. Бүх саналыг ИТХ-д оруулж улмаар холбогдох шийдвэрээ гаргадаг.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутаг нь Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) тухай хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль гэсэн хоёр тусдаа хуулиар зохицуулагддаг.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)-иар бүсчлэлд үндэслэн ТХГН-ийн ангилалд хамаарах зөвшөөрөгдсөн болон хориглосон үйл ажиллагааг тодтоосон байдаг. Дараах үйл ажиллагааг шууд хориглодог. Үүнд,

- **Дархан цаазат газар:** урьдчилан тогтоосон хэмжээнээс өөр барилга, байгууламж буюу өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга, байгууламж барихыг хориглох бөгөөд зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэхийг хориглоно (12 дугаар зүйл).
- **Байгалийн цогцолборт газар:** батлагдсан бүтээн байгуулалт, барилга байгууламжийн төлөвлөгөөг зөрчиж суурин газрыг өргөтгөх, барилга байгууламж барихыг хатуу хориглоно.
- **Байгалийн нөөц газар:** байгаль орчинд сөрөг нөлөө (ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх) үзүүлж болзошгүй арилжааны зорилготой аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- **Байгалийн дурсгалт газар:** Байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0.1-3.0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

⁶² Хороо гэдэг нь Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж

Тусгай хамгаалалттай газар нутгийн төрөл, зориулалтын бүс (холбогдох тохиолдолд) дээр үндэслэн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг Хүснэгт А2-д үзүүлэв.

Хүснэгт А2- Монгол Улсын ТХГН-т зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа

Дархан цаазат газар ⁶³		Байгалийн цогцолборт газар ⁶⁴		Байгалийн нөөц газар ⁶⁵	Байгалийн дурсгалт газар ⁶⁶
Бүс	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа	Бүс	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа	Бүс	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа
Онгон бүс	Зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болно	Онцгой	Хамгаалалтын арга хэмжээ; судалгаа, хяналт шалгалт; хөрсийг нөхөн сэргээх; ургамал, амьтны нөхөн үржихүй; байгалийн гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх.	Байгалийн онцлог, хүн амд сөрөг нөлөөгүй уламжлалт эдийн засгийн үйл ажиллагаа	Хашаа барих, анхааруулах тэмдэг наах зэрэг хамгаалалтын арга хэмжээ
Хамгаалалтын бүс	Ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг	Аялал жуулчлалын бүс	Заасан газар загасчлах; хөрс, ургамлыг нөхөн сэргээх; ойн		

⁶³ Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

⁶⁴ Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

⁶⁵ Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ. Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана: 1/ байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар; 2/ ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар; 3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар; 4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар; 5/ Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар.

⁶⁶ Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана: 1/ байгалийн дурсгалт газар (Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно. 2/ түүх, соёлын дурсгалт газар (Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүе зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

	нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.		арчилгаа, цэвэрлэгээ; зохицуулалттай бэлчээр; булаг ашиглах; тодорхой маршрутаар аялал жуулчлал; тогтсон барилгыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглах; уламжлалт ёслолууд; байгалийн нөөцийг ахуйн хэрэгцээнд ашиглах.		
Хязгаарлалтын бүс	Хөрс, ургамлыг нөхөн сэргээх; ойн арчилгаа, цэвэрлэгээ; зохицуулалттай бэлчээр; булгийн ашиглалт; тодорхой маршрут бүхий аялал жуулчлал; тогтсон барилгыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглах; уламжлалт ёслолууд; байгалийн нөөцийг ахуйн хэрэгцээнд ашиглах.				
		Хязгаарлалтын бүс	Уламжлалт мал аж ахуйн аялал жуулчлал, спорт, нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам талбай, авто зогсоолыг батлагдсан зураг төсөл дээр үндэслэн хийх.		

Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) тухай хуулиар орон нутгийн засаг захиргаа нь нутаг дэвсгэрийнхээ харьяаллын бүс нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрдөг. Тус хуульд тусгай хамгаалалттай газар нутгийг тогтоох, зохицуулах эрх бүхий захиргааны байгууллагыг мөн зааж өгсөн. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь харьяа бүсэд иргэн, аж ахуйн нэгжид газар ашиглах зөвшөөрөл олгох бүрэн эрхтэй бөгөөд газар ашиглах гэрээг сумын ЗДТГ, эсвэл сумын ЗДТГ, хамгаалалтын захиргаатай байгуулдаг.

ТХГН нь тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчдыг Байгаль орчны хяналтын улсын байцаагчийнхтай адилтгадаг (31 дүгээр зүйл). Энэ нь шалгалтын эрх, бичиг баримт, эд зүйлсийг (буу, багаж хэрэгсэл, агнасан эсвэл цуглуулсан эд зүйл) хураан авах боломжийг олгодог. Байгаль хамгаалагчдад зэвсэг олгож болох боловч амь нас, эрүүл мэндэд аюул учирсан үед л зэвсгээ ашиглаж болно (32-р зүйл).

Орчны бүс

Тусгай хамгаалалттай газар нутаг нь орчны бүстэй байж болох талаар ТХГН-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан боловч ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль (1997)-д

нарийвчлан зохицуулсан байдаг. Тус хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс тогтоох, үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Орчны бүс нь тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг тодорхой болгох зорилготой юм.

Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын орчны бүс тогтооно, мөн байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхацсан байж болно. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл байгалийн нөөц газар, дурсгалт газарт орчны бүс, түүний заагийг тогтоож болно (3 дугаар зүйл).

Тус хуулийн 4-р зүйлд зааснаар орчны бүс болон түүний хил хязгаарыг экологи болон нийгэм-эдийн засгийн шалгуур үзүүлэлт болон тус хуулийн 5-р зүйлд зааснаар нутгийн иргэдийн оролцоонд үндэслэн тогтооно. Орчны бүсийн доторх бүтээн байгуулалтын талаар зөвлөгөө өгөхийн тулд тус хуулийн 6-р зүйлд зааснаар сум, ИТХ, орон нутгийн иргэд, Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны төлөөллийг (мөн ТББ-ын төлөөллийг оролцуулж болно) багтаасан орчны бүсийн зөвлөлийг байгуулахыг шаарддаг. Мөн тус зөвлөл нь тус хуулийн 7-р зүйлд зааснаар сан байгуулж болно. Тус хуулийн 8-р зүйлд зааснаар орон нутгийн Засаг дарга нар Зөвлөлтэй хамтран орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шаардлагуудыг тус хуульд заасан буюу тус хуулийн 9-р зүйлд⁶⁷ зааснаар орчны бүсэд үйлдвэрийн зориулалтаар мод бэлтгэх, ан агнах, анчдын отог байгуулах, ашигт малтмал эрж хайх, олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах, усан сан байгуулах, далан, хаалт барих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ. Мөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэд хамгаалалтын захиргааны санал, дүгнэлтийг тусгана.

Тус хуулийн 10-р зүйлд зааснаар Улсын байцаагч эсвэл холбогдох Засаг дарга нь гомдол гаргасан этгээдийн гомдлыг сонсож, шийдвэрлэгдээгүй асуудлыг шүүхэд шилжүүлэх үүрэг болгосон байна.

Газар

Монгол Улсын Газрын тухай хууль⁶⁸ (2002 онд батлагдаж өнөөдрийг хүртэл нийт 30 удаа хамгийн сүүлд 2019 онд шинэчлэгдсэн) нь иргэн, аж ахуй нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулдаг (1 дүгээр зүйл). Хуулиар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга, тэгш байдлыг баримталж газрыг үр ашигтай, зохистой, үндсэн зориулалтаар ашиглахыг шаарддаг. Тус хуулийн 4.1.5-р зүйлд зааснаар хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль

⁶⁷ БОНБУ-ний тухай хуульд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн бүх үйл ажиллагааг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар заасан байдаг.

⁶⁸ Тус хуульд газрын хэвлийн тухай тусгаагдаагүй бөгөөд газрын хэвлийн тухай хуулиар тусдаа зохицуулагддаг.

орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаарддаг. Газар ашиглалтыг дараах байдлаар ангилдаг. Үүнд,

- Хөдөө аж ахуйн газар;
- Хот, тосгон, бусад суурины газар;
- Зам, шугам сүлжээний газар;
- Ойн сан бүхий газар;
- Усны сан бүхий газар;
- Тусгай хэрэгцээний газар.

Тусгай хэрэгцээний газарт улсын тусгай хамгаалалттай газар хамаардаг. Тусгай хэрэгцээний газар нь төрийн өмч бөгөөд бусдад өмчлүүлж болохгүй (16 дугаар зүйл). Төрөөс тусгай хэрэгцээний газар гэж тогтоосон тохиолдолд өмчлөгчид бүрэн буюу хэсэгчлэн нөхөн олговор олгох ба орлуулах газрыг авах эсвэл авахгүй байж болно (42-43, 46 дугаар зүйл). Нөхөх олговор нь газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарахгүй (43.6-р зүйл).

Хуульд заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, харин гадаадын иргэнд газар ашиглах гэрчилгээг олгож болно. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа 15-60 жил байх боловч нэг удаад 40 жилээр сунгаж болно. Эзэмшлийн гэрчилгээг бэлчээр, хадлангийн талбай, ойн сан бүхий газар, нийтийн эзэмшлийн газарт олгохгүй. Газар ашиглалтын гэрчилгээ нь ихэвчлэн таван жилийн хугацаатай, сунгах боломжтой байдаг. Гэрчилгээ эзэмшигч нь хуульд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд гэрчилгээг хүчингүй болгож болно (40-р зүйл).

Газар ашиглагч болон эзэмшигч нь газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцахаар тусгасан байдаг (50-р зүйл).

Газрын төлбөрийн тухай хуулиар газар түрээслүүлэх тухай хууль (1997 онд батлагдаж, хэд хэдэн удаа шинэчлэгдэж хамгийн сүүлд 2019 онд шинэчлэгдсэн) төрийн өмчийн газар эзэмшиж, ашигласны төлбөрийг тодорхойлж, улсын төсөвт төлбөр төлөх үйл ажиллагааг зохицуулсан.

Ой

Монгол Улсын Ойн тухай хууль (2007 онд энэ хууль хүчингүй болсон, 2012 онд батлагдсан шинэчилсэн найруулга, дараа нь 2019 онд удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулсан)-ийн 1-р зүйлд зааснаар ойг хамгаалах, эзэмших, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах ба тус хуулийн 5-р зүйлд зааснаар ойн санг хамгаалалтын бүсийн ой болон ашиглалтын бүс ой гэж ангилна. Тус хуулийн 4-р зүйлд зааснаар Монгол орны ой нөөц нь төрийн өмч боловч нөөцийн ашиглалтын төлбөртэй гэрээ байгуулдаг. Тус хуулийн 6-р зүйлд зааснаар БОАЖЯ нь Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга

хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна. Тус хуулийн 29-р зүйлд зааснаар ойд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд,

- Насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, заг, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тэс болон чацаргана, мойл зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх
- Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос хуш, гацуур, нарсыг бэлтгэх, ашиглах
- Ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх;
- Ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах;
- Ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх;
- Байгалийн ойгоос зулзаган модыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн суулгах;

Тус хуулийн 8-р зүйлд зааснаар хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын⁶⁹ болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарагдах бөгөөд эдгээрийг арилжааны зориулалтаар ашиглах боломжгүй юм

Ус

Монгол Улсын Усны тухай хууль /2004 онд хүчингүй болсонд тооцогдож, 2012 онд шинэчилсэн найруулга, дараа нь 2020 онд удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулсан/ нь усны нөөц, түүний сав газрыг, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Тус хуулийн 7-р зүйлд зааснаар усны эх үүсвэрийн тооллого, мөн 6-р зүйлд зааснаар усны нөөц, чанар, бохирдлыг хянах усны хяналт- шинжилгээний усны нэгдсэн сүлжээ (6-р зүйл)-ээр дамжуулан холбогдох усны мэдээллийн санд оруулахаар тусгажээ.

Тус хуулийн 8-р зүйлд зааснаар Монгол Улсын Хурал нь ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоох, мөн томоохон гол мөрний урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах асуудлыг шийдвэрлэх, мөн хил дамнасан гэрээ хэлэлцээрт хяналт тавьдаг.

Мөн хуулийн 9-р зүйлд зааснаар усны нөөцийг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон холбогдох төсвийг ханган ажиллана. Тус хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр “Бохирдуулагч төлөх” зарчим болон байгаль орчны аудитыг нэвтрүүлсэн. Бохирдуулагчид (түүний дотор иргэн, аж ахуйн нэгж, байгууллага) бохирдлоос учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй⁷⁰.

Байршлаас хамааран тодорхой төлөөлөлтэй усны сав газрын зөвлөлүүд нь БОАЖЯ-ны хяналтын дор усны менежментийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажилд ард иргэдийг

⁶⁹ Дархан цаазат гарын онгон болон хамгаалалтын бүс, мөн байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газрын онцгой бүсэд мод бэлтгэхийг хориглодог. Харин ашиглалтын хязгаарлагдмал бүс, аялал жуулчлалын бүсэд сийрээжүүлэх, ойн цэвэрлэгээ хийхийг зөвшөөрдөг.

⁷⁰ Байгалийн нөөц ашигласны тухай хууль (2012), Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012), Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиудад (2011) холбогдох үүрэг хариуцлагыг тодорхойлж, усны хэрэглээний төлбөр авах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

татан оролцуулна (20 дугаар зүйл). Газрын доорх ус ашиглах, усны тусгай зөвшөөрлийг усны мэргэжлийн байгууллагаас олгох бөгөөд үйл ажиллагааны чиглэл, үүргийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд /21 дүгээр зүйл/ баталж, таван жилийн хугацаанд хүчинтэй байх ба дахин таван жилийн хугацаагаар сунгах сонголттой байна (21-р зүйл). Эрүүл ахуйн бүс нь усны эх үүсвэрээс дор хаяж 100 м зайд байх ёстой. Цаашилбал, тусгай зөвшөөрөлгүйгээр усны урсгалыг бүрмөсөн өөрчлөх нь хууль бус юм (22-р зүйл).

Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөрийн тухай хууль (1999 онд батлагдаж 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт хийгдэж хамгийн сүүлд 2019 онд шинэчлэгдэн батлагдсан) нь хамтын гэрээнд үндэслэн хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүргийг зохицуулах, хөдөлмөрийн ганцаарчилсан болон хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, менежмент мөн энэ хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, талуудын харилцан эрх тэгш байдлыг хангана.

Хөдөлмөрийн нөхцөл

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд⁷¹ ажил олгогч, ажилтны эрх, үүргийг тодорхойлсон. Тус хуулийн 6-р зүйлд зааснаар аюулгүй орчинд амьдрах, цалин хөлс, чөлөө, тэтгэмж авах эрхийг тодорхойлсон. Энэ нь албадан хөдөлмөр эрхлэх, үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, статус/байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийг хориглоно (7-р зүйл). Мөн тус хуульд эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрхийг (11-20-р зүйл) тодорхойлсон.

Тус хуулийн 3-р бүлэгт хөдөлмөрийн гэрээг бичгээр, хуулбарын хамт ажилтанд өгөх ёстой гэж заасан. Гэрээ нь дараах зүйлийг агуулсан байх ёстой. Үүнд:

- Албан тушаал/цол хэргэм
- Ажил үүргийн хуваарь (хийх ажил, үүрэг, үнэлгээ)
- Цалин, тэтгэмж (үндсэн цалин, нэмэгдэл төлбөр, шагнал, урамшуулал (47 дугаар зүйл). Амралт, чөлөө олгох. (46 дугаар зүйлд заасны дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, үүнд холбогдох суутгал зэргийг багтаасан байх)
- Ажлын байрны нөхцөл
- Хугацаа ба өр төлбөр (жишээлбэл, тогтмол эсвэл нээлттэй, гэхдээ таван жилээс илүүгүй)

Ажлын хөлсийг сард хоёроос доошгүй удаа төлөх ёстой (60-р зүйл), бэлнээр төлнө (61-р зүйл). Ажилтны ажлын цагийг бууруулсан тохиолдолд ажилтан өмнөх зургаан сарын хугацаанд олгосон дундаж цалинг авах эрхтэй (67-р зүйл).

Төрийн болон төрийн захиргааны байгууллагад ажилладаг гэр бүлийн гишүүд бусад хамаатан садан (27 дугаар зүйл) болон нэгэн зэрэг ажил эрхлэхийг (28 дугаар зүйл) тус тус хориглодог.

⁷¹ 1999. 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт хийгдэж хамгийн сүүлд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон.

Ажлын цаг нь долоо хоногт 40 цагаас хэтрэхгүй, ажлын өдөр найман цагаас илүүгүй, ажлын хоёр өдрийн хоорондох амрах хугацаа 12 цагаас багагүй байна (70-р зүйл). 74 дүгээр зүйлд илүү цагаар ажиллахыг зөвшөөрсөн тохиолдолд чөлөөлөлтийг заасан байдаг.

Хуулиар 14-15 насны хүнийг долоо хоногт⁷² 30-аас бага цаг, 16-18 насны хүнийг 36 хүртэл цаг ажиллахыг зөвшөөрдөг (71-р зүйл). 18-аас доош насны хүний ажлын төлбөрийг ажилласан цаг дээр үндэслэн тооцдог (58-р зүйл). Гэсэн хэдий ч насанд хүрээгүй аливаа хүний оюуны хөгжил, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж буй ажил эрхлүүлж болохгүй (109-р зүйл).^{73, 74}

102-р зүйлд шөнийн цагаар болон илүү цагаар ажиллахыг хязгаарласан, тэр дундаа жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй эх, 16-аас доош насны хүүхэдтэй өрх толгойлсон эх нь шөнийн болон илүү цагаар ажиллахыг хориглосон, тэр дундаа түүний зөвшөөрөлгүйгээр албан томилолтоор ажиллуулахыг хориглоно. Хуулийн 7-р бүлэгт жендертэй холбоотой хамгаалалтыг тодорхойлсон. Тухайлбал, жирэмсэн болон гурван нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг ажлаас халж болохгүй. Гурав хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэгт мөн адил хамаарна. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд тодорхой ажил эрхлэхийг хориглодог (101-р зүйл).⁷⁵ Эмэгтэйчүүдэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн чөлөө (104-р зүйл), бага насны хүүхэд асрах (103-р зүйл) чөлөө олгох ёстой.

Хуульд 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулахыг шаарддаг (111-р зүйл). Ажил олгогчид мөн өндөр настай ажилчдыг (тэтгэвэр авах эрхтэй хүмүүс буюу 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 65-аас дээш насны эрэгтэйчүүд) байрлуулах ёстой (112-р зүйл).⁷⁶

Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд (2010 онд 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг төрийн болон ажилтны байгууллагын төлөөллийг оролцуулсан Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороо тогтоохоор заасан (5 дугаар зүйл). Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний

⁷² In accordance with Article 109 children may not enter into a labour contract without the permission of their parents. Anyone aged 14 to 15 years may only enter a country for vocational purposes.

⁷³ The Law on Mongolia on the Protection of the Rights of the Child (2016) defines children to persons under the age of 18. It affirms the prohibition of child labour in hazardous conditions and established National Council for Children.

⁷⁴ The Order of the Ministry for Health and Social Welfare establishing the lists of the jobs prohibited to women and minors (No. A/36 of 2016). The list of prohibited jobs for children includes specific tasks in the i) mining industry, ii) prospecting work, iii) metal processing industry, iv) china production, v) glass industry, vi) construction industry, vii) timber industry, viii) printing industry, iv) light industry, x) food industry, xi) agriculture, xii) transportation and telecommunication, xiii) social services, xiv) health protection, veterinary and pharmaceutical industry, xv) other common jobs and professions.

⁷⁵ The Order of the Ministry for Health and Social Welfare establishing the lists of the jobs prohibited to women and minors (No. A/204 of 1999). The list of prohibited jobs for women includes specific tasks in the i) mining industry, ii) leather industry, iii) class industry, iv) textile industry, v) printing industry, vi) clothing industry, vii) meat processing industry, viii) transport industry, iv) construction industry, x) social services, xi) timber industry, xii) other common jobs and professions.

⁷⁶ The Law of Mongolia on Human Rights of Persons with Disabilities (2016) clarifies the right of persons with disabilities for the right to non-discrimination and specifies a number of acts that will be considered discriminatory. It requires State institutions to conduct awareness raising campaigns on the human rights of persons with disabilities (Article 7) and sets out requirements for accommodating designs (Chapter 3). Furthermore, the Law requires employment accommodations to persons with disabilities (Chapter 5). However, existing Government buildings and transportation remains largely inaccessible to persons with disabilities.

доод хэмжээ нь бүс нутгийн хамгийн өндөр амьжиргааны доод түвшинг хангахад хангалттай байна (4 дүгээр зүйл).

Хамтын хэлэлцээрийн үр дүнд үүссэн хөдөлмөрийн маргааныг Засаг дарга зохих түвшинд зуучлах (115-р зүйл) бөгөөд ажилчид эвлэлдэн нэгдэх, ажил хаях эрхтэй (16, 119-123-р зүйл). Хөдөлмөрийн хамтын маргааныг арбитрын шүүхэд шилжүүлж болно (118-р зүйл). Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс хянана (125-126 дугаар зүйл). Комиссын тогтоолыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор давж заалдаж, албан ёсны шүүхэд шилжүүлж болно (127-128 дугаар зүйл).

Монгол улсын Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд (1991) үйлдвэрчний эвлэлд урьдчилан зөвшөөрөлгүйгээр, хүч хэрэглэхгүйгээр элсэх эрхийг нарийвчлан тусгасан. Тус хуулийн аливаа заалт нь олон улсын гэрээнд харшлах юм бол ажлын гэрээг тэргүүнд үзнэ гэж хуульд заасан (8-р зүйл).

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) төсөлтэй холбоотой бүх үндсэн конвенцод нэгдэн орсон.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

Хөдөлмөрийн тухай хуулийн 6-р бүлэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, стандартыг тодорхойлсон бөгөөд үүнийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нарийвчлан тусгасан болно.⁷⁷ Хуульд ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, тухайлбал галын аюулгүй байдал (13 дугаар зүйл), эмийн шаардлага (14 дүгээр зүйл), хамгаалах хэрэгсэл, аюултай орчинд ажлын байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ бүхий эрх, үүргийг тогтоосон. Хуульд аюулгүй ажиллагааны журмыг хангахын тулд сургалт явуулахыг шаарддаг (17-р зүйл). Үйлдвэрлэлийн ослыг хуульд заасны дагуу шалгаж, бүртгэх ёстой (6-р бүлэг). Хуульд цаашид хяналт тавих, зөрчил гаргасан тохиолдолд торгох арга хэмжээг тогтоосон (Бүлэг 7-8). Төсөлд хамаарах тодорхой шаардлагыг Хүснэгт А3-д заасан журамд тусгасан болно.

Хүснэгт А3: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдох дүрэм, стандарт

Стандартын нэр	Стандартын код
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага	MNS 4990 - 2000
Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага	MNS 5803 - 2007
Хөдөлмөр хамгааллын хэмжил зүйн хангалт	MNS 0012-0-006: 1989
Эмэгтэйчүүд, цөөнхийг ажиллуулахыг хориглох ажлын байрны нөхцөл	MNS 0012-099: 1991

⁷⁷ 2008. Amended several times, most recently in 2018.

Стандартын нэр	Стандартын код
Үйлдвэрийн үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага	MNS 0012-0-006: 1991
Мод боловсруулалт. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 0012-3-002: 1908
Будгийн ажил. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.	MNS 0012-3-006: 1984
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	MNS 4968 - 2000
Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS ILO OSH 0 1908
Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм	MNS 4969 - 2000
Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 4992 - 2000
Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага	MNS 4996 - 2000
Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS 5010 - 2001
Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг	MNS 5029 - 2001
Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	MNS 5080 - 2001
Биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга	MNS 5107 - 2001
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны талаарх удирдамж	MNS ILO OSH 1 - 2003
Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэглэлд	MNS 5146 - 2002
Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 5150 - 2002
Дуу чимээг хэмжих ерөнхий шаардлага	MNS ILO OSH 1 - 1908
Шуугиан. Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин	MNS 0012-1-009: 1985
Хэт өндөр дуу. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 0012-1-016: 1988
Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд. Ангилал	MNS 0012-4-005: 1985
Ажлын тогтолцооны дизайн дахь эргономикийн шаардлага.	MNS (ISO) 6385: 2000

Стандартын нэр	Стандартын код
Сонсголын эрхтэн хамгаалах нэг бүрийн хэрэгсэл (чихэвч)	MNS 3306: 1991
Толгой хамгаалах хэрэгсэл. Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө, чихэвч)	MNS 5388: 2004
Толгой хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгсэл, нүдний шил	MNS 5389: 2004
Толгой хамгаалах хэрэгсэл, Дуулга	MNS 5621: 2006
Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч	MNS 5624: 2006
Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага	MNS (ISO) 13688: 2000
Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 4930: 2000
Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг	MNS 5620: 2006
Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага	MNS 5622: 2011
Хөлийн хамгаалалт Ажлын тусгай гутал	MNS 5623: 2006
Хамгаалах хашлага	MNS 0012-4-007: 1981
Аюулгүй техник. Өргөх краны хамгаалах хэрэгслүүд	MNS 1800: 1973
Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал	MNS 4284: 2006
Гал хамгаалал. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566: 2005
Хөдөлмөр хамгааллын стандартын систем, барилга угсралтын ажлын үеийн цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 12.3.009: 1990
Цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын хувцас	MNS 4660: 1998
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо – Шаардлага, хэрэглэх заавар	MNS ISO 45001: 2018

Соёлын өв

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуульд⁷⁸ түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг соёлын өв гэж тодорхойлсон. Энэ нь зан заншил, аман зохиол, уламжлалт арга, дүрслэл, илэрхийлэл, уламжлалт танин мэдэхүй зэрэг биет болон биет бус өвийг хамаардаг (7-р зүйл). Биет өвийг ач холбогдлоор нь ангилж, улмаар тэдгээрийн ач холбогдлоор нь бүртгэдэг. Биет бус өвийг үндэсний төлөөллийн жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт (8 дугаар зүйл, 4-р бүлэг)-ын дагуу бүртгэнэ. Шинээр байгуулагдсан Соёлын яам нь соёлын бүх өвийг хамгаалах хэрэгжилтэд хяналт тавьдаг (14-р зүйл). Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өвийг хамгаалах төлөвлөгөөг бүрэн эрхийнхээ хүрээнд хянаж, сайжруулна (15 дугаар зүйл). Тус хуулиар төрийн болон шашны байгууллагын өвийг хууль ёсны дагуу эзэмших эрхийг тогтоосон (31 дүгээр зүйл) бөгөөд мөн худалдах, худалдан авахыг тогтоосон (35 дугаар зүйл) байдаг. Хуульд заасны дагуу өвийг хамгаалах, илрүүлэх мөн үйл ажиллагаа нь өвийг хамгаалж буй иргэдийг төрөөс алдаршуулан урамшуулах боломжтой байдаг (40 дүгээр зүйл). Хуулиар тусгай хамгаалалттай газарт мал бэлчээрлэх зэрэг тухайн газрын физик шинж чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй олон үйл ажиллагаа явуулахыг хориглоно (Бүлэг 8). Тус хууль аливаа зөрчлийн торгуулийг 13-р бүлэгтээ нарийвчлан тодорхойлсон.

Хуулийн хэрэгжилт

Монгол улсын Цагдаагийн албаны тухай хууль.⁷⁹

- Баривчлагдсан хүнтэй хүнлэг бус, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглоно.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг Хүний эрхийн үндэсний комисст олгосон.

Цагдаа нар буудлагын техник, тусгай хэрэгсэл, холбогдох хэрэгцээг хангахын тулд галт зэвсгийн талаар бодлоготой байх шаардлагатай.

Монгол улсын Эрүүгийн хуульд (2002 онд энэ хуулийг хүчингүй болсонд тооцож, 2015 онд баталсан шинэчилсэн найруулгад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан) хуулийн өмнө иргэн бүр эрх тэгш байх тухай заасан байдаг (1.3-р зүйл). Мөн 16-аас дээш насны аливаа этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхээр насны хязгаарыг тодорхойлсон (6.2-р зүйл). Хуульд цаашлаад гэмт хэрэг үйлдсэнтэй пропорциональ ялыг i) торгох (5.3-р зүйл), ii) iv) албадан ажил хийлгэх (5.4-р зүйл), v) эсвэл vi) хорих (5.6-р зүйл) гэж тодорхойлсон. 8-р бүлэгт хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хариуцлага, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл (16 хүртэлх нас) гэсэн тодорхойлолтыг багтаасан болно.

Монгол улсын Эрүүгийн хэрэгбайцаан шийтгэх тухай хуульд (2002 оны энэ хуулийг 2017 онд хүчингүй болсонд тооцож, хэд хэдэн удаа, хамгийн сүүлд 2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) бүх иргэн хуулийн өмнө эрх тэгш байх (1.12-р зүйл), сэжигтний гэм буруугүй байх таамаглалыг (1.15 дугаар зүйл) тусгасан бөгөөд мөрдөн байцаалтын үйл ажиллагааг

⁷⁸ 2014. Amended four times, most recently in 2021.

⁷⁹ Original law is from 2013. However, the original law was repealed and a revised version approved in 2017. Amendments incorporated in 2019.

бодитойгоор явуулах шаардлагатай (1.7-р зүйл) гэж тус тус заажээ. Уг хуульд яллагдагчийн эрхийг, тухайлбал хэргийн талаарх мэдээлэл, өмгөөлөх, давж заалдах гомдол зэргийг тусгасан байдаг (7.1-д). Тус хуулийн 31.4-т баривчлах журмыг, мөн 4.10-т гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг хоёр сар хүртэл хугацаагаар баривчлах журмыг (сэжигтнийг 14 хоног саатуулж болно) заасан. Харин шүүгч 72 цагийн дотор цагдан хорих эсэхийг хянан үзэх ёстой (30.9-р зүйл). 30-р бүлэгт байгаль орчны эсрэг гэмт хэрэг, тэр дундаа ан агнуурын гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийг тодорхойлсон.

Жендэр

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль (2011) нь улс төр (8-р зүйл), хууль эрх зүй, эдийн засаг/хөдөлмөр эрхлэлт (9-11-р зүйл), нийгмийн (эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 13-р зүйл), соёл, гэр бүлийн харилцаа (14-р зүйл) дахь хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн. Энэ хууль нь эрх тэгш байдлыг хангахын төлөө төрөөс хариуцлага хүлээхийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд үндэслэсэн (3-р бүлэг). Энэ нь хөгжлийн бодлого нь жендерийг голчлон баримталж, жендерийн нэгдсэн мэдээллийг цуглуулах ёстой гэсэн үг юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой гомдлыг хувь хүн эсвэл төлөөлөгчөөр дамжуулан Хүний эрхийн үндэсний комисст гаргаж болно (23 дугаар зүйл). Тус хуулийн 5-р бүлэгт хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон.

Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004 онд батлагдсан өмнөх хууль 2004 онд хүчингүй болсон, шинэчилсэн найруулга 2016 онд батлагдсан, 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан, хамгийн сүүлд 2019 онд батлагдсан) нь хохирогчийн хүний эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох (1 дүгээр зүйл) тухай тодорхойлсон. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбод, сэтгэл зүй, бэлгийн болон эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрүүдээр илэрдэг (6 дугаар зүйл). Хуульд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүргийг төр, цагдаа, нийгмийн ажилтнууд (2-р бүлэг) нарт заасан бол төрийн бус байгууллага (ТББ) нь хамгаалах байраар хангах, сургалт явуулах, хохирогчийн төлөөлөгчөөр ажиллах боломжтой (22-р зүйл) тухай заасан. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж сэжиглэгдэж байгаа тухай мэдүүлэг өгөх иргэний үүргийг төрийн бүх албан тушаалтны хуулиар тогтоосон байдаг (13-р зүйл). Хохирогчийн гомдлын дагуу шүүх гэмт этгээдийг таслан сэргийлэх арга хэмжээ авч болно (17 дугаар зүйл).

2. Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамжийн дагуу мөрдөгдөж буй олон улсын стандартууд

Германы сэргээн босголт, зээлийн банкны тогтвортой байдлын удирдамж нь эрсдэлийг урьдчилан таамаглах, зайлсхийх, багасгах, бууруулах, бууруулахад шаардагдах арга хэмжээг дөрвөн түвшний ангиллын дагуу тодорхойлдог: А ангилалд өндөр эрсдэл, В+ ангилалд ихээхэн эрсдэлтэй, В ангилалд дунд зэргийн эрсдэл, С ангилалд бага эрсдэлтэй үйл ажиллагаа тус тус багтана. Эрсдэлийн ангилал нь байгаль орчны болон нийгмийн эрсдэлийг хоёуланд нь харгалзан үздэг. Дараах дэд хэсгүүдэд Германы сэргээн босголт, зээлийн банкны санхүүжилттэй төслүүдэд хамаарах олон улсын стандартуудыг тоймлон харуулав.

Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандарт

Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартууд нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэхтэй холбоотой шаардлагыг бүрдүүлдэг.

Байгаль орчин, нийгмийн стандарт 1 буюу Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент нь байгаль орчин, нийгмийн эрсдэл, үйл ажиллагааны нөлөөллийг бусад байгаль орчин, нийгмийн стандартуудтай нийцүүлэн тодорхойлох, үнэлэх, удирдах ерөнхий удирдамжийг тусгасан байдаг. Байгаль орчин, нийгмийн стандарт 1 нь байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны зарчмуудыг мөн тодорхойлсон. Байгаль орчин, нийгмийн арван стандартууд болон тэдгээрийг төсөлд хэрхэн хэрэглэхийг Хүснэгт А4-д тусгасан болно.

Байгаль орчин, нийгмийн стандарт	Гол хүчин зүйл эсэх?	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэх байдаг
<p>1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент</p>	<p>Тийм</p>	<p>Байгаль орчинд үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл нь бага зэрэг, тухайн газар нутгийн онцлогтой, буцаах боломжтой, удирдахад хялбар байх төлөвтэй байна. Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь сонгогдсон ТХГН-ууд болон орчны бүсийн зөвлөлд шаардлагатай барилга байгууламж, аялал жуулчлалын зориулалтаар бага хэмжээний барилгын ажил, зам барихад ихээхэн нөлөөлнө. Эдгээр байгууламжийг барьж байгуулснаар байгаль орчин, нийгэмд бага, дунд зэргийн сөрөг нөлөөлөл бий болно. Болзошгүй сөрөг нөлөөлөл нь хөрс бүрхэвчийн элэгдэл, эвдрэл, ургамлын талхагдал, тоосжилт, дуу чимээ, чичиргээг үүсгэж, мөн чухал газруудад газар шорооны ажил хийх замаар хязгаарлаж болзошгүй.</p> <p>Төсөл нь байгалийн нөөцөд нэвтрэх боломжийг хязгаарлах, байгалийн нөөцийг ашиглахад гаргах өөрчлөлттэй холбоотой болзошгүй зөрчилдөөний үр дүнд бий болох нийгмийн нөлөөллийг бий болгоно.</p> <p>Төслийн бүх үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн анхан шатны дүн шинжилгээ болон холбогдох үнэлгээнд хамрагдах ёстой бөгөөд ингэснээр шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахад хувь нэмэр оруулна. Үнэлгээ нь төслийн үйл ажиллагааны үе шаттай уялдсан байх ёстой бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгийн механизмаар дамжуулан мэдээллийг нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд болон ТББ-уудад хүргэнэ. Байгаль орчин, нийгмийн стандарт 1 нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг төслийн үйл ажиллагааг боловсруулах явцад аль болох эрт эхлүүлж, эдийн</p>

Байгаль орчин, нийгмийн стандарт	Гол хүчин зүйл эсэх?	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэх байдаг
		засаг, санхүү, институци, нийгэм, техникийн шинжилгээтэй нягт уялдуулахыг шаарддаг.
2: Хөдөлмөр ба хөдөлмөрийн нөхцөл	Тийм	Төсөл нь төслийн гүйцэтгэгчдээр дамжуулан хийх шаардлагатай, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХАБЭА) эрсдэл учруулж болзошгүй бага хэмжээний барилгын ажлыг санхүүжүүлэх болно. Ажилчдыг стандарт нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон хувийн хамгаалах хэрэгсэлээр хангах шаардлагатай, өөрөөр хэлбэл Ковид-19-ийн цар тархалтаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хувийн хамаалах хэрэгсэлээр хангасан байх ёстой. Мөн төслийн гүйцэтгэгч нар хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шударга ажиллах, ажиллах нөхцөлийг дэмжихийг шаардана.
3: Нөөцийн үр ашиг ба бохирдлоос урьдчилан сэргийлэх болон менежмент	Тийм	Төслийн гол зорилго нь байгалийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах явдал юм. Баг хэмжээний барилгын ажлуудыг санхүүжүүлэх тул үйл ажиллагааны төлөвлөгөөнд нөөцийн үр ашиг, хог хаягдлыг багасгахыг тусгасан байх ёстой.
4: Олон нийтийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Тийм	Төслийн үйл ажиллагаа нь иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөллийг үзүүлэхгүй байхаар тооцоологдсон. Гэсэн хэдий ч, барилгын ажлыг төслийн стандарт арга хэмжээнээс санхүүжүүлж байгаа тохиолдолд төслийн гүйцэтгэгч компанийн ажилчдын ёс зүйн дүрмийг тусгасан байх шаардлагатай.
5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хязгаарлах, албадан нүүлгэн шилжүүлэлт	Тийм	Төслийн хүрээнд албадан нүүлгэн шилжүүлэх, хязгаарлалт хийхийг зөвшөөрөхгүй. Гэсэн хэдий ч бэлчээрийн менежмент болон байгалийн нөөцийг сайжруулахын тулд төслийн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, ялангуяа бэлчээрийн менежменттэй холбоотой зарим нэмэлт хязгаарлалт шаардлагатай байхыг үгүйсгэхгүй юм. Төсөл нь нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж, байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогод тусгасан олон нийтийн оролцооны журмын дагуу олон нийттэй зөвлөлдөх, хэлэлцүүлгийг хийх ёстой. Нөхөрлөл, айл өрх, хувь хүмүүс зэрэг нь нөлөөлөлд өртсөн тохиолдолд, нийгмийн үнэлгээг хийх ёстой бөгөөд үйл ажиллагааны төлөвлөлтийн салшгүй хэсэг болгон алдагдлыг бүрэн

Байгаль орчин, нийгмийн стандарт	Гол хүчин зүйл эсэх?	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэх байдаг
		нөхөхийн тулд төслийн бусад үр өгөөжөөр дамжуулан нөлөөллийг арилгах ёстой..
6: Биологийн олон янз байдлыг хамгаалах болон амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент	Тийм	Төслийн зарим үйл ажиллагааг биологийн олон янз байдал, байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор байгуулагдсан ТХГН-ийн нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлнэ. Чухал ач холбогдол бүхий газруудыг зохих ёсоор тодорхойлж, сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд холбогдох стандарт, журмыг байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогод тусгасан болно.
7: Уугуул иргэд/Сахараас өмнөд Африкийн түүхэн дутуу үйлчилгээтэй уламжлалт нутгийн бүлгүүд	Үгүй	Монголын нүүдэлчин хоёр бүлэг болох Цаантан, Эвэнки нар байгаль орчин, нийгмийн стандарт 7-ын дагуу уугуул иргэд гэдгээрээ алдартай. Тус бүлгүүд нь Монгол улсын зүүн болон хойд хэсэгт оршин суудаг бөгөөд орчны бүс нутаг амьдардаггүй бас харьяалагддаггүй. Иймд, байгаль орчин, нийгмийн стандарт 7-ын шаардлагад хамаарахгүй болно. Гэсэн хэдий ч төсөл нь нийгмийн эмзэг бүлгийг эрт илрүүлж, үр өгөөжийг тэгш хүртээх арга хэмжээг баталгаажуулахын тулд нийгмийн үнэлгээ хийх болно.
9: Санхүүгийн зуучлагчид	Үгүй	Санхүүгийн зуучлагчдыг ашиг хүртэгч ард иргэдэд хөрөнгө шилжүүлэх хэрэгсэл болгон ашиглахгүй тул энэхүү стандарт нь Төслийн үйл ажиллагаанд ямар ч хамааралгүй юм.
8: Соёлын өв	Тийм	Төслийн үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд өртөх боломжтой биет болон биет бус өв байхгүй байгаа хэдий ч барийлгын ажлын худалдан авалтад санамсаргүй олдох журмыг багтаах шаардлагатай болно. Эрт илрүүлэлт нь мэдэгдэж буй соёлын өвийг тодорхойлох ёстой бөгөөд үүнээс зайлсхийх хэрэгтэй.
10: Олон Нийтийн оролцоо	Тийм	Төсөлийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчин, нийгмийн стандарт 10-ын шаардлагын дагуу олон нийтийн оролцоо, гомдол барагдуулах механизмыг багтаана.

Хамгийн сүүлчийн хүснэгтэд байгаль орчин, нийгмийн стандартуудын зорилго, зохион байгуулалт болон зарчим болгон ашигласан бөгөөд байгаль орчин, нийгмийн үнэлгээний хоорондын зөрүүг үнэлсэн болно.

Дэлхийн Банкны байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамж

Дэлхийн Банкны байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамж нь олон улсын аж үйлдвэрийн сайн туршлагын ерөнхий болон салбарын тусгайлсан жишээ бүхий техникийн лавлагааны баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ мөн үйл ажиллагаанаас ялгарах утааны ялгарлын түвшинг тодорхойлдог.

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамж нь шинэ байгууламжуудыг одоо байгаа арга технологи мөн бага зардлаар хүрэх боломжтой гүйцэтгэлийн түвшин, арга хэмжээг багтаасан байдаг. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамжийг одоо ашиглагдаж буй үйл ажиллагаанд хэрэглэхдээ тухайн үйл ажиллагаанд тусгайлсан зорилтууд болон түүнд хүрэх зохих цагийн хуваарийг тусгаж болно.

Байгаль орчин, нийгмийн стандарт 1-ийн дагуу шаардлагатай байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх явцдаа тухайн төсөл хэрэгжих талбайн хэмжээнд тусгайлан шаардах хувилбарын (дээд эсвэл доод) арга хэмжээг санал болгох шаардлагатай байж болно.

Хэрэв тодорхой нөхцөл байдлыг харгалзан байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамжид заасан хэмжээнээс өөр түвшний арга хэмжээ авах шаардлагатай бол тухайн төсөл хэрэгжих талбайн хэмжээнд тусгайлсан үнэлгээний нэг хэсэг болгон санал болгож буй хувилбаруудын бүрэн бөгөөд нарийвчилсан үндэслэл шаардлагатай. Энэхүү үндэслэл нь үйл ажиллагааны гүйцэтгэлийн аль түвшинд иргэдийн эрүүл мэнд ба байгаль орныг хамгаална гэдгийг харуулах ёстой.

Төсөл хэрэгжүүлэгч улсын дүрэм журам нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдамжид тусгагдсан түвшин, арга хэмжээнээсээ ялгаатай байвал үйл ажиллагаанд илүү хүчтэй журмыг баримтална.

Төсөл нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий удирдамжийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд,

1. Үйл ажиллагааны талбайг сонгож төлөвлөхдөө болзошгүй эрсдэл, нөлөөллийг эрт илрүүлэх
2. Үйл ажиллагааны эрсдэлийн менежментийн стратеги нь мэдэгдэж буй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах, үлдсэн нөлөөллийг бууруулах замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах эрсдэлийг арилгах
3. Аюул ослын үед ард иргэд, ажилчдыг бэлэн байлгах.

Төслийн хэрэгжилт нь байнгын хяналттай, үр дүнтэй байх болон хариуцлагатай байхыг шаарддаг. Төсөл холбоотой удирдамжид дараах зүйлс багтаж болно.

- **Байгаль орчин.**
 - Хийн ялгаралт ба гадаад орчны агаарын чанар (1.1)
 - Аюултай материалын менежмент (1.5)
 - Хог хаягдлын менежмент (1.6)
 - Дуу чимээ (1.6)
 - Бохирдсон газар (1.8)

- **Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй.**
 - Байгууламжийн ерөнхий зураг төсөл ба ашиглалт (2.1)
 - Харилцаа холбоо ба сургалт (2.2)
 - Физик бохирдол (2.3)
 - Хувийн хамгаалах хэрэгсэл (2.7)
 - Байгаль орчны онц аюултай үзэгдэл (2.8)
- **Олон нийтийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй.**
 - Ундны усны чанар ба хүртээмж (3.1)
 - Төслийн дэд бүтцийн аюулгүй байдал (3.2)
 - Амь нас ба галын аюулгүй байдал (3.3)
 - Тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал (3.4)
 - Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ (3.7)
- **Барилга угсралтын ажил болон татан буулгах**
 - Байгаль орчин (4.1)
- **Үйлдвэрлэлийн тусгай заавар:**
 - Ус ба ариун эрүүл ахуй

**ХБНГУ-ын хоёр талын техник, санхүүгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн саналд
жендэрийг оролцуулан хүний эрхийн стандарт, зарчмуудыг тусгах тухай удирдамж**

Герман Улын дэмжлэгтэй төслүүдэд хүний эрхийн хандлагыг голчилж авч үздэг бөгөөд стандарт, зарчмуудыг тусгасан удирдамжтай байхыг шаарддаг. Удирдамжид хэд хэдэн эрсдэлтэй хэсгүүдийг тодорхойлсон бөгөөд үүнд:

- Тодорхой бүлгүүдийн хохирол
- Оролцооны эрхэд нь хөндлөнгөөс халдах
- Албадан хураан авах болон албадан нүүлгэн шилжүүлэлт
- Хөдөлмөрийн эрхэнд нь халдах

Удирдамжид хүний эрхийн эрсдэлтэй хэсгүүдийг харуулсан бөгөөд үйл ажиллагаанд хүний эрхийн чиг баримжааг сайжруулах арга замыг санал болгож байна (Хүснэгт А5). Эрсдэл, түүнээс зайлсхийхийн тулд санал болгож буй арга барилыг доорх хүснэгтэд жагсаасан бөгөөд БОНМБ-ыг боловсруулахад нэгтгэсэн болно.

Хүснэгт А5: Хөгжлийн хамтын ажиллагааны арга хэмжээний хүний эрхийн болзошгүй эрсдэлүүд

Эрсдэл	Эрсдэлээс хэрхэн зайлсхийх вэ
Байгалийн нөөцийн хэрэглээг хязгаарлах нь зарим бүлгүүдэд хохирол учруулна.	Хүртээмжтэй, төлөөллийн оролцоог дэмжих; Байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд нь өрхүүдэд санхүүгийн дарамт учруулах үед ядуу болон эмзэг бүлгийн өрхүүдэд дэмжлэг олгох ;

Эрсдэл	Эрсдэлээс хэрхэн зайлсхийх вэ
	Ядууралд амьдарч буй хүмүүсийг улам дордуулахгүйн тулд байгалийн баялгийн ашиглалтыг хязгаарлах үед зохих нөхөн олговор олгох ба орлого олох өөр эх үүсвэрийг дэмжих.
Байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах арга хэмжээний хүрээнд эмзэг бүлгийн болон цөөнхийн бүлгийн оролцооны эрхийг зөрчих	Уугуул иргэдийн эрхийг хөндсөн үед хөгжлийн хамтын ажиллагааны арга хэмжээнд үнэ төлбөргүй, урьдчилан, мэдээлэлтэй зөвшилцлийн зарчмыг хэрэгжүүлэхийг дэмжих.
Байгалийн нөөцийн тогтвортой менежментээс үүссэн ашгаас орон нутгийн иргэд хүртэж чдахгүй байх	Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн үр шимийг шударгаар хуваах загваруудыг боловсруулах

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын үндсэн стандартууд

ОУХБ нь нийгэм шударга ёсонд тулгуурласан тохиолдолд л бүх нийтээр, мөнхийн энх тайван тогтоно гэсэн үндсэн хуулийн зарчимд суурилдаг. ОУХБ ажлын өдөрт найман цаг, жирэмсний хамгаалал, хүүхдийн хөдөлмөрийн тухай хууль, ажлын байрны аюулгүй байдал, амар тайван үйлдвэрлэлийн харилцааг дэмжсэн олон төрлийн бодлого зэрэг аж үйлдвэрийн нийгмийн онцлог шинжүүдийг бий болгосон.

Монгол Улс хүүхдийн албадан хөдөлмөрийн, болон ялгаварлан гадуурхах конвенцод нэгдэн орсон. Монгол Улс соёрхон баталсан хөдөлмөрийн үндсэн стандартын үзэл санааг ажиглах, мөн хөдөлмөрийн үндсэн стандартын үзэл санааг тусгасан хөдөлмөрийн үндэсний хууль тогтоомж холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Хөдөлмөрийн үндсэн стандартууд нь гарын үсэг зурсан орнуудын холбогдох хууль тогтоомжийг орлохгүй.

ОУХБ-ын үндсэн конвенцуудаас төсөлд хамаарах нь:

- **1930 оны Албадан хөдөлмөрийн конвенцод (№29)** гарын үсэг зурсан орнууд аливаа хэлбэрийн албадан хөдөлмөрийг таслан зогсоох үүрэг хүлээсэн. Энэхүү конвенц нь олон нийтийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэсэн нийтийн үйлчилгээний бага зэргийн үйлчилгээг "иргэний энгийн үүрэг" болон онцгой байдлын үед шаардлагатай үйлчилгээ нь гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Монгол Улс уг конвенцод 2005 онд нэгдэн орсон.
- **1951 оны "Тэгш цалин хөлсний тухай конвенц" (№ 100)** нь эрэгтэй, эмэгтэй ажилчдад ижил үнэ цэнтэй хөдөлмөрийн хөлсийг ижил хэмжээгээр олгох зарчмыг гарын үсэг зурсан орнуудад үүрэг болгосон. Монгол Улс 1969 онд уг конвенцод нэгдэн орсон.
- **1958 оны Ялгаварлан гадуурхах тухай (Ажил эрхлэлт, ажил мэргэжил) конвенц (№ 111)** нь аливаа ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд ажил эрхлэлт, ажил мэргэжлийн талаар үндэсний бодлогоор дамжуулан *тэгш боломж, харилцааг дэмжихийг* гарын үсэг зурсан орнуудад үүрэг болгосон. Ялгаварлан гадуурхах нь

арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэсний гарал үүсэл, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхах, гадуурхах, илүүд үзэхийг хэлнэ. Монгол Улс 1969 онд уг конвенцод нэгдэн орсон.

- **1973 оны Насны доод конвенцод (№ 138)** гарын үсэг зурсан орнуудад хүүхдийн хөдөлмөрийг халах, насны доод хэмжээг залуучуудын бие бялдар, оюун санааны бүрэн хөгжилд нийцсэн түвшинд хууль ёсны дагуу тогтоох үүрэг хүлээсэн боловч ямар ч байсан 15-аас доошгүй настай, 18-аас доошгүй насны залуучуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд аюул учруулж болзошгүй ажилд. Монгол Улс уг конвенцод 2002 онд нэгдэн орсон.
- **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны 182 дугаар** конвенцод гарын үсэг зурсан орнуудад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг яаралтай хориглох, устгах үүрэг хүлээсэн. Монгол Улс уг конвенцод 2001 онд нэгдэн орсон.

ОУХБ-ын үндсэн зарчмуудаас төсөлд хамаарах нь:

- Ажлын байрны стандарт, үндсэн зарчим, эрхийг сурталчлах, хэрэгжүүлэх ^[1]_{SEP}
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд зохистой ажлын байраар хангагдах боломжийг бүрдүүлэх ^[1]_{SEP}
- Бүх нийтийн нийгмийн хамгааллын хамрах хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх
- Гурван талт нийгмийн яриа хэлэлцээг бэхжүүлэх

Газар, загасны аж ахуй, ойн эзэмшлийн хариуцлагатай удирдлагын сайн дурын удирдамж

Газар, загасны аж ахуй, ойн эдэлбэр газрын хариуцлагатай засаглалын тухай сайн дурын удирдамж нь өлсгөлөн, ядуурлыг арилгах, тогтвортой хөгжлийг дэмжих, байгаль орчныг сайжруулах арга хэрэгсэл болох бөгөөд газар, загас агнуур, ойд аюулгүй эзэмших эрх, тэгш хүртээмжийг хөхүүлэн дэмждэг. Удирдамж нь төрийн, хувийн хэвшлийн, нийтийн эзэмшлийн, уугуул иргэдийн, заншил, албан бус өмчийн бүх хэлбэрийн хувьд нөөцийн ашиглалтын хариуцлагатай засаглалыг дэмжинэ. Гол зорилго нь хүн бүрийн хүнсний аюулгүй байдлыг хангах, үндэсний хүнсний аюулгүй байдлын хүрээнд хүрэлцэхүйц хоол хүнсээр хангах эрхийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм. Уг удирдамж нь өлсгөлөн, ядуурлыг арилгах хүчин чармайлтыг дэмжихийн зэрэгцээ тогтвортой амьжиргаа, нийгмийн тогтвортой байдал, орон сууцны аюулгүй байдал, хөдөөгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулах зорилготой юм.

Хууль сахиулах байгууллагын ёс зүйн дүрэм ба хүч хэрэглэх

Хууль сахиулахтай холбоотой асуудлуудын хувьд байгаль орчин, нийгмийн стандарт 4-өөс гадна НҮБ-ын Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны ёс зүйн дүрэм⁸⁰, хууль сахиулах байгууллагын албан тушаалтны хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд⁸¹ байна.

НҮБ-ын Ёс зүйн дүрэмд хууль сахиулах байгууллагууд хүний нэр төрийг хүндэтгэж, хамгаалах, хүний эрхийг дээдлэхийг уриалсан байдаг. Албаны хүмүүс хүч хэрэглэхдээ тэвчээртэй байж, зөвхөн зайлшгүй шаардлагатай үед л оролцох ёстой. Эрүүдэн шүүх, харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг гутаасан аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч болохгүй.

Хүч хэрэглэх болон галт зэвсэгтэй холбоотой үндсэн зарчмууд нь хууль сахиулах ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь хүний эрхийг зохих ёсоор хүндэтгэн, зайлшгүй шаардлагатай үед зөвхөн хүч хэрэглэх, галт зэвсэг хэрэглэх шаардлагатайг заасан. Хүч хэрэглэх болон галт зэвсэг⁸² хэрэглэх тухай дүрэм, журам баталж, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг үхлийн хүчний хэрэглээг багасгахын тулд зохих зэвсгээр ханган, бусад арга хэрэгсэл үр дүнгүй тохиолдолд л хүч, галт зэвсэг хэрэглэх журамтай байхыг засгийн газруудад уриалж байна. Түүнчлэн хохирсон аливаа хүнд тусламж үзүүлэх, ойр дотны хүмүүст нь мэдэгдэх, тухайн үйл явдлыг цаг алдалгүй мэдээлэхийг албаны хүмүүсээс шаардаж байна.

3. Орхигдлын дүн шинжилгээ ба төслийн санал болгосон арга

Төслийн хүрээнд баримтлах зарчмыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулах үүднээс Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартад тулгуулсан тоймыг дараах хүснэгтэд үзүүлэв.

⁸⁰ United Nations Human Rights Office of the High Commissioner, Code of Conduct for Law Enforcement Officials, Adopted by the General Assembly 34/169 of 17 December 1979.

⁸¹ United Nations Human Rights Office of the High Commissioner, Basic Principles on the Use of Force and Firearms by Law Enforcement Officials, Adopted by the Eight United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, Cuba, 27 August to 7 September 1990.

⁸² Intentional lethal use of firearms should only be when strictly unavoidable in order to protect life. Section 11 specifies that: Rules and regulations on the use of firearms by law enforcement officials should include guidelines that:

- (a) Specify the circumstances under which law enforcement officials are authorized to carry firearms and prescribe the types of firearms and ammunition permitted;
- (b) Ensure that firearms are used only in appropriate circumstances and in a manner likely to decrease the risk of unnecessary harm;
- (c) Prohibit the use of those firearms and ammunition that cause unwarranted injury or present an unwarranted risk;
- (d) Regulate the control, storage and issuing of firearms, including procedures for ensuring that law enforcement officials are accountable for the firearms and ammunition issued to them;
- (e) Provide for warnings to be given, if appropriate, when firearms are to be discharged;
- (f) Provide for a system of reporting whenever law enforcement officials use firearms in the performance of their duty.

Монгол улсын байгаль орчин, нийгмийн эрхзүйн орчин болон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандартын орхигдлын дүн шинжилгээ.

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
Байгаль орчин нийгмийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент			
<p>Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, менежмент</p> <p>Нөлөөллийг бууруулах үе шат:</p> <ul style="list-style-type: none"> •Эрсдэл, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийх •Хэрэв зайлсхийх боломжгүй бол эрсдэл, нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах буюу багасгах •Эрсдэл, нөлөөллийг аль болох бууруулж эсвэл бууруулсны дараа багасгах ба •Их хэмжээний үлдэгдэл нөлөөлөл үлдсэн тохиолдолд техникийн болон санхүүгийн хувьд боломжтой бол тэдгээрийг нөхөх буюу нөхөн сэргээх. 	<p>БОНБУ тухай хуульд үнэлгээний хамрах хүрээг хүний эрүүл мэнд, байгаль орчин (тодорхой бус өгүүлбэр) гэж тодорхойлсон байдаг.</p> <p>Хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдах үйл ажиллагааны төрлийг нарийн тодорхойлсон. Эрсдэл, нөлөөлөл багатай үйл ажиллагаа нь хянан шалгах шаардлагагүй.</p> <p>Үнэлгээний үйл ажиллагааны явцад тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, арилгах арга хэмжээ авах тухай хуульд мөн тэмдэглэсэн. Төсөл нь арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, төсөвлөсөн төсвийг тодорхойлох ёстой.</p> <p>БОНБУ-ний тухай А-117 (Сайдын тушаал) аргачлалд байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг нэгтгэх талаар тусгасан.</p>	<p>Нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ нь тэнцүү байна. Гэсэн хэдий ч Монгол Улс зөвхөн В+ болон А-тай дүйцэхүйц үйл ажиллагааг хянахыг шаарддаг бол байгаль орчин нийгмийн стандарт 1-д бүх үйл ажиллагааг үнэлэх шаардлагатай байна.</p>	<p>Төсөл нь үйл ажиллагааны төрлөөс үл хамааран байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг үнэлэх нэгдсэн арга барилыг хэрэгжүүлдэг. БОНМБ нь бүх үйл ажиллагаанд хамаарах стандартчилагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээг агуулж байгаа бол тухайн газар нутгийн онцлогт тохирсон нөлөөллийг В, В+, А ангиллын шалгалтаар тодорхойлно (А ангиллын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй).</p> <p>В+ болон А эрсдэлийн зэрэглэл бүхий үйл ажиллагааг үндэсний хуулийн дагуу хяналт тавьж түүнийгээ тайлагнах шаардлагатай.</p> <p>С эсвэл В үнэлгээтэй үйл ажиллагаа нь Төслийн журмын дагуу явагдана.</p>
Сөрөг нөлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг	Хууль эрх зүйн орчин нь тэгш хамгаалалтыг тусгасан боловч	Монгол Улсын хууль эрх зүйн орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үе	Оролцогч талуудтай хамтран ажиллах, нийгэмд үзүүлэх

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>бүлгийнхэнд жигд бус байдлаар нөлөөлөхгүйн тулд өөр арга хэмжээг авах</p>	<p>ялгавартай арга хэмжээг тодорхой шаарддаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн тухай хуульд орон сууцны дизайн, ажлын байр зэрэгт тавигдах шаардлагыг заасан байдаг.</p>	<p>шаттайгаар хамруулах боломжийг олгодог хэдий ч жигд бус байдлыг шийдвэрлэх хууль эрх зүйн шаардлага байхгүй. impact. ESS1 objective will therefore take precedence.</p>	<p>нөлөөллийн үнэлгээний хүрээнд төсөл нь эмзэг бүлгүүдийг тодорхойлж, тэгш байдлыг хангахын тулд тусгай арга хэмжээ авна. Мөн байгаль орчин нийгмийн стандарт 7-г үзнэ үү.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн үндэсний байгууллага, тогтолцоо, хууль тогтоомж, дүрэм журам, журмыг зохих тохиолдолд ашиглах.</p>	<p>БОНБУ-ийн тухай хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдах үйл ажиллагааны төрлийг нарийн тодорхойлсон бөгөөд зөвхөн В+ эсвэл А ангиллын үйл ажиллагаанд тайлагнахыг шаарддаг.</p>	<p>Үйл ажиллагаа нь В+ эсвэл А гэж үнэлэгдсэн тохиолдолд ялгаа байхгүй. Гэсэн хэдий ч эрсдэл багатай үйл ажиллагаа явуулах шаардлага байхгүй тул зөрүүтэй байна.</p>	<p>Германы сэргээн босголт, зээлийн банк болон Монголын эрх баригчид В+ болон А ангиллын үйл ажиллагааг хянана. Эрсдэл багатай үйл ажиллагаа явуулахын тулд холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгож, холбогдох байгууллагуудтай хуваалцана.</p>
<p>Зээлдэгчийн чадавхыг хүлээн зөвшөөрч, сайжруулах арга замаар байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах.</p>	<p>Холбогдох үндэсний хууль тогтоомжид чадавхыг нэмэгдүүлэх, сайжруулах ямар нэг шаардлага байхгүй.</p>	<p>байгаль орчин нийгмийн стандарт 1-н зорилтууд нь хэрэгжилтийг удирдан чиглүүлдэг тул түүнтэй адилтгах зүйл байхгүй.</p>	<p>Төсөл нь үйл ажиллагааны загварт тусгагдсан үндсэн зарчим болгон байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн үр ашиг, тогтвортой байдлыг дэмжих болно.</p> <p>Төсөл нь эрх баригчид болон ажлын хэсгүүдтэй хамтран ажилласнаар орон нутгийн чадавх, байгаль орчин, нийгмийн менежментийн олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэгийг дээшлүүлэхийг зорьж байна.</p>

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
Байгаль орчин нийгмийн стандарт 2: Хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл байдал			
Ажлын байранд аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих.	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль нь бүх ажил олгогчдод үйлчилдэг бөгөөд дуу чимээ, ус, эрүүл ахуйтай холбоотой арга хэмжээг тодорхой журамд тусгасан байдаг.	Монгол Улсын тогтолцоонд агаарын чанар, барилга байгууламжийн талаар зааварчилгаа байдаггүй.	<p>Үндэсний нөхцөлд зохицуулалт байхгүй тохиолдолд Төсөл нь Дэлхийн Банкны Группийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжийг дараах зүйлтэй холбоотой нарийвчилсан зааварчилгааг ашиглана.</p> <p>Байгууламжийн ерөнхий зураг төсөл, ашиглалт (2.1)</p> <p>Харилцаа холбоо ба сургалт (2.2)</p> <p>Физик аюул (2.3)</p> <p>Химийн аюул (2.4)</p> <p>Хувийн хамгаалах хэрэгсэл (2.7)</p> <p>Хяналт шинжилгээ (2.9)</p>
Ажилчдад шударга хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг олгох.	Хөдөлмөрийн тухай хуульд ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг.	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны тушаалаар (1999 оны А/204 тоот) эмэгтэйчүүдийг хэд хэдэн ажилд орохыг хориглодог. Лесбиан, гей, бисексуал, трансжендер гэж тодорхойлсон хүмүүст ямар ч хамгаалалт байхгүй.	Төсөл нь ESS2 болон Үндэсний хууль тогтоомжийн дагуу олон төрлийн ажиллах хүчийг сонгон шалгаруулж, тэднийг ижил тэгш хамгаалалттай байлгах болно. Төсөл нь ажилд авах, нөхөн олговор (цалин, тэтгэмжийг

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Ажилчдыг хамгаалж, эмзэг бүлгийн ажилчдыг онцлон авч үзэх.</p>	<p>Ажил олгогчид Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн дотоод журам гаргах, мөн сэдвээр ажлын байранд сургалт явуулах үүрэгтэй ажил олгогчид тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах шаардлага тавьдаг.</p>	<p>Үндэсний хууль тогтоомж болон ESS2-ын зорилтууд нь зорилгын хувьд ижил төстэй байна.</p>	<p>оролцуулан), хөдөлмөрийн нөхцөл, түүний дотор хүйс, нас арьсны өнгө, эсвэл чадвар дээр суурилан аливаа асуудалд ялгаварлан гадуурхах, дарамтлахгүй байх мөн хяналтаар хангана. Төсөлтэй холбоотой аливаа ажилтныг ажилд авахдаа ялгаварлан гадуурхахгүй байх, шударга харьцах, тэгш боломжийг дэмжих ёстой.</p>
<p>Бүх төрлийн албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг ашиглахаас урьдчилан сэргийлэх.</p>	<p>Албадан хөдөлмөр эрхлэхийг Хөдөлмөрийн тухай хуулиар хориглосон ч Эрүүгийн хуулиар зөвшөөрдөг.</p> <p>Хөдөлмөрийн насны доод хэмжээ 15 нас байна. (Эцэг эх, асран хамгаалагч, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр). Гэхдээ 18 нас хүрээгүй хүмүүс аюултай ажил эрхэлж болохгүй.</p> <p>Монгол Улс ОУХБ-ын үндсэн конвенцод гарын үсэг зурж, 15-аас доош насны хүнд хөдөлмөр эрхлэхийг хориглосон, аливаа хэлбэрээр албадан хөдөлмөр эрхлэхийг хориглосон байдаг.</p>	<p>Монгол Улс хорих ангид хоригдож байгаа хүмүүсийг албадан хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрдөг. Хууль эрх зүйн орчин нь өөрөөр хэлбэл ESS2 зорилтуудтай дүйцэхүйц байна.</p>	<p>Хийж буй хөдөлмөрийн төрлөөс үл хамааран ажилчдын насыг тухайн ажил олгогч бүртгэж, хянах ёстой.</p> <p>БОНМБ-д тусгагдсан эрсдэлийг шалгаснаар 18-аас доош насны хүмүүсийн үйл ажиллагаанд оролцох эрсдэлийг тодорхойлно.</p> <p>Аливаа Төсөл болон холбогдох үйл ажиллагаанд албадан хөдөлмөрийг ашиглаж болохгүй.</p>

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
Ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээрийн зарчмыг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн дэмжинэ.	Хууль эрх зүйн орчин нь Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хууль зэрэг эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангах өргөн хүрээтэй заалт, хамгаалалттай.	ESS2 зорилт болон үндэсний хууль тогтоомжийн хооронд ялгаа байхгүй.	Төсөлд хамрагдаж буй бүх ажилчдад, түүний дотор төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй ажилчдын гэрээний заалтууд нь ажилчдын холбоонд оролцох, байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой.
Ажилчдыг ажлын байран дээрх санаа зовоосон асуудлуудыг шийдвэрлэх боломжоор хангах.	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ажилтны гашуудах эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг ч ажлын байранд гомдол барагдуулах механизмыг бий болгохыг үүрэгдээгүй.	Үндэсний хуульд ажлын байрууд гомдол барагдуулах механизмыг бий болгохыг шаарддаггүй.	Төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтууд нь ажлын байрны гомдол барагдуулах механизмыг бий болгож, ажилчдад журмын талаар мэдээлж, гомдлыг төсөл хэрэгжүүлэх нэгжид мэдээлэх ёстой.
Байгаль орчин нийгмийн стандарт 3: Нөөцийн үр ашиг ба бохирдлоос урьдчилан сэргийлэх болон менежмент хийх			
Эрчим хүч, ус, түүхий эд зэрэг нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжинэ.	Байгаль орчны хуулиудаар Монгол Улсын бүхий л нөөц баялгийн зохистой ашиглалтыг сурталчилж байна.	Төслийн хэрэгжүүлэх нөөцийн үр ашгийн хувьд байгаль орчин нийгмийн стандарт 3 нь Монгол Улсын хуулиас илүү өргөн хүрээтэй.	БОНМБ-ийн нэг хэсэг бөгөөд БОНУАД-д тусгагдсан нөлөөллийг бууруулах стандарт арга хэмжээ нь нөөцийн үр ашиг, бохирдлоос урьдчилан сэргийлэх, менежментийг багтаасан болно.
Үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдол хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх буюу багасгах.	Байгаль орчны хуулийн зорилго нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад оршино.	Ямар ч ялгаа байхгүй. Зорилго нь Төслийн журамд тусгагдсан болно.	Дунд зэргийн, их эсвэл өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа нь

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
Төсөлтэй холбоотой богино болон урт хугацааны уур амьсгалын бохирдуулагч утаа ялгаралтаас зайлсхийх эсвэл багасгах.	Уур амьсгалын нөлөөллийн талаар тодорхой заалт байхгүй.	Төслийн хэрэгжилтэд байгаль орчин нийгмийн стандарт 3-ийн зорилтууд чиглэгдэх тул Монгол Улсын хэмжээнд ижил төстэй зүйл байхгүй.	талбайн тусгай төлөвлөгөөнд ESS3 зорилтыг тусгана.
Аюултай болон химийн хортой аюултай хог хаягдлыг бий болгохоос зайлсхийх эсвэл багасгах.	Байгаль орчны хууль эрх зүй нь нөлөөллөөс зайлсхийх, багасгахыг шаарддаг. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуульд зөвшөөрөл олгох шаардлага, устгах журмыг тогтоосон.	Ялгаа байхгүй	
Пестицидийн хэрэглээтэй холбоотой эрсдэл, нөлөөллийг багасгах, түүнд менежмент хийх	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006) нь Байгаль орчин, хөдөө аж ахуйн яамны харьяа пестицид хэрэглэх тусгай тушаалын хамт пестицидийг зохицуулдаг.	Ялгаа байхгүй	
Байгаль орчин нийгмийн стандарт 4: орон нутгийн иргэдийн аюулгүй байдал эрүүл ахуй			
Үйл ажиллагааны явцад ердийн болон ердийн бус нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаанд өртсөн орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл ахуйд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан таамаглах эсвэл зайлсхийх.	Байгаль орчны хууль эрх зүйн орчин нь хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлохыг шаарддаг.	Хэдийгээр байгаль орчин нийгмийн стандарт 4 нь Монгол Улсын стандартад бодитой дэлгэрэнгүй мэдээллийг өгдөг боловч стандартын зорилгод ямар ч ялгаа байхгүй.	Төсөл нь үйл ажиллагааг тодорхойлох, төлөвлөх ажлын хүрээнд олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг тодорхойлох болно. Шаардлагатай журам нь худалдан авах ажиллагааны

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Дэд бүтцийн зураг төсөлд чанар, аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар анхаарах мөн далан зэрэг бүтээн байгуулалт хийхэд анхаарна.</p>			<p>баримт бичигт тусгагдсан байх бөгөөд ирээдүйн төслийн гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчид өөрсдийн саналын нэг хэсэг болгон зардлыг тооцох ёстой.</p>
<p>Үйл ажиллагаатай холбоотой замын хөдөлгөөн, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэл, өвчин эмгэг, химийн хорт болон аюултай материалд олон нийт өртөхөөс зайлсхийх эсвэл нөлөөллийг багасгах, онцгой байдлын үед үр дүнтэй арга хэмжээ авах.</p>			
<p>Ажиллагсдын болон эд хөрөнгийн хамгаалалтыг нөлөөлөлд өртсөн олон нийтийн эрсдэлээс сэргийлэх эсвэл багасгах арга замаар хийж байгаа эсэхийг баталгаажуулах.</p>	<p>Хууль сахиулах ажиллагааны тогтолцоо нь хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг гутаан доромжилсон харьцахаас урьдчилан сэргийлэх ажилд хүний эрхийг харгалзан үзэхийг шаарддаг.</p>	<p>Ялгаа байхгүй.</p>	<p>Төсөл нь үндэсний хууль тогтоомжийг мөрдөж буй тусгай хамгаалалттай газар нутагт хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой ХАБ-ыг сайжруулах, эсвэл хөгжүүлэх, түүнчлэн НҮБ-ын Хууль сахиулах албан тушаалтны ёс зүйн дүрэм, хууль сахиулах байгууллага хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмуудыг дэмжих болно.</p>
<p>Байгаль орчин нийгмийн стандарт 5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хязгаарлах болон албадан нүүлгэн шилжүүлэх</p>			

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Үйл ажиллагааны төлөвлөлтийн хувилбаруудыг судлах замаар албадан нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх эсвэл багасгах</p> <p>Албадан нүүлгэхээс зайлсхийх</p>	<p>Ямар ч заалт байхгүй.</p>	<p>Хэрэв тухайн үйл ажиллагаа нь үндэсний ашиг сонирхолд нийцэж байгаа бол нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх эсвэл багасгахыг шаардсан заалт үндэсний хууль тогтоомжид байдаггүй.</p>	<p>Төслийн зарим үйл ажиллагаа нь хүртээмжийг хязгаарлаж, байгалийн нөөцийн ашиглалтад шинэ хязгаарлалтуудыг нэвтрүүлэх төлөвтэй байна. Эдгээрийг олон нийтийн оролцоотойгоор боловсруулж, FPIC-ээр баталгаажуулах бөгөөд аливаа нөлөөллийг үйл ажиллагааны төлөвлөгөөний салшгүй хэсэг болгон багасгах ёстой. Төслийн хүрээнд нэвтрүүлсэн хязгаарлалтын үр дүнд нэг ч хувь хүн, айл өрх улам дордохгүй байхыг Төсөл баталгаажуулах ёстой.</p> <p>Төсөл нь аливаа хандалтын хязгаарлалттай холбоотой ашиглалтын гэрээгээр дамжуулан эзэмшлийн аюулгүй байдлыг боломжийн хэрээр хангана. Төсөл нь тодорхой үйл ажиллагааны чиглэлээр оролцох замаар тэгш бус хохирол учруулахгүй байхын тулд гол оролцогч талууд</p>
<p>Нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх үеийнх нь амьжиргаа, амьжиргааны түвшинг бодитойгоор сайжруулах, ядаж л нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн нөхөх өртгөөр нь нөхөх замаар газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалтаас үүсэх зайлшгүй сөрөг нөлөөллийг бууруулах..</p>	<p>Өмчлөх буюу эзэмших тусгай зөвшөөрөлтэй газар эзэмшигчид нүүлгэн шилжүүлэх зардал зэрэг нөхөн төлбөр авах эрхтэй.</p>	<p>Үндэсний хууль тогтоомж нь ердийн хэрэглээний эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд амьжиргаа, амьжиргааны түвшинг харгалзан үздэггүй.</p>	
<p>Орон байраар хангах, үйлчилгээ авах, орон сууцны аюулгүй байдлыг хангах замаар бие махбодийн хувьд шилжин суурьшсан ядуу болон эмзэг бүлгийн хүмүүсийн амьдрах нөхцөлийг сайжруулах..</p>	<p>Ямар ч заалт байхгүй.</p>	<p>Үндэсний хууль тогтоомжид нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн эмзэг бүлгийн хүмүүст зориулсан тусгай заалт байдаггүй.</p>	

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг зохих мэдээллээр ил тод болгох, зөвлөлдөх, мэдээллийн оролцоотойгоор төлөвлөж, хэрэгжүүлэхийг баталгаажуулна.</p>	<p>Ямар ч заалт байхгүй.</p>	<p>Үндэсний хууль тогтоомжид нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх шаардлага байхгүй.</p>	<p>болон эмзэг бүлгийн хүмүүсийг тодорхойлох болно.</p>
<p>Байгаль орчин нийгмийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент</p>			
<p>Биологийн олон янз байдал, амьдрах орчныг хамгаалах, Биологийн олон янз байдалд нөлөөлж болзошгүй төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нөлөөллийг бууруулах шатлал, урьдчилан сэргийлэх арга барилыг ашиглах.</p>	<p>ТХГН-ийн тухай хуульд үндэсний цэцэрлэгт хүрээлэн, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газарт газар ашиглахыг хориглоно гэж заасан байдаг. Ашиглалтын хязгаарлагдмал бүсэд ойн арчилгаа, цэвэрлэгээ хийхийг зөвшөөрнө; Үндэсний цогцолборт газрын ашиглалтын хязгаарлагдмал бүсэд аялал жуулчлалын байгууламж, зам, автомашины зогсоол байгуулахыг зөвшөөрнө. Орчны бүсийн тухай хуульд хязгаарлалт хийх үйл ажиллагааг заагаагүй</p> <p>Ойн тухай хуульд ойг хамгаалах хэд хэдэн төрлийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийг бэлтгэх, өөрчлөхийг хориглодог</p>	<p>Үндэсний хууль болон байгаль орчин нийгмийн стандарт 1-н зорилт нь ижил байна.</p>	<p>Төслийн зорилго нь биологийн олон янз байдал, оршин суугчдыг хамгаалах, хамгаалахад оршино.</p> <p>БОНМБ нь төслийн үйл ажиллагаа нь амьдрах орчны биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх стандарт арга хэмжээгээр хангадаг.</p>

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Байгаль хамгаалах хэрэгцээ, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг нэгтгэсэн туршлагыг нэвтрүүлэх замаар нутгийн иргэдийн амьжиргаа, түүний дотор орон нутгийн иргэдийн эдийн засгийн хүртээмжтэй хөгжлийг дэмжинэ.</p>	<p>Ямар ч заалт байхгүй.</p>	<p>Орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээнд тавигдах шаардлага байхгүй.</p>	
<p>Байгаль орчин нийгмийн стандарт 8: Соёлын өв</p>			
<p>Соёлын өвийг үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, хадгалахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Соёлын өвийн тухай хуульд биет болон биет бус соёлыг хамгаалах тухай заасан байдаг. Соёлын өвийн тухай хуульд тусгай зориулалтын соёлын дурсгалт газруудад болон ойр орчмын газруудад хориглох үйл ажиллагааг жагсаасан байдаг. Хуулиар соёлын биет бус өвийг хамгаалдаг.</p> <p>ТХГН-ийн тухай хуулиар үндэсний дурсгалт газруудаас 3 км-ийн зайд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагааг хязгаарласан.</p>	<p>Ялгаа байхгүй</p>	<p>Төсөл үйл ажиллагаа эхлэхээс өмнө аливаа соёлын өвийг тодорхойлох болно.</p> <p>Хэрэв барилга угсралтын ажил хийгдэх тохиолдолд аливаа төслийн гүйцэтгэгч эсвэл туслан гүйцэтгэгчид санамсаргүй олох журам шаардлагатай бөгөөд Төсөл хэрэгжилтэд хяналт тавина.</p>
<p>Соёлын өвийг тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг болгон авч үзэх.</p>	<p>Ямар ч заалт байхгүй.</p>	<p>Соёлын өвийг тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг болгон авч үзэх шаардлага байхгүй.</p>	<p>Төсөл нь соёлын өвийг үйл ажиллагааны төлөвлөлтийн салшгүй хэсэг болгон авч үзэх болно.</p>

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
Соёлын өвийн талаар сонирхогч талуудтай зөвлөлдөх ажлыг дэмжинэ.	Ямар ч заалт байхгүй.	Соёлын өвтэй холбоотой оролцогч талуудад тавих шаардлага байхгүй.	Төслийн үйл ажиллагаатай холбоотой соёлын өвийг тодорхойлсон тохиолдолд биет болон биет бус өвийг үл харгалзан өвийг боловсруулах, төлөвлөх талаар зөвлөлдөх хэлэлцүүлэг хийнэ.
Соёлын өвийг ашигласны үр шимийг тэгш хүртэхийг дэмжинэ	Ямар ч заалт байхгүй.	Соёлын өвтэй холбоотой ашиг шимийг тэгш хүртэх тухай хуулийн заалт байхгүй.	Төслийн эхлүүлсэн үйл ажиллагаанаас үр өгөөж гарах тохиолдолд холбогдох төлөвлөгөөнд байгаль орчин нийгмийн стандарт 8-н зорилтуудыг дагаж мөрдөх үр ашгийн хуваарилалтыг тусгана.
Байгаль орчин нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал			
Зээлдэгчдэд оролцогч талуудыг тодорхойлох, тэдэнтэй бүтээлч харилцаа тогтооход тусалдаг оролцогч талуудын оролцоонд системтэй хандлагыг бий болгох.	БОНБУ тухай хуульд зааснаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангахыг шаардлагатай. БОНБУ тухай хуульд байгаль орчны стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд олон нийтэд ил тод болгохыг шаарддаг.	Байгаль орчин нийгмийн стандарт 10-ийн зорилго нь Төслийг удирдан чиглүүлэх ёстой маш их зөрүү байна. Бүтээн байгуулалтын төслүүдэд оролцогч талуудыг өргөнөөр оролцуулах шаардлага байхгүй бөгөөд аливаа үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй гэж тооцогдохгүй бол (БОННУ-г хийх шаардлагагүй) төслийн нөлөөлөлд өртсөн бүлгүүдэд олон нийтийн оролцоо, мэдээллийн хүртээмжтэй байх шаардлага байхгүй.	Төсөл нь холбогдох бүх хүмүүс, олон нийт, бүлгүүдийг тодорхойлохын тулд оролцогч талуудын зураглалыг хийнэ. Төсөл нь үйл ажиллагааны оролцооны журмыг боловсруулж, тэдний санал бодлыг авахын тулд байнгын оролцоотой оролцогч талуудтай зөвлөлдөх болно.
Үйл ажиллагаанд оролцогч талуудын сонирхол, дэмжлэгийг үнэлж, үйл ажиллагааны загварт оролцогч талуудын саналыг тусгах боломжийг олгох.			Байгаль орчин, нийгмийн бүхий л баримт бичиг, журмыг оролцогч талуудад

Байгаль орчин нийгмийн стандартын зорилго	Монгол Улсын ижил төстэй заалт	Орхигдлын дүн шинжилгээ	Төслийн хандлага
<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн туршид үйл ажиллагаанд өртсөн талуудтай үр дүнтэй, хүртээмжтэй хамтын ажиллагааг дэмжих, хангах арга хэрэгслээр хангах.</p>			<p>хүртээмжтэй байдлаар, тэр дундаа төрөлх хэлээр мэдээлнэ.</p>
<p>Тохиромжтой мэдээллийг оролцогч талуудад цаг тухайд нь, ойлгомжтой, хүртээмжтэй, зохих байдлаар нээлттэй болгох.</p>			
<p>Төслийн нөлөөлөлд өртсөн талуудыг гомдол барагдуулах механизм нь хүртээмжтэй байх мөн Зээлдэгчдэд эдгээр гомдолд хариу өгөх, зохицуулах боломжийг олгох.</p>	<p>Гомдлыг улс төр, шүүх, хууль сахиулах байгууллага гэх мэт уламжлалт сувгуудаар гаргаж болно.</p>	<p>Төслийн үйл ажиллагааны явцад гомдол барагдуулах механизм гэсэн шаардлага байдаггүй.</p>	<p>Төсөл нь аливаа асуудлыг аль болох доод түвшинд шийдвэрлэхийн тулд гомдол, санал хүсэлтийн журмыг бий болгож, асуудлыг саадгүй шийдвэрлэх болно.</p>

